



АЙСУЙ

Айсуй

Зохиолч: Б.Төгсжаргал

ISBN: 978-99962-0-772-3

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Уялга үг

Сэтгүүлч, яруу найрагч Ишийн Батсүхийн бага охин аавынхаабийр янтайг нийлэн бичиг номынх нь үйлийг залгамжлан яваагаатовчоолон уншигч танаа бариж байна. Ишийн Батсүх сэтгүүлч,шүлэгч хүн байсныг “Шүүдрийн дусал”, “Үнэн санаа хүчтэй”,“Өглөө”, зүрхний бичлэг, “Сэтгэлийн суврага” шүлэг найраг,нийтлэлийн номуудаар нь уншигчид мэдэх билээ.И.Батсүхийн өөрийнх нь бичсэн номуудаас болон найз нөхөдшавь нарынх нь дурсамж дурдхалаас ямаршуухан нөхөрсөг,хүмүүнлэг, дүн нуруутай хүн болохыг мэдэж болохын зэрэгцээманай яруу найрагчидын сэтгэлийн орчилонг гийгүүлэнгэгээрүүлэгч багш нь, тэдний бага залуу цагийнх нь хамгийндоотно, хамгийн эрхэм хүн нь явсныг О.Дашбалбар, Д.Нямсүрэн,Ай.Төмөр-Очир нараар нь төлөөлөл болгоход нэн ч бахдалтай.Сайн аавын алдар сайхан нэрийг саран дээр боловч бичихэдбэлэн яваа Б.Төгсжаргал бүсгүйн эл номд энэ л цаг үеийнзахиалгаар мэндэлсэн их бурханч лам Г.Пүрэвбат, гайхашруулагчзураач С.Төгс-Оюун, С.Саранцацралт, бичгийн их утгач Г.Аким,Хөх нуураас төрсөн, хөх монгол гэгээнтэн Ажиа, монгол хүнийсүүн сэтгэлээр угжуулж ухаажсан хятад зохиолч Зян Рун, ухаанжагсаж, ур тэгширсэн зураач, уран барималч Ж.Дүүрэнтөгс, ихбичээч М.Чимэдцээ, их найрагч Б.Лхагвасүрэн, Д.Нямсүрэн,Г.Мэнд-Ооёо, цаглашгүй номын үйл бүтээгч М.Шагдарсүрэннарын энэ л цагийн эзэд эрхэмүүдтэй уулзаж, заримынх нь яриагдуу хураагуурт шингээснээ цааснаа буулган бичиглэн үйлдсэн аж.Б.Төгсжаргалын уулзсан энэ эрхэмүүд бол тус тусдаа эрдэмсудалгааны судлагдахуун болохын учир хожим хойно, хэзээ нэгэнцагт хэн нэгнийх нь ярисан хэлсэн нэг үг, нэг өгүүлбэр нь боловчдээдийн үнэ цэнэд хүрэхийг хэн ч үгүйсгэж эс чаднам. Энэ номынамин сүнс үүнд л байгаа хэрэг.Сэтгүүлч, зохиолч эцгийн охинд сэтгэн бодохуйн, зохионбүтээхийнх нь билиг оюун задарч, урлан бүтээхүйнх нь ухаан тэлж,улам улмаар өсөн сайжирч өрнөн бадрахын өлзий ерөөнөмү.

Ц.Базаррагчаа.

(МУСГЗ, зохиолч, орчуулагч, доктор, профессор)

Энэхүү номоо миний хайрт аав

Сэтгүүлч, Яруу найрагч агсан

Ишийн Батсүхийнхээ гэгээн

дурсгалд зориулав.

Хоног хэдий олон ч холдуулж мартуулах нь үгүй



Миний аав сэтгүүлч, яруу найрагч И.Батсүх

Нэг. Найрагч ааваа дурсан санахуй.

Аавтай явсан цаг хором хоромоор алсалж

Амьдралд үүрэх ачаа хоног хоногоор хүндэрнэ

Хүүг чинь баярлуулж хүмүүс дандаа

таныг дурсах юмаа

Миний сайхан аав хүний сайн нь байж дээ....”

Аавын минь тэрлэж үлдээсэн шүлэг, миний дэрлэж хоносонбодол. Чухам хүн гэмээн үр хүүхэддээ шингэхийн учир энэболов уу.Нөмөрт нь хоргодох дуртай модны минь навчиснахиалж, үргэлж хажуугаар нь өнгөрдөг цэцэрлэгт миньягаан цэцэг дэлгэрээд, Дорнодын тал нутгаас ээж удахгүйирнэ гэсэн сураг дуулдаж, өдөр хоногууд ямар сайхан үйлявдлаар дүүрэн билээ дээ. Аавын тухай ярихад ээжийнтухай, ээжийн тухай ярихад аавын тухай өгүүлэхгүй байжболомгүй ийм гэгээн дурсамж бидэнд олон байдаг юмаа.Аав минь амьдралынхаа намартай золгож чадалгүй цэцэгдэлгэрсэн урин цагаар орчлонгийн алс хязгаар уруу хувьзаяаны гүүр дамжаад яваад өгчихсөн. Ээж минь харин хувьзаяаны энэ бараан сүүдрийг гэгээн сэтгэлээрээ цайлгаж, үрхүүхдүүд биднийхээ дунд гэрэлтэн сууна. Энэ бурхны зурсанзаяа зураг юм болов уу даа. Аавын маань дэндүү эрт биднээсхолдон одсон нэрлэж мэдэхгүй энэ зураг харин нададер таалагдаагүй ч би энэ зургийг дахиж арай өөр өнгийнхарандаагаар, яг адилхан үл чадах ч яльгүй төстэй ч боловзурж явах хүсэл мөрөөдөлтэй аж төрж байна.“Зурах тусам жам гэсэн нэг л үг, нэг л дүрс харагдаххэдий ч би цааш илүү адилхан, илүү гэгээлэг зурсаар,зурсаар л явнам”... хэмээн аавдаа захидал бичээд ямар чдугтуйнд хийлгүй, дусал нулимс унагалгүй найрагч шавьО.Дашбалбараар нь дайж явуулсан юм. Өгсөн байна лээ.Би аавынхаа амьдарч ирсэн хөх цэнхэр дэлхий дээр оршиж,барьж байсан ногоон үзэг, хүрэн цүнх, дуу хураагуурыгнь бариад өнгө өнгийн зураг зурсаар л явна. Зарим ньуйтгартай, зарим нь баяр хөөртэй. Ихэнх нь гэгээлэгөнгөтэй.Харин

миний өвөө Лувсан-Иш 1932 онд МонголРабфакийн анхны төгсөгч байж, 40 гаруй жил малынэмчээр ажиллан, Монголд анх удаа малын эргүү өвчнийгэмчлэн, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон,“Алтан гадас” одонгоор хоёр удаа энгэрээ мялааж, маршалХ.Чойбалсангаас “ИМЗ-72” маркийн гурван дугуйт,калибрь буугаар шагнуулж явсан алдарт их эмч байсангэдэг. Аав минь эцэг эхийнхээ ачийг хариулсан сайн хүүбайж, богинохон амьдралаа үргэлжийн бичиж туурвих,унших бодох, бясалгах, хань үр хүүхэд, бусдыг хайрлах тиймл гэгээн тунгалаг агшнуудаар дүүрэн үлдээсэн сэтгүүлч,яруу найрагч байлаа.“Шүүдрийн дусал”, “Үнэн санаа хүчтэй”, “Өглөө”,“Зүрхний бичлэг”, “Сэтгэлийн суварга” гээд яруу найраг,сурвалжлага, нийтлэл, тэмдэглэлийн номуудын нь мөрбадаг бүхнийг нутгийн зон олон, уул овоо, уншигч түмэн,умдаалж өссөн ус ургамал нь хүртэл андахгүй ээ.“Үлэмжийн сайхан орчлонд төрсөн заяандаа бахдажҮлгэр домгийн диваажинг хаанаас ч би эрэхгүй”хэмээн амьдарч байсан аав минь,

“Төрсөн бие зуу наслах нь ховорхон ч

Тарьсан бодол мянганыг дамнана” хэмээн зөгнөж,

“Хүмүүс бие биеэ хайрлаваас

Хүсэл биелэх сайны үр бүрэлдмөй”

хэмээн захиж сургасаар одсон ч уран бүтээлээрээ, ус нутаг,зон олныхоо хайр бишрэлийн хураангуй болж, бидэнтэйгээхамт байсаар л...Нэг насаараа намын “Үнэн” сонины сурвалжлагчийналбыг хашиж, “МОНЦАМЭ” агентлаг, Монголын радио,“Тоншуул”, “Сүхбаатарын зам”, “Дөл” гээд төв ороннутгийн олон хэвлэл мэдээллийн байгууллагын тусгайсурвалжлагч, эрхлэгчийн албыг хашиж, энэ салбартаа үгийнбилэг, үзгийн хурцаар үнэний тухай ихийг сэтгэж, олныгөгүүлж, үнэнч анд, бусаддаа үлгэр дууриал болмоор сайханхүн байсныг нөхөд нь дурсан ярьдаг юм.Одоо ч гэсэн “Үнэн” сониныг зорин очиход сэтгэлддотно санагдаж, аавын тухай дурсамжаас эхлээд, бичижтэмдэглэсэн бүхнийг минь хэвлэн нийтэлж, аавынхааүргэлжлэл болон аж төрөхөд халуун сэтгэлээр тосон авдагтбид баяртай байдаг. Аавын үеийнхнээс “Үнэн” сонинд одооЦ.Бөхдамбий ах, Жа.Пүрэв гуай хоёр л байна даа.МУСГЗ Жа.Пүрэв ах “Аливаа хэргийг их бага гэхгүйбаараггүй л хийдэг хуучны улсуудын нэг бол миний андИ.Батсүх байсан юм даа. Тэрээр хэлье гэснээ ёстой хэлжбайгаа юм шиг хэлнэ. Хэнээс ч айхгүй, үг хэл нь хурц тод,шударга бус юмыг үзэн ядна. Зүгээр нэг шударга бишюм гээд хэлээд өнгөрөхгүй. Үг хэл, үйл хөдлөл, дууныхааөнгөөр ч дурайтал ялгаад өгнө. Тэгсэн хэрнээ бусдыг,ялангуяа ядарсан зүдэрсэн хүмүүсийг өрөвдөж хайрлах ньбүр нэг сэтгэлээсээ байдагсан. Ер нь И.Батсүх шиг тиймахиад, сэргэлэн цовоо хэн байдаг билээ гэж бодоход тэр бүрхэн нэг хүн санаанд ордоггүй юмаа” гээд сайхан дурсамжярихад нь самсаа шархирдаг.

МУСГЗ, зохиолч, сэтгүүлч Г.Жамц гуай “И.Батсүх мааньөөрийн авьяас чадвар, хөдөлмөр хичээл зүтгэлээрээ манайсонины “даалуу”, “бэрс” шиг сэтгүүлч болсон. Түүнийбичсэн мэдээ сурвалжлага, өгүүлэл, тэмдэглэл, найруулал ньилүү дутуу үггүй, санаагаа цэгцтэй илэрхийлдэг, бичлэгийннайруулга зүй нь төгс төгөлддрөөрөө бусдаас ялгардаг байлаа.Сонины газраас өгсөн захиалгат бичлэгийг хурдан шуурхайбиелүүлнэ. Энэ нь орон нутгийн сурвалжлагчийн маш чухалшаардлага. Тэр маань хүний хувьд ёстой л эр хүний хуйхбайлаа.

Шүлэг найраг нь их гүн агуулга, нарийн сэтгэмжтэй. Үзэг нэгт нөхөд маань хожим хойно Батсүхийн хүн чанарыгилүүтэй дурсан ярьдаг байлаа” гэж бичсэн юм. 2010 онд бид аавынхаа шүлэг яруу найраг, уран бүтээл, дурсамжаас бүтсэн “Сэтгэлд уянгалах яруухан хөгжим шиг” ном бүтээхээр зорьж явахад олон хүмүүс дурсамж бичижөгсөн. Миний хятад хэлний багш, МУСГЗ, дуун хөрвүүлэгч, зохиолч, хэл бичгийн ухааны доктор Ц.Базаррагчаа энэ номыг уншаад: “Би аавыг чинь сайн мэдэхгүй ээ. Харинаавын чинь тухай дурсамж, уран бүтээл, хөрөг нийтлэлээс бүтсэн “Сэтгэлд уянгалах яруухан хөгжим шиг” номыг уншлаа. Хүн бүрийн өгүүлж байгаа дурсамж аавын чиньхэзээ ч хувиршгүй сайхан сэтгэл, ажилч хичээнгүй, авьяаслаг дүр төрхийг өгүүлсэн байна. Хүн бүрийн хувиршгүй сайн анд, авьяаслаг найрагч, сэтгүүлч байжээ.

Чи аавынхаа үйлсийг үргэлжлүүлэх гэж хичээж байгаа хүнтийм л хүн болох хэрэгтэй дээ” гэж үргэлж аминчлан хэлсэн юм. Аавыг минт тэнгэрт халихад засагт данстай бичгийн машин, ширээ, сандал, дуу хураагуур гээд бүхий л юмыгнь хурааж авдаг ёс горимтой. Харин тэр үеийн “Үнэн” сонины эрхлэгч, нэрт зохиолч, сэтгүүлч, Л.Түдэв гуай “Танай долоон хүүхдэд аавынхаа мэргэжлийг өвлөх хүүхэд байгаа гэж итгэж байна” гэж аавын минь хэрэглэж байсан бүх зүйлсийг номын өрөөнд нь үлдээж өгсөн юм. Аавынхаа хэрэглэж байсан дуу хураагуураар олон арван сурвалжлага, нийтлэл, ярилцлага бичиж тэмдэглэн хэвлүүлсэн дээ. Л.Түдэв гуай аавыг маань дурсаж: “Орчин үед уран зохиолнь баримтат уран сайхны шинжтэй болж тэгснээрээ сэтгүүлзүйн бүтээлтэй “ойрхон нягтрах” үйл явц хүчтэй болж буйн шинжийг тэртээ гучаад жилийн чанадаас мэдэрч уран бүтээлдээ баримталж эхэлсэн цөөн сэтгүүлчийн нэг нь Ишийн Батсүх болсон юм. Үнэн санааны хуулиар урлаж бүтээж явсныг хорьдугаар зууныг өндөрлөх жилүүдэд монгол үндэсний хамгийн том индэр асан “Үнэн” сониныхуудаснууд гэрчлэхээс гадна шүлэг найраглал, нийтлэлийг нь агуулсан уран зохиолын номууддаа тэр л санаа бодлоо шингээж үлдээжээ” гэж бичсэн нь хайр бахархал төрүүлэмнандин санагддаг. Аав минь ийм нэр хүндтэй, олны итгэлийг даасан оюунлаг гэгээлэг хүмүүн байсан юм даа. Ялангуяа уул усаа хүнчлэн сэтгэж, бурханчлан шүтэж:

Сэтгэлд уянгалах яруухан хөгжим шиг

Сэргэлэн багын минь ялгуухан бодол шиг

Аль ч талаасаа сүмбэрлэн харагдах

Алтан-Овоо миний нутаг ...гээд шад мөр бүхэн нь нутгийн үнэр аниртай, санаа бодол болгонд нь хайр оршсон байхуйд хүн гэмээн дэлхий дээр яажамьдрах ёстойн үлгэр болсон аавыгаа цаг ямагт дурсан явнам. Дагшин нутаг Дарьгангадаа өсөж, Алтан-Овоо, Ганга нуур, Шилийн Богд, Цагаан овоо гээд олон цэнхэр суварга мэт Дарьгангын уулс дундуураа сүлжинаж төрж, их найрагч Данзангийн Нямсүрэнтэй Гангынхөвөөнд бөх барилдаад, шүлэг тэрлэн, овооныхоо энгэрт морь тарлаж, шавь О.Дашбалбар, Ай.Төмөр Очирнарыгаа найргийн замд хөтлөн оруулж, дүү Г.Мэнд-Ооёогийнхоо нутгийн ах, шүлгийн онгодхайрлагч найргийн анд нь байсныг тэдний мартагдашгүй дурсамжуудаас уншиж, сонсож, уярач тайтгарч явдаг юм.

Анхныг ахуйн ахуйг мөнх гэгч
Холын багшар өйлөгөн бол хосгүй хүнсэн Товуу Та
Эгэл Бүтэцнэ Зүүр нь чүү энүүгүсүүн ухаан
Морин гэх гээр согдон өвчлөгч манууш ^{Юмсан}
Болох эр нилсан
Ховор тохиох Буданга Ашиглан Та
Хойноор гуртах ахуйг ^{Харсангүй} Та Гэтлүү Доромоо
Өсөн хөгжих ёсоороо ^{Халсангүй} харвоо ^{Самсан}
Өгөрт ^{Цингэрт} ганзах ёзоороо Товуу Сүхтэ
Мохон Батца

1988 26
Өмнөд Танын Товуу Та
ӨНӨӨ ТЭЙГЭЛЭ
702 ХОН Б-МС.

Миний аав И.Батсүхийн “Товуу” шүлгийн гар бичмэлТөрийн соёрхолт, нэрт яруу найрагч агсан О.Дашбалбарах “Багш” нийтлэлдээ: “Ангийн хаалга нээгдэж И.Батсүхбагш орж ирэх нь ертөнцийн хаалга нээгдэж Бурхан багшзалрах лугаа адил бөгөөд энэ нь нэгээхэн ч хэтрүүлэг бусбагшийгаа “Бурхан багш” гэж бод хэмээн манай шашинсургах бөлгөө. И.Батсүх багш минь хичээл зааж байхадтүүнээс гэрэл цацрах мэт байдагсан. Түүний цээл сайханхоолой тасалгаа дүүрэн цуурайтаж, бид түүний чин зүрхнийүг, дуу хоолойн аялга, хөдөлгөөн бүхэнд олзлогдож, түүнтэйөнгөрүүлсэн агшин бүр энэ ертөнцөөс бидэнд заяасаннэгэн их бэлэг, хайр хишиг болдог байлаа... Тэрээр биднийгГогольтой уулзуулж, Тарас Бульбатай танилцуулж, түүнийачаар бид Дундад зууны Англи улсад нисэн одож, Шекспирхэмээх нэгэн их хүнтэй учран Ромео хөвгүүнийг бахархаж,Жульетад дурлана” гээд л яг л шүлэг мэт яруу сайхнаарбичсэн байдаг. Багшийгаа ингэж дурсаж, хайрлаж, санажбичнэ гэдэг шавийнхаа сэтгэлд, хүүхдийн бодолд ямар ихүнэн байж чадсан, үлгэр жишээ болж өгсөн хүмүүн байсныгнь харж болох юмаа.Миний аав хань ижил, үр хүүхэд, анд нөхөр, шавь нартаайм их хүндлэгдэж, “Хүнд хүн чанар, эрүүл саруул биебайхад бүх юм байна гэсэн үг. Хүнд тусалж, бусдын тусыгмартаж үл болно, миний хүүхдүүд эрт бос, ном унш, оньсоготаалцаж бай ухаан тэлнэ. Элсэнд асгасан ус шиг худалбитгий хэлж бай, эх нутгаа хайрлаж уул овоогоо шүтэж бай”гээд л үргэлж хэлж сургаж захидаг сайн эцэг, сайхан хань,багш, сэтгүүлч, яруу найрагч хүн байсан даа.Хамгийн гол нь миний аав сайн үйл бүхнийг өөрийнбиеэр үлгэрлэж чаддаг байлаа. Бүх зүйлийг чин сэтгэлээс яв цав хийдэг, цэцэн цэлмэг үг яриатай, ухаан бодол, уужуусанаа нь тэгширсэн аав минь жижигхэн хүрэн гар цүнхэндээдуу хураагуураа хийгээд хуйлаастай сониноо бариад гэртээяаран орж ирдэгсэн. Энэ л үед гэр минь тэр аяараа

халуундулаан уур амьсгал, хайр хүндлэл бялхаад явчихдаг байлаа. Хэдэн зуун номтой бичгийн өрөөндөө чимээгүйхэн уншиж, бичсээр л сууна. Орсон гарсан хүнд гурилтай шөл хийж өггээд л (өөрөө шөлтэй хоолонд их дуртай) биднийг дуудаж, холоос ирсэн гийчнийг бидэнтэй заавал танилцуулж, хүнийг нас намба алба ажилаар нь огт ялгаварлалгүй хууч хөөрөхдуртай хүн байсан юм. Би тэр үед Дорнод аймгийн хүүхдийн дуу бүжгийн “Талынянзага” чуулгын бүжигчин сурагч байлаа. Манай чуулгын ханаймгийнхаа сумдууд, хөрш зэргэлдээ Ага, Чита мужид тоглолтхийх нь цөөнгүй. Энэ үед аав минь “Корреспонденты” (сурвалжлагч) гэсэн жижиг улаан тэмдэглэлийн дэвтрийгнадад дурсгаж, “байнга биедээ авч явж очсон газартаа үзсэн харсан сонин содон зүйлээ тэмдэглэж яваарай” хэмээн захиж өгсөн юм. Энэ бол аавын минь өндөгний хээ, халуун амьсгаашингэсэн үнэт эрдэнэ болсон дэвтэр юм. Энэ дэвтрээсээ би хүүхэд насныхаа олон дурсамжийг эргэн хардаг юм. Урлаг, сурлага гээд тун завгүй байхад бүххүүхдүүдээсээ зөвхөн намайг л дуудаж өрөөстэй ном бүрийн тоосыг авах, шинэ сонин уншиж дуусахаар дэс дэсээр нь хадгалах, өөрийнх нь бичсэн сурвалжлага гарсан сонин дээртэвэн хошуу зурж тэмдэглэх зэрэг ажлуудыг ихэд нямбайхийхийг зааж сургадагсан. Бид долуулаа дунд сургуульд байх үед эхэлж сурахад яг л гадаад хэл шиг хэцүү санагддаг монгол бичгийг “умшумш умш” гээд хэд дахин уншуулж бичүүлж сургасан нь хожмоо намайг хятад хэл сурч судлахад хамгийн их хэрэг болсон доо. Учир нь миний анхны хятад хэлний толь бичиг монгол бичгээр байсан. Энэ мэт аав минь охиныхоо урлагт дуртай урмыг нь хугалж мэднэ гээд бүжигчин болоход минь цааргалж байгаагаа шууд хэлэлгүй, алсын бодол тээж сэтгүүлч болох замд минь хөтөлж байсан нь энэ байжээ. Насан эцэс болохынхоо ердөө л гуравхан хоногийн өмнө “Миний охин аавынхаа мэргэжлийг өвлөж аваарай. Энэхорвоод аав нь үгүй болсон ч чамайг сэтгүүлч болоход хэрэг болох их зүйл үлдээсэн шүү” гэж тэнхээ мэдэн хэлснээ итгэл горьдлого тээсэн харцаар намайг харсан юм. Тэр цагаас хойш би бяцхан хунгийн цагаан өмсгөлөө тайлж, бүжгийн урлагийг анхлан заасан Цэрэнчимэдбагшийнхаа бүжгийн дугуйлан, “Талын янзага” чуулгын дуучин байхаа больсон ч огт харамсаж үзсэнгүй ээ. Сэтгүүлч болох хүсэл зорилгодоо хөтлөгдөн шалгалтандаа бэлтгэнулам олон шүлэг, зохион бичлэг бичихийг хичээж, дунд сургуулийн монгол хэлний багш Алтанцэцэг, Наранцэцэг, ангийн багш Сайнцаг болон бусад олон арван эрдэмт багш нарынхаа буянаар амжилттай төгссөн дөө. Биеийн тамирын хичээлд хэзээ ч “онц” дүн авч үзээгүй миний хувьд энэхичээлээ бүжиг бүжиглэн “гайгүй дүнтэй” төгсөөд тэржил сургуулийнхаа “Урлагийн тэргүүний сурагч”-ийн туузыг энгэртээ зүүж инээмсэглэн зогсож байсан мөчөө би мартдаггүй юм. Сурагч насандаа сурч байсан бүжгийн урлаг, оюутан насанд сурч эзэмшсэн утга зохиолын мэргэжил, ажлын гараагаа эхэлсэн радиогийн сурвалжлагч миний амьдралын хөтөч болж өгсөн. Энэ бүхэнд залж, зааж сургасан эцэг эхийн минь холч ухаан гэрэл гэгээтэй замаар хөтөлж, сайн сайхан амьдралын минь эх булаг болсон юм. 1996 он. Аавынхаа сурч байсан МУИС-ын утга зохиолын ангид элсэн орж, өгсөж уруудаж явсан шатаар нь алхаж, сууж байсан танхимд нь эрдэмтэн багш наараараа хичээл заалгаж, дөрвөн жилийг ардаа орхисон. Төгсөхдөө аавыг минь хүнийх нь хувьд төдийгүй бүтээлээр нь сайн мэдэх хэл бичгийн ухааны доктор, профессор Д.Цэдэвбагшийн удирдлага дор аавынхаа шавь О.Дашбалбарынуран бүтээлээр дипломын ажил бичиж, үерхэж нөхөрлөж явсан сайхан нөхөдтэй нь үг хэлэлцэх завшаан олон таагохиолдож дурсамж дүүрэн яриаг нь сонсох бүртээ би аав, ээжээрээ улам бахархдаг. Харин миний ээж долоон хүүхдээ хүний зэрэгт хүргэхгэж аавын оронд аав болсоор өдий хүрсэн дээ. Аавын маань ном судар, бурхан шүтээн өвлүүлсэн бүхнийг яг тэрхэвээр нь нандигнан хадгалж, бидний төлөө цаг наргүй хөдөлмөрлөж, уран гар, ухаан билгээрээ орчлонгийн нүхнийг даван туулсаар өдгөө жаран нас хүрчээ. Дарьганга суманд хөөрхөн өндөр

цагаан багш охин бэрболж очиж анхны хүүгээ төрүүлж байсан ээж минь өнөөдөр “Өндөр ажаа” гэж дүү нартаа хүндлэгдэн үр хүүхдүүдбидэнтэйгээ аж төрж байна. Би ээждээ зориулж:

Бүсгүй хүн шүлэг л байдаг

Бүтэн нойргүй шөнө л байдаг

Үнэндээ тэднийг ээжүүд гэдэг ч

Үнэнд дийлдсэн аавууд байдаг

Эр хүний нөмөрт жаргадаг гэдэг ч

Эргэх дэлхийн тэнхлэг байдагхэмээн шүлэглэсэний минь учир энэ болой. Аав ээж хоёрынминь “Анх танилцаж байхдаа хятад зурагчнаар даруулсанюмаа” гэж дурсах дуртай хуучны гэрэл зураг манай гэрийнхойморт чимэг, бахархал, дурсамж, хайр, баяр баясгаланболдог доо.



Миний аав И.Батсүх, ээж Ж.Наранчимэг 1969 он

Аав минь ноён нуруутай холч ухаантай, хөдөлмөрч нэгэнбайсан төдийгүй сэтгүүлч хүний эрхэм чанар болсоншударга зарчимч, үнэн хурц үгтэй хүнлэг сэтгэлийг мөнчанараа болгож чаддаг хүн байсныг нөхөд нь үргэлждурсдагсан.Аав минь 1990-ээд оны эхэн үеэс Дорнод, Хөлөнбуйраймгуудын сонины газруудын хооронд түншийн харилцаагогтоож, хамтарч ажиллах эхлэлийг тавьж байсан юм.Хожим Хайлаар хотын “Өдрийн сонин”-ы үзэг нэгт нөхөднь ааваар минь бахархан, Монголд ирж байсан сайханөдрүүдээ дурсаж: “Аавтай чинь арван жилийн өмнө сайханнөхөрлөж ажил хэрэг амьдрал уран бүтээлийн яриа өрнүүлжявсан

юм. Дорнод аймгийн Булган сумын малчин айлдзочилсноо ер мартдаггүй.

Буурлын буман үеэс

Буян хишгээ татаагүй

Ухаант гүнжийн домгоор

Удам дамжин магтагдсан гэж дуулахад,

- Та нар чинь манай дууг уяртал дуулж, зохиол бүтээлийгнэ түгдрэлгүй уншиж, эх монгол хэлээрээ сайхан ярих юмаагэж гүрэн алсалж яваа бидэнд урам өгч билээ. Намайг,

- “Бид чинь тав гэзэг тавьж, тасам монгол гутал өмсөөд,бургас зайдлан, модон морь болгон унаж байх үеэсээ“Хуучин хүү”, “Хоньчин Найдан” зохиолыг уншиж сурсан”гэхэд аав чинь их бахархаж баярлаж билээ.Шүлэг зохиол сайхан бичнэ, уншина, сайн сэтгүүлч.Мөн хашир анчин хүн болохыг нь бид анх уулзаад л мэдсэн.Билгийн улирлын 8 сарын 15. Тэр жилийн тэргэл сарыг бидэх сайхан монгол нутагтаа, Хэрлэн мөрний хөвөөнд, Булгануулынхаа хормойгоос харж билээ. Харин тэр үед бид нарт“Тоонто нютаг” дууг дуулж өгч байсан жаахан охин нь иймолон жилийн дараа сурвалжлагч болоод, хятад хэл сурахаарХайлаар хотод ирсэн нь сонин учрал байна” гэж намайгбага залуу гэж саналгүй яг л аавтай ярилцаж байгаа мэтажил байдлаа танилцуулж, зочлон дотно яриа өрнүүлсэнюм. Хүний газар холын нутагт хүртэл надад ийм сайхан хувьерөөл тохиож байсныг би билэгшээн бодож эргэцүүлвэл хүнгэмээнэ үр хүүхэддээ буян хишгээ хүртээхийн учирьг санажээж аав, эх нутгаа санан хоолой зангирч хэдэн оныг үдсэнюм.Ингэж аав минь тэнгэрээс хүртэл биднийгээ үргэлжхарж, ивээж, хайрлан, явах замын минь зүг чигийг заажбайдаг нь юутай ч зүйрлэшгүй их хувь тавилан гэж боддог.Орчлонгийн өдөр хоногийн уртад ааваасаа асуумаарих зүйл байдаг ч амьдралын үнэнд дийлдэхийн учиргэрийн хойморт залрах бүрх малгайтай зурагны нь өмнөжаахан сууж тайвширдагаа. Би аавынхаа дуу хураагуурыгнь өвөртөлж, сэтгүүлч мэргэжилээр нь ажиллаж, үзгийгнь барьж үйлсийг нь үргэлжлүүлэхээр зорьж явна. Жилбүр аавынхаа төрсөн нутаг Дарьгангад очиж, төрөл садан,нутгийн ах дүүстэйгээ уулзаж, нуур бүхнийхээ эрэг дээрхэрх балчир хүүхэд насаа эргэн санаж, шувуудтай ньярилцан, нутгийнхаа олон цэнхэр уулсын дундуур эрхдураараа сэлгүүцэж, өвс ургамлынхаа анги ондоог мэдэрч,Алтандарь овоогоо эргээд насны амь шим хүртдэг авай.Өглөө эрт босож, жаахан Лхаамаа өвөөгийн бурхнаасадис хүртэж, цайгаа уучихаад, Дагшин булгийнхаа цэнгэграшаанаас хүртэж, Дуутын цэнхэр мандал дээр нисэнбуух хун шувуудын ганганааг сонсох гээд нутагтаа очиходтовлосон хоногууд үл хүрэлцэнэ. Очих бүртээ би аавтайгаауулзсан юм шиг санагддаг учраас Дарьганга нутгаа дахиндахин зорьдог юмаа.

Энэ тоолонд нутаг минь шинэсэх мэт санагддаг ч хуучьярдаг хөгшид минь нэг нэгээрээ одсон байх нь харуусмаар.Дарьганга сумын бага сургуулиар нь орж, ууж байсан рашаанбулгаас нь амсаж, аавын минь төрсөн эгч Хорлоомоо, өвгөнах Лхамсүрэн, дүү Үржинханд, найз Дугарсүрэн ах гээд олонхүмүүсээс очих бүртээ сайхан дурсамж сонсдог. Тэднийминь дурсамж биднийг баярлуулахын сацуу уйлуулдаг.

Үүрд үл мартагдах аав минь

Залбирал бишрэлийн оргил болсон Алтан-Овоондоо эх дэлхийгээсээ, эх орноосоо, энхрий үрсээсээ хагацатлаа «Алтан-Овоо минь» гэж амандээ шингэнхэн сүжиглэж явсан нэгэн бол миний хайртай «Аав» билээ.

Яг нэг жилийн өмнөсөн... Бидэнтэйгээ буцалнаж байсан, сургаж, ашиглаж эр хүний гүндүүгүй сайхан төрх, эцэг хүний ариун наандни ёсыг гээлгүй өрх гэрийн түшиг, тэл нутгийнхэн нам хан атлаа сүртэй үүлсэн оргил шиг л байсан.

Хорвоо дээр гагцхүү үнэний төлөө, үнэнчээр зүтгэж явсан аав минь эх дэлхийн хэв газар шороонд, эгэл түмнийхээ сэтгэл зүрхэнд ховог шин үлдэж чадсан билээ.

Бичгийн ширээний бяцхан шилэн дорхи хийх, бичих үйлдлийнх нь төлөвлөгөө, Ном, цаас бүгд хэвээр үлдлээ. Тэр ч байтугай «Сэтгэлийн суварга»-ныхаа эхний хуудсыг эргүүлж амжилгүй хорвоог орхилоо. Гэсэн ч миний авьяан үнэнч шударга зан, цэцэн цэлмэг ухаанд нь үзэг, үйлс нэгт хэн бүх-

ний сэтгэлд тод үлдсэн хэвээр байлаа.

Хүний орчлонгийн тоосонд хөл нийлүүлэн гишгэж, хурц ухаан оюун билгээрээ бүгдийгээ өөртөө шингээж нисан буантай сайхан авьяаг минь бурхан тэнгэр нээж буй гэдэгт итгэнэм.

Буян хишиг арвижих болтугай!

Бүх хүмүүс зуу наслах болтугай!

Сурагч Батсүхийн
ТӨГСЖАРГАЛ

“Дөл сонин” №23 1994.05 сар

За яахав дээ. Хорвоогийн бас л нэг өнгө. Хүрээ хотодтухалж, хүмүүний амьдралыг элээж явахад, ах дүү шигнөхөрлөж явсан сайхан үеэ мартаж, нүүр буруулах хүмүүснэг хоёр байдаг л юм. Энэ нь миний аавын муугийнх бишгэр хүний өөрийнх нь мөн чанар бизээ. Хүн болгон адилгүй, хүлэг болгон жороогүй гэдэг. Аавын минь үр хүүхэдбидэндээ үлдээсэн буян, ээжийн минь хэзээнээсээ аливаадухарч, улцайхыг үздэггүй ухаалаг тэвчээртэй, ажилсаг, уйгагүй зан чанарын ач гавьяа гэж боддог.

Хоёр. Аавын өрөө

Аавын өрөө гэж манай гэрийн гэрэлт ертөнц байлаа. Аавын өрөөнд Монголын төдийгүй дэлхий дахины түүх, урлаг утгазохиолын олон ном сэтгүүл, тэр үеийн бараг бүхий л сонинхэвлэл, бичгийн машин, өвөг дээдсийн минь шүтээн бурхад, Алтан-Овооны чулуу, алдартай зохиолч, уран бүтээлчдийнхөрөг зураг, модон шатар гээд хэн хүний нүдийг хужирлажсэтгэлийг гэгээрүүлэх зүйлүүд олон. Аав минь өрөөндөө суун бидэнд түүх шастир, уранзохиол орчлонгийн сайхан зүйлүүдийг ярьж зааж зөвлөн, амьдралын их ухаанаас үлгэрлэн үзүүлсэн. Аав гэртээбайхгүйд өрөө нь түгжээтэй. Хүн бүр дур зоргоороо оржболохгүй. Гаднаас орж ирээд л нар их тусдаг байсан өрөөгөөнээхэд гэр минь гэрлээр дүүрч улам дулаахан болчих шигсанагддагсан. Өрөө нь номоор дүүрэн. Өөрөө бүгдийг нь уншчихсан. Орос хэл дээр хэвлэгдсэн дэлхийн сонгодогуудыг ч аавминь уншсан юм. Өөрөө гэрийн номын сангийн эрхлэгч. Гэртээ байгаа бүх номыг нэгд нэгэнгүй мэднэ. Хэд дэхтавиур дээр ямар номнууд зэрэгцэж байдгийг хамгийн сайнмэднэ. Ном уншихаар аваад эргүүлж байранд нь хийгээгүйгаав андахгүй мэдэж, асууж шалгаана. Номын тавиурыг ертоостой байлгадаггүй. Үргэлж арчиж зүлгэхийг даалгана. Энэ чухал ажлыг гол төлөв надаар л хийлгэдэгсэн. “Аавнь чамайг насаараа дэргэдээ дагуулж явахгүй. Ямар нэгзүйлийг бага гэлтгүй өөрөө хийж сурах хэрэгтэй” гэдэгбайлаа. Аав ээжийнхээ зааж зөвлөснөөр одоо бид бүгдмэргэжил боловсролтой, ажил амьдралтай болсон нь хоёрбурхны маань ач гавьяа юм даа. 1989 онд Дорнод аймгийн “Болор цом” наадмынтэргүүн шагналыг Эрээнцав сумын ойролцоо орших манайулсын хамгийн нам дор, шувуудын чуулга чуулах “Хөхнуур”-ын тухай бичсэн шүлгээрээ авлаа.

Эх орны минь хамгийн намд тогтсон

Эгэлхэн нуур тэнгэр мэт тунгалаг

Мяралзан цуварч хөөцөлдөн наадах

Мянга мянган долгис мөнгөлөг

Чулуу шидэхэд ёроолд нь торойж

Чуулсан загас ив илхэн

Хөх номин усанд нь дэвссэн

Хөрс ургамал тов тодхон

Дагинас нүүрээ тольдож, үсээ засахад

Давалгаагаа татаж толиорох усан эрдэнийг

Хөх нуур гэж ард түмэн

Хичнээн онож нэрлэсэн юм билээ... гээд их урт шүлэг.

“Болор цом” авсан энэ үдэш аавын минь бийр бэх нэгтэйнөхөд нь цугларч, шүлэг яруу найргаа уншиж утга уянгынхур буулаа. Шөнө дундын үест гэрийн үүдэнд хэн нэгэнлимбэдээд байх шиг сонсогджээ. Лимбэний эгшиг уламтод эгшиглэж ээж очоод үүдээ нээж өгөхөд үе үеийнхүүхэд багачуудын дуулах дуртай “Ботго” дууг зохиосон, авьяаслаг хөгжмийн зохиолч, лимбэний М.Ганболд багш “Болор цом”-ыг хоймртоо залсан аялгуу шиг өргөөнд тань лимбэний эгшигтэй орж ирлээ” гэж баяр хөөртэй тэрүдшийг лимбэний аялгуугаар чимж байж билээ гэж ээжминь дурсан ярьдаг. Энэ тухай Г.Мэнд-Ооёо ах:

...Гэрийн минь гадаах улиас уруу

Гэрлийн шувууд нисэлдэн ирээд

Лимбийн дуутай өргөө уруу минь

Өнгийж хараад тормойлдож байна ... (Лимбэчний дууль) хэмээх гайхалтай шүлгээ аавд минь зориулж бичсэн юм. Аавын өрөөнд болсон мартагдашгүй дурсамж олон дооолон. Хожим аавын өрөөний хойморт уран бүтээлийнх нь андгэрэл зургийн сурвалжлагч Б.Батцэрэн ахын дуран авианаа буулгаж, Дорнодын алдартай зураач агсан С.Лувсаншаравын засварлан бүтээсэн бүрх малгайтай зураг нь ялимгүй инээмсэглэн угтаж, малгай бүс нь бичгийн машин дээрээ эвхээстэй, модон шатар, нүдний шил, үзэг бал нь ширээндээрээ эзнээ хүлээх мэт үзэгдэнэ. Хэн ч үл хүрнэ. Бидтэйшээ зарим нэг ном судар үзэх, арц хүж уугиулан, цайныдээж болоод идээ будааг нь сольж, тоос шороог нь авахаас өөр нэг их шалтгаан үгүй бол ордоггүй байлаа. Хүүхэд ахуй цагт маань өглөө сэрэхэд бичгийн машины тог тог хийх мөнөөх чимээ угтаж, орой унтахад энэ чимээ үлдэгсэн. Одоо ч чихэнд сонсогдох шиг болж, аав миньямар их гэгээн тунгалаг ухаантай, мэргэн цэцэн үгтэй, билэгавьаастай хүн байсныг улам мэдрүүлдэг юм.

Ээж минь аавтай нөхөрлөж явсан уран бүтээлч нөхдийг нь дурсан ярьж, уран бүтээлчийн гэргийн жаргалтай сайхан үе эргэн санах дуртай. Хожим манайх энэ байрнаасаа нүүсэн ч цонхон доогуур нь өнгөрөх бүртээ би олон арван гэгээн дурсамжуудыг санадаг юм. Ялангуяа үдэшорой болтол гэрэлтэй байдаг аавын өрөөний цонх миний амьдралын хамгийн тод гэрэл болон сэтгэлд үлдсэн. МУСГЗ, яруу найрагч Г.Мэнд-Ооёо ах, аавын хамгийн сүүлд хэвлүүлсэн “Сэтгэлийн суварга” хэмээх номын оршилд:

“Би түүний газар усаа гарын алга мэт таньж, өвөгдээдсийн үүх түүх үлгэр домог, ер дуулаагүй юм үгүй мэтэлбэг баян оюуны багтаамжийг бахархан гайхаж, хонгортохөвстэй, сүүмэлзэх талын сэрвээн дээгүүр үнэгэн соргялтганан хөдлөхийг анзаарах гярхай хурц хараанд биширч догдолж явсан билээ. Нэгэн айлын зүс ижил адуу мэт Дарьгангын олон уулсыг нэг бүрчлэн ярьж, уран бүтээлийн онгод хайрлан, газар нутгаа танихын ухааныг ахын ёсоор сургасны ачийг үл мартаж учир надад буй. “Үүлэн хээтэй тэнгэрт, үрлэн бороо цайрахыг”, “Дэргэн цувах адуу шиг зэрэглээ яралзах “талд харж”, “Үүлс миэгнэх тэнгэрийн цайвар хөх дэвсгэрт”, “Үлэмж сүрлэг Алтан-Овоогоос сэтгэлдээ зурж хайрлаж биширч, уярч догдлон явсаар талнутгийн бат суудалт энгүүн намбалаг, даруухан дөлгөөнуулс мэт тийм уран бүтээлч болж төлөвшсөн ажгуу” хэмээн өгүүлсэн байдаг.

Ингэж уул овоогоо хүнчлэн сэтгэж, нутаг ус газаршорооныхоо эд эс ширхэг бүрийг нь таньж,

чин сэтгэлээссүжирч, шүтэж, мөргөж, шүлэг найрагтаа магтан дуулж, хэн бүхний сайн ах, сайхан анд байсан аавын минь гэрэлтчанарыг Дорнын их яруу найрагч Б.Явуухулан “Дарьгангын нэвтэрхий толь” хэмээн дуу алдсан байдгийг нь утгазохиолын хүрээнийхэн дурсан санаж, бахдан ярилцдаг юмаа.

Хоног хэдий олон ч холдуулж мартуулах нь үгүй билээ.

Бага охин, сэтгүүлч, яруу найрагч Б.Төгсжаргал

Б.Төгсжаргал

Миний ээж



Миний ээж Ж.Наранчимэг 1986 он

Дээр цэлийх хөх тэнгэрт нар ганцхан байдаг юм

Дэлхий хэмээх захгүй орчлонд нутаг ганцхан

Ижий минь та саран гийх мэт сэтгэлд ганцхан

Эргэн санахад сургаал ачлал тань ижилгүй ганцхан

Хүн бүхэн ээжийгээ хүний дээд хэмээн хайрладаг, ээждэээрхэлдэг, ээжийгээ санадаг. Ээждээ тунирхдаг. Би тэдний лнэг, айлын бага охин.Б.Энхтуул, Б.Энхтуяа гэж ааш араншин аливаабүхнээрээ надаас өөр хоёр эгчтэй. Өөр гэсэн нь тэд миньнадаас илүү ухаантай, даруу төлөвхөн араншинтай.Миний ээж, ах, эгч тэд намайг сүрхий их загнаж,зандарч, онц сурахыг шаардаж, олон болзол тавьжбайсангүй. Амьдралдаа хийж байгаа алхам бүрт минь нададитгэж, болохгүй бүтэхгүй гэж хорьж цааргалж байсан тухайтод дурсамж огт үгүй. Амьдралын туршлага надаас илүүболохоор алдаа оноог минь олж хараад хааяахан их аргадахайрлах янзтай өгүүлэхээс илүү үг хэлдэггүй. Надад жааханширүүлчихвэл уйлчихна. Би гэж дэндүү эрх танхи өссөнюмаа. Энэ нь би гэдэг хүн өө сэвгүй, өөдтэй хүн учраасийм биш. Миний гэрийнхэн намайг ингэж л өдий зэрэгтхүргэсэн. Гэтэл би өөрөө хүүгээсээ маш их зүйл шаарддагээж болчихсон байдаг. Заримдаа хүүгээсээ уучлалт гуйдаг лдаа. Би.

2000 оны луу жил. Би өхөөрдөм хөөрхөн хүү төрүүллээ.Аав нь түүнд Бэлгэдэл гэсэн содон нэр өгч, бид хүүгээхайрлан энхрийлж, эрхэлж тоглоно. Энэ л цагаас биеэжийгээ илүү ойлгож

мэдэрч, улам хайрлах болсон юм.Бурхны бүтээсэн хамгийн агуу зүйл бол эх үрийн хүйнхолбоо, агуу их хайр гэж би бодож биширдэг. Орчлонхорвоогийн хүмүүн бүхэн ийн бодож, төсөөлдөг бизээ. Энэл нандин холбоо их хайрын үрээр хавар болж цэцэг дэлгэрч,байгаль дэлхий өнгөө сэлгэн өөрчлөгдөн хувьсаж, шинэсэнгэрэлтдэг болов уу.Хорвоо дээр энэ их хайрын шимээр мэндэлж, ээжаавынхаа баяр хөөр болж байхаас эхлээд өнөөдрийг хүртэлээжтэйгээ хамт аж төрж байгаа маань хамгийн их бахархалюм. Ээж минь арван дөрвөн хүүхэдтэй айлын том охин. Нэгхтай байсан. Долоон хүүхдийн ээж, арван хоёр дүүгийн эгч,ард олны мянга мянган хүүхдийн багш, сайн хань, сайханбүсгүй юмаа.Миний ээж бол бидний “Их хүн”. Эгэл жирийн багшхүн. Тэр дундаа долоон хүүхдээсээ илүүтэй түмний мянгамянган хүүхдүүдийг хүний зэрэгт хүргэсэн далай хүн. Өдөрбүр гэрэлтэй үг, гэгээн үйлсээрээ үлгэрлэн, сэтгэлийних хаттай байж, орчлонгийн түмэн нугачаанд бүдэрч,бүдгэрэхийг мэддэггүй гэрэлт хүн. Сайхан ээж миньхорвоогийн үнэнд дийлдсэн аав хүн. Туулж өнгөрүүлсэнамьдралын их хөлгөн судраасаа дэлгэн үлгэр мэт хүүрнэж,үдэш оройгүй үйл мэтгэж суудаг уран хүн гээд л би ээжийгээдуусашгүй их гэгээн сайхан үгээр магтаж чадна.

Биднийг бага байхад хүүхдийн баяр болгоноорөөрийн урласан шинэ даашинз, хувцасаар гоёж, өөрөөхүүхдүүдтэйгээ адилхан баярладаг байсан нь сэтгэлд тодхонсанагдаж одоо ч энэ л янзаараа хайр энхрийллийн хатан хаанболж үр хүүхэд, ач зээ, арван хоёр дүүгээрээ хүрээлүүлэн,“Өндөр ажаа” хэмээн өргөмжлүүлж, хүндлүүлж суудаг.Хүүхэд байхад урлагийн наадмуудад их оролцдог байлаа.Ээж минь байнга л гоё даашинз, дээл урлан намайг гоёжбусдын өмнө өнгөтэй өөдтэй яваасай гээд хичнээн шөнийннойроо хугаслан суусныг тоочин хэлж барамгүй юм.Ингэж л шинэ өглөө шиг гэгээн сэтгэлтэй, сэржчадамгүй нандин зүүд шиг инээмсэглэлт ээж минь эртэчшувуу шиг өдөр бүр бүхнээс түрүүлж босоод өөдрөгамьдралынхаа хором бүрийг хайрладаг. Амттай сайхан цайхоол хийж, алдар цуутай олон зохиолч уран бүтээлчид,найз нөхдөөсөө чин сэтгэлийн үгийг нь сонсож, ханийнхаачимэг, гэрийнхээ багана болсоор өнөөдрийг хүргэсэнбурхан сэтгэлтэй буянтай сайхан ээжүүдийн нэгэн.Сэтгүүлч, яруу найрагчийн гэргий хэмээх ховорхонхийгээд азтай хувь тавилангаараа бахархан аавтай манайхаарирдэг байсан М.Цэдэнжав, Б.Явуухулан, Д.Пүрэвдорж,Д.Гармаа, Р.Чойном, Ш.Сүрэнжав, Д.Нямсүрэн, Д.Маам,О.Дашбалбар, Г.МэндОоёо гээд олон арван сайханзохиолчдын тухай хуучлан ярих нь миний амьдралын баярбахархал болдог.

Гэрт минь зочилсон хүн бүхэн ээжийн маань уран гар,уяхан зан, гоо үзэсгэлэнг нь магтдаг байсан ч аав миньээжийг ер магтдаггүй хүн байжээ. Би анх сонсоод их гайхдагбайсан ч аавын минь дотоод сэтгэлийн мөн чанарын нэгэнилэрхийлэл энэ байсан юм байна гэж ухаардаг юмаа. Нэгудаа их зохиолч Д.Маам гуай нутагтаа ирж, ээжийг байхгүйдманайд зочилоод, аав хоол унд болоод их л дайлжээ. Д.Маамгуай:

- “Танайх олон хүүхэдтэй, ховор нандин номын сантайсайхан айл юм. Харин зочин ирэхэд заавал байх ёстой хоёрюм алга. Нэгдүгээрт манай зохиолчид чамайг их сайханэхнэртэй гэж ярилцдаг. Эхнэр чинь алга. Хоёрдугаарт чиөөрөө тамхи татдаггүй чинь хамаагүй. Айлд сайн тамхизаавал байх ёстой” гэж хошигнон хэлжээ. Үүнээс хойшД.Маам гуай насан эцэс болтлоо аавтай минь ах дүү шигнөхөрлөж явахдаа олон удаа манайхаар зочилж, аав тэрүеийн сэхээтнүүдийн татдаг байсан “ВТ” тамхиар дайлж,ээж минь амттай сайхан хоол цайтай

үдэж, угтдаг байжээ.Р.Чойном гуай мөн залуу цагтаа аавтай минь ах дүүс шигнөхөрлөж манайхаар их ирдэг байсан гэдэг. “Чойном гуаймандолин хөгжим сайхан тоглодог. Нэг оройжин мандолинтоглоод, шүлэг уншиж, аав чинь “Алтай” найраглалыгнь арван найман минут тасралтгүй цээжээр уншдаг байжбилээ. Мөн Чойном гуай сайхан зурна. Эмэгтэй хүн шигмаш гоё гартай. Намайг нэг удаа зурсан юм. Тэр үед залуубайхад тийм сайхан хүнээр зуруулж байна, хадгалж үлдээгэж бодож явсангүй. Их харамсалтай санагддаг” гээд лээжийн яриа ямар сонин содон үйл явдлаар дүүрэн гээч.“Доржийн Гомбожав багш манай ангид уран зохиолордог байлаа. Ангийн цонхоор хараад Гомбожав багширэхийн бараанаар хүүхдүүд томоотой суудаг байж билээ.Голдуу жаахан улаа бутраад бага зэрэг балгачихсан янзтайявж байдаг байсныг нь санадаг юм. Хүүхэд байж юун тиймх гярхай байсан юм. Их цэвэрч нямбай, мэдлэгтэй сайханхүн байсан шүү” гээд л ээж Дарьгангын бага сургуульд сурчбайсан үеэ сэтгэл догдлон дурсдаг юм.Мөн “Дашбалбар тэр үед их жоохон хүүхэд байсан шигсанагддаг юм. Багшаа миний жохиол гээд 12 мөнгөнийдэвтэр бичсэн баахан шүлгээ багшдаа үзүүлдэг байсан.Жаахан дулитраа хэлтэй, эргэлдсэн хөөрхөн том нүдтэй.О.Дашбалбар, Ай. Төмөр-Очир хоёр бол шавь нараас ньбагшийгаа хамгийн их дурсдаг, их ирж уулздаг байсан даа.Том зохиолч нар болсон хойноо ч үргэлж багшийгаа ярьдаг,дурсдаг, бичдэг юм” гээд л ээжийн дурсамж хөвөрсөөр л...Аав ээж минь Дарьгангадаа гал голомтоо бадрааж,ажлын гараагаа багшийн ажлаараа эхлэн, нэгэн үеийншижигнэсэн сайхан багш залуучууд гялалзаж явсан гэдэг.

“Зарим орой бид нар нэгнийдээ цуглаад дээл оёно. Нөхөрхүүхдүүдээ тэр үеийн залуу багш нар бид өөрсдийн урласандээл хувцасыг өмсгөж, янз бүрийн хаггамалаар гэрээ гоёдогбайсан тухайгаа дурсан ярих хамгийн дуртай. Аргагүй дээ.Хүний амьдралын залуу нас гэдэг хэзээ ч бүдгэрэхийнаргагүй гэгээн дурсамжаар хичнээн их баялаг билээ.Одоо хүртэл тэр үеийн багш нар хот хөдөө хаана ч гэсэнбие биенээ үгүйлж, уулзаж залуу халуун насаа дурсахдааамьдралынхаа хамгийн алтан үедээ эргэж очсон мэт баярхөөртэй байгааг нь харах бахтай санагддаг. Амьдралынжамаар олон хүн ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн байдаг.Тэдний яриа бол жаргал зовлонгийн нэгэн судар болонүлдмээр гэгээн дурсамж тэдний амьдрал бол мянга мянганшавь нарынхаа амьдралын эх булаг гэж би боддог юм.

Аав минь :

“Наран болоод чимэг болохоор

Нэр нь хүртэл яруу сайхан”

хэмээн ханийгаа хайрлан:

Сул асгасан сувд шиг цул мөнгөн шүүдэр дунд

Нэл алтан нарыг зулай дээрээ залсан

Аадрын дараах солонго адил санагдан

Анх надтай учирсан тэр дүрээрээ ир дээ.

Одтой хорин нас ахиад бидэнд ирэхгүй

Олж чамтай учирснаа цагийн урсгалд мартахгүй

Он цаг үсэнд хяруу цацахад

Онгон хайрын сэтгэлд мөнгөн сор шиг санагдана.

Улирах хугацаа магнайд үрчлээ тавьсан ч

Уяхан ханийнхаа нүдэнд унаган төрхөөрөө үзэгдэнэ... гэж шүлэглэсэн нь насан туршийнх нь хайрын дуулал. Бидийм нандин сэтгэлийн модноос ургасан үр жимс юм даа. Улам л олуулаа болсоор. Б.Дөлгөөн, Б.Тэргэл, Б.Есүнхэй, Б.Тэмүүжин, С.Оюунтөгс, З.Хонгор, З.Сайнхүү, П.Бэлгэдэл, Х.Зулсар, Х.Дарханхүү гээд олон хөөрхөн ачзээ нар нь өсөж том болсоор байна. Үр хүүхдүүдээ өсөж том болоод олуулаа болох тусам амьдрал нь утга төгөлдөр болохын үнэнийг би ээжээсээ олж хардаг юмаа. “Сайн ээж, аав байна гэдэг үр хүүхдийнхээ хийморьлундаа өргөж хувь заяаг нь тэгшилж явдаг учиртай. Одоо танар минь бүгдээрээ ээж аав боллоо. Өдөр бүр ухаарч сайн бодож, үр хүүхдийнхээ төлөө хөдөлмөрлөж эрдэм номыг чухалчлан явах хэрэгтэй. Аав нь тэнгэрээс харж байгаа” гэжээж минь үргэлж захидагсан. Өнөөдөр бид бүгдээрээ өөр өөрийн замаар аж төрж байна. Өөдтэйхэн явбал ээж аавынхаа заяа буянд биширч өөдгүйхэн байвал өөрийн муугийнх хэмээн санаж бодож ухаарч чадахаар ээж аав болсон. Харин ээжийнхээ сэтгэлд бүгдээрээ нялхаараа... Ээж минь “Миний охин бүсгүй хүнөөрийн санаагаар амьдрахын нэг зүйл бол үйл мэтгэх. Эрдэм номыг хичээн суралцаад, аж төрөхүйн ухаанаас өөрийн санаагаар өдөр бүр суралцахгүй бол амьдралын босго өндөршүү” хэмээн захиж сургасаар жар гарчихлаа. Залуу цагаасаа нутаг усандаа үйлэнд уран, ажилсаг бүсгүй гэж магтагдаж, олон арван загвар зохиож, 2000 гаруй дээл хувцас урлан, уран хүний нарийн ухаанаараа агайхаждаг яваа бурхан ээжүүдийн нэг. Ээжийн урласанд ээл эзэндээ элбэгдэж, зохиогүй гэж бид сонсоогүй ээ. Янздонж нь таарсан олон дээлүүдээр түмнээ гоёсон гавьяатай. Би ч гэсэн найр наадам хөтлөх, найргийн наадамд шүлгээ уншихдаа эрээн даашинзнаас илүү ээжийнхээ урласан торгон дээлүүдээр дандаа гоёдог юмаа. Мөн бага байхаас минь хожим хэрэг болно гэж цуглуулсан ном, сонин сэтгүүл нь тоймгүй олон. Бидний бага байхад хэзээний л цаас хайчилж, нааж, цуглуулж гарбичмэлээр гайхамшигтай бичдэг билээ. Монголын төдийгүй гадаадын зохиолч уран бүтээлчдийн сонины хайчил бараар зуу гаруй хавтастай үзүүлэн бэлтгэн өөрийн ажилдаа хэрэглэх нь хэн ч хэзээ ч хийж чадаагүй бүтээл байдаг юм. Монгол хэл уран зохиолын багшийн мэргэжлээрээ насаараа ажиллаж энэ мэт баялаг өв санг хуримтлуулж бидэнд өгсөн хүн дээ. Мөн МУЗН-ийн гишүүнээр гуравдугаар ангийн жаахан охин байхдаа элсэж, хэдэн мянган хүүхэд залуусыг хүмүүнлэгийн үйлсэд нэгтгэн, олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулсан нь түүхийн хуудаснаа бичигдсэн байдаг. Ардын боловсролын тэргүүний ажилтан, Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч цол хүртэж, Монгол Улсын Боловсролын салбараас анх удаа МУЗН-ийн “Нигүүлсэнгүй үйлстэн” эрдэнийн очирт алтан медаль хүртсэн юм. Олон улсын “Найрамдал” зусланд амарсан гадаад дотоодын мянга мянган хүүхдүүд ээжийн маань хийсэн “Монгол наадгайн гайхамшиг” тоглоомоор тоглодог оор нь бид нар бахархан баярладаг. Энэ нь ээжийн маань хүүхэд бүхэн миний хүүхэд гэж ойлгож, хайрлаж явдаг нандин сэтгэлтэй нь хүйн холбоо мэт оршиж байдгийг өгүүлж буйхэрэг. Оюутан байхад орчин үеийн уран зохиолын багш, зохиолч Ч. Дагвадорж маань ээжийгээ өөд болоход хамт байж чадаагүйдээ их

харамсаж: “Ээждээ бурхан бүтээж,дээлийг нь дэрлэж, шүлэг, дуу зохиож үзлээ. Ээж миньэргэж ирээгүй. Ирэхгүй нь хорвоогийн үнэн юм. Харинби амьдад нь баярлуулсан нь тун цөөн. Өнгөрсөн хойно ньюу ч бүтээгээд ирэхгүй. Миний хүүхдүүд ээжийгээ л сайнхайрлаж яваарай” гэж захиж хэлсэн нь үргэлж бодогддог.Ээжийгээ төдийгүй эх орноо баярлуулсан гавьяатай хүнингэж ярьж байхад бид нар ээжийгээ яаж баярлууллаа даагэж бодоход дэндүү чамламаар юм даа.Их сургуулийн оюутан боллоо гэж ээж минь хүн хүндяриад их баярласан. Хөөрхөн жаахан зээ хүү Бэлгэдэлийгээхорвоод мэндлэхэд бүр ч их баярласан. Нутаг алсланхилийн чинадад эрдэм сурч ирэхэд минь мөнгөн аягатайсүүгээ барьж тоссон. Аавынхаа үзгийг барьж үйлсийг ньүргэлжлүүлэн ажиллахад үнэнч зөвлөгч, шүүмжлэгч миньболсон. Шинэ номын хурим хийхэд минь сэтгэлээ барьжчадалгүй нулимс унаган догдолсон. Эргэцүүлж бодоход биээжийгээ жаахан ч гэсэн баярлуулжээ гэж санавч энэ болүр хүүхэд бидний үүрэг юм. Ингэж л бид ээжтэйгээ эринцагийг хамт туулж байгаа азтай хүүхдүүд.



Ээж бид хоёр Бээжин хот 2012 он

Намайг их сургуульд элсэн ордог жил ээж минь “Минийхүү эрдэм сурахаас илүү ээжийгээ бодоод байж болохгүйшүү” хэмээн захиж байсан ч харилцуурны цаанаас дуугнь сонсоод гэрээ санаж, ээжийгээ улам их санаж байсанээжийн эрх охин доо. Одоо ч би ээжийгээ маш их санадагюмаа

Сүүн бурхан ижий заяа зөвхөн таных

Сүүдэр дарж гэгээ татуулах увдис таных

Мэлмий цагаан саран гэрэлт сэтгэл таных

Мэндийн орчлонд үрээ төрүүлсэн тавилан таных

Ээж минь та

Миний сэтгэлийн хамгийн

Их хүн билээ.

Бага охин, сэтгүүлч, яруу найрагч Б.Төгсжаргал

Усан луу жилийн зун цаг ээж бид хоёр



Ээж Дарьганга нутагтаа 2012 он

Энэ зун сайхан зун боллоо. Хүүгийн минь жил орж байна. Усан луу жил. Аргагүй л хур ихтэй зун боллоо. Цахимхуудсандаа “Бороо бороо ороорой, Оросын маамуирээрэй” гэж бичсэнд олон хүн загнаж байна шүү. Хурмастдэлхий хураа хайрлахаас илүү жаргал юу байхав дээ. Гангачиг болсон халуун зун байвал яах бидээ. Газар хатуу, цэцэгногоо гундуу, хөгшид хүүхэд нозоороод, гол ус уйтгарт охиншиг хэтэрхий тогтуухан, уул тал хийморь сүр нь дордчихсонэр хүн шиг л үзэгдэх байх даа. Байгаль ээж ийм өнгө төрхтэйбайвал ямархан гунигтай билээ. Хур бороотой сайхан зун. Усан луу жилийн зун цагаар ээжтэйгээ хамтнутгаараа аяллаа. Дөрвөн жилд нэг удаа тохиодог АлтанДарьвооныхоо их тахилгад ээжтэйгээ, Б.Барсболд, Б.Зуунбилэг ах нартайгаа зорин очиж, мөн Сүхбаатараймаг маань байгуулагдсаны 70 жилийн ойд оролцож, хөршгүрний нийслэл Бээжин хотоор аялан, дэлхийн долоонгайхамшгийн нэг Цагаан хэрэм, Хааны ордон, 13 хааныонгон, Хааны зуны цэцэрлэгт хүрээлэн, Бээжингийн ихсургуулиар зочилж, Хятадын алдарт зохиолч Зян Рун, монголч эрдэмтэн Яао Као Чинг, зураач Чөн Жи Чиннартай уулзаж дурсамж дүүрэн өнгөрүүлээ.

Ээж минь Дарьгангадаа очихоор залуу насаа уламих дурсдаг нь сэтгэл хөдөлгөдөг юмаа. Найзуудтайгаауулзаж, нутгийн хөгшчүүлийнхээ залуу цагийг ярьж, энэорчим тэднийх байсан, харин энд манайх байсан, Магсарбагшийнх тэнд байсан гээд л хуучилж эхлэнэ. Залуубайхад бид нар өдөржин сургууль дээр завгүй ажиллана. Ахмад багш нараа их хүндэтгэнэ. Хүүхэд бүрийн төлөөөөрийн хүүхдээс ялгаагүй санаа тавьж ажилладаг байлаа. Оройдоо нийлж дээл оёно, гэр орны ажилаа хийнэ, хүүхдээхүмүүжүүлнэ гээд л үзэгдэх харагдах бүхий л зүйлс,

уулзсаньярхан хүн бүхэн ээжийн минь дурсамжийг сэргээж байгаагарахад сэтгэл уярмаар санагдана. Их зохиолч Ч.Лодойдамба гуай амьдралын сайхануулзалтандаа байдаг гэж юутай үнэнийг хэлсэн билээ. Нададийнхүү ээжийнхээ аз жаргалтай байхыг харах сайхан байлаа. Аймгийнхаа 70 жилийн ойгоор мөн өөрийнхөө урласанцагаан торгон дээлээр гоёж, дүү нартайгаа уулзаж, арванжилд хамт ажиллаж байсан багш нарынхаа гэрээр зочилжойн медалиар энгэрээ мялаасан юм.

Алба амины хэргээр цөөнгүй зорьж байсан Бээжин хотмонголчуудын очих дуртай газар. Хятад гүрний хэл соёлыгшигмтэн сурч байхад гүнзгийрэх тусмаа арга мухардах шигадармаатай санагддаг ч өдгөө дэлхий дахиныг “Хятад хэлсурах халууралд хөтлөж байна”. Намайг хятад хүнтэй ярихаар их л сонирхон харж “Миний охин ээжийнхээ мөнгийг уг нь дэмий үрээгүй, хятад хэлийг сайхан сурсан юм байна” гээд сэтгэл их лөөдрөг. Би харин заримдаа дэмий үрсэн юм болов уу даа гэжбодож өөрийгөө их чамладаг юм. Ээжтэйгээ урьд нь Дорнодаймагтай хил залгаа байдаг Хөлөнбуйр аймгийн Хайлаар, Манжуур хотоор олон удаа хамт аялж байсан ч энэ удаагийнаялал ээжид минь ер бусын сайхан санагджээ.



Хааны зуны цэцэрлэгт. Бээжин хот. 2012 он

Бээжинд ирсэн хүн Тиан Ан Миний талбайд очиж, Цагаанхэрэм үзэж, шарсан нугас иддэг жамтай. Ээж маань ихазтай юм. Анх удаа Бээжинд ирж байгаа хүн гэхэд бүгдийгнь үзээд амжив. Мао Зэ Дуний хөргийг залсан томоос томталбай, харуул хамгаалалт, цэвэр цэмцгэр байдал, ногоонбайгууламж бүгд л сонирхолтой. Бидний аялал 130 гаруй жилийн түүхтэй ШанҮ хэвлэлийн газрын орчуулагч нартай уулзсанаарүргэлжилж, Хятадын их удирдагч агсан Мао Зэ Дунытөгссөн Хятадын хамгийн нэр хүндтэй Бээжингийн сургуульд зочилсон юмаа. Хуучны түүхт барилгабайгууламжаасаа эхлээд орчин үеийн томоохон номынсан, ховор сонин үзэх зүйлсээр дүүрэн энэ сургуулийн ЯоКао Чинг профессор бол миний хүндэлж явдаг багш нарынмаань нэг юм.

Ээж бид хоёрын усан луу жилийн зуны аялал олонүйл явдлуудаар дүүрэн байж, сэтгэлд шингэсэн гэгээндурсамжтай өдрүүд дараа жил үргэлжлэхийн ерөөлтэйгөөрөндөрлөлөө. Дараа жилийн аялал даанч хол байна даа.

Ажиа гэгээнтний “цагийг бэлгэдэгч Наран чөлөө”-д өгүүлмөй




Хөх нуураас тодорсон Монгол гэгээнтэн Ажиа гэгээнтэн 2010 он

Төвдийн Гүмбүм хийдийн их хамба Ажиа Ренбүүчи Америкийн Нэгдсэн улсад Гватемалаар дамжин улс төрийн учраар дүрвэн ирсэн тухай сонин хэвлэлийн хуудаснаас луншиж байсан юм. 2010-10-5 өдөр. “Интерном” номын их дэлгүүрийн ерөнхий менежерээр ажиллаж эхлээд удаагүй байсан даа.

“Цагийг бэлгэдэгч наран чөлөө” номны нээлт хийх захиалга ирснийг сураглавал өмнө нь сонссоноос цаашгүй байсан Ажиа Гэгээнтэн ийнхүү манай номын орд өргөөнд ирэх, номныхоон ээлтийг хийх завшаан тохиосонд их л баяртай байлаа. Хятад монголоор тэгш сайхан ярьдаг, инээмсэглэлдүүрэн дотно дулаахан төрхтэй энэ их хүмүүнтэй уулзах гэж Америк уруу орчлонгийн дөрвөн зүг найман зовхисоос хүмүүс зорин очдог юм билээ. Харин монголын хамгийн том номын дэлгүүрт номын баяраа хийх тов зарласан нь бахархмаар сайхан үйл явдал. Олон хүний шинэ номыг гөлгийдөн авч баяр хөөрийг нь хуваалцдаг манайхны хувьд Ажиа Гэгээнтэн залрах болсонд их бэлэгшээсэн дээ. Хөх нуураас тодорсон Ажиа гэгээнтэн өөрийн туулсан амьдралыг өгүүлсэн “Цагийг бэлгэдэгч наран чөлөө” номын хуримдаа өөрөө залран ирж, бурхан шашныг дээдлэн хүндэлдэг жирийн иргэдээс эхлээд шашин төрийн төлөөлөл хүмүүс оролцож өргөн хүрээнд боллоо.

Гэгээнтэн “Урьд нь би “Интерном” номын их дэлгүүрт нэг удаа урилгаар ирж нээлтэнд оролцож байсан бол одоо өөрөө номын нээлтээ хийж байгаадаа баяртай байна. Миний энэхүү номын хоёр дахь хэвлэлтийг УИХ-ын гишүүн Ж. Батбаяривээн тэтгэж хэвлүүлэн олныхүртээл болголоо. Эхний удаа хэвлээд түмэн олондоо үнэгүй тараасан бол хоёр дахь удаагаа хэвлүүлсэн номоо зарж борлуулан олсон орлогыг нь монголдоо хүүхдийн хавдарын эмнэлэг байгуулах буяны үйлсэд зориулах болно.



Англи хэлээр бас хэвлэгдсэн. Монгол хүн бүхэн монголоороо ярьж бодож сэтгэж, баян ядуугийн ялгаа багач болов арилж, боловсрол мэдлэгээ дээшлүүлэхэд дор бүрээанхаарч, эрүүл энх сайхан амьдраасай гэж залбирч явдаг. Энэ ном бол дан ганц миний амьдралын түүх бус. Монголын түүхийн нэгээхэн хэсгийг өгүүлж байгаа. Залуучууд та нарминь сонирхон уншаарай” гэж инээмсэглэн өгүүлсэн юм. “Эрэлчид дөрөө мулталхад аав угтан гарч, хүндэтгэлийндээдээр зочдоо гэртээ залахад, аяллынхаа тухай амнээсэнгүй. Ээж хуврагуудыг тавгийн идээ, сүүтэй цайгаар дайлахдаа балмагдан сандарчээ. (Тусгайлан бэлтгэсэн идээ будаа нь далд байв)”. Нутаг ус, амар мэндээ мэдэлцэн, холойрыг ярих урт ярианы төгсгөлд настай хувраг босч, энхмэндийн цагаан хадаг дэлгэн аав ээжийн хүзүүнд тохож, “Түвэдийн Бурхан шашны Гэлүгба уламжлалыг үндэслэгч Богд Зонховын аавын VIII дүрийг төрүүлээ” гээд баярхүргэжээ...”

Ажиа гэгээнтэн энэ номондоо ийнхүү Гэгээнтнээртодорсон үеэсээ эхлээд Төвдөд өнгөрөөсөн амьдралынхаа баяр баясгалан хийгээд айдас хүйдэс, өлсгөлөнг хэрхэн гэтэлсэн, шашин номын бүхий л зэрэг зиндааг дамжсаарсүүлийн Банчин Богдын ойр дэргэд алба эрхэлсэн болон Хятадын удирдлага дорх төвд түмнийхээ тусын тулд улстөрийн аюул заналтай хэрхэн тулгарч зохицуулж явсан тухайгаа чин үнэнээр өгүүлснийг номын үг үсэг болгоноос мэдэрч чадах юмаа.

ᠠᠵᠢᠶ᠋ᠢ ᠷᠢᠨᠫᠤᠴᠢ
ᠠᠵᠢᠶ᠋ᠢ ᠷᠢᠨᠫᠤᠴᠢ
ᠠᠵᠢᠶ᠋ᠢ ᠷᠢᠨᠫᠤᠴᠢ
ᠠᠵᠢᠶ᠋ᠢ ᠷᠢᠨᠫᠤᠴᠢ

阿嘉·洛桑图旦。

Ajia Rinpoche

10.5.2010

Ажиа гэгээнтэний дурсгалын гар бичмэл

Миний багш, хэл бичгийн ухааны доктор Ц.Базаррагчааэнэ номыг хичээнгүйлэн уншиж, балын харандаагаартодруулан доогуур нь зурж хэд дахин уншиж тунгаан бодож,уулзах бүртээ надад:

- Чи хятад хэл сурч байгаа хүн энэ номыг маш сайнунших ёстой. Их л тогтож унших хэрэгтэй шүү гэж дахиндахин захиж харандаагаар зурж уншсан номоо надад өгсөн юм. Ажиа Гэгээнтэн “Үүлээр тойрон хүрээлэгдсэн арвантавны саран дээр зогсох эвг дөрвөн амьтны зураг зурж үүлнь бидний газар дэлхийг тэтгэж байдаг хур бороог, арвантавны сар нь нинжин сэтгэл, эрүүл энх, хүсэл мөрөөдлийнбиелэлийг, эвг дөрвөн амьтан нь эв найрамдал, амьдралынсайн сайхныг тус тус бэлгэдэж байгаа юм. Энэхүү зургаа би Монголын ард түмэнд туслах хүсэл эрмэлзлийнхээ бэлгэтэмдэг болгон сонгосон. Эвг дөрвөн амьтнаар бэлгэдсэнэнэ гурван үйлсийг минь та бүхний сэтгэлийн дэм,буяны хандив наран мэт тэтгэн гийгүүлж, саран мэт заангэрэлтүүлж, рашаан мэт тэжээн умдаалахын хүсэл эгээрлийгэвийн хадгаар түшин дэвшүүлэе” гэсэн ерөөл тавьсан юмаа.Одоо миний, таны ширээний ном болсон энэхүү номтанд маш содон түүхийг өгүүлнээ.

“Номын түлхүүр” сэтгүүл 2010.10 сар

Хонины шар хэвтлэгэн дээр төрсөн Сэхээтэн монголд надаар шувтарч Байгаа байх даа

МУСГЗ. нэрт дуун хөрвүүлэгч, сэтгүүлч Г.Аким



Жавар аялсан өвлийн адаг сарын арван дөрөвний өдөр. Үндэсний төв номын сангийн үүдэнд очлоо. Цагийн зүүарван зургааг заана. Нутгийн их бичгийн хүмүүнтэй уулзаж ярилцахаар “болзсон” цаг маань энэ буюу. Номын сангийн өмнө Билгүүн номч Бямбын Ринченгуайн хөшөөг барьж босгосноос хойш хүрээ орж амжаагүй явсан миний хувьд хөшөөний өмнө хэсэг зогсож байгаад дотогш орлоо. Их сургуулийн оюутны ширээгээ орхисноос хойш ховорхон зүглэсэн энэ их орд өргөөний өнгө төрх үүдхалганаасаа л дотно санагдлаа. Ийм том өв соёлын орд өргөөг Дорнод нутгийн уугуул их бичгийн хүмүүн удирдаж байгаа гээд багагүй нутгархах хүсэл төрсөн ч ёстой л энэхүний хийх ажил даа гэж бодогдлоо. Дэлхийд цорын ганц номын хөшөө гэгддэг Монгол Данжуурын гэрэлт хөшөө Үндэсний номын санд хадгалагдан байдгийг бид мэднэ. Хөшөөг сэргээн засварлаж, шилэнхоргонд гэрэлтүүлэн залсан ёслол өнгөрсөн онд болсныг нутгаасаа хол интернетийн мэдээнээс л олж мэдээд сүсэглэж суусны учир сая л бодотоор нь олж үзэв. Монгол түмэн маань ном соёлын далай баян санхөмрөгтэй. Хэдэн арван оюу толгой, алт эрдэнэсээр сольшгүй өвгөд дээдсийн маань өв соёл сан хөмрөг болном, номын сан юм даа. Аргагүй оюуны сүн далай гэж хэлж болно. Энд үзэж харах, гайхаж бишрэх юм бишгүй олон ч товлосон цагаасаа хоцорч болохгүй гэсэн захиасыг санаж яаравчлан шатаар дээш өгслөө. Г.Аким гуай хэзээнээсээ л хээгүй сайхан энгийн хүмүүн. Тас тас хийсэн дотно инээдээрээ биднийг угтаж, тал нутгийн сонин сайхныг асуух зуураа Матад Хан уулынхаа манан хөх оргил шиг буурал тэргүүнээ байн байн илбэж, чихэр амттанаар дайлан, шинэ номоо дэлгэн үзүүлж, “Гавьяатын найраасаа хойш ч гавьтай юмгүй шив дээ” гэж ганц хоёр хошин үг ярьсан юм. Түүнтэй уулзах, харилцах, ярилцах болгонд бичиж туурвисан бүтээснээ л ярьж байдаг эгэлгүй нэгэн билээ. Өнгөрсөн оны босгон дээр Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн хэмээх эрхэм хүндтэй шагналаар энгэрээ мялаагаад байсан Дорнод нутгийн уугуул нэрт сэтгүүлч, орчуулагч, Үндэсний төв номын сангийн захирал, Хатагиновогт Готовын Акимтай уран бүтээлийн нь талаар хийсэн ярилцлагаа та бүхэндээ хүргэе.

- Таныг төрийн дээд шагнал хүртсэнд тань баяр хүргэе!

- Төр засаг маань хийсэн бүтээсэн, хийх гэж оролдож байсныг минь үнэлсэнд баяртай байна. Матад хануулынхаа нөмөр түшиг, Хэрлэн их мөрнийхөө хүчинд тэнд суугаа ард түмнийхээ сэтгэлийн их эрчим хүчээр энэ шагналыг авсан гэж бодож байгаа.

- Зохиолч орчуулагч хүмүүст уран бүтээлийн дуртай сэдэвгэж байдаг. Таны хувьд?

- Би уянгын зохиол орчуулах дуртай. Хүн уянгагүй болволалдаг, талдаг, хараадаг, зүхдэг болно. Монголчуудуянгалаг сэтгэлгээтэй улс. Бүгдээрээ шахам шүлэг хэлж,зүйр цэцэн үгээр ярьдаг. Энэнд нь би туслах юмсан гэжмөрөөдсөөр ирлээ. Тиймээс би та нарын унших дуртай“Аранзал дарвуулт хөлөг”-өөс эхлээд хэдэн арван номорчуулсан юмаа.

- Та дэлхийн сонгодог зохиолуудын сор дээж, олон хүнийширээний ном болсон “Зуун жилийн ганцаардал”,“Цаазын тавцан”-г яагаад сонгож орчуулах болсон бэ?

- Би ямар ч орчуулгаа хэний ч захиалга даалгавраар хийжбайгаагүй юм. Өөрийн хийдэг орчуулдаг өнгө аясадтаарсан тийм бүтээлийг сонгон орчуулах гэж оролддог.Энэ хоёр зохиол бол миний үзэл бодолд нийцсэнсэтгэлд таарсан тийм зохиол байсан. Уран зохиолынорчуулгыг ч гэсэн онгодоор хийдэг юм шүү дээ. Энэхоёр зохиолыг уншаад энэ зохиолыг би л орчуулвалтаарах юм шиг, дийлэх юм шиг итгэл зориг төрөөд уранбүтээлийн чөлөө аваад Сэлбийн амралтанд суугаадорчуулсан. “Зуун жилийн ганцаардал” аа эхэлсэн байсанучир тэндээ дуусгаад, ахиад арван тав хоногийн чөлөөавч “Сонгино” амралтанд очиж, “Цаазын тавцан”-гааорчуулсан. Бараг зэрэг дуусгасан. Олны унших дуртайорчуулга болсонд баяртай байдаг юм. Миний бодсонбас талаар өнгөрсөнгүй гэж боддог шүү (инээв).

- Орчуулагдаад удаж байгаа байх шүү. Хэдэн онтой золгожбайна даа?

- 1989 онд юм даа. Сэлбэд суух гээд явах гэж байтал нэгорчуулагч бүсгүй утасдаж, “Цаана чинь төр эргэх гэжбайна”, “Залуучууд” зочид буудлын дугуй танхимдзалуучууд цуглачихсан, тантай уулзъя гээд байна,та яваад ир” гэж байна. “Хотоос ирсэн гэдэг чиньхоргойноос илүү сонин байна” гэдэг шиг “Төр эргэнэ”гэдэг жигтэй сонин санагдаад, тавьж хүрсэн дээ.Ц.Элбэгдорж, Дарь. Сүхбаатар гээд залуучууд “Моринтөвөргөөн”-өө эхлүүлсэн нь тэр л дээ. Би бас түүндээр хэдэн үг хэлж залуучуудаа зоригжуулаад, машинирсэн учир Сэлбэ руу явсансан. Намайг Сэлбэд номоорчуулж суух завсарт л “хэрэг мандсан” даа.

- Таны хамгийн сэтгэлд хүрсэн орчуулгын бүтээл таньямар бүтээл вэ?

- Хорь шахам бүтээл орчуулсан. Манай нутгийн эрдэмтэнГ.Амар гуай намайг анх орчуулагчийн замд хөтөлжоруулсан. Арай гайгүй нь Оросын зохиолч А.Гриний“Аранзал дарвуулт хөлөг” гэдэг гуравхан хэвлэлийнхуудас жижиг тууж болов уу. Залуучуудын хайрдурлалын тухай, уянгын романтик, тансаг найруулгатайном л доо. Гурван жил нухсан. Орчуулга урт богинодообиш. Энийгээ би уран зохиол болж чадсан гэж боддогюмаа. Мундаг гэж хэлэхгүй ч арай дөмөг болж чадсангэж бодож явдаг юмаа.

- Орчуулга гэдэг мэдээж хэлний маш өндөр чадвар, мэдлэгшаарддаг. Б.Ринчен гуай нэг удаа “Хүмүүс надаас яавалгадаад хэлийг хурдан сурах вэ? гэж асуух юм. Тиймамархан элэглүүлээд сурчихдаг хэл гэж байхгүй шүү дээ”гэж хариулсан байдаг. Та энэ асуултанд ямар хариубарих вэ?

- Ри багшийн өгүүлдэг туйлын үнэн юм. Ер нь ямар чюмыг оролдвол хурдан сурна. Өөр ямар ч арга аврал идшид гэж байхгүй. Оролдоод, зүтгээд, хөдөлмөрлөснийхүчинд л сая чадна даа.

- Та сүүлийн үед бурхан шашны тухай орчуулгыг нэлээдтүлхүү бүтээж байна. Бурхан шашны англи, монгол, толь бичиг бусад олон бүтээлүүдийг тань нэрлэж болох юм.

- Миний ганц бодож, хэлж хашгирч явдаг зүйл бол Монголыг оюун ухаан л хөгжүүлнэ гэж хэлдэг. Бид булчинг шүтээд яах юм бэ. Хүнээр аваад үзэхэд толгой нь л байвал бусад нь өрөөл татуу ч байсан нэг яваад л байдаг шүү дээ. Нийгэм бас адилхан юм. Нийгмээр авч үзвэл сэхээтэн гэж нэг ад үзэгдсэн амьтад бол энэ нийгмийн толгой юм. Миний үеийн марксист үзлээр бол сэхээтэн нь давхарга, ажилчин малчин боланги. Эдний хүчинд л нийгэм хөгжинө гэж байсан.

Тэр үеийнхээр толгойг нь тасалчихаад хөл гарыг нь хөгжүүлэх гээд байсан байхгүй юу. Энэ бол манай Монголын хөгжилд их сөргөөр нөлөөлсөн юм. Би бол толгойг нь үлдээгээд л гар хөлийг нь тастчихаа гэж бодож байгаа юм (инээв)

- Оюунлаг хүмүүс хөгжлийн гол тулгуур гэдэгтэй та санал нийлэх үү?

Тэгэлгүй яахав. Одоо морь уралдуулах, барилдуулах, дуу дуулах зэрэг нь улс Монголоо мөхөөхийн цондон. Энэ олон утгагүй баяр, хурал чуулган. Бид оюун руу хошуурах цаг болчихжээ. Мэдлэг хүмүүжил хоёр хослон байж, Монголын өнөөгийн залуу үеийг хүмүүншүүлнэ. Дэлхийн түвшингээс давсан мэдлэгтэй байх учиртай. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг 12 жил болгоод 10 жил байснаасаа илүү хүмүүжил мэдлэг олгож чадаж байна уу? Зүгээр л дэлхийн жишиг гээд хугацааг нь сунгаж байна уу гэдгээс эхлээд сэтгэлээсээ хандах зүйл зөндөө байна. Үндэснийхээ бичиг үсэг сурах соёл, үндэсний үзэлтэй болгох, би монгол хүн шүү гэж үнэн голоосоо хичээнгүйлдэг болгох хүмүүжил мэдлэгийг мах цусанд нь шингээж өгөх юмсан. Оюуны царааг нь лтэлж өгөх хэрэгтэй.

- Тодруулвал?

Маш тодорхой шүү дээ. Оюунд нь л сайн юм хийж өгвөл гар хөл нь сайн хөдөлнө биз дээ. Минийхээр толгойг нь хөгжүүлж байгаад л гар хөлийг нь хөдөлгөх гээд байгаа юм. Би оюунд нь юм хийж өгөх гээд л орчуулдаг туурвидаг. Бид чинь түүхээ нэг хэсэг их гуйвуулсан. Хэлмэгдлийн түүх бол шал худлаа бичигддэг. Үүнийг зөв болгож оюунд нь хийж өгөөд ийм юм болж байсан. Энийг дахин бүү давтаасай гэж хэлж өгөх гэсэн оролдлого л доо. Манай бурхан шашны ном зохиол маш хийсвэр онолын зүйл. Аливаа ухаан гэдэг практикаас хийсвэр уруу, тэгээд хийсвэрлэснээс практик уруу гэсэн зарчимтай. Бид хийсвэрлэхүй уруу явъя. Үүнийг би уншигчиддаа бага ч болов хүргэж өгье гэж бодож байна. Бурхан багшийн хоосон чанарын сургаал бол агуу юмшүү дээ.

- Го. Аким гуайн ширээний ном ер нь ямар ном юм бол?

- Манайхан ширээний ном гэж хэлж дасчээ. Оросоос орчуулсан үг л дээ. Гэхдээ үүнд муу юм юу байхав. Ширээний номны сэдэв насны байдлаас өөрчлөгдөж болно. Залуу байхад адал явдал, зориг, баатарлаг, хайрдурлалын ном сайхан санагдаж, байхад нас жааханахихад нэлээн буурьтай, хүний ухаанд ухаан нэмэрлэх, гүн эргэцүүлэл бүхий ном тэдгээрийн байрыг эзлэх жишээтэй. Гэвч хэзээ ч ширээнээс буудаггүй ном гэж байдаг. Миний хувьд бол "Монголын нууц товчоон". Хичнээн уншсанаа ч санахгүй байна. Хүүхэд байхад Чингисийнхээ

мундгийг гайхаж, залуу байхад гавьяагнь бахдан, 40-өөд наснаас учирьг нь олж, утгыг ньгунгаах гэж уншдаг болсон. Одоо ч би уншсаар л байна. Хамгийн гайхамшигтай нь унших бүртээ “Нууцтовчоон”-оосоо шинийг нээдэг юм даа. Иймд хэзээ чуншиж барагдахгүй ном юм.

- Таны бичсэн “Тэнгэрийн нохой” гэж сонирхолтой номгараад л үзэгдэхээ больсон. Өвөрмонголд хүртэл хэдэнмянган хувь зөвшөөрөлгүй хэвлүүлээд олдохгүй байсан. Энэномынхоо тухай товч өгүүлэхгүй юу?

- Чонын тухай ном л доо. Сайхан амьтан шүү. Байгалийгшүтэх үзлийг арай өөрөөр илэрхийлэх гэж оролдсон. Монгол оронд маань одоо ухагдаагүй, сэглэгдээгүй газар нутаг гэж байхгүй болжээ. Байгаль байгальтайгаа хамт байж л хүн байгалиасаа эрчим хүч авч бид оршино. Байгалиа хамгаалах, амьтнаа хамгаалах, нутгаа хамгаалах тухай үзгээрээ л үзэлцэх юм даа. 2002 онд ид сайханнамрын цагаар би Японы нэг эрдэмтэнтэй Дорнодаймгийнхаа Чойбалсан сум, Эрээнцав гээд нутгаа нэгбүтэн тойрсон юм. Ганц ч тарвага гозойж хошгирчбайгааг нь хараагүй. Монголынхоо нутгаар зун болгонаялдаг хууч домог сэлт цуглуулж, өвөл нь бичдэг иймхүн. Энэ жил 5000 гаруй км тойрлоо. Үнэхээр ганц анхарсангүй. Үлдэж байгаа нь муу нэртэй, луу данстай чоно. Алсан чоноо машиныхаа хоншоор дээр тавиадгудамжаар давхин гайхуулах болжээ. Гашуун үнэн ньэнэ. Энэ бүхнийг эсэргүүцэж экологийн асуудлыг урансайхны аргаар өгүүлэх гэж л оролдсон маягтай.



Эрдэмтэн Го.Аким гуай, Матад сумын Алтан-Очиртын хийдэд шавилан сууж байсан буурал Жүрмэд, нутгийн малчин

С.Балжинням, сурвалжлагч Б.Төгсжаргал нарын хамт.

Матад сум 2003 он

- Та шүлэг бичдэг үү?

- Хүн эхээс газарт л унадаг. Одоо ч яахав цагаан даавуундээр ойчдог байх л даа. Би бол хонины шар хэвглэгэндээр ойчсон. За ер нь тэгээд хонины шар хэвглэгэн дээр ойчсон сэхээтэн надаар шувгарч байгаа байх. Тэгээдингэж унасан болоод ч тэр юмуу тэрний доор намайгтосож авсан чулууд байгаа болоод ч тэр юмуу. Зун айлынхотонд бууж сууж явахад та нарын дуртай Францынүнэртэй уснаас илүүг мэдэрч баярладаг юм (инээв)Мундаг байтугай

муу яруу найрагч ч биш мөртлөөөрийн дотоод сэтгэлийн гүнээс эх нутгаа магтан дуулжявдаг даа. Дуулахаа ч алд даа. “Сэтгэлийн тахилгат уулбууу Хатагины арван гурван овоонд өргөсөн арвангурван чулуу” гэж Матад нутгийнхаа тухай бичсэнномыг маань сайн үзээрэй. Тэнд миний зохиосон шүлэгбий.

- Энэ номыг бичиж байх үед таны төрсөн нутаг Дорнодаймгийн Матад сумаар хамт явж их л олон зүйл мэдэжявсан даа. Очсон газар болгондоо хээрийн цэцэг, тахилгатуулын зургийг авч явдаг гэж хуучилж байсныг би санажбайна. Энэ тухайгаа ярихгүй юу?



Эрдэмтэн Го.Аким Дорнод аймаг Матад сум,

төрсөн газар “Тэмээт” 2003 он

- Оросын их яруу найрагч “Эх орон юунаас эхэлдэг вэ” гэж шүлэглэснийг манайхан “Эх орон юунаас эхэлдэгвэ” гээд л өнгө өнгөөр ярих нэг сэдвээ болгосон. Энэ бол хийсвэр ойлголт. Газар шороо, хөх тэнгэрард түмэн, одоо Чингис хаан гээд л бүх юм магтана. Минийхээр эх орон юмнаас эхэлдэггүй юм. Эхлэлбайвал төгсгөл байгаа. Эхлэл төгсгөлгүй юм гэж ерөөсөөбайдаггүй. Эхлэл төгсгөлгүй юм гэж байдаг бол тэр эхорон. Эх орон ард түмний сэтгэл зүрхэнд мөнх байдагтийм л ойлголт. Харин эх нутаг юунаас эхэлдэг вэ? гэжасуувал өөр. Гэтэл энийг манайхан хольж хутгаад байдагюм. Эх нутаг юунаас эхэлдэг вэ? гэвэл тэр тахилгатайуулнаас эхэлдэгээ гэж эргэлзэлгүй хэлнэ.

- Яагаад...

- Учир нь нутгийн ард түмэн хамгийн өндөр уулаа биш хамгийн өвөрмөц уулаа шүтдэг. Тахилгатай уул бол тэр нутгийн эрчим хүчний төв байдаг. Үүнийг Монголчууд эртнээс мэдэж авсан. Бурхан халдун уул бол Монголын эрчим хүчний төв. Яагаад Чингис хаан Бурхан Халдун дээр гарч аян дайнд гарахын өмнө хар тугаа тахиж бясалгал үйлддэг байсан бэ гэхээр тэндээс эрчим хүч авдаг. Тэндээс мөнх тэнгэртэй харьцдаг. Мөнх тэнгэр дээд огторгуйгаас ирж байгаа эрчим хүч газраас өөдөө гарч ирж байгаа эрчим хүч хоёр бол тэр уулын орой цэг дээр уулздаг. Тэрнээс хүн эрчим хүчээ олж авдаг. Орчин үеийн үг хэллэгээр бол цэнэглэгддэг. Чингис хаан аугаа их зөн совин билэгтэй, мэдрэх чадвартай хүн байсан учраас Мөнхтэнгэр, Этүгэн эхийг шүтдэг байсан. Тэгвэл Хатагинчууд Зотол хан, Матад хан, Дархан хан уулаа шүтдэг. Энэ гурав бол Хатагинчуудын эрчим хүчний төв болно. Тийм учраас шүтэж байгаа. Тэгээд би Монголын тахилгатай уулан дээр гарч мөргөөд эрчим хүч авах гээд байгаа юм шүү дээ. Би эрчим хүчээр ядуу юм болохоор (инээв). Гол нь уулсыг маань ухаж байна, сэндийлж

байна. Хэдэн жилийн дараа гэхэд уулгүй болох нь байна. Тийм учраас би Монголын тахилгат уулуудын зургийг авдаг, ном бичих бодолтой. Тэгэхдээ би чинь хүний юмаар хүүдэгнэх дургүй их зовлонтой амьтан. Өөрөө хийнэ. Өөрөө бичнэ. Хүний авсан зураг тавихгүй. Өөрөө харсан юм гэдэг бол бичихэд заавал нөлөөлдөг. Тийм учраас л өөрөө бүх зургийг нь авдаг.

-Тэгвэл цэцэгний тухайд...

-Цэцэгний өнгө, ялгарч байгаа үнэр хүн төрөлхтөнийг үеийн үед баясгаж ирсэн. Хүнд онгод урам хайрлаж ирсэн бодос. Бүсгүйчүүдийг заавал цэцэгтэй зүйрлэдэг нь яруу найрагчдын уянгын халил төдий зүйл биш. Цэцгэнд дургүй хүн гэж үгүй. Би нүдээр үзсэн ганган цэцэгсийг дуран авайдаа буулгаж цуглуулдаг.

-Цуглуулгынхаа талаар бидэнд сонирхуулаач. Таны гэрийг байгалийн музей, түүхийн музей, уран зургийн галерей гэж хэлж болохоор гайхамшигтай цуглуулгатай гэж сонссон.

-Хамгийн гол нь саваагүй амьтан л байхгүй юу даа. Нэг их гүнзгий мэддэг юм байхгүй (инээв) Юм юм сонирхоод л явдаг. Модны үндэс цуглуулдаг. Багадаа би их зураг зурдаг байсан. Миний багш Урлагийн гавьяат зүтгэлтэн зураач Ч.Батмөнх гуай намайг сайн зураач болно гэж итгэсэн байхаа. Пионер сурагчдын уран зургийн улсын уралдаанд хоёрдугаар байр эзлэж, их данхалзаж явлаа. Ингээд шугам зургийн ангид хуваарь аваад ирсэн чинь дээд тоо үздэггэхээр нь нөгөө тооны хичээлд голдуу бусдаасаа будаа идэж төгссөн хүн чинь ер нь хагас жилээр хөөгдөхийн нэмэр гээд орос хэл утга зохиолын ангид элсэн орж төгссөн. Тэгээд би зургаа хаясан ч гэсэн байгаль хамаагүй урныг мэдэрсэн гэхүү, янз бүрийн дүрстэй модны үндэс цуглуулдаг болсон. Зураач болоогүйгээ нөхөж байгаа юмуу даа. Чингисийг би орой дээрээ шүтдэг. Чингистэй холбоотой тэмдэг цуглуулаад зуу шахам юм бий. Үнэтэйг нь бас чадахгүй юм даа. Бас бяцхан ном цуглуулдаг. Гадныхан хөөрхөн ч хэвлэх юм даа. Харин онгироход, тахилгат уулын зургаараа бол нэлээд дээгүүр орно. Урлагийн гавьяат зүтгэлтэн зураач Г.Дунбүрээ олон Богдын зураг зурсан. Дараа нь би орох байх (инээв) Хааяа энэ цуглуулгуудаа харж баясаж суудаг юм.

-Та нэгүдээ хас тэмдгийг их эрхэмлэдэг болох тухай ярьж байсан. Таны одоо зүүж гоёж байгаа хас бөгж, бугуйвч зэргээс харахад ямар учиртай юм бол?

-Гоёл ч биш юмаа. Эрхэмлэнэ гэж хэлвэл арай дөхөж очно. Хас тэмдэг бол та бидний этүгэн эхийн тэмдэг. Зүүж явахад хүнд их ээлтэй. Чингис хаан баруун гартаа хастай, том алмаазтай, бөлзөг зүүж байсан юм билээ. Уг нь бол бөлзөг юм шүү дээ. Бөгж гээд байдаг чинь авдар савны энд тэнд төмрөөр товойлгож урласан зүйлийг хэлдэг юм. Тэр хүн ч яахав их хүн. Эрхэмлэх үзлээрээ ижил байгаагийн хувьд эгэл жирийн миний хувьд солгой гартаа жижиг хастай бөгж зүүж явдагаа. Дорно дахины их бэлгэдэл түмэн наст хээний нэг хэсэг нь юм. Хасаар бол хийсвэр бэлгэ тэмдгийн хувьд юуг ч тайлбарлаж болно. Арга бэлгэ гээд ч тайлбарлаж болно. Социализмын үед хасыг их муушааж бидний тоглоом хорол баясгалангийн хасаар тоглуулахгүй их хорьдог байсан. Монголынхоо болоод Дорно дахиныхаа энэ бэлгэ тэмдгийг шоовдорлож байсанд нь би бас эсэргүүцэж зүүдэг юм даа.

-Та Монголын орчуулагчдын холбооны ерөнхийлөгч. Залуу орчуулагчидад хандаж юу хэлэхсэн бол?

-Зөвхөн гадаад хэлийг мэдсэнээр зогсохгүй эх хэлээ маш сайн мэдэх ёстойгэдгийг байнга санах ёстой. Бүдүүн өвс багтахгүй найруулга гэж байдаг. Тиймээс дунд сургуулийн монгол хэлний боловсролоороо орчуулга хийнэ гэвэл бүтэхгүй л дээ. Ер нь орчуулагч гэхгүй манай дээд сургуулиудад эх хэлний найруулга зүйн хичээл ордоггүйгээс дунд сургуулийн найруулга зүйн боловсролоороо алба амины бичиг хэргийн ажилд зүтгэх нь их учир дутагдалтай. Бичгийн хэлний найруулга бүр алдагдлаа. Хуучин Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн гээд үг найруулгыг засдаг, зад шүүмжилдэг хүмүүс бүхэл бүтэн нийгмийг авч явж байсан шүү дээ. Одоо цагийн тухай олон юм ярих болно. Ингээд зогсооё.

-Ярилцлагынхаа төгсгөлд миний асуугаагүй таны яримаар...

-Баргийг нь асуучихлаа шүү дээ. Сэтгүүлчид гэж орсон гарсан газар болгоноосоо учир жанцангийн олз хайж явдаг тийм хүмүүс. “Хурдан буунаас хурц үзэг хол тусна” гэсэн үг байдаг. Дорнод сонины хамт олны “Үзэг нь хурц байгаасай” гэж ерөөе. Гавьяа шагнал авлаа гэж өчүүхэн намайг мандуулаад л УИХ гишүүн Д.Одбаяр, нутгийн зөвлөл зон олон маань надад мэндчилгээ хүргэсэн. Засаг дарга Ц.Жанлав мэнд дамжуулан өргөмжлөл хишгээ хүртээсэн. Хамгийн түрүүнд дурьдсан Хэрлэн их мөрөн, Матад Хан уулынхаа нөмөрт Дорнодчууд маань ирэх ондоо төдийгүй ирээдүй, хойч, үеийн үедээ өөдрөг хэвээр байг гэж ерөөе. Цэндийн Дамдинсүрэн, Дондогийн Цэвэгмид, Данзангийн Нямсүрэн гээд Монголын утга зохиолын суут хүмүүсийн өлгий нутагт маань Зохиолчдын нэгдлийн 70 жилийн ой болох гэж байна. Молхи бичээч ахыгаа урина гэсэн. Тэнд бүгдээрээ уулзацгаая. Ном, ном, ном. Номын буян хишиг дэлгэрэх болтугай.

Танд уран бүтээлийн амжилт хүсье.

2007.02.20. “Дорнод” сонин № 6

Олонтой явсан аавын хүү



МЗЭ-ийн шагналт, “Морин хуур”-наадмын эзэн, сэтгүүлч, яруу найрагч С.Амартайван

Амьдрал хэмээх уртаас урт галт тэргэнд суугаад аялж явахад уран бүтээлийн, ус нутгийн, ажил албаны олон хүмүүстэй уулзаж тэднийхээ авьяас билгийг шүтэн биширч, үг яриаг нь бодол оюундаа тунгаан бясалгаж явдагаа. Хүн бүхэн давтагдашгүй содон ертөнц, нэгэн хөлгөн судар болох тухай бид их л уншсан даа.

Энэ олон хүмүүсээс Айлтгүйн Төмөр очир, Сумьяагийн Амартайван хэмээх уран бүтээлч хоёр ахынхаа хосгүй авьяас, их онгод хийморь, аав шиг түшиг нөмөр нөөлөгт нь багтаж хайрлаж, хайрлуулж олон оныгүджээ. Хөдөө нутаг, хүрээ хот, алс буйд хил хязгаар олон газар хоёр ахтайгаа хамт уран бүтээлийн уулзалт цэнгүүн, уралдаан наадамд дөрөө харшуулан давхиж, оюун санааны ертөнцөд сор болсон сайхан хүмүүстэй уулзаж, танилцаж “өөр өөрийнхөө өнгөөр эгшиглэх” эгнэшгүй их авьяасыг нь магтан биширч явдаг юм.

Ямар ч утга уулгагүй зүгээр жирийн нэг яриа хөөрөө гэж тэдэнд огт үгүй. Зүггүй маазарсан хоосон яриа бол ер байхгүй. Зүйрлэн хэлэх, хайрлан дуулах, гуниглан гансрах, баярлан хөөрөх нь бусдаас ангид энэ хоёр ахынхаа тухай би олон дурсамжийг өгүүлж чадна.

Тэр дундаа “Олонтой явсан аав”-ын түмэнтэй хүү сэтгүүлч, яруу найрагч Сумьяагийн Амартайван ахыгуясан хүлэг, унасан морьд, сурсан эрдэм, тэрлэсэн шүлэг, аялсан дуугаар нь монголын уншигчид андахгүй сайн таних билээ. Хуучнаар ЗХУ-ын Фрунзе хотын цэргийн нисэх хүчний нэгдсэн сургуулийг төгссөн хөвгүүн ирээдүйд Монголын яруу найргийн ертөнцөд өөрийн гэсэн алдар гавьяатай, манлай хурдан хүлгүүдээрээ Монгол түмнээ баясгасан нэгэн болох тухай төсөөлөөгүй нь лавгай. Эр хүний дотор эмээлтэй хазаартай морь багтдаг хойно доо. С.Амартайван найрагч төмөр хүлэг эзэгнэн тэнгэрийн уудамд дүүлэх мэргэжилээсээ “урвасан” ч уран бүтээлээрээ, унаган хүлгүүдээрээ жилээс жилд өндрөөс өндөрт дүүлэн нисэж явдаг хийморь лундаа авьяас билиг нь цогцолсон монгол эр хүн.

“...Түмэнд зартай

Үнэн домогтой

Чоно голын унага”

гэхээр манай нутгийнхан төдийгүй хурдан хүлэг морьтой, хийморьтой аавын хүүхдүүд бүгд л андахгүй сайн мэднэ. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум Чоно голын хөвөөнд төрж, Хатагины их тахилгат Зотол хан уулын бэлээр нутаглаж, “Луу жилийн намар, луу унжиж ижийгээ их л зовоож төрсөн чанга хүү”. Шүлэг бүхэн нь нутаг амьтай, хүлэг бүхэн нь хурдны шинжтэй энэ хүмүүний ажил алба нь ч аймаг орон нутгаа өөд татах, нутагусаа алдаршуулах гэгээн мөртэй.

Зуун төгрөгтэй явснаас, зуун найзтай яв гэсэн үг таньд хуучны юм шиг санагдаж мэднэ. Харин энэ үгний үнэ цэнэ улам гэрэлтэх өнөө цагүед арван зүгтээ анд нөхөдтэйгөөр нь бахархан, авьяас билэг, ажил үйлс бүхнээ хослуулан,

хурдан морьдынхоо тоосонд хийморио сэргээн, хуур цоорын аялгуут дуу шүлгээ түмэндээ өргөх С.Амартайван ахын тухай ихийг өгүүлж болно.



“Болор цом-2010” наадмын үеэр. Дархан хот

Тэнгэр уужрах тэгш тал минь Тэвэрч уужрах ижий тал минь Буман оныг элээх буурал тал минь Нар тоссон бор тал минь Надад үлгэр шивнэх Богд тал минь Дутуу юмгүй их тал минь Дуунд минь уярах эх тал минь Саран хээрлэх их тал минь Салаад би хаачих юм бэ Эх тал минь ...

гэж тэрээр монгол найрагчийн ур ухаан шингэсэн нутаг амьтай олон шүлэг бичсэнийг манай нутгийнхан эх дэлхийн хаана ч явсан бүтэн бадгаар нь бүрэн уншдаг нь сайхан санагддаг. Уран бүтээлчийн хувьд ингэж найраг шүлэг нь хүний сэтгэлд хүрэхээс илүү жаргал гэж байдаг гэжүү.

2005 он. Хайлаар хотын их сургуульд сурч байхад Сүхбаатар нутгийн маань хүмүүс очиж уулзаад, нутгийн сонин сайхныг дуулгаад л, сэтгэл баясан сууж байхад

Мандах наран зүгт нутаг минь байдаг Маргах юмгүй тэнд дулаахан байдаг Мал нь тогтуухан хүн нь аядуухан Мандах наран зүгт нутаг минь байдаг

гээд дуу нэгтэй уншиж, аялгуулан дуулахад сэтгэл хөдөлж, найрагч ахынхаа авьяас билэг, үгийн шидийгулам биширсэн юм. Энэ дууг одоо манай нутгийнхан ардын дуу шиг аялан дуулж, айлын гадаа буугаад мордоход арав хүрээгүй жаахан хүүхдээс азай буурал өвөө эмээ хүртэл уяран хайлдаг нь гайхамшиг гэж би зоригтой хэлнэ.



Сүхбаатар аймгийн “Морин хуур” наадмын тэргүүн байрын шагналтнууд. (Яруу найрагч Ай.Төмөр-Очир, С.Амартайван, Хөгжмийн зохиолч Б.Мөнхжаргал нар)

“Олонтой явсан аав”, “Ай Сэлэнгэ минь”, “Орчлонд ганцхан ээж минь”, “Чоно голын хилийн хороо”, “Аравгар хээр”, “Орлой хонгор” гээд ээж аав, элбэрэл хайр, нутаг уус, уул овоогоо магтан дуулсан олон сайхан дуу нь олны хүртээл болж, нутгийн уран бүтээлч ахаараа бахархах сэтгэл төрсөөр байдаг. Ардын жүжигчин А.Энхтайван аялгууг нь зохиож, МУСТА Б.Батболдын дуулснаар олны хүртээл болж, 2004 оны “Морин хуур” наадмын шагналыг хүртсэн “Олонтой явсан аав” дуу зөвхөн монголын ард түмэн биш

Монгол туургатны ач үрс, монгол хэлээр дуулдаг хүн бүхэн дуулж байна. Бахархан дуулж байна. Аавыгаа санан санан дуулж байна. Хайрлан хайрлан дуулж байна. Уран бүтээл гэж үүнийг л хэлнэ гэж би мөхөс оюундаа тунгаан боддог.

Манай нутгийн нэрт яруу найрагч, Соёлын гавьяат зүтгэлтэн Г.Мэнд-Ооёо ах “С.Амартайваны шүлгүүдэд тал нутгийн цээл алс, хүлэг морины төвөргөөн, ардын дууны задгай гэгэлгэн аялгуу, талын зэрэглээ, хөдөөгийн амгалан чийрэг эрсийн гүндүүгүй сэтгэл нэвт шингэсэн байдаг” гэж бахархан өгүүлсэн нь бий. Төрийн гурван удаагийн шагналт, Ардын уран зохиолч, академич Ц.Дамдинсүрэнгийн 100 жилийн ойд зориулсан яруу найргийн наадамд түрүүлж, Хатагины шаргал талынхаа уул ус, хүн зоныг баясган:

“Барагдахгүй энэ талыг туулна гэж Байдсан гүүний унага босоо төрдөг Харагдахгүй бүхний нууцад нэвтэрнэ гэж Хан эцгийн үрс билгийн мэлмийтэй төрдөгхэмээн шүлэглэсэн нь хүн бүхний бахархал болсон юм.

Ийнхүү яруу найрагчид уул ус ургамал ногоо, хүн зон, ан амьтан, жигүүртэн бүхнээ баясгаж үгийн шидээр хөглөн амьдрах хувь тохиол анги ондоо хүмүүс юмаа.

МУСГЗ Л.Одончимэд:

Эх орны зүүн хязгаар амар тайван Эх орны зүүн хязгаар амар тайван Их Егүзэрийн шүншигтэй Лхачинвандад ууламар тайван Ар Халхын мөнхийн харуул Шилийн Богдамар тайван Алтан-овоо Ганга нуур амар тайван. Зоо нь тэнүүн мал сүрэг, зээрийн хүрээамар тайван Хатагины хурд төрийн наадамд алтан жолоо өргүүлээд амар тайван

Харсан түмний сэтгэл түүнийг харж тэнийгээдамар тайван

Үүрээр адуундаа мордсон аавын сэтгэл амар тайван

Үдшээр сүүлдэж хажуулдсан ээжийн сэтгэламар тайван

Суугуул хуучид, үзэмчин, уугуул хатагин цөм бүгдамар тайван

Сумьяа гуайн том хүү шүлгээ бичээд бас Амартайван

гэж бичсэн нь найрагч ахыг маань хүндлэн дээдэлдэг, шүлэглэн хэлж, бахархан ярьдаг олон хүмүүсийн зөвхөн нэг нь юмаа.

2005 он. “Дорнын хүлэг” яруу найргийн наадам Сүхбаатар аймагт болж, Болор цомын эзэн яруу найрагч А.Эрдэнэ-Очир, Ц.Бавуудорж, Х.Чилаажав, хөгжмийн зохиолч Пүрэвхүү, Алтангэрэл нар манай нутагт очлоо. Баруун-Уртаас эхэлж, Эрдэнэцагаан суманд С.Амартайван ахын адуун сүрэгт гүү унагалахыг харж, Дарьганга суманд Алтан овоондоо мөргөж залбирч, Наран суманд Балбар ахыгаа нэг дурсаад, Г.Мэнд-Ооёо ахын нутаг Онгон суманд Дэлхийн яруу найрагчдын өдрийг тэмдэглэж сумын сургуулийн хүүхдүүдэд шүлэг найргаа уншсан өдрүүд санаанаас огт гардаггүй юм. Энэ өдрүүдэд С.Амартайван ах, Ай.Төмөр-Очир ах хоёр маань тэднийг “Та хоёр ер нь шууд зохиогоод байна уу, өмнө нь зохиосон шүлгээ уншаад байна уу” гэж дуу алдахад хүргэсэнд нь би бахархдаг юм. Эх хэлнийхээ яруу тансагийн гайхамшигийг гүзүүлж, төрж өссөн эх нутагтаа үзэг нэгт нөхөддөө ч хүртэл гайхагдаж хүндлэгдэж явна гэдэг бол юутай их аз жаргал билээ.

Уях хүлэгтэй, унших шүлэгтэй, дуулах дуутай, хөөрхөн хүүхдүүд, сайхан ханьтай, эрдэм билэгтэй уран бүтээлч ах маань аргагүй л дутуу юмгүй “Амартайван” аж төрж суугаа найрагч, уяач, аав, ах, анд нөхөр гэсэн эрхэм алдарт эзэн суусан энэ цагийн сайхан монгол эрсийн нэгэн билээ.

Онгод хийморь нь улам бадрах болтугай.

Б.Төгсжаргал. 2011 он.

Заяаны эмгэнийг зааж өгсөн багш минь



МУСГЗ, Хэл бичгийн ухааны доктор нэрт нанхиадч, Зохиолч яруу найрагч Ц.Базаррагчаа багшийнхаа хамт

Багштайгаа анх танилцсан минь

Анх цэцэрлэгийн жаахан хүүхэд байхаас эхлээд радиогийн сурвалжлагч болтлоо би хичнээн олон эрдэмтэн багш нараар хичээл заалгаж өдий зэрэгт хүрсэн хүн билээ дээ. Хүн бүрийн амьдралын хэмнэл ийн өнгөрдөг ч дурсамж бүхэн нь өөр өөр байдаг.

2006 онд болсон Дэлхийн яруу найрагчдын их хурлын үеэр би “Бүсгүй хүн шүлэг л байдаг” яруу найргийн номоо монгол, англи, хятад хэлээр хэвлүүлэх гээд багагүй ажил боллоо. Нэрт орчуулагч Го.Аким гуайн бичсэн өгсөн уялга үгийг хятад хэл руу орчуулах яггүй ажлыг хэнд ханддаг билээ дээ гэж бодлоо. Го.Аким гуай,

-Ц.Базаррагчаа гэж сайн багш, орчуулагч миний найз. Чи ер нь тэр хүн дээр намайг явуулсан гээд оч. Уулзсан

хэрэг юу билээ дээ. Багш шавь болбол бүр сайн. Чи сайн хятад хэлтэй хүн больё гэвэл тэр хүнд л шавь ор гээд намайг явууллаа. Тэр үед “Сургуулийн нар” гэдэг зохиолыг нь уншсан, хятад хэлний том эрдэмтэн орчуулагч гэдгээс өөр юу ч мэддэггүй байлаа.

“За ер нь тааруухан хэдэн шүлгийг минь тас шүүмжлэх байх даа. Аким ах явуулсан юм чинь очоод үзье” гээд 11-р хороололд байдаг гэрт нь очлоо. Багш өөрөө хаалгаа тайлж байна. Жаахан эмээж байсан ч учираа хэлээд хадгаа барьчихлаа. Нэг ч уулзаагүй, хичээл заалгаж байгаагүй байж тийм том хүнд хадаг бариад багш шавийн барилдлагатай больё гэж хэлэх надаас багагүй зориг шаардсан.

Ц.Базаррагчаа багш маань угийн шулуун шудрага зантай, даруу хүн болох талаар Хайлаар хотод хамт суралцаж байсан Ц.Мөнхцацрал багшаас сонсож байсан юм. Багш миний шүлгүүдийг үзэж надаас олон юм шалгаалгүй хэдэн өдрийн дараа ирээд аваарай гэхээс өөр үг хэлээгүй санагддаг. Энэ өдрөөс хойш надад зохиол бичих, хятад хэлнээс орчуулах адармаатай ажлынхаа туршлагаас харамгүй хэлж өгсөн дөө. Мөхөс би харин тусган авч, тунгаан хичээсэн нь дэндүү бага юм.

Миний бичсэн шүлэг, ярилцлага, нийтлэл, орчуулга багшид минь байнга гологддог ч тэр гологдлуудынхаа буянаар багштайгаа улам ойр дотно байж, өнөөдөр харахад багш шавийн барилдлага бат бөх болжээ. Удалгүй би багшийнхаа яг хажууханд хөлсний байранд амьдрах болсон нь надад улам их ойр дотно байж, сургаал зэмлэлийг нь сонсож суух хувь тохиосон юм. Дажгүй бичээд, орчуулчихсан байвал их л тоож баяр хөөртэй. Тааруухан байвал царай нь хүрлийгээд их л бухимдуу. Ээ балай, ээ балай, чи ийм ч юм хийх гэж дээ, үг нүдтэй, нүдийг нь олж тавихгүй бол олны элэг доог болно гээд чин сэтгэлээсээ харамсан халаглана. Бүр чин сэтгэлээсээ шүү.

-Тэгснээ гомдчих вий гэж бодсон уу, сайн бүтээл туурвил туурвисан хүмүүсийн зохиол бүтээлээс жишээлэн ярьж тайлбарлан хэлнэ. Албархсан юмуу аль эсвэл ихэмсэг бардам зан гаргах явдал багшид минь огт үгүй.

Багш маань ном зохиол уншихдаа хажуугийн зай, мөр хоорондын завсараар олзуурхсан хийгээд ой гутсан зүйлүүдээ зурж тэмдэглэж уншдаг заншилтай. Энэ нь хожим хойно үзэхэд уул номыг дахин уншсан мэт болдог гэж ярьдаг. Харин дандаа балын харандаагаар зурж, тэмдэглэдэг нь багшийн маань онцлог юм даа. Зарирмдаа би багшийн бичээч болно. Орчуулга, судлал шүүмжлэлийн хэд хэдэн бүтээлийг нь балын харандаагаар бичсэн гар бичмэлээс нь буулгасан юм. Хожим намайг “Монсудар” хэвлэлийн газар хятад хэлний редактор болоход ерөнхий редактор маань боллоо. Багштайгаа хамтран “Хятад монгол хэлц үгийн толь” гаргалаа. Толь бичгийн дардасны баруун, зүүн булан дээд доод талд олон засвар оруулж, монгол хэлээрээ оноож хэлэх ажлын дийлэнхийг нь багш хийсэн дээ. Дэндүү тааруухан хийсэн орчуулгууд дээр тархиндаа хадаастай хүн шиг орчуулжээ гээд хадаастай толгой зурж, оноод хэлчихсэн орчуулганд бол урмын зөөлөн үг бичиж чин сэтгэлээсээ засаж танаж, хянасан нь сайн толь бичиг болоход хамгийн том буян болсон юм. “Сүмбэр уул шиг хэрэг бүтээе гэвэл тэр нь гагцхүү толь бичиг зохиох билээ” гэж хятадын нэрт эрдэмтэн Лү Сү Шань хэлсэн байдаг. Миний багш энэ сайхан үйлсэд өөрийн сурсан эрдэм, цаг заваа харамгүй зориулсан хүн дээ.

70 насыг хэдийнээ давсан ч буурал багш минь жилийн дөрвөн улиралд бичиж, орчуулах, редакторлах ажилаа уйгагүй хийнэ. Аргагүй дээ. Бичгийн их хүмүүн Чой. Лувсанжав, Ш.Гаадамба нарын шавь болохын хувьд эрдэмт багш нарынхаа зааж сургасан бүхнийг үлгэрлэн дууриаж чадсан сайн шавь даа.

Ном унш, ном унш, ном унш. Монгол хэлээ сайжруул. Багш минь уулзах бүртээ л энэ хэдэн үгийгүргэлж хэлж захидаг билээ. Хэдийгээр би багшийнхаа санаанд хүртэл сайн хятад хэлний орчуулагч болоогүй ч болох боловуу гэсэн горьдлого тээж явна. Нэрт орчуулагч Д.Болдбаатар, М.Чимэдцэеэ, Я.Ганбаатар нарын олон сайн шавь төрүүлсэн багшид маань би ч өдий л байна даа.

Миний багш мундаг

Багш маань Архангай аймгийн Эрдэнэ мандал сумын хүн. 1957 оноос хойш өнөөдрийг хүртэл 60 шахам жил ажиллахдаа “Монцамэ” агентлагийн хятад хэлээр гардаг “Монголын мэдээ” сонинд орчуулагч редактор, МУИС-ийн хятад хэлний салбарт багш гэсэн хоёрхон газар л ажилласан байдаг. Хоёр газар ажиллаад, уран зохиол, орчуулга гэсэн хос морьтой

хорвоог туулсан тухай нь сонины хуудаснаас уншаад багшаараа улам бахархсан юм.



Залуу цагийн эрдэмтэн найзууд МУСГЗ, Хэл бичгийн ухааны доктор профессор, Зохиолч яруу найрагч Д.Цэдэвийн хамт

Эдүгээгээс бараг 3000-4000 жилийн тэртээх Хятадын хамгийн анхны бичигт буусан Ши Жин хэмээх 350 шүлэг бүхий “Шүлэглэлт ном”-ын 70-ыг нь багш орчуулсан байдаг. Эртнийх нь бичгээс шүү. Үнэхээр амаргүй. Монголд багшаас өөр хэн ч дахин орчуулаагүй л байна. Уран зохиолын “Цаст уулын цас”, “Тамирын чулуу”, “Сургуулийн нар”, “Галын илч”, “Цэцэгт нугын цэцэг”, “Унаган жороо”, “Зүүдний цэнхэр хөндий”, “Нохойн дуу”

зэрэг өгүүллэг, тууж, нийтлэл, шүлэг найраглал, роман бичсэн. Мөн “Хавирган сар” тууж өгүүллэг, “Гэрлийн дуун”, шүлэг найраглал”, “Буяны залбирал” хятадын эрт эдүгээгийн шүлэг зохиол, Тайваны монгол үндэстэн эмэгтэй зохиолч, зураач, уран нийтлэлч, яруу найрагч Ши.Мөрний “Цагаан хэрэмний чинад нутгийн дуу”, Вьетнамын их удирдагч Хо Ши Миний Хятадын шоронд байхдаа бичсэн шүлгүүд зэрэг олон арван орчуулгын бүтээл туурвисан билээ. ХХ зууны монгол зохиолчид цуврал номын “Цэдэвдоржийн Базаррагчаа” номд залуу судлаач Цэвээндорж багшийн бүтээлийн тухай маш тодорхой өгүүлсэн байдаг .

Багшийн маань “Монгол хятад хэлний орчуулга зүй” ном өнөөдөр хятад хэл сурч байгаа оюутан залуусын заавал үзэх гол ном болж байна. Багшийн зохиол бүтээлийг хүн бүхэн мэддэг болохоор би багшийнхаа дотоод ертөнцийн тухай товч өгүүлэхийг хичээлээ. Харин “Ц.Базаррагчаа судлал”-ыг хөгжүүлж болохоор бөгөөд эрдэмтэн багшийн маань судалгаа үгүйлэгдэж эхлээд байна. Энэ ажлыг эхлүүлэе гэсэн бодолтой л явна аа.

Миний багш ажилсаг

Би хэд хэдэн удаа би танайд очиж хоол иднэ гэж утас цохилоо. Багш маань сайхан гурилтай шөл хийгээд л тавьчихна. Заримдаа “Чи өөрөө ирээд хийгээд идвэл мах шөл бүх л юм байна” гэж хэлэх нь ч бий. Өглөөний цайгаа олон удаа багшийндаа уусан юм. Өөрийгөө их л эрт боссоноор тооцож найм болоогүй байхад ороход багш хэдийн босчихсон цайныхаа дээжийгөргөөд тагтан дээрээ зогсож байдагсан.

Би эрэгтэй хүн цайны дээж өргөж байхыг ингэж анх удаа харсан юм. Хөгшнөөсөө хойш үргэлж л бурхан тахилаа шүтэж, зул барьж, цайнхаа дээжийгөргөж байгаа багшийгаа харахаар сэтгэл их уярдаг юм даа.

Очихоор “За чих руу чулуудчихаар юу байна” гээд л надаас асуухад би уулзаагүй хэдэн өдрийнхөө сонин сайхныг ярина. Багш өөрөө ч үе тэнгийн нөхдийнхөө бүтээл туурвил, аж амьдрал аливаа бүхнийг надад ярьж өгнө. Ширээ дүүрэн бичиг цаас, зузаан зузаан толь бичигөрөөстэй байх. Том эрдэмтдийн амьдралын дадал юм даа. Тэдний амьдралд үзгээ барихгүй, номын хуудас нээж харахгүй өдөр гэж байваас цаг хугацаагугтаагүй өнгөрүүлсэнтэй адил санагддаг бизээ.

Удаан уулзахгүй удаж удаж очоод их л завгүй байсан тухайгаа ярихад минь, “Завгүй завгүй л гэх юм. Би орчуулга хийж, зохиол бичиж, хичээл зааж, үр хүүхдээ өсгөж, хүргэж өгч авч байсан. Тасганы овоо давж очоод хүүхдээ ээжид нь хөхүүлчихээд эргэж гэртээ хүргэж өгчихөөд ажилдаа явдаг байлаа. Энэ бүхэн завтай ажилуу? хэмээн зэмэлдэгсэн. Энэ нь намайг ойрхон ажилтай ганцхан хүүхэдтэй, байж ном зохиол, орчуулгын дорвитой юм хийсэнгүй гэж намайг өөрийн хүүхдээс өөрцгүй зэмлэж, ухааруулж байгаа хэрэг л дээ.

Номуунаа, Эгшиглэн гээд ач, зээ охидуудтай нь эгч дүүс шиг нөхөрлөж, хөвгүүдийг нь би өөрийнхөө ах нартай адилтган хүндэлж бид одоо нэг айлын хүмүүс шиг болж дээ. Том зээ охиныхоо хуриман дээр намайг хүүхдүүтэйгээ хамт нэг ширээнд суулгасан нь би хадаг барьж ирсэн хариугүй шүлэгтэй байсан үеэсээ хайртай охиноос нь дутахгүй шавь нь болсон юм байна гэж бодож билээ.

Шүлэг зохиох, орчуулга хийх, сурвалжлага авах, номын дэлгүүрт ажиллах гээд миний хийж байгаа ажил, хичээж байгаа оролдлого болгоныг минь багш маань сайшаадаг ч би одоохондоо багшдаа тоогдох бүтээл нэгийг ч туурвиагүй л явна.

Нэгүдээ “Заяаны эмгэн чинь чамайг номтой нөхөрлүүлж дээ. Аавынхаа ажил үйлсийгүргэлжлүүлж сайн монгол хэлтэй л байх хэрэгтэй дээ” гэж багшийн минь хэлсэн үг сэтгэлээс огт гардаггүй юм. Намайг энэ бүхнийг “Чи чадахгүй боль гэж хэлэхгүй байгааг бодоход багш маань надад найдаж л суугаа бололтой.

Өнөөдөр аав минь дэргэд үгүй ч аав шиг минь намайг хайрлаж, зааж сургаж, зэмлэж явдаг багштайгаараа бахархдаг юмаа. Заяаны эмгэн намайг багштай маань уулзуулсанд би энэ хувь хишигтээ залбирч явдаг даа

Б. Төгсжаргал 2012 он

Чулуу үл өгүүлэхийн тулд хүмүүнээ тааламжтай гэж үг байдаг



Нэрт уран бийрийн бичлэгч, зураач Д.Баттөмөр

Энгийн амьдрал, энгийн өдөр, энгийн араншин, энгийн байдал. Энэ мэт олон энгийн зүйлийн талаар зорьж очсон зураачтайгаа ярилаа. Харин түүний бүтээлээс би энгийн зүйлийг олж хараагүй. Нэрт уран бичлэгч, зураач Д.Баттөмөр ахын бүтээл бүхэн нь их урлагийн үнэ цэнийг мэдрүүлж, бүтээлийнхээ тухай ярих тусмаа урлагийн сайхныг биширч бахархаж, үргэлж бүтээж туурвиж яваагаа ярьсан юм. Бидэнд дуу хураагуур огт байгаагүй. Урлангийн нь ханаар дүүрэн уран бичлэгийн бүтээлүүд, энд тэндгүй ном, олон төрлийн бийр будаг, уран баримал хөшөөний эх загвар, судалбарууд гээд тоочоод байвал содон сонирхолтой зүйлүүд олон. “Чи асуултаа асууж л бай, ах нь бүтээлээ хийж л байя. Тун яаралтай, хариуцлагатай бүтээл дээр ажиллаж байна. Хариуцлагагүй бүтээл гэж ер нь үгүй. Чамд жишээн хариуцлагагүй ярилцлага байж болохгүй биз дээ” гээд завгүй ажлынхаа хажуугаар намайг огтхон ч төвөгшөөлгүй урлагийн тухай яриа өрнүүлснийг уншигч та бүхэндээ хүргэж байна.

Бийрийн уран бичлэг хэмээх энэ гайхамшигт урлаг дэлхий дахинаа хэрхэн дэлгэрсэн бэ?

Бийрийн бичлэг нь Азид дэлгэрсэн, төмөр үзгээр Европод ихэд дэлгэрсэн. Тэр дундаа Араб үсэг бол хамгийн их алдартай. Араб, Азийн улс орнууд уран бичлэгээрээ их гоёдог. Жинхэнэ урлагийн бүтээл болгож чадсан үнэхээр гайхалтай ард түмнүүд. Энэ нь өөрсдийн бичиг соёлоороо бахархаж, үр хойчдоо өвлүүлж чадаж байгаа сайхан хэрэг. Хот суурин даяараа хотын үзэмж, хаяг нэрээ бүгдийг нь уран бичлэгээрээ бичдэг. Сүмүүд нь хүртэл бурхны сургаалаа уран бичлэгээрээ бичсэн нь гайхамшигтай харагддаг. Уран бичлэг буюу каллиграф гэдэг үгний утга нь ч Эртний Грекийн гоё сайхан бичих гэсэн үг юм.

-Азийн орнуудад энэ урлаг илүү их хөгжсөн үү?

-Хүмүүс ханз үсэгтэй ард түмний л урлаг гэж ташаа ойлгодог нь уран бичлэгийн талаар анхны ойлголтгүй хүний л бодол. Дэлхий дээрх бичигүсэгтэй бүхий л улс орнуудын урлаг юм. Тиймээс би “Их урлаг” гэж хэлнэ. Герман, Итали, Франц, Англи, гээд бүх л орнуудад

очиход хамгийн түрүүнд уран бичлэг нь нүдэнд тусдаг. Яагаад гэвэл тухайн орны бичиг, соёл, эх хэл гэдэг юу юунаас чухал. Бичигүсэгтэй бүхий л улс орон өөрийн гэсэн уран бичлэгтэй байдаг.

-Манай улсад хэр зэрэг хөгжиж байна вэ?

-1990-ээд оноос монгол бичгээ суръя, бичье, төрийн бичиг болгоё гээд эхэлсэн. Зааж сургах, түгээн дэлгэрүүлэх ажил хийгдэж байгаа ч учир дутагдалтай л байна. Боловсролын хуульд өөрчлөлт оруулвал зүйтэй гэж боддог. Багш бэлтгэх сургуулийн оюутнуудад зааж, 3, 4,

5-р ангид зургийн хичээл дээр уран бичлэгийн урлагийн сайхныг багаасаа мэдэрдэг байх бодлого боловсруулан багш нарыг бэлтгэх, давтан сургах, үзүүлэнгүүд зохион байгуулах гээд орчин үеийн уран бичлэгчдийн холбоо төр засагтай олон талаар хамтран ажиллах бодолтой байгаа. Мэргэжлийн Дүрслэх урлагийн сургуулиудад уран бичлэгчдийн анги байхгүй гээд бодоход харамсмаар. Би нэг хэсэг Дүрслэх Урлагийн дээд сургуульд энэ хичээлийг заасан ч удалгүй болиулчихсан. Дэлхийн жишгээр монгол бичгээ урлаг талаас нь илүү мэдрүүлвэл улам хөгжинө, сурна гэж боддог.



- Уран бичлэгээр авьяастай хүн л бичих үү?

-Мэргэжлийн зураач хүн хийвэл илүү сайн. Гэхдээ зураач биш, сонирхолтой, авьяаслаг, сэтгэлтэй залуус бас их бичиж байна. Мэргэжлийн уран бүтээлчийн төвшинд хүрч байна. Мэргэжил, гарын ур, дээр нь авьяас чадвар гээд олон зүйл нөлөөлнө. Онцлог нь баллуурдаад юмуу, дээр нь засаж болдоггүй учраас их мэдрэмж шаардана. Тэгээд хамгийн гол нь зохиомж. Зохиомжгүй зүйл бол урлаг биш. Урлагийн хэмжээнд бичиж бүтээх нь хамгийн чухал шүү дээ. Энэ бол тухайн үеийн мэдрэмжээр нэг л удаа татдаг давтагдашгүй урлаг. Жишээ нь: Уул гэдэг үгийг мянган удаа бичихэд мянган өөр болдог. Зурах бол өөр л дөө. Техник их сайн байх ёстой.

-Орон орны уран бичлэг хоорондоо адил төстэй зүйл олон байдаг уу?

- Дэлхийн бүх түүх соёл, ёс заншил хоорондоо холбоотой байдаг. Заавал бие биенээсээ нэг юмыг нь авсан байдаг. Энэ нь уран бүтээлч хүний нүдээр харахад урлагийн бүтээлээр илүү илэрч гарч ирээд байгаа нь мэдрэгддэг. Жишээ нь: Дээр үеийн модон барын номнуудад эртний европ үсгийн элементүүд ихээхэн орсон байдаг. Томоохон ном судруудад ч их байдаг. Энэ мэт олон жишээг дурьдаж болно.

- Миний уншсанаар шүлэг яруу найраг, бурханы сургаал, мэргэдийн үгийг уран бичлэгээр бичих нь илүү байдаг уу?

- Яруу найрагуран зураг хоёр бол нэг юмны хоёр тал. “Уран зураг бол харах яруу найраг, яруу найраг бол сонсох уран зураг” гэж Леонарда Да Винчи хэлсэн байдаг. Уран бичлэгээр үлэмж их гоо сайхныг илэрхийлэхэд хараад л хүнд гоо сайхны таашаал төрүүлдэг. Цэцэггэдэг үг нь хүртэл цэцэг шиг харагддаг. Огт тайлбарлах хэрэггүй. Урлагийн мөн чанар нь ерөөсөө л энэ.

“Цэцэг хэрвээ дуун гарваас илүү үйл болоод

Чулуу үл өгүүлэхийн тулд хүмүүнээ тааламжтай”

гэж В.Инжинашийн үг байдаг. Сайхан байгалийн зургийг бид эхлээд ямар сайхан байгаль вэ гэж харж, мэдэрч дараа нь харин аль нутгийн уул ус болох талаар сонирхдог. Ардын зураач О.Цэвэгжав гуайн “Азарганы ноцолдоон” гэдэг зургийг хаанахын хэний азрага вэ гэж тэнэг л хүн асуух байх. Тэр зургийн сайхныг, хүнд өгч байгаа эрч хүч мэдрэмжийг л эрхэмлэдэг юм. Түүнтэй адил гоё сайхан бичсэн уран бичлэгийг хүн урлаг талаас нь эхэлж хараад дараа нь яг юу гэсэн үг болох тухай нь сонирхдог. Иймээс уран зураггэдэг маргахын аргагүй гайхамшигтай харах урлаг.

- 2006 онд манай улсад болсон Дэлхийн яруу найрагчдын их хурлын үеэр уран бичлэгийн үзэсгэлэн гарсан. Таны бүтээлүүд орон орны яруу найрагчдын анхаарлыг их татаж байсан.

- Би өөрөө шүлэг яруу найргийгуран бичихийг илүүд үздэг. Ноён хутагт Данзанравжаа, В.Инжинаш, Дорнын их яруу найрагч Б.Явуухулан, нэрт дуун хөрвүүлэгч М.Шагдарсүрэн гуайн орчуулгаар Омар Хайямын шүлгүүд, Г.Мэнд-Ооёо гуай, Д.Нямсүрэн гээд яруу найрагчдын бүтээлийг их бичсэн. Тэр үеэр гарсан бүтээлүүд бүгд л зарагдсан. Энэтхэг, Тайван, Японы яруу найрагчид ч худалдаж авсан. Мөн албан байгууллагууд ч их авсан нь нэг талаас монголчууд өөрсдийн бичиг соёлоо дээдлэх, хүндэтгэхэд суралцаж байгаа том соёл, нөгөө талаас уран бүтээлч бидний эх бичгээ түгээн дэлгэрүүлэх зорилго бага боловч биелэж байна гэж боддог. Сонирхуулахад, Японд уран бичлэгээр бичиж байж л шүлгээ бусдад хүргэдэг хүмүүс их бий. Үүнийг хүмүүс ихэд тааламжтай хүлээж авдаг юм билээ.

- Таны бүтээлүүдээс дэлхийн олон оронд байдаг уу?

- Миний зурсан уран зураг, монгол зураг, график болон уран бичлэгийн бүтээлүүд дэлхийн 80 гаруй оронд бий. Үүнээс Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдууд, бусад орны төрийн тэргүүнүүд, алдартангуудад бэлэглэсэн төрийн хэмжээний бэлгийн бүтээлүүд их бий. Жишээ нь: АНУ-ын Ерөнхийлөгч асан Ж.Буш, Английн хатан хаан Елизабета, Японы эзэн хаан Акихито, угсаа залгамжлах хан хүү Нарухито, Солонгос улсын Ерөнхийлөгч И.Мён. Бак, Ватиканы хамба Иоан Павел, Австри улсын канцлер Альфред Гузенбауэр, БНАСАУ-ын Хөдөлмөрийн намын ерөнхий нарийн бичгийн дарга Ким Жон Ир, НҮБ-ын бясалгалын төвийн захирал гэгээнтэн агсан Шри Чинмой, Казахстан улсын ерөнхийлөгч Н.А.Назарбаев, Дани Улсын угсаа залгамжлах хан хүү Фредерик, Монакогийн хан II Альберт гэх мэт олон доо.

Ромын Ватиканы ордонд “Мянган морины зураг” гээд бүтээлээ өгсөн. Энэ бүтээлээ мянган морины тамгаар хийсэн. Миний бүтээл шүү гэхээсээ илүү Монгол бичиг соёлыг тэр хүмүүст хүргэснээрээ сайхан санагддаг. Өөрийн улсын уран бичлэгийг сурталчлах нь бусад орнуудын хувьд ихээхэн эртний явдал.

- Хүмүүс бие дээрээ уран бичлэгээр бичүүлэх явдал элбэгшжээ. Та бичдэг үү?

- Тийм тийм. Хүмүүс уран бичлэгээр шивээс хийлгэх гээд эх загвар хийгээд өгөөч гэдэг л юм. Өөрсдийн дуртай үг, орд гээд янз бүрийн зүйл бичүүлдэг. Хувь хүний хобби л доо. Урлаг талаас нь сайхан бичиж өгөхийг л боддог. Ер нь мод, чулуу, торго, арьс гээд бүх л юман дээр бичиж болно. Сайхан бичиж байгаа залуучууд ч бас байна даа.



О.Дашбалбарын шүлэг “Амьддаа бие биенээ хайрла” Уран бичлэгч Д.Баттөмөр

- Уран бичлэгээр бичнэ гэдэг бас түүхийн мэдлэг, судалгаа чухал байдаг боловуу?

- Түүхэн зохиол, түүхэн зураггээд ер нь түүхийн мэдлэг бол ямар ч ажил мэргэжилд чухал байдаг. Японы нэг сэтгүүлч монгол уран бичлэг манайхаас ямар ялгаатай вэ гэж надаас асуухад: Та нар бол суурин амьдралтай хүмүүс. Нэг тийшээ очих бол тэр гудамжны зүүн тийшээ эргээд, дээшээ өгсөөд, баруун тийшээ яваад гээд л нэг хэсэг ийш тийш эргэнэ. Бид

бол нүүдэлчин ард түмэн. Мориндоо мордоод тэгш сайхан уудам тал нутгаараа саадгүй давхина. Ийм учраас бичигүсэг маань тэр мэт чөлөөтэй байдгаараа бахархдаг гэж хэлэхэд тэд нэгэн зэрэг алга ташсан шүү (инээв).

Монгол бичгийн онцлогийг тодруулах юм бол?

Монгол бичгийн олон дүрс нь их түүхэн ач холбогдолтой. Монголчууд орон орныг эзэлж байсан нь монгол дармал үсэгт тэр орны бичигүсгийн элементүүд их ороход нөлөөлсөн. Ханзаар жишээлээд авахад зурлагыг нь чөлөөтэй өөрчлөх боломжгүй. Монголоор улаан наран гэж сайхан бичээд нарыг нь нэг цэг тавьчихвал сайхан бүтээл болох жишээтэй. Харин ханзаар бол нэг цэг нэмчих юм бол өөр утга санааг илэрхийлэх болдог учраас маш хязгаарлагдмал. Иймээс манай монгол бичиг бол үнэхээрийн гайхалтай, уран тансаг. Талын морьтон нүүдэлчид өөрсдийнхөө сэтгэлгээ шиг тийм агуу бичгийг зохиосон. Доошоо бол хүн маш хурдан бичдэг. Харин хажуу тийшээ бол арай удаан. Энэ нь газрын татах хүчтэй ихээхэн холбоотой.

- Яг одоо та ямар бүтээл урлан бичиж байна вэ?

- Манай нэг найз дүүгийнхээ хуриманд бэлэглэх юм. Энэ шрифт нь бол арай өөр. Сүхбаатар аймгийн Алтан-Овоон дээр гараад “Дуулалт үсэг”-ийг зохиосон юм. Би өөрөө энэ шрифтээрээ бичих дуртай. Жишээ нь: сайн ажиглавал “дор” гэдэг үгийг долоон янзаар бичсэн байгаа. Ингэж нэг бүтээлд нэгүсгийг олон

хэлбэрээр зохиомжилж бичвэл улам сонирхолтой болдог юм. Байгаль дээр нь уран бичлэгээр бичих их сайхан. Францын зураач Ален Хийморийн овоон дээр цасан дээр уран бичлэгээр бичсэн. Бас нутгийнх нь усаар бичвэл илүү амьд ер бусын энергитэй болдог. Данзанравжаагийн “Үлэмжийн чанар”-ыг Хамарын хийдийн Шамбалын элсэнд рашаанаар бичиж бүтээл хийсэн. Энерги нь их өөр байдаг юм билээ. Дарьгангын Ганга нуурын усаар бичсэн. Би сүүгээр ч бичсэн. Энэ нь бичиж байгаа болон бичүүлсэн хүндээ илүү амьд сайхан сэтгэгдэл төрүүлдэг. Харин үүнийг натур уран бичлэг гэж нэрлээд байгаа юм.



“Улаан”. Д.Баттөмөрийн бүтээл

- Та монгол бичгийг багаасаа сурсан уу?

- Биднийг сурагч байхад заадаггүй байсан. Анх зургаан настайдаа эмээгээрээ заалгаж байгаад, 3-р ангидаа 1973 онд 45-р сургуульд монгол бичгийн дугуйланд сурсан. Дараа нь өөрөө бие дааж бичсэн. Би Москвагийн Строгановын нэрэмжит Урлаг үйлдвэрлэлийн дээд сургуульд 1981-1985 онд суралцах хугацаандаа Европын бүх шрифтийг заалгаж төгссөн. 20-оод жил уран бичлэгээр бичиж байна.

- Энэ дашрамд сонирхоход “Чингис хааны одон” таны бүтээл юм билээ. Та график дизайны ажлуудаасаа нэрлэнэ үү?

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шагнадаг “Төрийн дээд шагнал”, “Чингис хаан” одон, мөн МУ-ын ерөнхийлөгч бөгөөд зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн штандарт, нэрэмжит шагналын нь эх загвар гээд бүгд миний бүтээл л дээ. График дизайны ажлуудаас гэвэл 1982 онд МИАТ-ын билэг тэмдэг морийг нисгэгчийн хувцасны загвартай нь хийсэн. МУ-ын дээд шүүх, Монголын эмэгтэйчүүдийн байгууллагын билэг тэмдэгтэх мэт 300 гаруй лого хийсэн.

- Уран бичлэгээр бичиж сурах залуучуудад хандаж та юу хэлэх вэ ?

- Дуучин хүн өглөө бүр гамм уншдаг шиг өдөр бүр л зурж бичиж, урлагийн бүтээлүүдтэй танилцаж байх ёстой. Эзэн хичээвэл заяа хичээнээ.

Танд баярлалаа Уран бүтээлийн амжилт хүсэе.

“Цог” сэтгүүл 2010 №3 123-р хуудас. Ярилцсан Б.Төгсжаргал

Кино урлаг бол төрд хэрэгтэй зайран



Кино найруулагч Ж.Биндэр киноны зураг авалтын үеэр

Сар шинийн өмнө Бавуугийн Лхагвасүрэн гуай “Соёл урлагийн мэдээлэлтэй “Их урлаг” сэтгүүл гаргана. Найруулагч Жигжидийн Биндэрээс ярилцлага аваад ирнэ үү” гэсэн “томилолт” өглөө. Ж.Биндэр найруулагчтай уулзах бодолтой хэд хэдэн удаа залгаад холбоо барьж чадсангүй. Харин киноны зураг авалттай гээд завгүй байгаа тухай сонсоод кино урлагийн талаар яриа өрнүүлэх гэсэн хүсэл минь улам яарчихлаа.

Сар шинийн дараахан “Ах нь ажлын өрөөндөө байна, одоо хүрээд ирээ” гэсэн нааштай үг хэлэхэд нь би даруйхан яваад очсон юм. Найруулагч гэхээр энгийн биднээс их ондоо, нэг их адгуу, яаруу сандруу тийм л хүн байх боловуу гэсэн таамаглал санаанд буудаг. Надад тэгж л төсөөлөгдөж байсан. Товлосон цагтаа албан өрөөнд нь ороод очиход

нүдээрээ инээмсэглэсэн, нэлээн тайван дүр төрхтэй хүн угтлаа.

Эрхлэгчийн “томилолтоор” тантай уулзаж, их урлагийн талаар хууч хөөрөх гэсэн юмаа гэхэд анх уулзаж байгаа гэхэд огтхон ч цааргалалгүй аав ээжээсээ эхлээд туулсан амьдрал, уран бүтээл, урлаг соёлын тухай хуучны танил шиг халуун дотно яриа өрнүүлсэн юм. Удаан суухад нэлээн хүйтэн, тохь тухгүйхэн гэмээр энэ өрөөнд ямар их хүсэл мөрөөдөл хөвөрч, ажил ундарч байна даа гэсэн гэгээн бодол төрлөө. Ж.Биндэр ах:

-“Супер монито” гэж хүүхдийн киноны зураг авалт ид дундаа явж байна. “Монгол хүүхдийн үерхэл нөхөрлөл, бие биенээ хайрлана хүндлэнэ гэдэг чинь ийм байдаг юм шүү гэдгийг үзүүлэх гэсэн юм. Энэ киног найруулснаар багш хүний зовлон жаргалыг аргагүй мэдэрлээ. Олон хүүхэдтэй ажиллана гэдэг амаргүй ажил юмаа” гээд их л зав муутай сууж байлаа.

Янжинлхам бурхнаа хоймортоо залсан жижигхэн өрөөндөө монголын кино урлагийн түүхийг бичилцэж яваа эрхэм хүмүүн их зүйлийг бүтээж, цаашид ч улам ихийг бүтээхээр төлөвлөж сууна.

Миний аав зургийн талбайд зохиолоо хардаггүй хүн байсан

-Би кино урлагийн гайхамшигийг ярихын тулд ааваасаа эхэлж ярих учиртай. Миний аав 11 хүүхдээсээ жаахан байхын нохойгоор тоглож, дүрсгүйгээс өөрийг мэддэггүй байсан намайг онцолж, энэ сайхан урлагт хөтөлсөн хүн дээ. Анх галч хийлгэж ажлын амтыг мэдрүүлэхэд нь би үнэндээ самирсан (инээв) Дараа нь намайг курст суулгаад, техникч болгосон. Кино үйлдвэрээсээ Бүх Холбоотын кино урлагийн дээд сургуульд зураглаачийн мэргэжлээр суралцахаар явсан юм. Тэр хэдэн жил аав минь намайг хэр зэрэг сайн уран бүтээлч болж ирэх юм бол доо? гэж сэтгэл түгшиж суусан байх даа.

Харин би төгсөж ирээд гологдож, санаанд нь хүрээгүй. Аргагүй шүү дээ. Өөрөө онолын сургууль төгсөөгүй мөртлөө

агуу их онолтой, арга барилтай, туршлагатай хүн байсан юм. Би Оросын дэг сургуулийг ярьсан “том” амьтан ирэхэд аав минь өөдөөс монголын кино урлагийн гайхамшигт дэг сургуулийг яриад сууж байх жишээтэй. Төгсөж ирснийхээ дараа дөрөв таван киноны зурагт дагаж явсан. Операторын драматург буюу зураглаачийн жүжиглэл гэдгээ бүтэлтэй сурч ирээгүй амьтан чинь гологдолгүй яахав дээ. “Танай сургууль заадаггүй юмуу, чи сураагүй юмуу” гээд л зэмлэдэг байж билээ. Энэ нь эцэг хүний алсын хараа, намайг ихэрхэж мэдэмхийрч байгаад бүтэлгүй амьтан болчих вий гэж болгоомжилж байсан хэрэг юм билээ. Би ааваасаа л их юм сурч, өвлөн авч нээрээ ингэж зураг авч, найруулдаг юм байна гэж ойлгосон доо. Одоо болтол кино хийх гээд явж байна.

Аав минь алга. Одоо надад багш гэж байх биш дээ. Жаахан дөртэй болоод ирэхэд аавын маань энэ хэдэн кино л миний багш болж байна. Кинонуудыг нь үзэх болгондоо шинэ юм сурч авдаг. Би нэгд нэгэнгүй уншиж, улам ухаарч, ойлгохыг хичээж явна. Аав минь аппарат хэрэгсэл нь хүнд хүчир, чадал муутай цагүед өөрөө асар их юмыг харьцуулан боддог, ухаалаг хүн байсан учраас үе үеийн үзэгчдийн үзээд, үзээд уйддаггүй киноны цөөнгүй хэдийг нь хийсэн юм.

Биднийг хүүхэд байхад байсан хоёр талдаа улаан хөхтэй харандааг бариад хуучин монголоор тэмдэглэн, зурж 4-5 хоног суудаг л байсан даа. Гоё зохиол бүхэн кино болохгүй. Кино болгохын тулд найруулагчаас маш их хөдөлмөр, авьяас чадвар шаардана. Би бол яахав. Хоёр айлын хооронд ч юмуу, цөөхөн хэдэн хүний хэрүүл маргааны тухай кино хийгээд байна шүү дээ.

-Харин миний аавын кино бол улс нийгмийнхээ хөгжилд ард түмнээ уриалан дуудсан, хувьсгал тэмцэл, нэгдэлжих хөдөлгөөн атар газар эзэмших гээд том шүү дээ. Ийм кинонуудыг хийхийн зэрэгцээ биднийг тэжээсэн. Хүний мөс чанарыг өөрөөрөө үлгэрлэн үзүүлсэн үнэхээрийн гайхалтай хүн байлаа шүү дээ.

Би гурван хүүхдээ ийм хэмжээнд өсгөж чадахгүй л байна. Тэгэхээр агуу байгаа биз. “Хүргэн

хүү” киногүзээд би дотроо ийм кино хийчих юмсан гэж бодоод болмоор

юм шиг санагдаад байдаг. Гэтэл болдоггүй. Миний аав зургийн талбайд зохиолоо хардаггүй өөрөө эхлээд киногоо үзчихсэн учраас жүжигчдээс тэр хэмжээнд л шаарддагаараа их онцлог хүн байсан даа. Найруулагч хүн кино жүжигчнийг тоглуулахад амьдралын ухааныг зааж, үз, хар гэж үлгэрлэж ухааруулаад өгөхөөр сайн кино болж байна шүү дээ. Энэ бол найруулагч хүний ур ухаан.

Бүх холбоотын дээд сургуулийг төгссөн зураглаач залуу ирээдүйд найруулагч болно гэж бодолгүй кино урлагт орж ирсэн ч зураглаач байвал найруулагч болно гэж аавынхаа хэлснийг арав гаруй киноны зураг авалтанд яваад илүү олж мэдэрчээ. Мянган гоё юм бодоод хүний нүдээр харахаар болохгүй. Зураглаач хүн чинь өөрөө кадраа харчихна, өрж чадна, хуулиа мэднэ. Авьяас байвал найруулагч бол гээд сүүлдээ аав намайг зөнд нь орхисон гэж Ж.Биндэр найруулагч ярилаа. 1973 оноос эхлээд одоо болтол энэ их урлагт зүтгэхдээ, кино нэгтгэл долоон ширхэг тамганаас болж тарж, уран бүтээлчид нь орох оронгүй оочих аягагүй болж байсан ч өөрийн эзэмшсэн мэргэжил, эцгийнхээ захиас сургаалыгүл умартан “Орчлон” кино компанийг байгуулж, “Далд уянга”, “Хүйн холбоо”, “Алганы хээ” зэрэгкиног найруулан бүтээсэн нь үзэгчдийн таашаалд нийцсэн бүтээл болсныг мэргэжлийн хүмүүс үнэлдэг. Тэрээр Монгол ахуй, монгол сэтгэлгээг тусгасан сайн кино олныг хиймээр байна. Хэдэн бор юм нь байвал манай уран бүтээлчид авьяастай шүү хэмээн ярьж сууна.

Энгийн хүмүүний энгүй ухааныг би Ж.Биндэр гуайгаас бүтээл бүхэндээ хүний сайхан сэтгэл, бие биенээ хайрлаж энэрэх гэгээлэг, уянгалаг, хөгжимлөг тийм дүрийгүргэлж үгүйлж, мөрөөдөж, сэтгэлдээ тээж явдаг нэгэн болохыг нь мэдэрсэн юмаа. Кино урлаг бол үзэл суртлын гол зэвсэггэдэг үг одоо хүртэл үнэ цэнээ алдаагүй, хүнийг хүмүүжүүлэх, хүнлэг энэрэнгүй болгох, нийгмийн болох болохгүй олон явдлыг илчлэн үзүүлж, ард түмнийг ухааруулж ойлгуулж байдаг ач тустай, аргагүй л төрд хэрэгтэй зайран болохыг нь дахин дахин ярьж байсан юм.



Ж.Биндэр найруулагчийн аав, нэрт кино найруулагч Д.Жигжид

Ер нь зураглаач хийж чадвал найруулагч болно гэж аав минь хэлдэг. Сургуулиа төгсөөд арваад киноны зураг авлаа. Дараа нь найруулагч болсон. Бидний сурч ирсэн вошмерикгэж нэг зураг

авалт байдаг л даа. Тэрийг аав маань наймаалж гэж хэлдэг байсан юм. Яаж хэлэх нь хамаа алга. Яаж авах вэ гэдэг гол чанар нь байгаа юм шүү дээ. Мөн гадаад энгэр, дотоод энгэр авах гэж зураг авалтын талаар аав минь сургадаг. Энэ чинь өөд өөдөөсөө харах ёстой хуультай гэж намайг их мэдэхэд,

-Чи энийг сураагүй бол киноны зураг авахгүй гэж хэлсэн нь киноны зураг авалтын анхны том сургууль байсан. Сургуульд заадаггүй юм. Амьдралынхаа явц дунд үзээд хараад байсан чинь хоёр хүн сууж байхад хоёуланг нь ташруулаад зураг авахад анхаарах нэг чухал арга барил юм. Ийм жишээ олныг хэлж болно л доо. Ялангуяа түүхэн киноны баатар их төстэй байх ёстой. “Ард Аюуш”-ын Чойжилсүрэн гуай, “Өглөө” киноны Дашнамжил гуай бүгд тус тусдаа гэрэлтэй шүү дээ. Аппарат зоох энэ тэр бол тусгай. Хамгийн төсөөтэй нь энэ талаасаа байна, ийм байвал илүү адилхан харагдана гээд маш их ур бий. Үүнийг миний аав бүтэн эзэмшсэн хүн байсан даа.

Ер нь тэгээд хүний хорин жилийн амьдралыг нэг цаг гучин минутын кино болгож, үзэгчдэд хүргэнэ гэдэг амаргүй ажил шүү дээ. Үзэгчдэд арай үгүй байлгүй дээ гэсэн таамаглал төрүүлэхгүй, мэдэгдэхгүйгээр үйл явдал өрнөөд дуусдаг тийм сайхан кино болоход найруулагч, зураглаачаас их хөдөлмөр, тэвчээр, мэдлэг чадвар шаардсан том ажил. Мөн киноны амин сүнс бол зохиол. Хуучны зохиолуудын сэдэв нь яг таг монгол ахуй, сэтгэлгээ, монгол хүний мөн чанарыг харуулсан байдаг. С.Эрдэнэ, Б.Догмид, Б.Лхагвасүрэн гээд манай нэрт зохиолчдын зохиол бүтээлүүд кино болоход цагүеэсээ хоцроогүй монгол үнэртэй. Хоцрох ч үгүй. Б.Лхагвасүрэн гуайн, “аав нь хүүгээ согтуу явахыгүзлээ” гээд сайхан шүлэг бол тэр чигээрээ кино. Үүнийг бүр хүүгээ хөлчүү ирэхэд нь сураар ороолгож байгаа, дараа нь өрөвдөж хайрлаж байгаагаар тод үзүүлж дэлгэцийн бүтээл болгох юмсан гэсэн их мөрөөдөл байдаг. Олон хүнд уярал, ухаарал өгөх юм даа. Тэгээд мөнгө төгрөг нь болохгүй л байна.

Бидний яриа монгол киноны хөгжил, тэр тусмаа дэлхийн тавцанд гарах тухай яриагаар үргэлжилсэн юм. Монгол дээлтэй хүний планыгкинондоо тавихгүй, монгол гэрт амьдардаггүйл явдал байх ёсгүй гэсэн хууль гарчихсан мэт кино хийхээр чинь дэлхийн тавцанд гарах тухай яриад ч яахав гэж халаглаж байлаа. Монгол гэрт ядруухан амьдралтай ч ямар сайхан сэтгэлтэй, хүнлэг, нинжин сэтгэлтэй хүн байдаг юм бэ гэдгийг л кино үзүүлэх ёстой. Дэлхийд үзүүлчихээр кино алга. Манайхны хийсэн бар ресторанд суусан, алж талсан, буудалцсан залуучууд, бор шилбээ гаргасан охидыг дэлхий сонирхохгүй. Дээр нь дэлхийд үзүүлэх кинонууд видео фроматаар биш 35 мм-ийн хальсаар л хийдэг. Яагаад гэвэл тэр чинь дэлхий шүү дээ. Залуучууд дэлхийд үзүүлнэ гэж зоригтой ярьж байна. Гэхдээ сэдэв нь биш юм. Манай нүүдэлчний амьдрал агуу том философитой гэж Ж.Биндэр найруулагч нэг л бухимдангуй өгүүлж суулаа.

Кино урлаг бол төрд хэрэгтэй зайран. Энэ зайрангаа төр нь тоохгүй бүр хаячихлаа шүү дээ. Жишээ нь “Хүргэн

хүү” кинон дээр Жамц баян мөнгөө хулганад идүүлчихээд сандраад сууж байдаг. Аав минь сангийн яаман дээр төсөв батлуулах гээд сууж байхад нь банкны ажилтнууд хүмүүс мөнгөө хадгалуулахгүй, итгэхгүй байгаа тухай ярьж байсан гэнэ. Үүнээс санаа аваад кинондоо оруулснаар банкны эргэлт сайжирсан гэж байсан. Энэ мэтчилэн болох болохгүйгээ уран сайхны киногоор гаргахгүй бол баахан хэрэгжихгүй хууль яриад яах юм бэ. Одоо бүгд хувиа

хичээгээд, зоосны нүхээр хараад байх болжээ. Киноны бодлогыг нь уран бүтээлчид мэргэжлийн хүмүүс биш кино театр нь тодорхойлдог тэнэг тогтолцоо манайд байна.



Кино зураг авалтын үеэр уран бүтээлчдийн хамт. 2010 он

Энэ театруудын маркетингийн албанд мэргэжлийн хүмүүс байх ёстой юм. Хүний толгойд чулуу чихчихээд зоос олж болохгүй. Нэг хүн мөнгөтэй болоод нэг хэсэг хүмүүс толгойд чулуутай болж байна шүү дээ. Мэргэжлийн хяналт гэж байдаг бол хүний оюун руу юу орж байгааг яагаад хянаж болохгүй гэж. Нэг хүн мөнгө олоод үр дагавар нь үзэгчид үсээ шараар будуулаад, хүн зодоод, охид нь

нүцгэлээд л. Заавал хяналт шалгалт байх ёстой. Хүн өөрийнхөө сайн мууг тольдоод, энэ чанар маань сайхан юм байна, энэ нь муухай юм байна гэж бодуулдаг тийм кино үгүйлэгдэж байна. Ард түмнийхээ тархи руу нь чулуу чихэх биш бал бурам хийдэгкиног л хийж өгмөөр байна. Үүнд төр засаг бодлого боловсруулж, хөрөнгө зарж ажиллах хэрэгтэй хэмээн Ж.Биндэр гуай учирлалаа

Тэрбээр амьдралын хатуу хүтүү, жаргал зовлон бүхнийг туулж явахдаа аавынхаа “Кино буянтай урлаг, бурхантай урлаг” гэж хэлснийг санаж их урлагийнхаа төлөө амьдралынхаа агшин хором бүхнийг зориулсаар яваа эрхэм хүмүүсийн нэг. Цагийн эрхээр кино урлагийн гэрэлт ертөнцөд хөтөлж оруулсан ааваасаа, авьяасыг нь өнгөлж, дэмжиж тэтгэж урам хайрлаж явсан эгчээсээ хагацсан ч ээжийнхээ элгийг дэвтээж, үргэлж баярлуулж, аавынхаа ажлыгүргэлжлүүлж яваа энэ хүмүүн аргагүй сайн хүү юмаа. Сайн үйлсэд садаа мундахгүй хойно Ж.Биндэр найруулагчийн бие нь жаахан чилээрхэж байсан ч “Урлаг гэж сайхан шүү” гээд ер ажрахгүй шинэ кино найруулж, олон арван шавь нартаа зааж сургаж, хүүдээ ч бас мэргэжлээ өвлүүлж, монголын кино урлагаа дэлхийн тавцанд хүрээсэй гэсэн сүүн бодолтой уран бүтээлчдээ ертөнцийн толь болсон их урлагтаа үргэлж од мэт гялалзаж, нар мэт мандаж явахын сайхан ерөөлийгөргөө.

Б.Төгсжаргал 2010-03-26 “Цаг төр хүмүүс” сэтгүүл

Миний сэтгэл шиг нуур



МУЭ-ийн гишүүн, зураач Я.Гантуяа

Дорнод аймаг зураачдын өлгий нутаггэдгээрээ алдартай. Төрийн хошой соёрхолт О.Цэвэгжав, Төрийн соёрхолт Ардын зураач Г.Одон, Төрийн соёрхолт, Ардын зураач Ү.Ядамсүрэн, Төрийн соёрхолт, урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Чойдоггээд олон доо олон.

Эрдэнээс ч үнэтэй сайхан хүмүүнээ амьдад нь биш алдсаныхаа дараа үгүйлж суудаг монгол зангаараа МУЭ-ийн гишүүн агсан Ядамын Гантуяа ахыгаа дурсахын учир буй. Дөнгөж сэтгүүлч болоод Пүрэвийн Мэлс, Ядамын Гантуяа ах нарынхаа тухай “Ихэр хоёр зураач” нэртэй тэмдэглэл бичсэн ч ерөнхий редактораараа ур дүй муутай бичсэн гэсэн шалтгаанаар хасуулсан маань одоо ч надад байдаг юмаа.

Тэгэлгүй яахав дээ. Тийм авьяасын эх булаг болсон сайхан хүмүүсийн тухай энгийн нэг бичиж боломгүй хэрэг. Энэ “азгүй” сурвалжлагаас хойш ихэр юм шиг энэ хоёр зураач ах нартайгаа дэндүү ойр дотно аж төрж, шүлэг зураг

хоёр амь нэг, амьдрал ойр болохыг мэдэрч он оныгүджээ.

Их хүмүүсийн буянаар сор болсон уран бүтээлчдийн сонор мялаах сайхан үгийг олонтаа сонсож явсан ч харин Я.Гантуяа ахыгаа ийм эрт, цаг бусаар бурхны оронд одчих тухай огтхон ч төсөөлж бодсонгүй дээ.


Тэдний зураач мэргэжил, их үс гээг, ааш аяг, авьяас билгийг өөрийн нүдээр өнгөц харснаа л ихэр хоёр зураач гэж нэрлэсэн учиртай. Мэдээж уран бүтээлчийн хувьд тэд өөр өөр ертөнц, өөр өөр өнгөөр хорвоог хардаг хүмүүс. Хол ойроос ирсэн зураачдаас гадна, зохиолч, яруу найрагч, сэтгүүлч гээд бүхий л хүмүүстэй ойр дотно байж энэ хүрээний уулзалт, яруу найргийн наадам гээд аймагт болж байгаа урлаг соёлын үйл ажиллагааг тэдэнгүйгээр

төсөөлөхийн аргагүй.

М.Гантуяа ах “Арван мянгатын” хоёр өрөө байрандаа уран зургийн урлантай. Бид гэрээр нь орж гарч, номын санч гэргий Хоролмаагийнх нь хоол цайг идэж ууж, хоорондоо яг хүүхэд шиг л ярилцан үргэлжийн эв найртай байдаг тэднийхээр олон хүн хөлхөнө. “Зан сайтай айлд хүн бүхэн цуглана. Замаг сайтай нууранд шувууд бүхэн чуулна” гэж сайхан үг байдаг. М.Гантуяа ахынд ороход ийм л нэг нандин сайхан мэдрэмж төрдөгсөн. Тэрсхэн өссөн хоёр хүү нь ч ээж аав шигээ их л дөлгөөхөн хөвгүүд. Анхны номоо гаргах гээд сэтгэл догдлон гүйж явахад ах маань “Сарны өвөрт хонолоо” нэртэй зураг зурж өгч, будаг нь хатаагүй байхад нь бэлэглэхдээ,

“Чиний шүлгэнд зориулсан энэ зураг намайг “эвдсэн” шүү” гэж их л олзуурхан хэлж, надад уран бүтээлийн дэм өгч би хэдэн сайхан шүлэг бичсэн дээ. Олон арван сайхан баатрын дүрийг бүтээж, агуу их Ц.Дамдинсүрэнгийн хөшөөг цогцлоосон зураачаас ийм зураг бэлгэнд авсан маань надад бол мөнхийн дурсамж болж үлдсэн юм.

Авьяас их хүмүүнийхээ гавьяаг амьдад нь үнэлж чаддаггүй хүмүүс дээ бид. Монголд ганцхан байдаг бичгийн их хүмүүн Цэндийн Дамдинсүрэнгийн хөшөөг Дорнод аймгийн Төв номын сангийн өмнө босгож, Дорнын их яруу найрагч Данзангийн Нямсүрэнгийн хөргийг нь зурж, Монголын их түүхт баатрууд, хатдын хөргийг бүтээсэн гавьяатай хүнийг бид одоо илүү их дурсан санаж байна. “Бүх юм сайхан. Хүн чамайг гомдоосон бол сайхан. Чи бас гомдож байгаа чинь ч сайхан шүү дээ” гэж аливаагүргэлж сайхнаар төсөөлж явсан хүний амьдрал ийм болох тухай бидний хэн нь ч бодоогүй, бас анзаараагүй, хайрлаагүй нь харамсалтай.



Зураач М.Гантуяа ахын миний “Сарны өвөрт хонолоо” шүлгэнд зориулсан зураг. 2004 он

Өнгөрсөн жилийн намар есөн сарын эхээр юм даа. Ханийгаа алдчихаад ах маань гундуухан явна. Урт хүрэн савхин хүрмээ өмсчихсөн, хар малгайгааа донжтойхон тавьчихсан ажил дээр маань санаандгүй ороод ирлээ. Архи дарс ууж, гандаж гундчихсан нэгэн биш, “Ах нь хоёр хүүгээ сайхан уран бүтээлч болгох юмсан. Хөвгүүд маань зургийн чиглэлээр ажиллаж, сурч их сайн яваа. Хоомоо эгчийн чинь ганц захьсан юм л тэр.

Ах нь архи дарс, хүмүүсээс ч хол, Шар хаданд хашаа байшин хөлсөлж байгаа. Хөгшний маань

найзууд Шири ширигийн бясалгалд явахад тусалсан. Одоо нүүрсээ авчихвал тэгээд л өвөлжингөө тэндээ зургаа зураад суучихна

даа” гэсэн гэгээлэг сайхан юм ярьсаар уулзсан юм. Харин түүний сэтгэл ямар их гандуухан байгааг мэдэж байсан ч сэтгэлийн шархыг нь сэдрээхгүйн тулд нутагус, уран бүтээл гээд нэлээн ярьж суулаа.

Би жил бүр амралтаа аваад хунгийн чуулган үзэж, нутагтаа очиж, Алтан-Дарь овоогоо эргэнэ. Очих бүртээ заавал нэгуран бүтээлчтэй хамт явдаг юм, та энэ жил надтай хамт явах уу? гэж хэлтэл,

-Ах нь уг нь танай нутагт цэргийн алба хаасан хүн. Одоо ч очоогүй олон жил болжээ. Лав 20 гаруй жил болчихлоо гэсэн яриаг нь сонсоод, дүүтэйгээ яваад Алтан-Овоон дээр гарч, алба хаасан ангийнхаа барааг нэг хараад ирж болно шүү дээ гэж хэлэхэд минь хүүгээсээ асууж байж больё гээд явсан юм.

Хэдэн өдрийн дараа хүү маань яваад ир гэж байна, ах нь хамт явья гээд бид аяны дөрөө харшуулан алсын замд гарсан юмаа. Нийтийн унаанд сууж, аймагт очсоны маргааш нь өглөө эрт цааш явах унаа таарч, бид Дагшин нутаг Дарьгангад маань саадгүй хүрч билээ. Монголын утга зохиолын хүрээнийхэнд “Ай сэцэн” хэмээн алдаршсан яруу найрагч ах Ай.Төмөр-Очир тосож авсан юм. Найрагч ах маань биднийг хүлээнгээ гэргий Оюунцэцэгтээ:

-За ямар ч байсан би хүлээх учиртай нэг хүнийг ирэхээр явна. Гантуяа гэдэг юм. Яахав залуудаа учирч явсан Гантуяа гэж өндөр сайхан хар хүүхэн байгаа. Төгсөөтэй хамт ирж байгаа. Уулзаж байгаад явнаа гэж хошигнон хэлж байжээ. Зураач, зохиолч хоёр Дарьгангад уулзаж их л бэлэгшээн баярлаж байж билээ. Гурван өдрийн турш яруу найрагч Ч.Эрдэнэбаатар, миний авга ах Ш.Мөнхбаяр, уран уншигч малчин найз У.Мөнхзаяа нарын хамт Алтан-Овооны Батцагаан суврагад мөргөж, Ганга, Дуут, Дагшингаар өртөөлөн, Эрдэнэ-Уулын эрэг орчим намаржиж байгаа авга ахынд маань очлоо.

Я.Гантуяа ах авга ахынд ирсэн малчин ахтай Г.Найрамдалтай танилцаж, нэг нүд нь яльгүй “даруу” түүнийг хараад “Би Сүвээдэй баатраа оллоо. Өмнө нь би аавынхаа хөргийг харж байгаад зурсан юм” гэж уран

бүтээлчийн гэгээлэг сайхан ухаанаар ихэд олзуурхан баярлаж байсан нь саяхан мэт санагддаг юм.



Зураач Я.Гантуяа, яруу найрагч Ч.Эрдэнэбаатар, миний авга ах Ш.Мөнхбаяр, уран уншигч
найз Ц.Мөнхзаяа нар

Намрын сүүл сарын шаргал өдрүүд налайж, цөөхөн үлдсэн хун шувуудын үр зулзагыгөрөвдөж, нисэж сурахаасаа нааш явдаггүй юм гэнэ лээ гэж гуниглан, санааширч байсан нь одоо ч сэтгэлд тодхон байнаа. Харин ханиа алдаад удаагүй байсан уран бүтээлчийн сэтгэл хун шувууд нь хэдийн нисчихсэн ганц ч хунгүй Ганга нуурын зайрмагтсан мандлыг ширтэж зогсохдоо “Энэ нуур өнөөдөр миний сэтгэл шиг болжээ” гэж хэлээд хоолой нь зангирч байсан юм. Чойбалсан хотын гудамжаар урт хүрэн савхи өмсөн алхах гэгээн сэтгэлтэй, их үс гэзэгтэй, эрдэм авьяас цогцолсон энэ хүмүүндээ бид алдрын титэм өмсгөж чадаагүй ч энгүй их атлаа энгийн даруу аж төрсөн сайхан амьдралыг нь санаж явах учиртай. Олон сайхан ийм гэгээн тунгалаг хүмүүсээ он дамжин үдэхдээ, хайрлахын үүдээ хаасан, халаглахын учиртай хүмүүс мэт амьдарч байгаагаа бодож үзмээр л хэрэг.

Одоо Хэрлэн мөрөн нэгэн авьяаслаг зураачынхаа бийрийн шидээр дугаж, билэг авьяасыг нь нэхэн урссаар, урссаар л байна.

“Үнэн” сонин 2009 он. Б.Төгсжаргал

“Хилийн заставын хар нүдэн бүсгүй” гэдэг шүлэг маань дорхноо л дуу болсон



МУСГЗ, Д.Нацагдоржийн нэрэмжит Ш.Дулмаагийн хамт 2005 он. Хайлаар хот

Найрагчидаа гэж... Хаа ч явсан дуутай, цуутай сайхан хүмүүс. Монголын яруу найргийн хатан, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, зохиолч яруу найрагч Ш.Дулмаа гуайтай анх удаа ӨМӨЗО-ны Хайлаар хотод суралцаж байхдаа уулзаж танилцсан юм. Хотын хэмжээний их дээд сургууль, сонины хороо, телевиз радио гээд олон байгууллагууд түүнийгурьж, танхим дүүрэн хүмүүсийн дунд Монголын их яруу найргийн дээжсээс хүргэж, хүртээж явсан энэ эрхэмсэг бүсгүйтэй нутаг буцахаас нь өмнө уулзаж ярилцсан юм. Намайг яг л ээж шиг минь үнсэж, эрдмийн ихээс өвөртөлж, эх нутагтаа хэрэгтэй хүн болоорой гэж ерөөж билээ. Дуу хураагуураа бариад танаас ярилцлага авья гэж хэлэхэд минь асуулт болгонд минь чин сэтгэлээсээ хариулж өөрийн амьдралын үнэн түүхээсээ хуваалцсныгуншигч та бүхэндээ толилуулж байна.

- Энд тантай уулзсандаа баяртай байна. Улаанбаатар хотоос Дорнод аймгаар өртөөлөн, Хөлөнбуйрын тал нутагт морилон саатжээ. Энэ нутагтай та хүйн холбоотой гэж сонссон.

- Хөлөнбуйрын тал нутаг бол ээж аавын нутаг. Цаашилбал миний өвөг дээдсийн минь нутаг. 1917 онд миний ээж, аав Монгол улсдаа нүүж очоод, би Төв аймгийн Сэргэлэн суманд төрсөн юм. Ээж аавынхаа сэтгэлийг орлож, нутгийнхаа агаарыг нь амьсгалж, зон олонтой нь уулзаж, шүлэг найргаа өргөлөө. Хаана нь ч очсон бялхам их хайр хүндлэлээр дүүрэн байдаг юм. Сайхан байна. Ээж аав маань энэ сайхан цагийгүзэх тавилан байсан бол эндээ ирэх байсан даа.

- Ээж аавынхаа нутагт шүлгэн цацалаа, сүүн цацалтайгаа өргөөд буцаж байгаа юм байна. Уран бүтээлээн туурвиж эхэлсэн он цагаа эргэн дурсахгүй юу?

- Залуу жаахан байхын тэр оргилуун сэтгэл, хувь тавилан авьяас билиг маань л эргэж буцалтгүй намайг их утга зохиолын аянд хөтөлсөн юм. Шүлэг зүрхнээс гарч, зүрхэнд хүрдэг, тийм нэгэн зүйрлэн хэлж боломгүй сайхан анир аялгуу. 60,70-аад оныхон гэж нэрлэгддэг бидний хэдэн зохиолчид Явуу багшийн яруу найргийн дугуйлангийн ширээг тойрон сууж,

идэвхтэй цуглаж, шүлгээ уншиж, бие биенээ урлаж, хөглөж л зам болоод заяа төөрөг ханьссан юм даа.

- Монголын нэрт найрагч бүсгүй таны хувьд Монголын утга зохиолын их түүхийг бүтээж ирсэн сод хөвгүүдтэй уран бүтээлээрээ зэрэгцэж ирсэн нь сайхан. Тэднээрээ бахархахгүй юу.

- Тиймээ бидний үед бүсгүй найрагч цөөхөн байлаа. Ёстой л найргийн гэгээн тансагөргөөнд, тэднийхээ дунд эрх танхи охин шиг л явлаа. Б.Лхагвасүрэн, Ш.Сүрэнжав, С.Дашдооров, П.Бадарч, Р.Чойном, П.Пүрэвсүрэн гээд олон хурдан хүлгийн тоосон дуунд

бүсгүй би давхисан, цахилсан. Тэд маань ямар ч юманд намайгаа гээгээгүй. Би ч үргэлж гал шиг асаж явсан. Уран зохиолын энэ их урт замыг туулахад бартаа их ч авьяастай олон нөхөд маань намайг хурцалж өгсөн юм. Бичихгүй байхын аргагүй ухаалаг сайхан үг, шүлгээр би амьсгалж амьдарч ирсэн. Одоо ч Монголын ард түмний унших, сонсох дуртай шүлэг нь байсаар. Хүндлүүлнээ. Манайд ирээд хэн нэг нь хоол хийдэг. Ганц эмэгтэйгээр хийлгэхгүй гээд л. Бахархдаг. Энэ он жилүүд саяхан санагдаж байна. Сайхан шүү. Одоо ч би бичсээр л байгаа. Уянга найраггэж сүжирч, сүсэглэмээр гэгээн ертөнц шүү дээ.

- Бүсгүй шүлэгч эрчүүдээс юугаараа эрс ялгарах бэ?

- Сайхан асуулт байна. Бүсгүй чанараараа л ялгарна даа. Бүсгүй хүний сэтгэл, намба төрх, хорвоог харах хараа, амьдралаас авах мэдрэмж, баярлах гомдох аль бүхнийг бүсгүй зүрхээр л тосдог. Бүсгүй зүрхний гуниг баяр шингэсэн байдаг л даа.

- Уран бүтээлч бүсгүйн түшиг болсон ханийн тань тухай дурсвал...

- Миний хань бол кино найруулагч, кино жүжигчин хүн байсан даа. Жинхэнэ эр хүний шинжийг хадгалсан, уран бүтээлчийн хань болохоор заяагдсан хүн байлаа. Бид бие биенээ ойлгосон учраас их аз жаргалтай гэр бүл байсан. Энэ жаргал нь хайрандаа л байсан. Зохиолчид бид чинь их хөгжинө шүү дээ. Үргэлжийн л инээж угтана.

- Дүрүүдээс нь нэрлэвэл манай уншигчдад илүү тодорхой байх болов уу?

- “Дайсны цэргүүдээ сонсоцгоо” киноны Гэлэг хошууч, “Анхны хайрын дууль” киноны Дандийн дүр, Дөрөвдүгээр ноён хутагт Да лам Цэрэнчимэд, То вангийн багшийн дүр, Жалханз хутагтын багшийн дүр гээд олон дүрийг бүтээсэн дээ. Туслах ба жинхэнэ

найруулагчаар ажилласан. Кино урлагт нэр мөрөө үлдээсэн сайхан хүн байсан юм даа.

- Төв аймгаас манай Монголын олон нэрт яруу найрагчид төрөн гарсан тухай бид мэднэ. Яг л нэггэр тойроод суусан мэт гэж та бас ярьж байсан.

- Тиймээ. Манай нутаг бол яахын аргагүй найргийн даллагатай нутгаа. Их найрагч Д.Нацагдорж Баяндэлгэрт, П.Бадарч Баянжаргаланд, Ш.Сүрэнжав бид хоёр Баянд, Б.Лхагвасүрэн Баян Өнжүүлд, Д.Цоодол Бүрэнд, Өндөрширээтэд Д.Банзрагч, Баянцогтод Г.Цогт төрсөн гээд л яг залгаа сум нутгийг дамжаад төрсөн байдаг юм. Дэлхийгээр алтны

судал дагаад бий болдог шиг манай аймагт найргийн халуун судал лугшсан сайхан нутаг даа.

- Мөн Д.Цоодолын Хулан гээд л....

- Тэгэлгүй яахав. Ямар сайндаа Цоодолын Хулан, Хулангийн Уянга гээд л жаахан хазайгаад хошигноцгоож байдаг юм. Бас яах аргагүй нэрт найрагч хүргэн манайх байсан юм.Б.Лхагвасүрэнгийн Хасар гээд үе дамжиж байна л даа.

- Таны уран бүтээлд дууны яруу найрагголлодог. Дуу бүтсэн түүхээсээ нэгийг ярьж өгөхгүй юу.

-“Амьдрал хайр дээр тогтдог”, “Алтанзул”, “Учралын блюз”, “Шүүдрийн ганцхан дусал”, “Холын од уруу харвачих вий дээ”, “Хүрээ хүүхэн” гээд л хэд хэдэн дуу бий л дээ. Дуу бүтсэн түүх гэвэл та нарын хамгийн сайн мэддэг “Хилийн заставын хар нүдэн бүсгүй” гэж дуу байна. Урлагийн бригадаар далаад онд Сулинхээрийн заставт тоглолт гээд явж байлаа. Яруу найрагчдаас би явсан юм. Үйлчилж байсан хүүхнүүдээс залуухан цэргийн даргын эхнэр хөөрхөн хар нүдтэй охин нүдэнд тусаж билээ. Би өөрөө бүсгүй хүн болохоор дотроо энэ алс говь нутагт энэ хөөрхөн охин нөхрөө дагаад ирсэн байна гэж бодоод л өнгөрсөн. Харин энэ бодолтой минь хамт

Зүүдэнд гийх саран байгаасай. Зүрхэнд гэрэлтэх наран байгаасай

гэсэн мөр орж ирээд дараагийн бадгууд нь бараг нисэн ирэх шувуу шиг орж ирсэн дээ. Тэгтэл ая зохиогч Магсаржав өрөөнд орж ирээд уншчихаад тун аятайхан шүлэг байна гээд л авч явсан. Маргааш орой нь үдэлтийн үдэшлэг дээр зохиогчдыг нь хэлээд “Зүрхний наран” гэж нэрлээд анх морины Батбаяр гитартай дуулсан. Дараа нь хилийн заставуудаар их л дуулдаг болсон. Ийм л юм (инээв).

- Мөн таны “Хүүгийн эцэгт бичсэн захидал” гэдэг найраглалыг тань манай уншигчид андахгүй сайн мэднэ. Энэ бүтээл тань гараад тухайн үедээ шуугиан тарьж байсан гэж уншсан юм.

- Тиймээ. Тэр үед чинь зохиолчдын уран бүтээлийн тухай сайн муу олон шүүмжлэлтэй захиа ирдэг байлаа шүү дээ. “Газар шороо” гэдэг бүтээл маань “Цог” сэтгүүлд хэвлэгдснээс хойш аймаг сумын олон бүсгүйчүүдээс захидал ирлээ. “Энэ эрчүүд чинь хүүхдээ орхих юм. Энэ тухай нэг зохиол бичиж өгөөч” гэж. Гэр бүлийн товчооны Цамба гуайгаас сураглаж үзэхэд эрчүүд нь их орхидоггэнэ шүү. Тэгээд зүгээр ч нэг шүлэг биш олон, олон бүсгүйн зүрх сэтгэлийн үг болгож үнэхээр бүр нэг нөхөртөө бичиж байгаа юм шиг, уянгын аястай захидлын хэлбэрээр бичсэн. Дараа нь талархлын олон захиа ирсэн. “Хүүгийн эцэгт” гэдэг нэртэй гаргасан юм. Ингээд л уран бүтээл гэдэг дан ганц онгодоор биш янз янзаар л төрнө шүү дээ.

- Уран бүтээл бүтээсэн сайхан түүхүүд байна. Харин одоо “Үнэн” сонинд ажиллаж байсан тухайгаасаа хуучилна уу?

- Тэр үеийн Зөвлөлт Холбоот Улсад сэтгүүлчийн мэргэжил эзэмшсэн. Хорин жил “Үнэн”

сонинд ажилсан даа. Сэтгүүлчийн ажил маань гадаад дотоодын олон орноор аялуулж, хэзээ ч завгүй байхын жаргал

зовлонг надад мэдрүүлсэн. Олон сурвалжилганд явсан. Цагтай уралдана. Тэрэндээ ядарч зүдэрдэггүй. Шүүмжилвэл, гомдол мэдүүлж захидал ирүүлнэ, шүүхэд өгнөгөөд янз янзын л хүмүүстэй харьцана. Хамгийн гол нь би энэ сайхан мэргэжлийнхээ жаргалыг нь ч их эдэлсэн, зовлонг нь ч бүтэн даасан. Эргээд бодоход туйлын аз жаргалтай он жилүүд.



- Таныг спортын сэдвээр, тэр дундаа бөхийн тухай илүү сайн бичдэггэж аав минь ярьдаг байлаа.

-Тийм. Яруу найрагч байж спортын тухай түлхүү бичихээр гайхдаг байлаа. Дэлхийн, Олон улсын хөнгөн атлетикийн тэмцээн, Чөлөөт бөхийн Азийн аварга гээд л арав гаруй улс оронд очиж, олон улсын уралдаан тэмцээнүүдийг сурвалжилж байв. Спортын сэдвээр бичих их дуртай. Ялангуяа бөхийн сурвалжлагад арав гаруй жил явсан. Тэр үед чинь манайхан бөх их үзнэ. Бүр очер дугаар болно шүү дээ. Нэг

удаа сурвалжлах ажилаараа орох гэж байтал дугаарлаж зогссон хүмүүс уурлаад эрчүүдийн үздэг юманд энэ нэг хүүхэн бас ордог нь ч юу билээ дээ гэж намайг загнаж байлаа. Тэгээд яахав сэтгүүлчийн ажил гэж сайхан шүү дээ. Би ямар ч байсан түрүүлээд орсон доо. (инээв)

- Сэтгүүлч яруу найрагч байна гэдэг таныхаар...?

- Сэтгүүлчийн ажилтай яруу найрагч байна гэдэг. Сэтгүүлчийн ажил, яруу найрагчийн ажил аль нэг нь нэгэнтэйгээ уялдаж, холбогдож чаддаг. Бас оюун ухааны маш өндөр хэмжээнд хийх

ажил. Аль аль нь саад болохгүй. Бичих тусам үг улам ундарч байдаг. Сайхан шүү.

- “Дорнод” сониноор дамжуулан Дорнодчуудтай уулзаж байна. Манай нутгаас таны сэтгэлийг хөглөж гарсан бүтээлээсээ сонирхуулна уу.

- Дорнодын тал нутгаар би олон ирж байсан. Төрөл садан маань ч энэ нутагт байдаг. Тал минь намайг маш их хөглөсөн. Учир нь би өөрөө талын хүүхэд. Тал нутгаасаа би оюун ухааны ид шидийгөвлөж авсан юм л даа. Яг энэ дашрамд би харин нэг дуу дуулмаар санагдлаа шүү. (инээв)

Дархан хилээ хамгаалахад

Дагаад явахааргүй алсхан суугаа ч

Даамай хайрын халуун сэтгэлээр

Дандаа л чамтайгаа хамт л явдагаа.

Ширүүхэн гишгэвэл цэцэг нь уйлах

Цэнхэр хязгаарын алтан босго.

Цэрвүүхэн явбал зүрх нь шимшрэх

Сэтгэлээс уяатай миний амраг.

Эрдэний чулуу өнгө нь ялгарсан

Эх орны минь хилийн хаяа

Энхрий наддаа хайрын итгэлтэй

Эрэлхэг дайчдын амрагийн заяа

гээд л 1984 онд Дорнодын хилийн заставуудаар сурвалжлах ажлаар явж байхдаа зохиосон дуу. Тэгэхэд би бүр жинхэнэ цэцэгт тал л гэж тэрийг нэрлэмээр өнгө алагласан цэцэгт талыг тэнд үзсэн. Цаад зах нь бүр үл үзэгдэх бөгөөд нэг ч гишгэгдээгүй тийм их цэцэгт тал. Хөгжмийн зохиолч Бадарч ая хийж, Сийлэгмаа дуулсан юмаа.

- Яруу найргийн тухай таны сэтгэлийн үг юу вэ?

- Хүний сэтгэлийн хамгийн дээд зэргийн онгод, авьяас. Үүгээр дамжин сэтгэлийн их өчилийггаргадгаараа онцлогтой. Яруу найраггүйгээр хүн төрөлхтөн оршин тогтнож чадаа ч үгүй, чадах ч үгүй. Яруу найраг бол зүрхнээс зүрхэнд харван оч мэт тусдаг. Оюун ухааны хамгийн өндөр цэг болоод тэр шүү дээ.

- Харин яруу найрагчийн тухайд ...

- Ганцхан жишээ дурьдая. Оросод Пушкины амьдарч байсан цагүе. Бидний ярьдагаар дээдсийн хүрээлэнгийнхэн жилдээ нэг цугладаг эрхэм дээдсийн дайллага юмуу даа. Хэн хамгийн хээнцэр ганган гэдгээ харуулдаг том дайллаган дээр жирийн ард, сод авьяаст А.С.Пушкин гайхамшигт шүлгүүдээрээ дээдсийг алмайруулж, хамгийн төгс төгөлдөр гоо үзэсгэлэнт бүсгүй Натальяггэргийгээ болгож аваад гарч байсан шиг олон жишээг дурьдаж болно. Ийм л тэнгэрлэг хүмүүс юм даа.

- Сонирхолтой ярилцлага өгсөн танд баярлалаа. Уран бүтээлд тань амжилт хүсье. Гэртээ харих зам тань гэгээн дардан байх болтугай.

2005-09 сар. Хайлаар хот

Ганга нуур минь ширгэж, гангар цагаан хун шувуудаар дутах вий



Ганга нуур 2010

Эрт урьд цагт Энэтхэг оронд номын мөр хөөж одоод нутагтаа эргэж ирсэн нэгэн хүн Ганга мөрний рашаанаас бумбанд хийж залаад түүнээ элсний хормойд булсан юм гэнэ. Хожим түүнээс булаг оргилж, Ганга нуур үүссэн тухай домогүеэс үед яригдсаар ирсэн билээ. “Зүүн талаас нь Оргихын булаг, урдаас нь Баянбулагундарч нуурын урд, баруун хэсгээр 19 булаг даацлан Гангын усыг сэлбэдэг. Баруун хойно нь Ганга нуурын усаар сэлбэгддэг “Гангын олгой” гэж ус байсан. Зуны өдөр хав халуун байдагсан. Одоо хуурай хонхор болсон байна лээ. Улаан номд орсон “Дорнодын мэлхий” Ганга нуурт байдаг гэж Ш.Содномдаш багшийн эмхтгэсэн “Дарьганга нутгийн домог” номд өгүүлжээ.

Ийм л ариун дагшин ус маань он он дамжин өртөөлөн хүн малаа умдаалан, сэрүүцүүлж, Дарьганга нутгийн нуур усны нь амин судас болон оршоор ирсэн билээ.

Ганга нуурын ус татарч, багасаж 21 булаг нь гарын таван хуруунд багтахгүй цөөрч, зарим жил хун чуулахгүй байгаа талаар бид нүдээрээ харж, чихээрээ сонсож байсан ч гараа хөдөлгөж хамгаалсангүй. Улсын тусгай хамгаалалтын газарт зүй ёсоор тооцогддог нуур маань шүлэг дуунд мөнхөрч, үүссэн домог нь өнөө болтол яригдаж байгаа ч удалгүй үгүй болж ширгэсэн муу ёрын домог үүсэх вий гэхээс зүрх шимширч байна.

Өнгөрсөн хэдэн өдрүүдэд Ганга нуурт маань урин цагийн аясыг даган нүүдэллэн ирсэн хун шувууд үхэж, үрэгдэж байгааг сонсоод өр өвдөж, сэтгэл сэмэрлээ. Үзэсгэлэнт төрхөөрөө нуур усыг минь чимж, хүн зонихоо сэтгэлийг баясгаж байдаг хун шувууд хаврын хаварт сүрэг сүргээрээ нисэн ирж, намрын намарт хэдэн мянгаараа чуулан цэнгэх нь гайхамшигтай.

Их зохиолч Д.Маам “Ганга та дэлэх жигүүртэн ажээ. Эрдэнийн усандаа таны манцуйлсан, биеийг нь өгч жигүүрийг нь сунгасан Гангын хун галууд хаана явна. Та өөрөө тэнд явна. Газрын мухарт галуу чинь улдахад элс чинь шархиран нурна. Эргэж унах сүүн цацал мэт тэнгэрийн хаяанаас хун чинь цайрахад булаг чинь хөөрөн оргино. Ганга та дэлэх жигүүртэн ажээ. Та минуу, зэ” гэж үзэглэсэн нь уран бүтээлчийн уянгын халил, уран сэтгэмж төдий өгүүлэмж бус Ганга, Хун хоёрын хүйн холбоог хүмүүн бидэнд улам ойлгуулж, учирлаж, хайрлаж тэтгэж яваарай гэсэн халуун сэтгэлийн үг болой. Та бүхэн анзаарч сонсож, бодож

бясалгаж, эвсэж нэгдэж ариун үйлс бүтээгээсэй.

“Бүсгүй хүний мэлмий гэлтэй Ганга нуур, Дарь уулын тэргүүнийг мөнх ширтсэн байдаг юм. Ганга нуурын мандал дундаас Алтан-Дарь овоо харагдана. Үүрд биесээ шүтэж байдаг уул, нуур хоёрын ийм нэгэн барилдлагааг билэгдэн өгсөн Дарьганга гэдэг нэрэнд их гүн утга шингэсэн. Бие биеэ мөнх харсан байгалийн энэ тохиол, хүн хүндээ нөхөр байхын учир утгыг хэлсэн бишүү?

Эх нутаг, эзэн хүн хоёрын хэлхээ холбоо ийм болоод эх орноо мөнх хайрлах хүний хайрын утга учир ч бас үүнтэй агуулга нэгэн билээ. Ганга нуурын ганган улаан бургас, хун

шувуу үй зайгүй буудалласан толин цэнхэр мандал, Гангын хөвөөг эмжсэн торгон элс. Элс усны сэжүүр гишгэн ургасан хайлаасан ой, тэхийн шээг, моносон төгөл, жимс тэргүүтэн алаглан харагдана. Ганга нуурын хөвөөнд багширсан адуун сүрэг” гэж аав минь номын хуудаснаа бичиж, кино болгон үлдээжээ.

Аавын минь бичсэн энэ өгүүлэл уран сайхны кино зохиол биш ус нутгийнхан маань оршин амьдарч байсан тэр үеийн үнэн дүр төрхийг өгүүлсэн хэрэг. Гэтэл энэ үзэмж, содон сонин гайхамшиг одоо бидний өмнө ямархан дүр төрхтэй хувирч байгааг зүгээр л харсаар суух уу. Гасалж гансраад ч эргэж ирэхээргүй болсон Монголын олон зуун нуур усны гашуун түүх юутай ихийг өгүүлж болох билээ. Энэ гашуун түүх нутгийн нуурыг битгий дайраасай.

Бурхан минь! гэж үзгээ барьж үгээ учирлах нь таныг ч бас бодоосой, гэр бүлээрээ, хамт олноороо хамгаалах ажилд оролцоосой гэж уриалж байгаа хэрэг. Хүн төрөлхтөн байгалийн баялгийн төлөө өрсөлдөн тэмцэлддэг боловч ус хэмээх ижилгүй эрдэнэ бас хамгийн түгээмэл хэрэглээ байгалийн баялгийг тэр бүр дээдлэн үзэхгүй байна уу гэсэн зовнил төрнө. Хүн мал нь ундаасахын зовлонгүзээгүй болохоор тэр байх даа.

Өдгөө хүн төрөлхтөн хүнийг ч хиймлээр бүтээж чадахаа илэрхийлээд байгаа боловч усыг бүтээж чадахгүй гэдгээ дуу нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Монголчууд аливаа рашаан ус, булаг шанд гол мөрнөө өөрийн эзэн сахиустай хэмээн шүтэн бишрэхийн зэрэгцээ газар усны савдаг лусын эзэн, ус хурын эзэн, ган зудын эзэн тэнгэр бүгд усан дотор оршдог гэж ихэд сүслэн дээдэлдэгуламжлалтай.

Булгийн эхэнд бүү хэл голын усанд хиртэй хувцас хэрэглэлээ бүү угаа. Лус савдгийн хорлол болно. Тусгай саванд ус авч, гол горхиноос хол угааж бай гэж хойч үе үр хүүхэддээ бага балчраас нь үргэлж захиж ойлгуулж хатуу чанд сахиулж байсан.

Голын эх түүний ай саваас мод огтолж хад чулууг ховхолж болохгүй. Хэрвээ ингэвэл лус хилэгнэж, ус ширгэнэ. Зайлшгүй хэрэгцээ гарвал ховхолсон чулууныхаа

ормыг шороогоор дүүргэж тэгшил. Огтолсон модныхоо хожуулыг нойтон шавраар хучиж бай гэж сургаж ягштал биелүүлж байсан сайхан уламжлал байдаг. Түүнчлэн рашаан усны мэлхий, загас, жараахай, шувууг егүүтгэж устгахыг цээрлэж, эдгээр амьтад нь рашаан усны эзэд албат төдийгүй усны шимийг тэтгэгч лусын хаан ч хэмээн үздэг.

Энэ бүхэн эх болсон байгаль дэлхий нутагусаа хамгаалахтай холбоотой бичигдээгүй хууль болон үеийн үед уламжлагдан ирсэн усаа дээдлэх монгол ухаан билээ. Заавал нутагус гэхгүй. Газар газрын олон зочин гийчин хөвөөнд нь буудаллаж, намрын шаргал гунигт өдрүүдийг хунгийн дуунаар сэргээж явдаг билээ.



Хос хунтай Ганга нуур 2010 он

“Газраас оргилон даргих хүйтэн харзын усаар цай чанаж, хөвөөнд нь үдлэхдээ Ганга нуурын ганган улаан бургас ганхаж байхыгүзээд нас нэмлээ” гэж зохиолч С.Эрдэнэ хэдэн жилийн өмнө дуу алдан бичсэнийг та лав уншаа биз.

Миний аав И.Батсүх “Ганга гэж ганган, үзэсгэлэн төгс гэсэн утгатай нэр юм гэдэг. Ганга нуурын хөвөөнд ирээд шүлэг дуу зохиолгүй буцсан яруу найрагч гэж байхгүй. Ганга нуурын тухай дуу шүлэгуран зураг маш баян бөгөөд олон

арван томоохон боть ном бүтээх уран бүтээл цогцолсон нь дамжиггүй” хэмээн өгүүлжээ. Ийм агуу нуур маань энэ жил урдаасаа 250 метр татарсан, ердөө 60 см гүнтэй байна гэж албаны хүмүүс мэдээллээ. Одоо л хамгаалахгүй бол ирсэн очсон зочин гийчид, морь маланд гишгүүлсээр элс шороонд дарагдан үгүй болох аюул тулгараад байна. Тэр байтугай хаврын хаварт уламжлал болсон мэт хун шувууд үхэж үрэгдэх нь элбэгшиж байгаа нь дэндүү эмгэнэлтэй.

Сар шинийн дараахнаас эхлээд нутгийн зөвлөлийн хүмүүс уулзаж, нуур усаа хамгаалах ажилд идэвхтэй оролцох талаар уугуул суугуул иргэдээ уриаллаа. Эрэг дээр нь очиж амрах зугаацах болохоор монгол хүн бүрийн хайртай Ганга нуур, хамгаалж хямгадах болохоор зөвхөн нутгийн ард олны ажил байж болохгүй. Ганга нуур ширгэчихвэл хунгийн чуулган хэмээх гайхамшигт үзэгдлээс эхлээд хичнээн олон гоо үзэмжийг бид үзэх хувь дутна. Тиймээс домогт нуураа ширгэхээс хайрлаж хамгаалах төсвийн мөнгийг бүрдүүлэхэд улсын төсвөөс гаргана гэвэл ширгэсэн хойно нь шилээ маажгаад ч нэмэргүй хүмүүс л үлдэх байх даа. Хун шувуу чуулдаг, хүн их цугладаг гайхамшигт нутагт минь хүн бүхэн очдог болохоор та бүхэн сэтгэлээ өргөж, итгэлээ өгч, энэ гайхамшигт нуураа хамгаалах ажилд оролцоорой.

Ганга нуур эрт цагт усаа сэлбэдэг хорин нэгэн булагтай, элбэг баян устай, эргээ хальтал цацсан сайхан нуур байжээ. Тийм нэгэн цагтаа баруун хойшоо Молцог элсний захын зүүн

захын нэгэн хотгор шар манхыг дайран голдирол үүсгэн урссан байна. Ингэж урсахдаа уул хотгор шар манхыг сэтлээд усаа “Өргөн” хэмээх гол уруу цутгасан гэнэ. Энэ үеэс тэр манхыг “гангын сэтэрхий шар”, Ганга нуураас “Өргөн” гол хүртэл элсэн дундуур үргэлжлэх нарийн хоолойг “Гангын нарийн хоолой” хэмээн тус тус нэрлэдэг болжээ гэж манай нутагт энэхүү үзэмжит нуурынхаа тухай ярьдаг олон домог бий.

МУСГЗ Г.Мэнд-Ооёо “Намрын Ганга нуурыгүзсэн хүний мэлмий өөрийн эрхгүй уяран зөөлөрдөг буй заа. Зарим нуур шувуу ч үгүй, навч ч үгүй, гунигтайяа мэлмэрч байхад заримд нь буух буудал олдохгүй шахам олон хун

шувуу шахцалдах нь юуны учир вэ? Заавал нэгучир байгаа. Хэдэн өдөр, хэдэн шөнө ингэж ганганалдсан билээ. Тэр өдөр тэнгэр нэг л дүнсгэр байв. Алтан-Овооны чанх орой дээгүүр чигтэй нэгэн бүлэг хун хошууран гарч ирээд Гангыг хөвөөлөн бүтэн эргээд өмнө зүг хандахад нуурын мандал хөдөлгөөнд орчихлоо. Нуур уснаасаа хагацан салж байгаа мянга мянган амьтдын гуниг зовлонг нүд халтираад харж чадсангүй. Үймэн чарлалдах дуу нь зүрх сэтгэл өмлөн авчих шиг. Шувуу буцахын гуниг дагаад тэнгэрийн ааш муухайрдаг билээ. Жилийн жилд л ингэдэг. Энэ хосгүй содон үзэгдлийг, энэ нарийн гүн утга агуулгыг бид мэдэрч, Дагшин нутаг Дарьгангынхаа Ганга нуурыг хамгаалах нь хэдэн мянган хун шувуудыг хамгаалах, үр хүүхэддээ энэ гайхамшигийгүлдээх гээд дурьдаад баршгүй олон зүйлийг ярина.

Олон зохиолч уран бүтээлчдийн шүлэг найраг, домог түүх гутамшигт домгоор солигдох вий. Зон олон минь ээ.

Ганга нуур минь

Ганга нуур минь

Ганган цагаан охин минь

Гараа мандалд нь хүргэж өхөөрдөм

Турьхан аалыг минь

Нас зүс адилгүй


Надаас эгчмэдхэн бүсгүй минь

Намрын намарт шувуудын чуулганаар гоёсон

Найрсаг зантай ижий сэтгэлт минь ээ...

Б.Төгсжаргал

Энэ хүрэл хөшөөг би 10000 жилийн настай гэж баттай хэлнэ



Зураач, уран барималч Ж.Дүүрэнтөгс

Баруун-Урт. Энд хүүхэд нас минь өнгөрч баяр хөөр бялхсан олон өдрүүдийг бид гэр бүлээрээ дурсах дуртай. Аавтай явсан өдрүүдийн хамгийн гэгээн дурсамж энэ нутагтаа үлдсэн дээ. Их жанжны хөшөөний дэргэд очиж тоглон, хүүхдийн баяр, майн нэгэн, октябрийн баяраар ээж аавтайгаа хөтлөлцөн, баярын жагсаалд туг дарцаг барин жагсаж, ээжийнхээ урласан дээлээр гоёод, өнгө өнгийн шинэ тууз цэцэглэж зүүгээд, ах, эгч дүүс бидэнд хайрлаж дурсмаар олон дурсамж эндээс хөвөрдөг юмаа.

Манай нутгийнхан төдийгүй аймгаар ирсэн буцсан зочин гийчин бүр энэ хөшөөтэй холбоотой өөр өөрийн дурсамжийг яривал их зүйлийг өгүүлж болно. Хүйтний ам цаашилж, хөхүүрийн ам наашлах урин цагийг угтуулан бид шинэ хөшөө сүндэрлэж байгаа тухай сайхан мэдээ сонслоо. Зөв санаа зориг байвал санасандаа хүрч болдгийг өгүүлэгч их жанжныхаа үзэл санаагаар зүг чиг хийж, дархан

хүний бурхан ухаанаар сэтгэж, ус нутагт маань өглөгийн гараа сунгасан сайн санаат хүмүүс, ард иргэдийнхээ дэмжлэгтэйгээр их жанжныхаа 115 жилийн ойн босгон дээр үе үеийнхний дунд ам дамжин яригддаг байсан хуучин хөшөөгөө халж шинэ хөшөөг босгож чадлаа.



Сүхбаатар аймгийн төвд шинээр бүтээсэн Их жанжины хөшөө 2008 он

Их хүсэл өвөрлөж, эд баялаг хөрөнгө сан нь байгаад ч энэ том урлагийн бүтээлийг бүтээж, олон хүний таалалд нийцүүлнэ гэдэг амаргүй ажил. Харин энэ их ачааны хүндийг үүрч дүүрч, богино хугацаанд авьяас билэг, ур ухаанаа заран их жанжныхаа ойн баярын өдөр Баруун-Уртынхаа төвд залсан Сүхбаатар аймгийн Онгон сумын нутгийн уугуул, зураач, уран барималч Ж.Дүүрэнтөгстэй ярилцсан юмаа. Их ажлын ард гарах сайхан байдаг. Хөшөөнийхөө нээлтийг хийж, сэтгэл амар инээмсэглэж

суух энэ эрхэм бүтээлчийн Дарьганга суманд “Алс Шилийн Богдоос наахна Ариун Ганга нуураас цаахна” бүтээсэн Торой бандийн хөшөө, Дорнод аймгийн төвд урласан Бөртэ хатны хөшөө, Онгон суманд байгаа Алтан ургийн сүлд гээд нүд баясгаж, сэтгэл ариусгам, түүх шастирыг өгүүлсэн олон бүтээлийг нь бид мэднэ.

“Шинэ Сүхбаатар” сонин сар шинийн босгон дээр уншигч та бүхэндээ авьяас билэгт уран бүтээлч Ж.Дүүрэнтөгстэй ярилцсанаа толилуулъя.

- Их жанжныхаа хөшөөг бүтээх азтай, бас гавьяатай уран бүтээлч танд уншигчдынхаа өмнөөс баяр хүргэе.

- Баярлалаа. Хуучин хөшөө бол Урлагийн гавьяат зүтгэлтэн, уран барималч М.Мижир гуайн бүтээсэн хөшөө. М.Мижир гуай манай аймагт олон бүтээл хийсэн л дээ. Анхнаасаа хүмүүсийн сэтгэлд хүрээгүй, жанжин хүний эрч хүчийгүзүүлж чадаагүй урлагийн бүтээл талаасаа хангалтгүй, фото зургаас хийсэн гээд хүмүүс янз янзаар л шүүмжилсээр ирсэн. Гол нь цагүе нь уран бүтээлчийн өөрийнхөөрөө чөлөөтэй сэтгэж, дүрслэх арга барилыг хааж

боож байсан үе шүү дээ. Гэтэл хөшөө өөрөө моменталь урлаг. Харахад эрч хүчтэй, үйл хөдөлгөөнтэй, тэр дундаа ардын баатар, цэргийн гарамгай жанжин оч болон гялалзаж явсан хүний хөшөө ноомой даруу, дутуу дулимаг байх нь зохисгүй. Ард түмэн энэ хөшөөг жинхэнэ баатарлаг, жанжны хөшөө байгаасай гэж үгүйлсээр өнөөдрийг хүрсэн. Цаг үе, улс төр, мөнгө санхүү гээд олон саад бэрхшээлээс болсон байх даа. Энэ дашрамд ийм чухал үйл хэргийг дэмжиж санхүүжүүлсэн. Төмөртийн уурхайн хамт олонд баярлалаа гэж хэлэх нь зүйтэй. Төмөртийн овоо ба Цагаан дээлт Дамдин тэдний, өвөг дээдсийн өвөлжөө юм. Тэндээс гарсан эрдэс баялгийн үр шимээр энэ хөшөөг барилаа. Юмны учир их сонин шүү.

- Хөшөөг ямар хугацаанд хийсэн бэ?

- Ер нь 5-6 сарын дотор хийх ёстой ажлыг гурван сарын хугацаанд дуусгалаа. Цагулирлын хувьд өвөл цаг. Хүрлээр цутгах ажил хийдэггүй улирал л даа. Гурван сарын дотор амжууллаа. Энийг би ойн баярын нь өмнө хийчих юмсан гэсэн сэтгэлээр бүтээж урласан. Бас намайг дэмжсэн, итгэсэн хүмүүст болон Ж.Дүүрэнтөгс чадахгүй, амжихгүй гэсэн хүмүүст ч бас маш их баярлалаа. Тэрнээс чинь бас уран бүтээлч хүн их эрч хүч авч байгаа юм. Гол хөдөлгөгч хүч гэх үү дээ. Ялангуяа миний найз Ай.Төмөр-Очир энэ ажлыг бас сайн “хийсэн”. Намайг бол асаасан гэж хэлж болно. Уран бүтээлч хүний гол онцлог энэ. Том юмыг хийхэд том эрсдэл, үйл хөдөлгөөн, бужигнаан болдог. Бүх юм болоод өнгөрч ямар ч байсан одоо хөшөөгөө сүндэрлүүлж санаа амарчихаад дараагийн бүтээл дээрээ ажиллаж эхлэх гэж байна.

- Хөшөөгөө яг хэдийд суурилуулсан бэ? Суурь нь бэлэн болчихоод хөшөө нь алга, амжихгүй юм байна гэсэн яриа ч байсан.

- 2008-01-31-ний шөнө бэлэн болсон. Тэгээд 2-р сарын 2ны өдөр 115 жилийн ойн баярын өглөө 10 цаг 30 минутад бэлэн болоод нээлтээ хийсэн. Олон хүний сэтгэл хөдөлж, ур хийцийг нь хүлээн зөвшөөрсөн байгаагуран бүтээлчийн хувьд их баярлаж сая нэг амсхийлээ. Ягүнэнийг хэлэхэд тэр болтол би амсхийж чадахгүй байсан. Яахав дээ. Ард нь заавал жиг жуг яриа гардаг. Хүн юу ч хийхгүй байхад юу ч хэлдэггүй. Хийгээд ирэхээр л элдвийн яриа, янз бүрийн үзэл бодол гардаг. Том юм хийвэл бүр том юм ярина шүү дээ. (инээв) Энэ бүхнийг би мэргэжлийнхээ үүднээс, уран бүтээл, уран бүтээлчийн үүднээс л ярина. Орон нутгийн ТВ-ээр бас ярьсан л даа.

- Та уран бүтээлч хүнийхээ хүний хувьд урлаг талаасаа ч санаанд чинь хүрсэн үү?

- Ямар ч юмыг дахин хийхдээ улам сайжруулахын л төлөө хийдэг. Сайн юмыг бол хэн ч хөндөхгүй. Жаахан дутуу дулимаг зүйлийг бол анзаарчихсан л байдаг. Хуучин хөшөөг Д.Сүхбаатарын хүү С.Галсан гуай анх хараад, “Миний аав ийм гутарсан, ядарсан, сул дорой хүн байгаагүй юм. Болдог бол буулгачих юмсан” гэж хэлж байсныг нь олон жилийн өмнө өөрийн удмын их өндөр настай хүн ярьж байсан гэдэг. Хонины морь унасан мэт. Оросын комиссар хувцастай. Байлдааны гавьяаны улаан тугийн одон нь ч энгэртээ алга. Орос эмээл, бахиалтай, цементэн хөшөө гээд элемент болгон нь болохгүйг нь батлаад өгч байсан. Сүүлдээ ташуур, сэлэм нь уначихлаа, зүүн хойд хөл нь хагарчихлаа, тойрон хүрээлж буй талбай нь хазайсан, хөшөөндөө 60-70 хувийн гэмтэлтэй болсон байсан. Үүнд иргэд их эмзэглэсэн.

- Шинэ хөшөө энэ бүхнийг өөрчилж чадсан уу? Их жанжин Д.Сүхбаатарын хөшөө дэндүү сүр хүчгүй болсон байсныг дахин 100 хувь шинэчиллээ. Одоо ямар ч байсан монгол дээлтэй, амьд сэрүүндээ авсан байлдааны гавьяаны улаан тугийн одон нь энгэртээ, жанжин малгай нь тэргүүн дээрээ монгол эмээлтэй, морь нь хөмөлдрөг хударгатай, эх орноо харийн дайснаас чөлөөлчихөөд нийслэл хүрээнд орж ирсэн энэ торгон агшныг хөшөөндөө илтгэсэн. Нэг их сүрлэг, морийг нь цоройлгоод, гарыг нь дээш нь сунгаад байх сэтгэгдэл төрсөнгүй. Миний хувьд болсон л гэж бодож байна.

- Материалууд нь жинхэнэ үнэт бүтээлүүд үү?

- Тэгэлгүй яахав. Хүрэл чинь өөрөө үнэт метал. Суурь нь цэвэр гантигаар, талбай байгалийн халтирдаггүй боржин чулуу гээд олзуурхууштай шүү. Тэгээд дандаа мэргэжлийн хүмүүс хийсэн. Одоо хайрлах хүндлэх дээдлэх л үлдлээ. Ташууранд нь алтан өнгөлгөө хийсэн нь цэвэр уран бүтээлч хүний шийдэл гэж хэлж болно.

Тэр ташуур ямар гавьяатай түүхийг бид бүгдээрээ мэднэ. Тийм гавьяатай ташуурыг алтаар өнгөлөх ч багадна. Одоо ч гэсэн бидэнд ташуур их хэрэгтэй байна шүү дээ. Ийм нийгэм цагүед хийж бүтээхийн их ташуураар ташуурдуулж, загнуулж, бас зэмлүүлж, хурдтай байхгүй бол хойрго байж болохгүй. Тиймээс бид энэ алтан ташуурыг харсан хэн бүхэнд ташуур маш их хэрэгтэйг бэлэгшээн зориуд ингэж онцгой хийсэн. Харин эхийг нь би өөрөө бэлдэж хэвийг нь Хятадын Хө Бэй хотод очиж хийсэн. Хятад бол хэв цуггуурын аргаараа мянга мянган жилийн түүхтэй, чанарын хамгийн өндөр түвшинд хийдэг орон. Манай улс энэ чиглэлээр нэг ч жилийн түүхгүй байхад хятадад хийлээ гэж шүүмжилж хүртэл яригдсан. Эхийг нь би өөрөө хийж хөшөөг хүлээлгэж өгтлөө өөрөө зүтгэсэн. Намайг нутгийн уугуул биш хятад л гэхгүй бол бүх юмыг монгол хүн урласаан гэж багтай хэлнэ.

- Их жанжны шинэ хөшөө багагүй бартаа замыг туулж бүтлээ. Харин чанарын баталгаа талаас нь та юу хэлэх вэ?

- Энэ баталгааг би өөрөө амьд дээрээ өгч байна. Яагаад гэвэл дэлхий дээр хүрлээс дээд алтан хөшөө, мөнгөн хөшөө гэж байдаггүй. Хүрэл өөрөө дээд зэргийн хатуулаг. Хүрлийг 10000 жилийн өмнөөс хүн төрөлхтөн олдворлож эхэлсэн. Ийм олон жилийн өмнөх археологийн олдвор хутга, сэлэм гээд л зүйлүүд одоо музейд ир нь ч эмтрээгүй байна. Иймээс энэ хөшөөнийхөө чанарын баталгааг би 10000 жилийн настай гэж багтай хэлмээр байна.

- Уран бүтээл хийнэ гэдэг зогсолтгүй эргэх хүрд мэт оюунлаггэгээнлэг сайхан хэрэг. Одоо ямар уран бүтээл дээрээ ажиллах гэж байна?

- Ер нь дэлхий дахинд оюуны сэргэн мандлын нэг шинэ үе эхэлчихлээ. Энэнд үзэг, бийр, цаас, шавар юу байдаг юм тэр бүх оюуны багажуудаа бариад хүн бүхэн чадах

бүхнээ хийхийг зорьж байна. Би ч гэсэн эдний л нэг адил уран бүтээлч хүн. Үүнийг дагаад хөгждөг. Одоо удахгүй Ерөнхий сайд асан Цэнгэлтийн Жигжиджав гуайн хөшөө хүрэл юмуу байгалийн чулуун байдалд шилжих гээд бэлтгэлээ хангаж байна. Ингээд бие биенээ дагаад сэргэдэг. Мөн би өөрийн бичсэн “Ай даа амьдрал ч мөн сайхан даа” гэж анхныхаа жүжгийн зохиолыг Сүхбаатар аймгийн шинэ театртаа өгчихсөн. Уншигдаад найруулагчид таалагдсан.

Ийм өөдрөг жүжгээр манай аймгийн шинэ театр драмынхаа шинэ түүхийг эхэлнэ. Баяртай байгаа.



Зураач, уран барималч Ж.Дүүрэнтөгсийн Сүхбаатар аймгийн Дарьганга суманд бүтээсэн
Торой бандийн хөшөө 1999 он

- Энд нэг зүйлийг асуухад “Их жанжныхаа хөшөөг буулгалаа гэсэн” хэл ам хамгийн түрүүнд хийж бүтээх гэж байгаа тань дээр тусаад байсан юм билээ. Энэ үед та ямар тайлбар өгч байсан бэ?

- Энийг би яг хэлье гэж бодож байлаа. Манай нутгийнхан чинь юуг ч байсан их улс төржүүлээд дэвэргээд байна. Энийг дор дороо жаахан бодоосой гэж санах юм. Багадаа адилхан тархиа хагалаад, чулуугаар тоглож

байсан найзууд маань намаар зааглагдчихсан гурвуулаа уулзах гэхээр гурван нам болчихоод хоорондоо хөндий болчихсонд их эмзэглэлээ. Ийм сэтгэлээр аймгийнхаа хөгжлийн төлөө хамтдаа бид зүтгэж чадахгүй. Энэ бол уран бүтээлч миний чин сэтгэлийн үг.

- Музейд хадгалж байсан чандрыг сууринд нь байрлуулсан гэж байсан. Энэ үнэн үү?

- Энэ бол гэрэлт хөшөө. Хорин хэдхэн насандаа хэлсэн үг нь бүрэн эхээрээ байгаа. Гэрэлт хөшөө гэдэггэрэл гялбаа биш хэлсэн үгнээс нь гэрэл цацрах мэт зуун зуун жил дамнахыг хэлж байна. Нөгөө талаар энэ бунханта хөшөө. Яагаад гэвэл музейд хадгалагдаж байсан чандрыг нь сууринд мөнхөлж өгснөөрөө бунханта хөшөө болно. Баруун-Урт хотын төвд байрлах учир шүтээний шинжтэй. Жанжнаа хүндэлсэн хүмүүс тэнд дүр төрхийг нь харж мөн бунханд мөргөж болно гэсэн үг. Иймээс энэ маш өвөрмөц шийдэлтэй хөшөө болж чадсан гэж хэлж болно. Үүнийг манай нутгийнхан сайн мэдэж байгаасай. Та бүхэн сар шинэдээ сайхан шинэлээрэй гэж ерөөе.

Баярлалаа. Танд уран бүтээлийн арвин их амжилт хүсье.

Б.Төгсжаргал “Шинэ Сүхбаатар” сонин. 2008.2 сар

Өгүүлэх нь: Зураач, уран барималч Ж.Дүүрэнтөгс ахтай уулзахад заавал нэг содон сайхан хууч яриа сонсож шинэ зүйл үүтгэн бүтээх санаа сэтгэл төрдөг. “Ах нь урьд насандаа нэг

хөшөө хийж байгаад дутуу орхисон хүний л сүнс юм шиг байгаа юм” гэж өгүүлж суух энэ эрхэм хүмүүн он онд олон шинэ хөшөөг бүтээсээр л байна. Өнгөрсөн жил Баянзүрх дүүрэгт сүндэрлэх болсон “Эвтэй дөрвөн амьтан”-ы хөшөө хүмүүсийн очих дуртай, эв найрыг бэлгэдэн ярих дуртай сайхан бүтээл болжээ.



Ж.Дүүрэнтөгсийн Баянзүрх дүүрэгт бүтээсэн “Эвтэй дөрвөн амьтан”-ы хөшөөт цогцолбор.
2011 он

Ооль хэмээгч нь зохиогч эзнээ "эрүүдэн зовоогч", хэрэглэгчдийн цагийг хэмнэж оюуныг баяжуулагч бүтээгдэхүүн

Хэл бичгийн ухааны доктор, Толь зүйч С.Дэмбэрэл



Манай улсын гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээ өргөжихийн хэрээр дэлхийн улс орнуудад монголчууд чөлөөтэй зорчих болсон. Аливаа улс гүрэнтэй харилцах хамгийн гол түлхүүр нь тухайн орны хэл соёлыг сайн сурахад оршдог.

Харин хэл сурах хүний хамгийн сайн туслагч бол толь бичиг. Манай оронд 1990-ээд он хүртэл Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв нарын “Орос-Монгол толь”, А.Лувсандэндэвийн “Монгол-Орос толь”, Д.Алтангэрэлийн “Англи-Монгол толь” зэрэг цөөхөн хэлний толь бичиг байсан бол бүх хэлний толь, сурах бичгүүдийн эрэлт хэрэгцээ улам нэмэгдэж байв. Толь зүйч, гадаад хэлний мэргэжилтнүүд төрөл бүрийн толь бичиг, сурах бичиг зохион хэвлүүлэх болжээ.

Манай улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих үеэс япон улс манай улсыг идэвхтэй дэмжиж, бүхий л

салбарт тусламжийн гараа сунгасан билээ. Түүнтэй зэрэгцэн соёлын хамтын ажиллагаа, иргэд хоорондын солилцоо ч өргөжиж, япон хэлийг заах, сурах хандлага ч эрс нэмэгдэж байв.

Хэл бичгийн ухааны доктор, толь зүйч С.Дэмбэрэл эх нутагт нь япон хэл сурсан анхны оюутан. Түүний эмхэтгэсэн “Дүрс үсгийн япон-монгол толь”, “Япон-Монгол толь бичиг”, “Ханзны япон-монгол хэлний сургалтын толь бичиг” япон хэл сурч байгаа хүмүүсийн “ширээний ном” болж эхэлсэн юм. Япон-Монголын харилцаа өргөжин тэлэхэд мэдлэг оюунаараа гүүр болж байдгийг түүний бүтээлүүд, хийсэн ажлаас харж болно.

Өнгөрсөн жил “Монсудар” хэвлэлийн газраас эрхлэн хэвлүүлэхээр зэхэж байгаа “Япон-Монгол, Монгол-Япон өврийн толь бичиг”-ийн ерөнхий редактораар ажиллахын хамт Сони пүүсийгүндэслэн байгуулагч Морита Акиогийн “Японд үйлдвэрлэв” номыг орчуулжээ.

2007 онд хэвлүүлсэн “Япон-Монгол толь бичиг”-ээ дахин ариутган шүүхийн зэрэгцээ толгой үг, жишээ үг хэллэгийн тоог ч үлэмж нэмж шинэчлэн хэвлүүлчихээд, залгуулан хэсэг нөхдийн хамт төрсөн нутгийнхаа ойд зориулан “Түүхэн замнал, гэрэлт ирээдүй” хэмээх

томоохон ном бүтээгээд дөнгөж дуусч байх үеэр уулзсан юм. Бүтээлүүдтэй нь танилцаж суухдаа энэ их ажлыг яаж амжуулдаг юм бол гэх бодол зурсхийж билээ.

Хятадын нэрт хэл шинжлэлч Лү Сү Шань “Сүмбэр уул шигүйл хэрэг бүтээе гэвэл тэр нь гагцхүү толь бичиг зохиох” гэсэн сайхан хэллэгийг санаж, толь зохиох үйлсэд өөрийгөө “золиосолсон” С.Дэмбэрэл багшийг эрхэм уншигч тантай уулзуулъя.

- Ярилцлагаа таны япон хэлийг суралцаж, судлах болсон тухай дурсамжаар эхэлье?

- Би Монгол хэл-уран зохиолын багшийн мэргэжилтэй ч 35 жилийн өмнө Гадаад хэргийн Яамны Хүний нөөцийн хэлтэст ажиллаж байлаа. Тэр үед солонгос, хиндигээс бусад хэлтэй ажилтнуудын нэлээд нь Москвагийн

Олон улсын харилцаа юмуу олон улсад данстай их, дээд сургууль төгссөн, ихэнх нь хос хэлтэй, олон улсын харилцааны чиглэлээр голлон мэргэшсэн хүмүүс ажиллаж байв. Тэдэнтэй харьцуулахад хэдийгээр орос, герман хэл сурах гэж идэвхтэй оролдож ирсэн над шиг “дотоодын бүтээгдэхүүн” ажлын шаардлага хангах хэмжээний хэлтэй болтол их л хол юм шиг санагдаж байсныг нуух юун.



Япон улсад. 2011 он

- 1970-аад оны эхээр японы “Зуурдын сэтгэл” гэж орос орчуулгатай уран сайхны кино “Ард кино театр”-т гарч эхэлснээр тухайн үеийн нийслэлийн залуусын японы тухай төсөөллийг их өөрчилсөн. Би ч гэсэн тэр киногүзээд “милитарист гүрэн, Япон хүн дайнч самурай” гэсэн ойлголтондоо эргэлзсэн юм. Удалгүй японд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн их дэлгүүрээр мэр сэрхэн үзэгдэх болж, арын хаалгатай хүн л түүнийг олж авдаг байлаа. Монголын энх тайван, найрамдлын хороон дээр япон хэлний оройн курс анх нээгдэхэд, япон хэлний цагаан толгойг заалгаж эхэлснээр улам бүр гүнзгийрч миний насан туршийн хоолоо олж идэх “мэргэжил”, сэтгэлийг минь чангаагч хоёр дахь “эх хэл” минь болсон юм даа.

- Хоёр орны харилцаа маш хурдан хүрээгээ тэлсэн болов уу?

- Тэр үеийн Монгол-Японы харилцаа, өнөө үетэй харьцуулахын аргагүй эхлэл төдий байлаа. 1972 оны хоёрдугаар сарын 24-нд хоёр орны хооронд албан ёсоор дипломат харилцаа тогтсон юм. 1974 онд байгуулсан Монгол-Японы соёлын солилцооны протоколын заалтанд багш, оюутан солилцож байхаар тусгагдсан байсан. Токиогийн Гадаад судлалын их сургуульд анхны

монгол багшаар Шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэнгийн захирал, Академич Д.Төмөртоогоо багш томилогдсон юм. Оюутны хувьд сонголтоос шалтгаалсан уу манай талаас 1976 оноос эхлэн жилд нэг оюутан илгээж эхэлсэн юм. Тэдний нэгэнд би багтаж, Осакагийн Гадаад судлалын их сургуульд япон хэл, соёлын чиглэлээр судлаач оюутнаар суралцах завшаан олдсон билээ. Ийм хувь тавилангаар би япон хэлтэй учирч, миний нэг насны судалгааны ажлын эх суурь тавигдсан даа

- Толь бичиг зохиож хэвлүүлэх нь гадаад хэлтэй хүн бүр хийчихдэг тийм ч энгийн хялбар ажил биш гэж эрдэмтэд дүгнэдэг. Та хэдийнээс энэ ажлыг сонирхон оролдож эхэлсэн юм бэ?

- ЭСЯ-нд ажилласан эхний жилүүдэд надаас өөр япон хэлтэй ажилтан байсангүй. Ажлын шаардлагаар эрүүл мэнд, уул уурхай, эрчим хүч улмаар улс төр, эдийн засагт янз бүрийн салбарын орчуулга хийнэ. Ажлын ачаалал ч их. Ашиглах толь байхгүй болохоор тэр үеэсээ ажилласан салбарынхаа чиглэлээр мэдэхгүй үг хэллэгийн толь хөтөлдөг байлаа. Хожим эмхэтгэсэн толь бичгийн минь суурь дэвсгэр болно ч гэж тухайн үед бодож байсангүй. Японы нэг хэвлэлийн компаниас олон хэлний толь бичгийн монгол орчуулга, монгол дуудлагын япон хадмал галиг хийж өгөх хүсэлт ирүүлснээр толь бичгээр оролдох ажлын минь гараа болсон юм. Ингээд

миний оролцоотойгоор хоёр бэсрэг толь бичиг 1994 онд Токиод хэвлэгдсэн.

- Ер нь тэр үед хүмүүс толь бичиггаргаж байв уу?

-Хоёр орны соёлын харилцаа жилээс жилд өргөжиж, япон хэл суралцагсад ч олширч, тэдэнд зориулсан ханзны толь бичиг үгүйлэгдэж байсан юм. Залуугийн зориг, эрч хүчинд дулдуйдан “Дүрс үсгийн Япон-Монгол толь” эмхэтгэж 1995 онд хэвлүүллээ. Толь бичиг бүтээх нь зохиол бичих, ном орчуулахтай адилгүй. Ёстой л хэлний мэдлэгтэй хүн болгон санаа шулуудаад хийчихдэг ажил биш болохыг тэр үед л яс махандаа шингэтэл ойлгож билээ. Орчуулгын толь бичгийг зохиож болдоггүй, үг хэллэгийн утга санааг нэмж хасах мэтээр хялбарчилж болдоггүй, утгын оноолт, ялангуяа үндэсний онцлогтой үг хэллэг, хэлц үгийг тал бүрээс нь тунгааж, олон эхтэй харьцуулж, нухацтай судалж, зөв дүйцүүлэн орчуулах гэх мэтэд ихээхэн цаг, зав тэвчээр шаарддаг. Харин ном орчуулах нь цөөн тооны үгэн дотор эргэлддэг. Толь бичиг бол тийм биш. Толь хэмээгч нь зохиогч эзнээ “эрүүдэн зовоодог ч” гэлээ хэрэглэгчийн цагийг хэмнэж, оюуныг тэлж баяжуулдаг бүтээгдэхүүн.

- Та толь бичиг бүтээхэд ямар зарчим баримталдаг вэ?

- Миний хувьд арав орчим зарчим баримталдаг. Ханзны дуудлага, түүний утга зохиолын хэлний төв аялгуунд тогтсон хэлбэр, үг ба бүтцийн бүрэлдэхүүн хэсэг, үгсийн аймгийн ангилал, үгийн хувиллын хэлбэрүүд, үгийн язгуур ба хувирах төгсгөлийн ялгаа, үгийн тайлбар, тайлал, нийлмэл ба үүсмэл үг, найруулгын үүргийг чухалчилдаг.

- Үгсийн санг бүрдүүлэхэд гол анхаарах зүйл нь юу байдаг вэ?

- Идэвхтэй өргөн хэрэглээний, практик амьдралд хэрэглэдэг үгээр үгсийн санг бүрдүүлдэг. Хамгийн гол нь салаа утга, холбоо үг, хоршоо үг, салаа үг, нэгж

бүрийн утга төдийгүй утгын анхдагч цөм утгыг нэн тэргүүнд гаргахыг хичээдэг. Орчуулгыг мэдээж зөв дүйцүүлэх ёстой. Хэл шинжлэлч нар үндэсний онцлог бүхий үг нь тухайн хэлний арван хувийг хамардаггэдэг ч түүнийг зөв орчуулахад үлдэх ерэн хувиасаа ч илүү хэцүү гэж хэлж болно.

- Жишээлбэл?

- Олон жишээ байна монгол хэлний ахуйн эд өлгийн зүйл: домбо, тагш, хул эсвэл хэлц ба өвөрмөц хэллэгийн бүрэлдэхүүнд ордог үгс: нохойн наадам, ам алдах, толгой мэдэх, толгой даах, харь гаралтай үг хэллэгүүд: хуйцаа, цуйван, плов, гоожин, ардын аман зохиолоос үүдэлтэй ойлголт илэрхийлэх: бэрд, ам цагаан хулгана гээд л нэрлэвэл барагдашгүй. Зөвхөн японд ургадаг цэцэг, мод ургамал, далай тэнгисийн бидний үзээгүй амьтан, ургамал үй олон. Түүнийг эх хэлнээ хэрхэн ойлгогдохоор буулгах вэ? Эдгээрийг гутгачилах, болохгүй бол чөлөөт орчуулгын хэлбэрээр орчуулдаг. Толь бичгийн орчуулгыг гутгачилсан бол ард нь хаалтанд үгчилсэн орчуулгыг бичих зарчим баримталдаг. Энгийнээр утга нь “Аавдаа адуу манахыг заах” боловч хэллэг нь “Сармагчинд модонд авирахыг заах” байх жишээтэй. Мөн хэрэглэгч толь бичгээс зөвхөн мэдэхгүй үгээ эрдэггүй. Зөв бичих дүрмээ шалгах, лавлагаа гэх мэтэд өргөн ашигладаг тул алдаа мадаггүй байхаас гадна хэл найруулга, мэдээлэл нь үнэн зөв байх ёстой.

- Японы толь бичиг хэрэглэх соёл, хэрэгцээний талаар манай уншигчдад сонирхуулна уу?

- Нэвтэрхий толь бичиг, тайлбар толь бичиг бол үндэсний бахархал, тухайн улсын тусгаар тогтнол гэж хэлж болно. Толийг бүтээхдээ бурхан бүтээж байгаатай адилд үзэх ёстой. Японд толь бичгийг нэлээд эртнээс төрийн бодлогын хэмжээнд дээдлэн үзэж ирсэн байдаг. 1935 онд “Кожин” хэмээх алдартай тайлбар толь хэвлэгдэх үеэс толь бичгийг нийтийн хүртээл болгох, юуны өмнө айл өрх

бүрийг толь бичигтэй болгох бодлого явуулж, иргэдийнхээ эх хэлний боловсролд ч онцгой анхаарч ирсэн байдаг. Энэ бодлогын үрээр 1980-аад он гэхэд айл бүр ямар нэг толь бичигтэй болсон. Японд бага сургуулийн сурагчаас эхлээд нас насныхан ямар нэг толь бичигтэй.

- Сайхан жишээ байна. Та толь зүйч хүний хувьд манай улсад энэ талаар ямар бодлого хэрэгжүүлвэл амжилтанд хүрнэ гэж боддог вэ? Монгол хэлний тайлбар толь, нэвтэрхий толь бичиг айл бүрт биш юмаа гэхэд байгууллага бүрт нэг байх ёстой гэж боддог. Орчуулгын толь бичгийг ч ялгаагүй төрөөс дэмжиж, иргэдийнхээ оюуны мэдлэгт хөрөнгө оруулалт хийх зорилгоор сайн толь бичгийг хэвлүүлэх зардлын зохих хувийг санхүүжүүлэх, номын сангуудад толь бичиг худалдан авах зардал зориуд тусгаж өгөх зэргээр төрийн дэмжлэг хэрэгтэй. Ер нь даяаршлын үеийн толь бичиг ямар байх, толь бичгийн нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн соёл ба толь бичгийн талаарх үзэл баримтлал, цаашид толь бичиг ямар шаардлага хангасан байх ёстой талаар судалгааны ажил манайд ихээхэн үгүйлэгдэж байна.

Орчуулагч хүнд монгол хэлний мэдлэг маш чухал. Таны бодол?

Орчуулагч хүний эх хэлний мэдлэг маш сайн байх ёстой. Үсгийн дүрэм, найруулга зүй бол орчуулгын амин сүнс. Уран зохиол, улс төрийн ном орчуулж байгаа хүн өөр өөр зарчим

баримталдаг. Толь бүтээхэд ч ялгаагүй зарчимаа сайн тодорхойлохын зэрэгцээ үсгийн дүрмийн талаар тогтсон ерөнхий зарчим баримталвал зохино. Их эрдэмтэн Ц.Дамдинсүрэн, багш Б.Осор нар зохиож, 1983 онд хэвлүүлсэн “Зөв бичгийн дүрмийн толь”-оос өөр өнөөдөр манайд “журамласан толь” алга. Нийт хүмүүсийн эх хэлний мэдлэгийг дээшлүүлэх ядахнаа зөв бичгийн дүрмийн жишиг тогтоох талаар төрөөс тодорхой бодлого явуулмаар санагддаг.



Япон үндэсний уламжлалт баярын үеэр. 2010 он

Япон, солонгос хэлний бичигүсэг, толь бичгийн уламжлал Хятадаас уламжлалтай. Он дарааллын хувьд хэзээнээс хэрэглэж ирсэн юм бол?

Япон, Солонгосчууд Хятадын ханз үсгийг бараг мянгаад жилийн тэртээгээс зээлдэн, түүнийгээ зуу зуун жилийн турш төгөлдөржүүлэн өөрийн болгон хэрэглэж ирсэн ард түмэн. Хятадад Умард Хань улсын (25-220 он) үед Сүй Шений эмхтгэсэн 9353 ханзыг тайлбарласан “Ханзны толь бичиг” зохиогдсон. Түүнийг толь бичгүүд дотроос хамгийн эртнийх гэж үздэг. Улмаар 535—551 оны үед 16917 ханзыг тайлбарласан толь бичгийг зохиосон. Гэтэл энэ толь бичиг хятадад уламжлагдаагүй. Харин Японд уламжлагдаад тэр нь эргээд Солонгос, Хятадад нөлөө үзүүлсэн гэж үздэг. Япон дахь толь бичгийн уламжлалыг Хятадаас салгаж ойлгох боломжгүй.

- Япон хэлний толь бичгийн уламжлалыг тодруулвал...

- 682 онд хэвлэгдсэн “Шинжи” хэмээх анхны тайлбар толь бичиг бий гэж ном сударт тэмдэглэсэн боловч

энэ нь уламжлагдаж ирээгүй. Харин уламжлагдан ирсэн хамгийн эртний толь бичиг нь 892 оны үед лам Шёожюүгийн эмхтгэсэн “Шиньсэн жикёо” юм. Энэ толь бичгийг хятад толь бичгээс санаа авч зохиосон бөгөөд хятадаас зээлдсэн япон ханзны толь бичиг юм. Уламжлалт толь бичгийн ихэнхийг хятадад сурч байсан лам нар зохиосон байдаг. Орчин үеийн Японд хэвлэгдсэн хэлний болон орчуулгын толь бичгүүдийн цар хэмжээ нэн гайхамшигтай гэхээс өөр үг олдохгүй байна. Зөвхөн “Япон хэлний их толь бичиг” гэхэд 13 боть, 500 мянга гаруй толгой үг, нэг сая жишээ хэллэг багтаажээ. Ийм дайны “Үгийн их далай”, “Үгийн цэцэрлэгт хүрээлэн” гэсэн өөрийн “брэнд” адартай толь бичгүүд бас бий. Толь бичгийн цар хэмжээгээр нь тухайн улс орны хөгжлийн цар хэмжээг тодорхойлж болно.

- Сонирхолтой түүх ярилаа. Монголд ч гэсэн олон төрлийн толь бичиг шил шилээ даран гарч

байгаа гэж та хэлсэн. Толь зүйчийн хувьд үүнийг юугэж үздэг вэ?

- Өнгөрсөн оны эхээр манайд хэвлэгдсэн зөвхөн орчуулгын толь бичгийн бүртгэлийг гаргаж үзсэн. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлснээс хойш бүх толь бичгийн 70 хувь, тэр дундаа 51 орчим хувь нь 2000 оноос хойш хэвлэгдсэн байв. Толь бичгийн хэрэгцээ их болсонтой ч холбоотой. Социализмын үед хэвлэлийн чадал тааруугаас гадна “Хэвлэл утга зохиолыг хянах газар”-ын нарийн шүүлтүүрийг давах гэж цаг хугацаа алддаг байсан байж болох юм. Олон арван мянган шошго (карт) хөтөлдөг байснаа больж цахим бичүүрээр эхийг бэлтгэдэг болсон. Хэвлэлийн хүчин чадал ч дээшилжээ. “Монсудар”, НЕРКО хэвлэлийн компанид толь бичгийн редакц ч байгуулагдлаа. Энэ сайн хэрэг. Толь бичгийн нэр хүнд, түүнд итгэх итгэлийг даах хэмжээний чанартай бүтээлийн тоогулам нэмэгдүүлвэл нийгэмд их ач тустай. Толь бичиг 20-р зууны сүүлч хүртэл ихэвчлэн цаасаар хэвлэгдэж байсан бол одоо CD-ROM/DVD-ROM, memory card, Веб гэх мэт янз бүрийн хэлбэртэй болсон. Та толь зүйч эрдэмтний хувьд электрон толь бичгийн талаар ямар бодолтой байдаг вэ?

Толь бичиг электрон хэлбэрт шилжсэнээр толь бичгийг бүтээгч, хэрэглэгч хоёрын хоорондын зааг ялгааг багасгах, ойлголцоход амар хялбар болсон. Японд л гэхэд электрон толь бичгийн борлуулалт 2004 онд 5 миллиард 400 сая иенд хүрсэн байдаг. Цаасан толь бичиг 1998 он хүртэл жилд 12 саяас дээш хувь зарагдаж байсан бол 2003 онд 10 сая хувь болж, борлуулалтын хэмжээ ойролцоогоор 20 хувь хүртэл буурсан нь хэрэглэгч ямар толь бичгийг илүү хэрэглэж байгааг илтгэх чухал үзүүлэлт.

- Цаасан толь бичиг, электрон толь бичиг хоёр хэрэглээний ямар ялгаа зөрөөтэй вэ?

- Орчуулгын электрон толь бичгийн хувьд хэзээ ч, хаана ч ашиглаж болох давуу талтай ч шинэ үг хэллэг мэтийг бичиж тэмдэглэн баттай тогтоох, өөрийн болгоход цаасан толь бичгийг гүйцэхгүй. Амар хялбарыг бодож электрон толь бичигтэй найдаад мэрийлт нь буурах, хялбарчлах, түүнд бүхнийг даатгах сөрөг хандлага үүсгэж болох юм. Ер нь электрон толь бичиг цаасан толь бичгийг л

цахимжуулсан зүйл. Хүссэн хүсээгүй нэвтрэх нэг зүйл бол электрон толь бичиг. Электрон толь бичгийн үүрэг хаа хүртэл хөгжин өөрчлөгдөхийг шууд тодорхойлох боломжгүй ч “хөгжил” нь хүнийг бодит юмнаас хэт төсөөрүүлэх цаг үе улам бүр ойртсоор байх шиг санагддаг. Шинэ хуучныг хослуулах л хэрэгтэй. Жишээ нь Японд тооны машин бүрэн хэрэглэдэг ч сампингаа орхиогүй. Заасаар л, ашигласаар л байдаг сайхан жишээ байна. Сайхан байгаа биз.

Хэл бичгийн ухааны доктор, нэрт толь зүйч, С.Дэмбэрэл багш бид хоёр энэ сэдвээр дахин уулзаж ярих болоод өндөрлөсөн юм. Толь зүйн судалгаагаар хэл бичгийн ухааны

докторын зэрэг хамгаалсан түүнтэй ярилцахад энэ салбарт эхлэл төдий яваа миний хувьд дэндүү ахадмаар байсан юм. Харин С.Дэмбэрэл гуайн далай их мэдлэг, нэг насаараа туурвиж япон хэл суралцагч бүхний ширээний ном нь болж өгдөг бүтээлүүд нь надад тусалсан юм. Толь бичиг хэмээх их хөдөлмөр шаардсан том бүтээлийн талаар үнэ цэнтэй ярилцлага өгсөн С.Дэмбэрэл багшдаа уншигчдынхаа өмнөөс баярласнаа илэрхийлье.

Кино нэг талаасаа урлагийн бүтээл, нөгөө талаасаа арилжааны том хэрэгсэл



Монгол Улсын Ардын жүжигчин, Урлагийн гавьяат зүтгэлтэн, Кино найруулагч,
Д.Нацагдоржийн шагналт, зохиолч Г.Жигжидсүрэн

Монгол Улсын Ардын жүжигчин, нэрт кино найруулагч, зохиолч Гомбожавын Жигжидсүрэн гуайг уран бүтээлээр нь бид андахгүй сайн мэднэ. “Анхны алхам”, “Хүний амь”, “Эх бүрдийн домог”, “Амин мөр”, “Суварган цэнхэр уулс”, “Хатанбаатар”, “Хүн чулууны нулимс”, “Бүлээн нурам”, “Араатан”, “Их хааны удам”, “Цагаан сүүний домог” зэрэг монголчуудын үзээд үзээд уйддаггүй олон арван киног найруулж үзэгч түмнийхээ хайр хүндэтгэлийг хүлээж, олонд зөвшөөрөгдсөн чансаатай уран бүтээлч.

Мөн Александр Вампиловын “Чулимскэд болсон явдал”, Михаил Булгаковын “Зойкагийн сууц” зэрэг жүжиг орчуулж, “Усан дээрх гал” хэмээх түүхэн тууж бичсэнийг уншигч та бүхэн андахгүй сайн мэднэ. Одоо МҮОНТ-ийн Нэвтрүүлгийн зөвлөлд ажиллаж, оюуны сор болсон олон арван хүмүүсийн билиг авьяасыг уйгагүй “онгичин” олон түмэндээ хүргэдэг “Одод тохиох мөч”, “Дэлгэцийн бурхад” цуврал нэвтрүүлгүүд бэлтгэж байгаа юм.

Мөн кино урлагийн хөгжлийн шинэ хэлбэр болох баримтат уран сайхны “Их Нацагдорж зургаан ангит” түүхэн кино, одоогоос 2000 жилийн тэртээ Монголын газар нутаг дээр үүсэн тогтнож хүчирхэгжин мандсан анхны төрт улс болох Хүннүчүүдийн түүхэн ул мөрийг тодруулж, дэлхий дахинаа тунхаглан зарласан “Хүннү гүрэн” хэмээх зургаан ангит туульсын цуврал кинонуудын эхлэлийг тавьсан юм.

Одоо тэрбээр олон зууны туршид хүн төрөлхтөний соёлын түүхэнд давтагдашгүй ул мөрөө үлдээсэн Монголын өнө эртний түүхэн дурсгал, үнэт өвийн тухай өгүүлсэн “Буурал түүхийн жимээр” цуврал баримтат кино бүтээхээр шамдан ажиллаж байна.

“Монгол киноны нэвгэрхий толь” хэмээх гайхамшигт бүтээлийг гэргий Д.Цэцэгийн хамт туурвисан энэ эрхэм хүмүүнтэй ярилцсан цөөхөн хормоос мэргэжлийн түвшний кино урлагийн хөгжлийн урт түүх, үнэ цэнээс мэдэж авснаа уншигч та бүхэндээ толилуулж байна.

Их эрдэмтэн Л.Түдэв гуай энэ даацтай том бүтээлийнх нь мялаалга үгийг “Сурагч хүнд бол сурах бичиг, судлаач хүнд бол тулгуур бичиг, сонирхогч хүнд бол сэцэн багш болохоор хувь

тавилан энэхүү бүтээлд шингэсэн гэлтэй” гэж төгсгөсөн тухай сонины хуудаснаа хуучилсныгуншиж билээ. Жийгээ найруулагч “Энэ сайхан мялаалга нь бүхий л кино урлагт амьдралаа зориулсан миний сэтгэлд өргөсөн сүү байсанд үгээр хэлж, үзгээр бичихийн аргагүй баярлаж явдаг” гэж их л бэлэгшээн баярлаж сууна.

Их урлагтай тавь гаруй жилийн амьдралаа холбосон Г.Жигжидсүрэн найруулагчийн сэтгэлийн чинад дахь нэвтэрхий толийгуншиж суухад кино урлагийн тухай хэрхэн өгүүлснийгуншигч та бүхэндээ хүргэе .

- Хоёулаа кино урлагийн үүсэл хөгжлийн талаар яриагаар эхлэе.

- Утга зохиол, уран зураг, хөгжим зэрэг нь хүн төрөлхтөн үүссэн үетэй холбогддогурт жилийн түүхтэй. Харин кино бол урлагийн төрөл зүйлийн хувьд эдгээрээс нилээд хожуу, бүр хамгийн сүүлд

буюу 1895-н оноос үүссэн байдаг. Кино урлаг шинжлэх ухаан техникийн ололт дээр тулгуурлан асар хурдтайгаар бусдыгаа гүйцэж түрүүлээд урлагийн бүх төрлүүдийн нэгдэл болон гарч ирж хөгжсөн. Утга зохиол, уран зураг, хөгжим, драм гээд орохгүй урлагийн төрөл гэж байхгүй. Ийм түгээмэл болох шинж нь цөөхөн жилийн дотор дэлхийн олон сая живаа хүмүүсийн дунд шуугиан тарьсан. Кино дуугүй байснаа дуутай, хар цагаан байснаа өнгөтэй, шүдэнзний хайрцаг шиг байснаа өргөн дэлгэц, үүнээсээ өргөн формат, 35 байснаа 70мм-ийн хальс, дуу нь моно байснаа стерео гээд яриад байх юм бол киноны хөгжил маш цөөхөн жилийн дотор танигдахгүй болтлоо дэвшсэн. Өнөөдөр хүн төрөлхтний амьдралыг киногүйгээр төсөөлөхийн аргагүй болжээ.



Кино найруулагч Г.Жигжидсүрэн “Дэв” киноны уран бүтээлчдийн хамт 2010

Кино урлагийн төрөл уран сайхны, баримтат, анимаци гэсэн гурван ангилалд багтдаг ч, сүүлийн жилүүдэд телевизийн олон ангит цувралууд болон баримтат-уран сайхны гэх томьёолол гарч, анимацийг аль ч төрөлд чөлөөтэй ашиглаж байна. Олныг хамрах хүрээ, хүний оюун ухаанд нөлөөлөх чадлаараа ч үнэхээр зүйрлэхийн арга байхгүй. Маш түргэн хугацаанд асар өргөн хүрээтэй мэдээлэл өгч чаддагаараа киноны аль ч төрөл их хүчтэй.

“Бүр урлагийн дотроос хамгийн чухал нь кино” Лениний хэлсэн тунхаг одоо ч мөн чанараа хадгалсаар л байна. Хамгийн сүүлийн жишээ гэхэд Египет гаралтай АНУ-ын иргэн нэрт кино найруулагч Бесли Какуяагийн “Лалынхан буруугүй” киноноос болоод олон улсын хооронд зөрчил үүсч, бараг дайтах дээрээ тулаад байна шүү дээ. Телевиз дүрсээр дамжиж хүнд хүрдэггэдгээрээ киноны нэг төрөл. Тиймээс өнөөдөр кино, телевизийн нэр хүнд, цар

хүрээ бол улам өргөжиж, хүн бүхэн энэ зүгт тэмүүлэх болж дээ.

Кино урлагийн гол цөмийг юугэж тодорхойлдог юм бол?

Кино нэг талаасаа урлагийн бүтээл, нөгөө талаасаа арилжааны том хэрэгсэл. Тодруулбал арилжааны кино нь бүх юмыг зоосны нүхээр харсан төрөл. Кино урлагийн бүтээл огт өөр. Олон улсын хэмжээнд зохиогддог Берлин, Москва, Карловы-Вар, Венеци, Канны “А” зэрэглэлэийн кино фестивалиуд, Оскар, Алтан бөмбөрцөг гэх зэрэг дэлхийн нэр хүндтэй киноны арга хэмжээнүүд урлагийн бүтээлүүдийг тодруулж гаргахад том үүрэг гүйцэтгэж байна.

- Урлагийн бүтээл, арилжааны бүтээл хоёрын ялгаа үнэ цэнэ нь юу юм бол?

- Бүхэлд нь аваад үзэхэд урлагийн бүтээл талаасаа үнэлэгдсэн кинонууд арилжааны урсгалыг бодвол мөнгө олох нь бага байдаг. Феллини, Куросова, Бергман, Тарковский зэрэг дэлхийн киноны нэртэй найруулагч нарын киног харахад тэдгээр нь урлагийн бүтээл талаасаа үнэлж баршгүй, алтан өв, хүн төрөлхтөний оюуны сан хөмрөгийг бүрдүүлж бүтээсэн байдаг. Гэтэл энгийн үзэгчид их урлагийн түвшинд бүтээгдсэн эдгээр киног ойлгох нь ховор учраас бага сонирхдог. Агуу найруулагч Федерико Феллини дэлхийд алдаршсан “Амттайхан амьдрал” киногоо бүтээж байхдаа Венето гудамжны орчныг ягүнэнээр нь харуулахын тулд продюсер Анжело Риццолигоос гудамжийг бүрэн

хяналтандаа байлгахыг хүсэхэд цаадах нь “хэрэв чи гэрээнд заасны дагуух киноны үзлэгийн орлогоос авах хувиасаа татгалзах юм бол болох л юм” хэмээн хариулахад нь Феллини зөвшөөрсөн байдаг. “Хэрэв би үзвэрийн орлогоос хувь авсан бол үнэхээр баяжих байсан боловч, кино бүтээлийнхээ төлөө би хоромхон зуур ч эргэлзэхгүйгээр тэр хувиас татгалзсан юм. Би кино бүтээснийхээ хөлсөнд тавин мянган доллар аваад л дууссан. Миний кино олон сая долларын орлого олж, маш олон хүн баяжсан боловч, би тэдний тоонд багтаагүй юм. Анжело Риццоли сүүлд нь надад нэг алтан цаг л бэлэглэсэн юм даг” хэмээн Федерико Феллини дурсжээ.

- Сонин дурсамж, сайхан түүх байна шүү.

- Ийм жишээ олныг хэлж болно л доо. “Японы киноны нар” гэгддэг суут найруулагч Акира Куросава өөрийнхөө гэр орныг барьцаанд тавьж байгаад дэлхийд алдаршсан мөнхийн бүтээлээ туурвиж л байсан. Дэлхийн кино урлагийн том найруулагч нар хэзээ ч зоосны нүхээр амьдрал уран бүтээлээ харж яваагүй түүх дурсамж их бий. Таксины жолооч Феллинээс “Та яагаад ийм ойлгогдохооргүй кино хийдэг юм бэ” гэж асуухад нь, тэрээр “Би үнэнийг л хэлдэг шүү дээ. Хүмүүс хэзээ ч үнэнийг ойлгодоггүй хирнээ, хуурамч юманд дандаа итгэж байдаг” хэмээн хариулжээ. “Үнэн үг хэлсэн хүнд хүн өшөөтэй, үхэр унасан хүнд нохой өшөөтэй” гэж үг байдаг биз дээ. Дэлхийн киноны томчууд бүтээлээ ингэж л туурвидаг даа. Өнөөдөр ч Ларс Фон трнер, Ким Ки дук, Александр Сокуров нар гэсэн ийм л янзтай. Кино урлаг хатуу ааруул шүү. Хамаагүй хазвал шүд хугарах аюултай. Хатуу ааруул мэрснээс, чихэртэй аарц зуурч идээд явах нь ихэнх хүмүүст амар байдаг байх. Амьжиргааны хувьд арилжааны киноны найруулагчид урлагийн бүтээл туурвидаг найруулагчдаас хэдэн арав дахин их орлого олж, амьдрал нь тэр чинээгээрээ баян тансаг. Энэ бол кино ертөнцийн

бичигдээгүй хууль.

- Монгол кино урлагийн үүслийн тухайд та юу өгүүлэх вэ?

- Манайд кино анх Богд хаант Монгол улсын үед нэвтэрч, Богдын ордон болон тэр үед хүрээнд байсан Францын биржид кино гаргаж байсан юм билээ. Францын хөрөнгийн бирж нь одоогийн барилгачдын талбайд байгаа Исүс Христосын залуу гэгээнтнүүдийн сүм шүү дээ. Энэ байшинг 1934 онд 40 мянган мөнгөн доллараар худалдаж аваад, засч анхны кино театраа “Ард” гэж нэрлэн 1935 оны 5-р сарын 1-нд нээсэн түүхтэй. Эндээс харахад монголын кино их орой эхэлсэн байгаа биз. 1935 оны 10-р сарын 11-ний БНМАУ-ын Сайд Нарын Зөвлөлийн 32-р хурлаар Монголын үндэсний кино урлагийг хөгжүүлэхийн тулд “Монгол кино үйлдвэрийг байгуулах тухай” тогтоол гарч, байр худалдан авах зардалд 200 мянган төгрөг, тоног төхөөрөмжид зориулж 30 мянган доллар олгохоор шийдвэрлэсэн байдаг. Сүхбаатарын талбайн өмнө талд дээвэргүй болчихоод саяхан болтол байсан хоёр давхар байшинг хотын захиргаанаас дансаар шилжүүлэн авч, “Монгол кино” үйлдвэр гал голомтоо бадраасан түүхтэй. Дашрамд дурдахад тэр байшин Улаанбаатар хотын захиргааны анхны байр гэдэг талаасаа ч яах аргагүй түүхэн үнэт газар байсан боловч хотыг ойлгох, хайрлах сэтгэлгүй хөдөөний хүмүүс хотын толгойд заларч байсны гайгаар үрэгдэж алга болсон юм. ЗХУаас урилгаар ирсэн мэргэжилтнүүд уригдан ирж, уран бүтээлчдийг бэлтгэхэд их тус болсон доо. Тухайн үед сэхээтнүүдийн уурхай болж байсан Багшийн сургуулиас авьяастай хүүхдүүдийг шилэн авч Германд сурч ирсэн орос хэлтэй Төмөрийн Нацагдорж буюу зохиолч бага Нацагдоржийг найруулагчаар томилон ажиллуулснаар уран бүтээлчдийн анхны цөм бүрэлдсэн байгаа юм. 1936 онд “Майн 47 жил”, “Октябрийн 19 жилийн ойн баяр”-ын тухай тус бүр нэг бүлэг дуугүй кино сэтгүүл бүтээсэн нь Монголын үндэсний кино урлагийн эхлэл болсон доо. Гайхалтай сайхан түүх шүү.

Монголын хамгийн анхны уран сайхны кино ямар нэртэй байсан юм бол?

Монголын анхны уран сайхны кино зарим хүмүүс 1936 онд “Ленфильм” кино студид найруулагч Илья Траубергийн бүтээсэн “Монгол хүү” киног гэж ярьдаг. Энэ киноны тухай 1937 оны ЗХУ-ын “Кино урлаг” сэтгүүлд тухайн үед “Ленфильм” кино үйлдвэрийн уран сайхны удирдагч Адриан Иванович Петровский бичсэн “Монголын ард түмэнд өргөх бэлэг” гэсэн өгүүлэлд “Бид “Монгол хүү” киног Монголын ард түмэнд бэлэг болгож байгаа юм” гэж бичсэн байдаг. Энэ кинонд монгол хүн анх удаа дэлгэцэнд гарч тоглон, тэр үеийн монголын амьдрал тусгагдсан уу гэвэл тусгагдсаан. Манай алтан үеийнхэн болох Шороотын Цэвээн, Дашзэвэгийн Ичинхорлоо, Нямын Цэгмид, Данзангийн Бат-Очир гээд олон жүжигчид энэ кинонд анх тоглосон юм. Харин монголын уран сайхны анхны кино 1938 онд Т.Нацагдорж гуай өөрөө зохиолыг нь бичээд найруулсан “Норжмаагийн зам” хэмээх хоёр бүлэг дуугүй кино шүү дээ. Ингэж анхны бүтээлүүд гарсан түүхтэй.

- Т.Нацагдорж гуайн тухай хүмүүс их бага мэддэг шиг санагддаг. Та энэ тухай тодруулж хэлж өгнө үү?

- Тиймээ Т.Нацагдорж гуайг ер нь бид нар бага ярьж байгаа ч түүхэн гавьяатай хүн. Харамсалтай нь тэр хүн 1942 онд “Хил дээр гарсан хэрэг” гэдэг киноныхоо зураг авалтыг хийж байгаад улс төрийн хэргээр баригдан хэлмэгдэж, арваад жил шоронд суугаад сүүлд нь

цагаатгагдсан юм. Гарч ирээд эргэж кинонд ирээгүй, өөр ажил хийгээд явчихсан юм билээ. 50-иад оны дундуур зохиолч С.Дашдооров, М.Цэдэндорж нартай хамтран “Гурван найз” киноны зохиолыг бичсэн юм шүү дээ.



Найруулагч Ж.Бунтарын хамт

- Тэр үед өөр ямар кинонууд бүтээгдсэн бэ?

- 1938-1942 онд “Монгол кино” үйлдвэрт “Сүрэг чоно”, “Анхны сургамж”, “Тарваган тахал” гэх мэт долоон богино хэмжээний кино бүтээгдсэн. Энд нэг сонирхолтой юм гэвэл 1945-1954 он хүртэл Монголд уран сайхны нэг ч кино бүтээгдээгүй байгаа юм. Энэ нь мэргэжлийн кино найруулагч байгаагүйгээс болсон хэрэг. Тэгэхээр 1945 онд “Цогт тайж” киног хэн найруулсан юм бэ гэсэн асуулт гарч ирнээ. Энэ их сонин түүх. 1943-1946 онд “Монгол кино” үйлдвэрийн уран сайхны удирдагчаар томилогдож ирж ажилласан Оросын Холбооны Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн, найруулагч, зохиолч Юрий Викторич Тарич гэж хүн байсан. “Цогт тайж” киноны зохиолыг эрдэмтэн зохиолч Б.Ренчин гуайтай хамтарч бичээд, ерөнхий найруулагчаар ажилласан юм. Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн шагналт Лувсанжамцын Цогзолмаа гуайгаас эхлээд манай алтан үеийнхэн бүгдээрээ “Тарич багшаа” гэж хүндэлдэг хайрладаг их буянтан байлаа. Зарим хэвлэлд энэ киног Ч.Лувсанжамц гуай, М.Болд гуай хоёрыг найруулсан гэж андуу бичсэн байдаг. Би энэ хоёр ахмад уран бүтээлчидтэй

аль алинтай нь уулзаж ярилцаж явсан. Л.Лувсанжамц гуай театрын найруулагчийн мэргэжлээр Ленинградод сурч байгаад ирсэн учир орос хэлтэйгээрээ Ю.В.Тарич багшид орчуулагч хийж байсан юм билээ. М.Болд гуайгаас асуухад:

- Ишц, Жигжидсүрэн, хүү минь, миний тийм том киног найруулах гэж юу байхав. Чи намайг мэдэж байгаа шүү дээ. Тарич багшийн удирдлаган дор эвлүүлгийг нь л би хийсэн юм” гэж хэлж байсан. Ч.Лувсанжамц гуай амьдралынхаа сүүлийн жилүүдэд кино үйлдвэртээ эргэж ирээд орчуулгын киноны найруулагч, жүжигчин байсан л даа. Манай Д.Жигжид гуай хүртэл “Би кино найруулах арга ухааныг Тарич багшаас сурсан юм” гэж ярьсан удаатай. Ингээд бодоход “Цогт тайж” киног Юрий Викторович Тарич удирдан найруулж бүтээсэн нь тодорхой юм. Монголын кино урлагийн түүхэнд мөнхөд дурсагдаж байх гавьяатан бол Юрий Тарич яах аргагүй мөн. “Усыг нь уухдаа худаггаргасан хүнийг ямагт санаж бай” гэсэн Хятадын цэцэн үг байдгийг манайхан санаж явахад илүүдэхгүй.

- Монголын мэргэжлийн кино урлагийн хөгжлийн талаар та ахмад найруулагчийн хувьд ямар бодолтой явдаг вэ?

- Энэ их чухал асуудал. Монголын кино урлаг дэлхий дахинд танигдаж, алтан соёмбот төрийн минь далбаа дэлхийн томоохон кино наадмуудын орд харшийн өмнө намирч байсан үе бий юм шүү. Тэр ч бүү хэл 1975 онд Карловын Варын олон улсын киноны их наадмын тэргүүн шагналыг Монгол улсын ардын уран зохиолч төрийн шагналт Сэнгийн Эрдэнэ, Сормууниршийн Дашдооров нарын зохиолоор УГЗ найруулагч Жамьянгийн Бунтар бид хоёрын хамтран бүтээсэн “Эх бүрдийн домог” кино хүртсэн. Энэ бол өнөөдөр хүртэл Монголын уран сайхны киноны олон улсын их наадмаас авчирсан хамгийн том шагнал байгаа юм. Энийг дурсахад биеэ тоосон хэрэгт орохгүй байх. Ер нь сандал ширээнээс эхлээд ямар ч юмыггарын дүйтэй

мэргэжлийн хүн хийсэн нь арай дээр болдог биз дээ. Кино ялгаагүй шүү дээ. Өнөөдөр Монголын кинонд ор тас дутагдаж байгаа юм бол мэргэжлийн продюсер байгаа юм. Алсыг харсан ухаалаг продюсер хэрэгтэй л байна даа. Ийм хүн алга байна.

- Та яагаад ингэж бодож байгаа юм?

- Ганц хоёр кинонд тоглосон жүжигчин юмуу хэн нэг хүн, мөнгөтэй хүнтэй уулзаад чихийг нь дэлдийтэл өнгөтөөр үлгэр яриад, би урьд өмнө нь Монголд гарч байгаагүй гайхалтай кино хиймээр байна, туслаач гэхээр цаадах нь итгээд мөнгө өгч “кино хийлгэж тоглуулдаг” гэнэн сэтгэлгээг би ердөө ойлгодоггүй юм. Мухар олгой нь өвдөөд тэвдэхэд хүн дайралдсан малын эмчээр хагалгаа хийлгэдэггүй л биз дээ. Гоёлын үнэтэй торгон дээлээ хүн сайн оёдолчноор л оёулахыг бодно. Ялгаа юу байхав. Тэр олон хүний хөдөлмөрийгүрж, бас ч гайгүй хэдэн төгрөг устгана гэдэг найруулагчийн заавраар камерын өмнө хөдлөхтэй адилгүй гэдгийг л хэн хэн нь бодмоор байгаа юм. Намайг сонгодог балет найруулна гэвэл Жамьяндагва ухаан алдаад унана биз дээ. Киног яагаад хүн бүхэн найруулна гээд байна. Тийм үнэ цэнээ алдсан “ажил” гэж үү? Сүүлийн 20 гаруй жил Монголын кино урлаг яагаад “дуугаа хураачихаад байна вэ” гэдгийн нэг зангилаа нь энд байж мэдэх л байх. Одоо харин итгэл даах авьяас чадалтай залуу уран бүтээлчид гарч ирж байгаад би үнэхээр баярлаж явдаг.

- Монголын киноны мэргэжлийн хүмүүс ихэнх нь Оросод боловсрол эзэмшсэн байдаг.

- Тиймээ. Ихэнх нь Бүх Оросын Кино Урлагийн Дээд сургуулийг (ВГИК) төгсөгчид байлаа даа. ВГИК-ийг 1943-1948 онд Цэвээний Зандраа кино зохиолчоор, 1942-1947 онд Дамбын Ганжуур кино оператораар, 1949-1955 онд Равжаагийн Доржпалам кино найруулагч мэргэжлээр тус тус төгссөн нь, манай киноны анхны

дээд мэргэжлийн уран бүтээлчдийн түрүүч байлаа. 1956 онд найруулагч Р.Доржпаламын “Бидэнд юу саад болж байна” кино Карло-Варын олон улсын кино наадамд оролцож, тусгай шагнал хүртсэн нь монголын кино урлагийн дэлхийд нэрээ дуурсгасан анхны гараа байсан юм. 1959 онд Москвагийн олон улсын кино наадамд найруулагч Д.Жигжидийн “Ардын элч” кино оролцож, жүжигчин П.Цэвэлсүрэн эмэгтэй шилдэг дүрийн мөнгөн шагнал авч Монголын кино урлагийн нэр хүнд дэлхийн дэлгэцнээ өссөөр ирсэн түүхтэй. Энэ бүхэн Монгол киноны мэргэжлийн түвшинг илтгэсэн үзүүлэлт байсан юм. Монгол улс өөрийн

үндэсний кино урлагтай юм байна гэдгийг дэлхий даяар мэддэг байсан юм шүү.

- Киноны хөгжлийн түүхийг найруулагчтай холбож ярихаас өөр аргагүй юм даа.

- Өөр хэнтэй холбохов дээ. Ер нь кино урлагийн бүтээлүүдийг найруулагчаар нь овоглож ярьдаг шүү дээ. С.Бондарчукийн “Дайн ба энх”, Ф.Копполагийн “Загалмайлсан эцэг”, С.Герасимовийн “Дөлгөөн дон” кино гэхээс биш зохиолчоор нь овоглодоггүй. Тэгэхлээр кино бүтээлийн хувь заяаггартаа атгаж яваа хүн бол яах ч аргагүй найруулагч нь. Ер нь өнөөг хүртэл кино найруулагч гэж хэн бэ гэдгийг нэг ч хүн тодорхойлоогүй нь сонин. Кино найруулагчийг дайны үеийн цэргийн жанжин юмуу, хөгжмийн удирдаач, эсвэл туршигч нисэгч нартай олонтаа зүйрлэж тайлбарласан байдаг. Федерико Фаллини Америк тивийг нээх гэж яваа Христофор Колумбтай кино найруулагчийг адилтгасан явдал бий. Хөлөг онгоц дээр яваа бүх хүмүүс зүрх нь үхэж буцах гээд байхад, ганцаараа урагшаа зүтгэсээр яваа Колумбыгкино найруулагчтай жишиж хэлсэн нь сонин байдаг. Нэг иймэрхүү л мэргэжил юмуу даа.



Хүү Ж.Бодьбаатар, ач хүү Б.Цогт-Очир нарын хамт

- Таны хувьд найруулагч мэргэжлийг юугэж тодорхойлох вэ?

- Би кино найруулагчийг сурдаг биш төрдөг “мэргэжил” гэж боддог. Сайн найруулагч юуны өмнө сайн хүн байх ёстой. Кино найруулахынхаа урьд хор найруулах ажилд гарших юм бол их урлагийг бузарлалгүйгээр эртхэн өөр тийшээ явсан нь дээр гэж хэлмээр байна. “Муу хүн хэзээ ч сайн дүр бүтээж чадахгүй” гэж Станиславский айлдсан удаатай. Мэргэжлээ хүндэтгэж мэргэжилдээ үнэнч явдаг хүмүүс бол хэзээ ч хэдэн тийшээ савлаж далдганадаггүй. Агуу их жүжигчин Марчелло Мастроянийгкино найруулаач гэж урихад “үгүй, ээ би жүжигчин хүн” гэж хэлсэн байдаг. Мөн Иннокентий Смоктуновский “Миний хийдэг ажил бишээ” гэж хариулсан. Андрей Рублёвоос эхлээд Андрей Тарковскийн ихэнх киноны гол дүрийг бүтээсэн, дэлхийд нэртэй жүжигчин Анатолий Солоницын миний “Хатанбаатар” киноны генерал Бакичийн дүрийг бүтээснийгүзэгчид мэдэх байх. Би Солоницынээс “чамд кино найруулах бодол байдаг уу” гэж асуухад тэрбээр мушилзан инээмсэглээд “Би чинь скрипка”

шүү дээ, Жийгээ” гэж хэлсэн юм. Эндээс харахад том уран бүтээлчид бол том л байдаг юм билээ.

- Киноны уран бүтээлчдийг бэлтгэдэг мэргэжлийн сургуулиудыг нэгтгэх болсонтой та хэр зэрэг санал нийлж байгаа вэ?

- Чанар нь муу байгаа учраас сайжруулах үүднээс төрийн өмчтэй сургуулиудыг нэгтгэж байгааг би зөв гэж боддог. Эсэргүүцэж байгаа хүн байгаа л даа, мэдээж. Өнөө маргаашийн хэдэн хүний амьжиргаа нь хэрэгтэй юмуу, аль эсвэл монголын кино урлагийн ирээдүйг бодох ёстой юмуу гэдэг асуудал чухал. Кино урлагийн дээд сургуулийг бүх талаар нь дэмжиж төр засгаас анхаармаар байна. Босго өндөр болно гэж бодож байна. Хүүхдүүдийн хэлдгээр кино үйлдвэр нь өөрөө будаа болчихоод байхад гарын арван хуруунаас олон киноны нэртэй дээд сургуулиар монгол улс яах юм бэ. Камер барьж үзээгүй хүн кино зураглаачийн, ганц кадр тавьж үзээгүй хүн кино найруулагчийн хичээл зааж байгааг юугэж үзэхэв. Хүүхдүүд хайран санагдаад байгаа юм. Хөөрхий ээж аав нь хумс хуруугаа хэлтлээд олсон мөнгөөрөө хүү маань жүжигчин, кино найруулагч болно гэж горьдоод байдаг. Энэ бол манайх шиг ийм цөөн хүн амтай оронд эмгэнэл л юм даа. Залуучууд хурдан нэг кинонд тоглоод олны өмнө гарахсан гэж боддог. Тэгтэл энэ бүхнийг зөв удирдаж, зөв зааж, зөв голдиролд нь оруулах үүргийг мастер багш л хүлээнэ шүү дээ.

- Мастер багш гэж яг ямар хүнийг хэлдэг юм бол?

- Гадны их дээд сургуулиудын уран бүтээлийн урланг мастер багш л удирддаг. Манайд тэрийг огтхон ч тоодоггүй. Мастер багшийн үүрэг бол авьяастай хүнийг олж хараад өөрт нь мэдэгдэхгүйгээр зөв хөтөлж, залж явахад байгаа юм. Мастер багшийн удирдлагад ажилладаг туслах багш заавал хэрэгтэй. Их онол ярьдаг хүн хамгийн муу жүжигчид байдаг юм. Дүрийн судалгаа тэгж хийнэ гээд л, нүднийх нь харц том болоод л, духаа

үрчийлгээд л, сургаал айлдаад байгаа юм шиг тийм хүмүүст би үнэхээр итгэдэггүй. Би том жүжигчидтэй ажиллаж үзсэн. Тэд зургийн талбай дээр гарч ирээд, Би энд яах ёстой вэ? гэж л асуудаг. Тэгэх ёстой гэж хэлээд өгөхөд л болоо. Акира Куросовагаас “Та жүжигчидтэйгээ хэрхэн ажилладаг вэ” гэж асуухад “Би тэдэнд мөнгө төлж байгаа юм чинь ажиллаад яах юм бэ” гэж хариулсан байдаг.

- Кино урлагийг хөгжүүлэхэд гадаадын улс орнуудад төр засаг нь уран бүтээлчдээ яаж дэмждэг вэ?

- Ер нь томоохон улс орнууд үндэснийхээ кино урлагийг дэмжих бодлого явуулдаг л даа. Хамгийн ойр байгаа Оросын кино урлагийг хар л даа. В.Путин Оросын үндэсний орлогын 0,2 хувийг жил бүхэн кино урлаг хөгжүүлэх фондод оруулна гэж зарлиггаргасан. Энэ бол Оросын кино урлаг сэргэж хөгжихөд нэг том хөшүүрэг болж өгсөн. Д.Медведев Оросын киноны холбооны дарга Н.Михалковыг хүлээж авч уулзахад, Михалков Оросын кино урлагт хоёр том асуудал байна. Дэлхийд нэртэй Бүх Оросын Кино Урлагийн Дээд Сургуулийн (ВГИК) маань материаллаг бааз нь хоцорлоо. Уран бүтээлчид, ахмадуудыгаа байрлуулдаг ордон маань хүнд байдалд байна. Дэмжлэгүзүүлээч гэсэн. Тэгэхэд Медведев, “Хүрэлцээтэй мөнгө гаргана, зарлигийн төслөө материалтайгаа аваад ирээ” гэж хэлсэн. Дараахан нь ВГИК-ийн 90 жилийн ойгоор В.Путин манай сургуулийнханд ирж баяр хүргээд, технологийн шинэчлэлийн мөнгө өгөхөө баталгаажуулсан. Сайхан байгаа биз. Америкад байдаг Гүржийн баячууд нийлээд Гүржийн кино үйлдвэрийг нь шинэ техникээр хангаад өгсөн. Тэр бол

мундаг шүү дээ. Манайх давын өмнө хуультай л болмоор байгаа юм. Би БСШУЯ-нд цөөн жил ажиллаж байхдаа киноны хуулийн төсөл боловсруулж, хоёр ч удаа зүтгүүлээд бараагүй юм. Энд уран бүтээлчид нэгдэж ажиллаж, зүтгэдэггүй буруу бас бий.

- Одоо та киноны ямар уран бүтээл дээр ажиллах гэж байгаа вэ?

- Би Монголын кино урлагтай амьдралаа холбоод тавь гаран жил болж байна. Хүний амьдралд бол бага хугацаа биш шүү. Монгол Улсын төрийн шагналт, Ардын уран зохиолч Сэнгийн Эрдэнэ гуайтай би нилээд ойр дотно явж хэд хэдэн хамтарсан бүтээл хийсэн юм. “Хойд насандаа учирна” гэдэг романыг нь би С.Эрдэнэ зохиолчийн түүний насны бүтээл нь гэж боддог. Энэ зохиолоор уран сайхны кино бүтээх бодолтой байна. Аль аль талаас нь мэргэжлийн түвшинд бүтээх санаатай. Өнөөг хүртэл шарх сорви нь гүйцэд эдгээгүй. Монголын түүхийн нэгэн хар толбо болох хэлмэгдүүлэлт хэмээх их хядлагын үр үндсийг нээн харуулж үнэн мөнөөр нь үзэгчдэд хүргэсэн дорвитой томоохон бүтээл Монголын кино урлагт хараахан гараагүй байна. Иймээс энэ кинонд нилээд ул суурьтай хандах шаардлага байгаа юм. Энэ киногоо би С.Эрдэнэ гуайнхаа дурсгалд зориулан бүтээх сэтгэлийн маань өргөл мөнхийн зул болгон бадраах чин эрмэлзэлтэй хүн дээ. Хамтарч ажиллах залуучуудын шижигнэсэн баг надад бий. Голдуу миний шавь нар. Бид ДБЭТ-ийн тайзан дээр “Гамлет” жүжгийг тоглож явсан улс шүү. До.Цэнджавын “Хөх жавар” туужаар кино хийе гэж бид хоёр олон жил ярьж, мөрөөдөж явна. До.Цэнджав туужийнхаа сэдвээр гайгүй аятайхан шинэ кино зохиол бичээд бэлэн болгочихсон.

- Кино найруулагчаар ажиллаж байгаа залуучууддаа юу гэж хэлмээр байна вэ?

- Миний ганц дургүй юм хүнд сургаал айлдах. Би хүүхдүүддээ ч нэг их сургаал хэлж үглээд байдаггүй юм. Түрүүнд хэлсэн найруулагч гэдэг номоор сурдаггүй, төрдөг мэргэжилээ гэж. Төрөх л ёстой гэж боддог. Одоо ч намайг киноны гэхээсээ илүү телевизийн Жийгээ гэх болж дээ. Энэнд би баярлаж явдаг. Дашрамд хэлэхэд би Үндэсний Олон нийтийн телевизээ хаяа сайтай айл гэж

боддог. Нэвтрүүлгийн зөвлөлд олон жил боллоо. “Одод тохиох мөч” нэвтрүүлгийг хөтөлж байна. Би хувьдаа Монголын хөгжлийг оюуны чадавхи л аварна гэж бодож явдаг. Хил дамнасан наймаа хийгээд, газрынхаа хэвлийг замбараагүй ухаад улс хөгжихгүй. Хойч үеийнхээ өмнө л бага нүгэл хураах ёстой доо. Хүн төрөлхтөн хойч ирээдүйнхээ төлөө алсыг харж амьдрах ёстой бус уу...

Кино урлагийн талаар сонирхолтой ярилцлага өгсөн танд баярлалаа

“Цаг төр хүмүүс” сэтгүүл. 2010 он. №3

“Чонон сүлд” монголчуудын ширээний ном болно гэдэгт эргэлзэхгүй байна



Хятадын алдарт зохиолч Зян Рун, найз Го.Акимын хамт 2009 он

Хятадын нэрт зохиолч Зян Рунг яг нэг жил нэг сарын өмнө ийн өгүүлж байсан нь биеллээ олж нэрт орчуулагч Д.Болдбаатар орчуулж “Монсудар” хэвлэлийн газраас эрхлэн гаргасан “Чонон сүлд” ном уншигчдыг татан дагуулж байна.

Монголд анх ирэхэд нь Бээжингээс номын садан маань надад найдсаны учир онгоцны буудал дээр тосон авч танилцаж, Г.Аким гуайтай уулзуулж, Дорнод Монголын уудам тал нутгаар хамтдаа аялж явахдаа энэ хүний алдартай зохиолын тухай илүү их ойлгосон юм.

Дэлхийн сонгодог зохиолуудаар уншигчдынхаа оюуны гэгээн мэлмийг мялаасан “Монсудар” хэвлэлийн газрынхан 51 дахь ботиороо “Чонон сүлд” номыг сонгож, нэг ч сурталчилгааны хуудас тараалгүйгээр шилдэг номын жагсаалтыг тэргүүлж эхэллээ. Монгол хэлээр хэвлэгдсэн тухайд зохиолч “Энэ нь Монгол чонын соёл өөрийн уугуул

оюун санааны эх нутаг болсон монголын талдаа эргэн ирж байгаа гэсэн үг юм. Үүнд би баярлавч баршгүй байгааг өгүүлэх юун” хэмээн өгүүлсэн захидал илгээсэн нь энгийн хэрэг биш санагдлаа.



“Монсудар” хэвлэлийн газраас эрхлэн гаргасан “Чонон сүлд” ном

ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн талын малчин айлд залуу халуун насандаа цөллөгдөн очиж аж төрсөн нь энэ бүтээл төрөх эхлэл болсон гэдэг. Энэ л үед үзсэн харсан бүхнээ үзэглэж, өөрийн туулж өнгөрүүлсэн амьдралаасаа сэдэвлэн, монгол чоно, хүн байгалийн харилцан шүтэлцээг тусгасан ном бичиж олон зуун монголчуудын ширээний ном болоод байгаа билээ.

“Номын түлхүүр” сэтгүүлийнхээ “Зохиолчтой ярилцах цаг” буландаа “Чонон сүлд” номын зохиогч Зян Рунтэй энэхүү ном монгол хэлээр хэвлэгдэн гарахаас яг нэг жил нэг сарын өмнө Монголд ирэх үед нь уулзаж ярилцсанаа товчлон хүргэж байна.

Монголд анх ирээд төрсөн сэтгэгдлээр тань энэхүү ярилцлагаа эхлэе.

Монголд ирэх хүсэл надад маш олон жилийн өмнөөс төрсөн. Боломж олдохгүй их удсан даа. Онгоцноос буулаа. Эргэн тойрон монгол хүн, цэлмэг хөх тэнгэртэй, олон төрлийн шувууд, зээр гөрөөстэй энэ сайхан нутгаас олз омог ихтэй буцах гэж байна. Би Дорнод Монголын уудам нутгаар аяллаа. Миний төсөөлж байснаас илүү сайхан санагдлаа. Дорнод аймгийн төв, Сэргэлэн сумаар очиж, зочломтгой халуун сэтгэлтэй монгол түмэнтэй уулзсандаа их бахархаж байна. Дөчин жилийн өмнө талын малчидтай хамт аж төрж байсан үеийг минь санагдуулам сайхан сэтгэгдэл төрлөө. Өөр хаана ч олж харамгүй зээр гөрөөс, зэрлэг ан амьтан элээ, хэрээ, тогоруу, бүргэд гээд жигүүртэн шувуудыг нь эгээ л дагаад нисчихсэнгүй (инээв). Замдаа машинаа хэд ч зогсоов доо.

- Та үргэлж онгон байгаль, ан амьтан, сайхан агаар цэнгэг ус гэж яриад байсан. Залуу насаа их дурсан санав уу. Дорнодын Сэргэлэн суманд очоод их л догдолж бахтай байх шиг санагдсан?

- Сэргэлэн суманд очиход би аргагүй залуу насаа дурссан. Хүмүүсийнх нь нүүрний төрх, настай хүмүүсийнх нь харц Шилийн голд амьдарч байсан үеийн хүмүүстэй дэндүү адилхан байсан шүү. Ялангуяа тэр малчин айлд байсан хүмүүс. Үзэмчин айл, үзэмчин хүмүүс тийм л сайхан хүмүүс байдаг даа. Жинхэнэ онгон байгаль гэдэг хотжилт, өөрчлөлт шинэчлэлтээс маш ангид байх ёстой. Өөрчлөлт шинэчлэл хөгжил гэдэг агаарын бохирдол, өвчин эмгэг, бухимдал, үзэл санааны дарамт гээд маш олон хэцүү байдлыг үүсгэж, амгалан тайван аж амьдралыг эвддэг. Тал нутаг малчны хотонд ахуйн маш олон тулгамдсан асуудлууд байдаг ч онгон байгаль, цэвэр агаар, тунгалаг ус гэдэг бол хүн, амьтанд юутай ч зүйрлэшгүй аз жаргал юм. Энэ бүхнээ хадгалж чадвал жаргал бөгөөд оюун

санааны хувьд ч гэсэн маш их эрх чөлөө аз жаргалыг эдлэж чаддаг. Онгон байгалиа хадгалж, орчин үеийн хөгжилтэй хослуулах нь дэлхий дахины анхаарлыг татдаг. Монголд шинэчлэлт нэгэнт эхэлж, Улаанбаатарт орчин үеийн барилга байгууламжууд, үйлдвэрлэл жинхэнэ хөгжил дэвшлээс их хол байгаа ч монголчууд хамгийн чухал нь цэвэр байгаль тал нутгаа хадгалан үлдээж чадсан байна. Тиймээс надад Дорнод Монголын тал нутаг миний дөчин жилийн өмнө сэтгэлд хадгалагдаж байсан сайхан дурсамжийг санагдууллаа. Хэнтий аймаг, Хэрлэн барсаар өртөөлөөд, үзэмчин ястангуудтайгаа уулзлаа. Сайхан байна. Хотны нохой нь хүртэл чоно төрхтэй байсан. Сонин байгаа биз (инээв).

- Азийн зохиолчдын 2007 оны шилдэг бүтээлийн шагнал авсан гайхалтай номынхоо тухай ярина уу. Нэрнээсээ эхлээд маш их сонирхолтой зүйлийг өгүүлж болох болов уу?

- Хятадын уламжлалт соёл сургаалд сайн муугийн бэлгэдэл байдаг. Сайн буюу буяны бэлгэдэл бол күнз, муу буюу нүглийн бэлгэдэл нь чоно. Чоно нь муу буюу нүгэл хилэнцийн бэлгэдэл болсон учир хятадын уламжлалт соёлд байж болшгүй гэж үздэг. Чоно бол маш олон муу юмны жишээ болж, чонон санаа чонон зүрхтэй гээд хэлц үгэнд ч муугаар жишээлүүлж, төлөөлүүлсэн юм их бий. Ад чөтгөрийн дүрийн илэрхийлэл болгож, ёс журамгүй, харгис хэрцгий, итгэлгүй гэж боддог. Би багаасаа хятадын уламжлалт соёлоо дагасан ч чонон тухай ойлголт бусад хүмүүсийнхээс арай өөр байж, маш нууцлаг санагдаж байсан. Чонон мөн чанар нь надад эгэлгүй санагддаг ч уламжлалт соёлын хүрээнд би ч чонон муу, нүгэлийн бэлгэдэл гэж үздэг байсан үе байдаг.

- Энэ ном дэлхийн олон хэлээр орчуулагдсан гэсэн. Аль хэлээр орчуулсан нь илүү сайн гэж үздэг вэ?

- Дэлхийн 32 хэлээр орчуулагдсан. Хамгийн сайн нь

герман хэлээр орчуулсан нь гэж ярьдаг. Англи, Япон хоёр нь бас их сайн гэж уншигчид нь хэлж байсан. Надад бол олон хэлээр гарч олон орны хүнд хүрсэн нь сайхан санагддаг. Орон орны нэртэй орчуулагчид чадах чинээгээрээ л орчуулсан даа.

- Го.Аким гуайтай танилцаж, “Тэнгэрийн нохой”-г их л оновчтой нэрлэсэнд нь баярлаж, та хоёр чонон тухай их сонирхолтой зүйлүүд ярьж байсан

- Тиймээ миний найз төдийгүй “Чоно багш” гэж хүндэлж байна. Чоно бол аргагүй л “Тэнгэрийн нохой” Би гадаадын улс орнуудын чонон тухай бичсэн тийм олон зохиолчтой

танилцаагүй ээ. Монгол зохиолчтой танилцаад сайхан байна. Их юм мэдэж авлаа. “Тэнгэрийн нохой” номыг өөрийн “Чонон сүлд” номоо хэвлүүлсэн хэвлэлийн компанид хэвлүүлэхээр болсон. Сайн орчуулагч л олно доо.

- Таны чонын тухай үзэл бодол хэзээнээс өөрчлөгдсөн бэ?

- Залуу насандаа тал нутагт очсоны дараа, маш богино хугацаанд бодол маань өөрчлөгдсөн. Өвөр монголчууд өөрсдийгөө чонотой зүйрлэх дуртай, эндэх монголчууд ямар байхыг бүү мэд. Шилийн голын монгол үндэстэнүүд намайг хан үндэстэн хүн болохоор таагүй байгаа сэтгэлээ илэрхийлж: “Танай хятад хүн ногоо иддэг, хонь адил, манай монголчууд мах иддэг, чоно адил” (монголоор хэлэв) байсан нь надад маш их цочроо өгсөн гэж хэлж болно. Уг нь муу хүнийг чонотой зүйрлүүлдэг байхад монголчууд яагаад өөрсдийгөө чонотой зүйрлэв, үүний цаана маш том соёл нуугдаж байна шүү гэдгийг би тэр үеэс мэдсэн дээ. Дараа нь би тал нутагт аж төрж олон чонотой тааралдаж, сонирхож, сүүлдээ өөрөө чоно тэжээж, улам гүнзгий ойлгож судлаж эхэлсэн. Энэ номын гол агуулга нь монгол үндэстний эртний түүх соёл. Мэдээж ганц номоор ийм том үндэстний бүх соёлыг үзүүлэхгүй ч чонын соёл нь монгол үндэстэний соёлын чухал хэсэггэдэг нь

тодорхой юм. Тодруулбал нарийхан утас шиг олон талт соёлын чухал зүйлийг бүгдийг холбосон гэж үздэг.



特克斯女士惠存

姜戎

2009年9月1日
于北京

Хятад хэлнээ гарсан "Чонон сүлд" ном зохиогчийн гарын үсэг

- Номонд чоно соёлыг баталж тодруулсан ямар зүйлийг өгүүлсэн бэ?

- Монгол хүн чоно хоёрын байгалийн харилцан шүтэлцээний хүрээнд чонын тухай үлгэр домгоос эхлээд цуцашгүй агаад сүрэглэн амьдрах нөхөрсөг чанар, хайр, тал нутагтайгаа зохицолдсон байгалийн зохилдолгоо гээд олон юм бий. Мөн малчдын хэдэн зуун жилийн турш чоныг шүтэж биширч ирсэн ёс заншилаар зогсохгүй агнах арга урынх нь тухай хүртэл өгүүлсэн байгаа.

- Энэ ном хэвлэгдэн гарснаар танд болон бусдад ямар нөлөө үзүүлсэн бэ?

- Миний хувийн амьдрал бол хуучин янзаараа. Харин энэ ном гарснаар хятад хүмүүсийн чонын тухай махчин,

зэрлэг амьтан гэдэгүзлийг өөрчилсөнд утга учир нь нь оршиж байгаа юм. Энэ номыг англи, франц, япон, герман зэрэг дэлхийн 30 гаруй хэлээр орчуулж, хэдэн сая хүн энэ номыгуншиж, чоно бол тэнгэрийн амьтан гэдэгүзлийг ойлгож байна. Дэлхийн хэдэн сая хүмүүс монгол үндэстний соёлыг ойлгож, нүүдэлчин ардын эгэлгүй аж амьдралаас бага ч болов мэдэж авсанд би баяртай байдаг.



Зохиолч Зян Рун, Францын нэрт кино найруулагч Жан Жак Аной нар Дорнод аймаг Сэргэлэн сум 2009 он

- Хятадад зарим үндэстнүүд энэ номыг эсэргүүцдэггэсэн. Энэ тухай тодруулбал ?

- Бүх юм сайн сайхан ойлголт төрүүлэхгүй нь лавтай. Хятад улс 56 үндэстэнтэй. Монгол үндэстний энэ том соёлыггаргаж ирэхэд бусад үндэстэн өөрсдийгөө агуу их гэж үзэж шүтэн биширдэг амьтнаа жагсааж эхэлсэн. Үндэстэн бүхэн өөрсдийнхөө ёс заншлыг дэлгэн үзүүлэхээс гадна бусдынхаа соёлыг хүндэтгэх хэрэгтэй юм. Хятадад байгаа Хорчин монголчууд хүртэл их эсэргүүцсэн. Тэд яахав тариачид. Нүүдэлчний амьдралыг сайн мэдэхгүй хүмүүс. Энэ “Чонон сүлд” гэдэг нь намайг өөрөө зохиосон мэт муучлах үзэгдэл

эхэндээ байсан ч одоо дэлхий дахин уншаад ойлгож байна. Ирэх жилээс монгол хэлээр гаргаж Францын нэрт кино найруулагч Жан Жак Аной баримтат кино бүтээж дэлхийн үзэгчдэд үзүүлэх гэж байна. Бид энэ удаа Монголоос уран бүтээлийн олз омог ихтэй буцлаа. “Чонон сүлд” монголчуудын ширээний ном болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Ярилцсанд баярлалаа. Танд уран бүтээлийн амжилт хүсье

Номын түлхүүр сэтгүүл 2010-10 сар. Б.Төгсжаргал

Монгол соёл-хүн төрөлхтний үүсэлтэй Чацуу



Төрийн Соёрхолт, Ардын уран зохиолч, Соёлын Гавьяат Зүтгэлтэн Нэрт яруу найрагч
Б.Лхагвасүрэн

*Монгол соёл - хүн төрөлхтний үүсэлтэй
Чацуу*

Өвлийн богино өдрүүд үргэлжилж, өдөр бүр эцэс төгсгөлгүй үргэлжлэх ажилдаа яарсаар бид дахиад нэгэн шинэ онтой золгох гэж байна. Өв соёл уламжлалынхаа талаар олон хүмүүс үгээ хэлж, үйлсдээ тусгаж яваасай гэж боддог сэтгүүлчдийн нэг болохын хувьд Төрийн соёрхолт, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн нэрт яруу найрагч Бавуугийн Лхагвасүрэн гуайтай цөөн хором ярилцлаа. Уран бүтээлээрээ түмэн олондоо ах дүү шиг танигдаж, олон арван шилдэг шүлэг найраг, жүжиг бүтээл туурвисныг нь хэн хүнгүй сайн мэднэ. Б.Лхагвасүрэн гуайн монгол өв соёлын

талаархи хууч яриа уншигч танд нэгийг бодуулж, хоёрыг сануулах буй заа.

- Та монгол өв соёлоо хадгалж хамгаалах талаар ямар бодолтой явдаг вэ?

- Уламжлалт өв соёлоо хадгалж, дээдэлж чаддаггүй өв соёлгүй ард түмнийг ямар ард түмэн гэхэв дээ. Монголчуудын биет болоод биет бус соёлын өв хязгааргүй арвин. Энэ язгуур үүсэл нь нүүдэлчдийн соёл. Нүүдэлчдийн соёл гэдэг нь тэнэж яваад газар бүр гээгээд байсан биш, ямагт тээж явсан соёл юм. Энэ тээгдэж ирсэн их соёл өнөөдрийн хойч үеийнхээ өмнө хэрхэн хүндэтгэл хүлээж байна. Тэд ямар хүндэтгэлтэй хандаж байна вэ гэдгээр нь Монголын өнөөдрийн соёл хэмжигдэх учиртай. Хэл бичгээ бүрэн авч явж байгаагаар соёлоо бүрэн хамгаалсан болдоггүй. Эд өлгийн соёл, түүх соёлын дурсгалууд, үнэлж баршгүй соёлын өв гэж төрлүүд байдаг. Энийгээ хэрхэн хайрлаж, хамгаалж, хадгалан дэлхийд гайхуулж чадсанаараа том үндэстэн байдаг л даа. Монголчууд энэ их соёлыг эзэгнэж чадаж байгаа. Түүхийн олон цагүеийн уртад үрэгдэж, хорогдсон зүйл бий л дээ. Гэхдээ өвөг дээдэс минь бидэнд багагүй зүйл үлдээснийг монгол цустай, монгол зүрхтэй хүн бүхэн мартаж аргагүй.

Мөн өв соёлыг зөвхөн хайрлаж, хадгалахад оршдогтоо биш өнөөгийн нөхцөлд хэрхэн ойлгож, хэрэглэж хөгжүүлж байна вэ гэдэгт их асуудал байна. Жишээ нь: Дэлхийн зохионголын урлаг гэж дизайны урлаг бий. Уламжлалт ёсоо хамгийн их хадгалж бүр жинхэнэ уламжлалынхаа сүнстэй нь авч яваа улс бол Япон. Өнөө болтол маш нарийн хадгалж жинхэнэ уламжлалаар нь хөгжүүлсэн. Ийм орон олон байна.

Монголчуудын хувьд өөрийн улсынхаа сүлд, бэлгэ тэмдгийнхээ олон зүйлд үндэстнийхээ дүрслэх урлагийн их өвийг хөгжүүлсэн, бодож сэтгэсэн, товчхноор уламжлалаа авч чадсан юм их бага байгаад харамсдаг юмаа. Яагаад гэвэл Монголчууд ийм эртний их урлаг соёлын түүхтэй атлаадандаа шинэчлэгдсэн бусдыг дууриасан, өөрийнхийгөө мартсан хэлбэрт шилжсэн байгаад их харамсаж байна. Өв соёл бол яах аргагүй монгол хүн бүрийн өмч мөн. Өлгийд нь зүүсэн хонх, дээр нь зүүсэн үнэгнээс эхлээд бүгд л өөрийнх нь хувийн өмч. Иймээс Монгол хүн өөрийнхөө гэсэн юмандаа үнэнч байгаасай л гэж дандаа хэлдэг юм.

- Хот, хөдөөгийн ялгаа гарч, үүнтэй холбоотойгоор өв соёл, ёс заншлаа гээх үзэгдэл газар авч байгаатай та санал нийлэх үү?

- Хэрэглээний соёл хаанаас ч орж ирж болдог. Тэнэмэл соёл. Монгол ёс заншил яагаад хөдөөдөө үлдэж байна вэ гэвэл аливаа юм үүссэн газартаа л их хоргодомтгой байдаг гэсэн үг. Жишээ нь: Ээж аавдаа хүн хоргоддог шиг, модны үр жимс нь ёроолдоо унадаг шиг үүслийнхээ дэргэд л үлддэг. Тиймээс нүүдлийн соёл үүссэн орчиндоо л үлдэж байгаа нь тэр. Суурин иргэншил байгаагүй болохоор тэр бол байх газартаа л байна гэж би бодож байна. Бид нүүдлийн соёлтой ард түмэн. Одоо хөдөөдөө өв соёл занданшиж, уламжлалт зан үйл хөдөөдөө үлдэж байна гэж хэлэх дуртай хүн олон байна. Гэхдээ хот явахдаа харамсалтай нь өөрсдийнхөө ухаарлын мунхаглалаас үүдэн хальсаа орхисон хорхой шигуламжлалт ёсоо хөдөө орхиж, хот уруу цуглаж гуужиж байгаа нь тэнэглэл л дээ. Орчин үеийн хотод бүтээн байгуулах, сурах хөдөлмөрлөх, амь зуух, илүү байх гэсэн сонирхол их цуглардаг. Бидэн шиг нүүдлийн соёлтой улсад бол хамгийн тэнэг бөөгнөрөл. Том хотуудад бол юу ч орж гарч болно. Нүүгээд явж байгаа соёлд бол хэн гуай ч жингийн цуваан дундуур өөр тэмээ хавчуулж чадахгүйтэй адил. Тийм болохоор би яруу найрагчийн хувьд биш монгол хүний хувьд сэтгэл зовж байгаа асуудлаа хэлж байгаа юм. Тэгэхдээ хүн язгуур соёлоо хаана ч гэсэн авч явах ёстой болохоор хот хөдөө гэж яримааргүй байна. Тэр үүргээ биелүүлдэгсэн бол өв соёл хөдөөд үлдэж, хотод байхгүй болжээ гэсэн тэнэглэлд бид тулахгүй л байсан байхгүй юу. Мах цусандаа байгаа өөрсдийнхөө энэ өв соёлыг хадгалж байвал хаана ч байсан адилхан.



- Монголын хөөмийн урлагийгурд хөрш маань ЮНЕСКОД өөрсдийн өв соёл гэж бүртгүүлсэн нь хүн бүхний сэтгэлийг сэрдхийлгэлээ. Таны бодол?

- Хөөмийн урлагийг хоолойн цоор гэж нэрлээд ЮНЕСКОД Хятад бүртгүүлчихсэн. Одоо Монгол наадам, Ордосын хурим мэтийг бүртгүүлэх талаар олон асуудал дэгдэж байгаа гэсэн. Энэ бол том эмзэглэл. Яагаад гэвэл байгаа юмандаа эзэн болж чадаагүй хүмүүсийн хохь гэж хэлж болно. Энэ их олон боломжуудаа ашиглаж өөрийн юмаа өөрийнхөөрөө дэлхийд бүртгүүлэх ёстой байтал аливаа нэгэн залхаг албан хаагч, юм мэддэггүй хүмүүсээс болж сүйхээтэй хүмүүст булаалгаж байгаа юм. Энэ бол Монголын соёл урлагт ноднингоос эхэлж туссан том сүүдэр. Энэ мэтчилэн үндэснийхээ соёл урлагийг бусдын мэт болгоод албан ёсны болгуулаад явбал Монгол соёлын их өвийн мод нүцгэрнээ дээ. Энэ бол их харамсалтай. Би энд юу хэлэх гээд байна гэхээр чиний л юм бол тэрэндээ үнэнч бай гэж хэлмээр байгаа юм. Энийг яаж хадгалж,

яаж дэлхийд гаргах, дэлхийн хүндэтгэлийг олох, өөрийн гэснээ баталгаажуулах тал дээр Монголчууд мэрийн хичээмээр санагддаг. Энэ ажлыг муу, хариуцлагагүй хийх юм. Энэнээс цааш бид хичнээн сайхан юмаа ч алдах юм билээ. Хэн мэдэхэв. Бид чинь гарахын орон зайд биш, орохын орон зайд амьдрах ёстой хүмүүс шүү дээ. Соёл урлагийн хорооны дарга гэж байгаагийн хувьд надад илүү их бухимдал төрөх юм. Аминдаа миний эрхэлж байгаа ажил. Яаж ч хашгираад хожимдсон юмны хойноос хэцүү байна. Бас л дахиад хэдэн үеэр нь өөрт нь өвлүүлсэн зүйлийг алдана гэдэггөнөөдөр хэрэглэж байсан зүйлээ алдахаас илүү маш хэцүү байдаг.



Монголын утга зохиолын сод найрагч андууд

- Таны шүлэг дуу, жүжигт нүүдэлчний соёл, зан үйл, ахуй, үг хэллэг нэвт шингэсэн байдаг.


- Би ёс заншлыг номлогч биш. Ёс заншил, өв соёлоо хүндэтгэгч жирийн нэг иргэн. Энэ тухай олон шүлгийн мөрүүд, тодорхой өгүүлбэрүүд бишгүй хийж өгөх юм. Тэр болгон минь уншигчдад хэр мэдрэгдэж, ойлгогдож, авмаар юмыг нь хэлж өгч чадаж байна уу, тэд хэрэгтэй гэж үнэлж байна уу гэдэг бол оньсого л доо. Энэ талаар их чармайдаг. Цус ойртолтоос эхлээд

өв соёлынхоо тухай өчнөөн л их юм бичих юм. Уран зохиол баримтат биш болохоор үнэмшил багатай байдаг юмуу. Яруу найраг, гэдэг сэтгэлээс сэтгэлд хүрээд ухаарахуй юмуу бодохын

гүнзгийрэл гэдэгт яруу найраг жаахан шоовдорхон ордог юмуу гэж боддог. Хичнээн бодож хийсэн шүлэг байлаа ч бодолд очдоггүй байж болно. Сэтгэлийн юм сэтгэлд л хүрэх ёстой гэсэн хатуу ойлголтоор явсан болохоор энэ бүхнийхээ үр дүнг нэг их тооцож чадахгүй юм. Гэхдээ би Монголын уламжлалт ёс заншил өв соёлыг хадгалахын тулд нэмэр болохсон л гэж чармайж явдаг хүн. Энэ соёлоо Эртний Эллений болон Ром Римийн соёлоос хожуу соёл гэж боддоггүй. Хүн төрөлхтөн үүссэн цагаас эхлээд өнөөг хүрсэн өвгөн соёл гэж боддог.

- Эх хэлээ хадгалж хамгаалах талаар таны чин сэтгэлийг үгийг сонсоё.

- Хэл бол ямагт баяжиж, хорж байдаг. Монгол хэл бол гадаад хэлтэй харьцуулахад маш баялаг. Цаад хэл нь багадана уу гэхээс биш монгол хэл бол хэзээ ч багадахгүй. Хэрхэн эзэмшснээрээ тодорхойлогдоно. Хүн эх хэлээ илүү мэдэх нь чухал. Гадаад хэлийг гоёл гэж боддог хүмүүс эх хэлээ их эвддэг. Хэл бол сав савандаа, цус цусандаа байх ёстой. Хэл хэрэглэгдэхүүн учраас сурах ёстой гэж боддог. Хэл ухаантай үйлчлэгч, хэрэглэгдэхүүн байдаг. Ухааны зарц юм даа.



Нүүдэлчин түмнийхээ хэл соёлын тухайд сайхан ярилцсан танд баярлалаа. Уран бүтээл тань улам их ундарч, ухаан бодол тань улам саруулсах болтугай.

“Монгол туургатан” сэтгүүл.2009 он № 01

“Д.Сүхбаатар сан”-гийн тэргүүн МУ-ын гавьяат багш С.Лувсанноров



МУ-ын Гавьяат багш, “Д.Сүхбаатар сан”-гийн тэргүүн С.Лувсанноров

Жил жилийн сар шинийн өмнө жанжин Д.Сүхбаатарын төрсөн өдөр тохиодогуламжлалтай. Их жанжныхаа 115 жилийн ойгөргөн дэлгэр тэмдэглэж, нийслэл Улаанбаатар хотын төвд сүндэрлэх хөшөөнд нь хүндэтгэл үзүүлж, Засгийн газрын гишүүд болон бусад олон хүмүүс цэцэгөргөлөө. Мөн байгалийн түүхийн музейн танхимд гэрэл зургийн үзэсгэлэн нээн, М.Горькийн номын санд “Д.Сүхбаатар номын ертөнцөд” үзэсгэлэн гаргах зэрэг урлаг соёлын үйл явдлууд болсон юм.

Жил бүр уламжлал болгон “Д.Сүхбаатар сан”-гийн шагнал гардуулан, шилдэг оюутнуудад урамшуулал олгодог нь их жанжнаа алдаршуулах, судлал шинжлэлийг хөгжүүлэх,

залуу үедээ таниулахад их үр дүнтэй ажил байдаг. Энэ бүхнийг санаачлан зохион байгуулдаг “Д.Сүхбаатар сан”-г Сүхбаатар аймгийн Дарьганга сумын уугуул, Гавьяат багш, түүхч Л.Лувсанноров гуай тэргүүлдэг билээ.

Буянтай буурал маань их жанжныхаа байгуулсан гавьяаг бахархан дуулж, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд үнэтэй хувь нэмэр оруулахуйц “Монголын цэргийн нэрт жанжин Д.Сүхбаатарын ураг төрлийнхөн” номыгуншигчдын гар дээр тавьж, сонин содон түүхийг өгүүлж байна. Нутгийнхаа түүх соёл, өв уламжлалын тухай хэд хэдэн ном бүтээл туурвисан нь оюуны томоохон өв юм.

Наян насны сүүдэр зооглож байгаа ч их жанжныхаа үйлсийгүргэлжлүүлж насаараа залгамж халаа үедээ зааж сургаж, үлгэрлэн дууриаж ирсэн ахмад багш маань өнгөрсөн жил “МУ-ын Гавьяат багш” цол хүртсэнд нутгийн зон олон нь баяртай байна.

Их жанжны ойн баярын босгон дээр “Д.Сүхбаатар сан”-ийн тэргүүн, МУ-ын гавьяат багш

С.Лувсанноровтой уулзсан товч ярилцлагаа та бүхэндээ хүргэе.

- Юуны өмнө танд “МУ-ын гавьяат багш” хэмээх эрхэм хүндтэй шагнал хүртсэнд тань баяр хүргэе. Нутгийн ахан дүүс, шавь нартаа их жанжны түүхт ой, сар шинийн баярын мэнд хүргэж, ерөөл өргөнө үү?

- Алдар цуут жанжны нутгийн ахмад буурлууд, анд нөхдийнхөө түмэн амгаланг айлтгая. Ардын нам, төрийг үүсгэн байгуулагчдын нэг, Монголын цэрэг армийгүндэслэгч, цэргийн гарамгай жанжин Дамдины Сүхбаатарынхаа бүтээсэн үйлс, байгуулсан гавьяагаар бахархан ажил хөдөлмөр нь өөдөлж, урт насалж, удаан жаргахыг ерөөж байна. Их жанжны уугуул нутгийн иргэд, өвгөд дээдэс, өтгөс буурлууддаа Д.Сүхбаатарын мэндэлсний 115 жилийн ой, амны хишиг дэлгэрэх ам цагаан хулгана жилийн сар шинийн мэнд дэвшүүлэн, нас буянаа нэмж намтар түүхээ арвижуулж, үр хүүхдийнхээ үйлсийн сайхныгүзэж, үзэсгэлэнт эх орныхоо хөгжилд тус нэмэр хүргэн, залуу

үеийнхэндээ үнэтэй сургамжаа хайрлаж явахын зэрэгцээ энэ жилийн УИХ-ын сонгуульд чин зоригт тууштай эх оронч Д.Сүхбаатар шигээ үнэнч шударгуу төрд түшиг болох түмэн олныхоо итгэлийг даах шилдэг хүнийг сонгон амар түвшин аз жаргалтай байхын ерөөл өргөө.



-“Д.Сүхбаатар сан” хэдэн онд байгуулагдсан вэ? 1993 онд Д.Сүхбаатарын мэндэлсний 100

жилийн ойгоор байгуулагдсан. МАХН-ын удирдах зөвлөл, судлаач, эрдэмтэд, нэрэмжит газруудын санаачлагаар үүсгэн байгуулагдсан тус сангийн зорилго нь их жанжны үйл хэрэг, байгуулсан гавьяаг нь үнэн мөнөөр нь таниулж, зөв сурталчилахад оршиж байгаа юм. 1990-ээд оноос хийсэн бүтээснийг нь үгүйсгэх хандлага гарсныг хүмүүс мэдэж байгаа. Тус сангаас нэрэмжит шагнал бий болгож, Д.Сүхбаатар болон түүний нөхдийн амьдралын тухай ном бүтээж, тэмдэглэлт ойн баярын өдрөөр нь олон сайхан ажил зохион байгуулах гээд

багагүй ажлуудыг хийгээд байгаа. “Монгол орноо тэгш журамтай баян хүчирхэгүлс болгох” Д.Сүхбаатарын үзэл санааг хэрэгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж байгаа малчин, ажилчин, эрдэмтэн, зохиолчид, төрийн зүтгэлтэн, Сүхбаатар судлал”-ын 30-аад хүмүүсийг тус сангийн шагналаар шагнаад байгаа юм.

- Түүхт ойг нь тохиолдуулан тус сангаас ямар ажлуудыг хийсэн бэ?

- Энэ жил 115 жилийн тэгш ойгоор МАХН, Засгийн газар, Д.Сүхбаатар судлаач эрдэмтэд жанжны нэрэмжит газрууд хамтран өргөн тэмдэглэлээ. Аймгийн төвд байдаг Д.Сүхбаатар жанжны талбай дахь хөшөөг хүрлээр сольж хийх, Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд байгаа жанжны музейг шинэчлэх, Үндэсний түүхийн музейд Сүхбаатарын үйл ажиллагааг харуулсан үзвэрийн буланг сэргээх зэрэг ажлууд хийлээ. Батлан Хамгаалах Их сургууль, Дотоодын цэргийн 05-р одонт хороо, нийслэлийн 2-р дунд сургууль зэрэг газрыг Засгийн газрын шагнал, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа. Мөн жанжны үйл амьдралыг судалдаг эрдэмтэн О.Пүрэв, Б.Дашзэвэг, зохиолч Х.Зандраабайды, АУ-ны доктор профессор М.Шагдарсүрэн нарын дөрвөн хүнийг “Д.Сүхбаатар сан”-гийнхаа шагналыг хүртээсэн. Жанжны гэргий С.Янжмаагийн нэрэмжит 19-р цэцэрлэггэж байдаг. Иймээс энд дурьдах ёстой нэг онцлогүйл явдал бол Чингэлтэй дүүргээс С.Янжмаагийн амьдарч байсан байшингийн хананд дурсгалын самбар байрлуулсан нь сайхан хэрэггэж бодож баярлаж байна.

Баярлалаа. Их жанжныхаа үйлсийгүргэлжүүлэх гэгээн үйлсэд тань амжилт хүсье.

Та сар шинэдээ сайхан шинэлээрэй.

2008.02. “Шинэ Сүхбаатар” сонин

580 гаруй ханз үсэг сайтар эзэмшвэл Хятадаар сонин хэвлэл бараг уншдаг болно



МУИС-ийн Күнзийн Институтын захирал асан Ли Мин Чи

21-р зуун Хятадын зуун болно гэж дэлхий дахин шуугиж байгаа энэ үед Монголчууд бидэнд урд хөршийнхөө ээдрээтэй ханз үсгийн адармааг тайлж, сурч мэдэх хэрэгцээ зайлшгүй тулгарч байна. Улсын хэмжээнд 30 гаруй их дээд сургууль, мөн бага дунд сургууль, олон арван түр дамжаанууд хичээллэж, хятад хэл суралцагчдын тоо нэмэгдсээр байгаа юм.

2007 оны 6-р сард Хятад улсын Гадаадад хятад хэлний сургалт эрхлэх улсын алба”, Монгол улсад суугаа Хятадын элчин сайдын яамны дэмжлэгтэй МУИС-ийн дэргэд Күнзийн Институт байгуулагдсан билээ. Дэлхийн 70-аад улсад нийтдээ 250 гаруй институт байдаг. “Монголд суугаа гадаадынхан” буландаа тус институтын захирал Ли Минчи багшийгурилаа.

- Күнзийн Институт Хятад хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулж эхэллээ. Үр дүн нь ямар байна вэ?

- Байгуулагдсан цагаасаа олон салбарын хүмүүсийн дэмжлэгээр өдий зэрэгт хүрч, цаашид улам өргөн цар хүрээтэй ажиллах сайхан боломж бүрдэж байна. Күнз бол Хятадын эртний агуу их сэтгэгч, соён гэгээрүүлэгч, нэрт сурган хүмүүжүүлэгч. Ийм их хүнээр овоглон ажиллаж байгаагийн хувьд “Күнз” хэмээх эрхэм хүндтэй нэрийг дааж явах учиртай. Монголчуудынхаа хятад хэл сурч, хятадын соёлыг таньж мэдэх хүслийг нь гүйцэлдүүлэхэд хувь нэмрээ оруулж, хоёр орны ард түмний найрамдалт харилцаагулам ойртуулахыг хүсдэг.

- Монголчууд хөрш орныхоо хэл соёлыг судлах, суралцахдаа ямар түвшинд байна вэ? Хятад хэл сурахад сургалтын ямар аргыг хэрэглэвэл зохистой бол?

- Өнөөдөр дэлхийн эдийн засаг даяарших хандлагатай байгаа ч, хэл, соёл нь олон ургальч байна. Манай хоёр орны эдийн засаг, соёлын харилцаа, найрамдал хамтын ажиллагааны хүрээ улам өргөжин тэлэхийн хэрээр, монголчууд хятад хэлийг сонирхон сурах явдал жилээс жилд нэмэгдэж байна. Бусад хэлтэй харьцуулвал ялгарах хамгийн том онцлог нь ханз үсэг. Нэгэн зүйлийн утга бичиг болох бөгөөд үсэг бүхэн тодорхой утга санаа агуулж байдаг. Хүмүүс ханз сурахад маш хэцүү гэж зүрхшээдэг. 580 гаруй ханз тогтоовол, хятадын сонин хэвлэлийн нийтлэлийн 80-аас дээш хувийгуншиж чаддаг гэсэн үг бий. Үндсэн гол ханзнуудын утга санааг ойлгож аваад, их уншиж, их бичвэл ханз үсэг бидний төсөөлдөг шиг тийм ч хэцүү

бэрх зүйл биш.

- Күнзийн Институтын цаашид хийх ажлын талаар мэдээлэл өгнө үү?

- МУИС-ийн Күнзийн Институтын эрхэм зорилгыг “үйлчилгээ, үлгэр жишээ, солилцоо, хөгжил” гэж хэлж болно. Энэ нь МУИС-ийн хятад хэлний сургалт, судалгааны ажилтай нийцэж, үлгэр жишээ байж, хятад

хэлний сургалт судалгаа явуулах, хятад хэлний багш нарыг давтан бэлтгэх гол төв нь байж, хятад монголын боловсрол соёлын солилцоонд тус хүргэх гүүр болох, институтын сургалт судалгааны түвшингулам дээшлүүлж, тогтвортой хөгжлийг хангах гэсэн утгыг агуулж байгаа юм.

- Күнзийн Институт өдөр тутмын сургалтаас гадна соёлын хүрээний үйл ажиллагаа явуулдаг уу?

- Бид сар тутам “Күнзийн Институтын форум” зохиож, 5 сард “Хятадын соёлын 7 хоног”, “Хятад хэлний баяр” зэргийг зохионо. Сонирхсон бүх хүнд манай хаалга нээлттэй байх болно. Түүнчлэн Хятадын эртний сонгодог зохиолыг орчуулж хэвлэх, хятад хэлний сурах бичгийг монголчлохоос гадна, Монголын хятад хэлний багш нарын сургалтыг зохион байгуулна. Манай институт Монголын хятад хэлний сургалт, судалгааны түшиц газар, хятад хэлний багш нарыг бэлтгэх төв, хятад монголын боловсрол соёлын солилцооны гүүр байгаасай гэж бид хүсдэг юм.

- Монголд ирээд байгалийн үзэсгэлэнт сайхан газруудаар их аялав уу?

- Тэрэлжийн үзэсгэлэнт газар, Чингисийн хүрээ, Манзуширийн хийд, Богдын музей, Гандан хийд, Баянбуурал гээд олон газраар аялсан. Очсон газар бүхэн надад сайхан сэтгэгдэл төрүүлж, Монголын өнө эртний гайхамшигт соёлыг мэдэрч явлаа. Очмоор газар их ч, цаг хугацааны боломж гарахгүй юм. Одоо Монголын ёс заншилд дасаад, харилцааны ёс журам, хоол унд, соёл зэрэгт нэгэнт дасчээ. Тэгээд ч энд нэлээд удаан ажиллаж, амьдарч байна шүү дээ.

- Та өөрөө Күнзийн нутагт төрж өссөн үү?

- Тиймээ. Би Хятадын Шаньдун мужаас ирсэн. Эртний хятадын Хавар Намар Байлдаант улсын үед, Одоогийн Шаньдуны нутагт Чи улс, Луулс гэсэн хоёр гол ханлиг

улс оршиж байсан түүхтэй. Тиймээс Шаньдунийг бас Чи Лугэж нэрлэдэг. Одоогийн Шаньдун мужийн товчилсон нэрийг Лу хэмээдэг. Хятадын эртний нэрт сэтгэгч, соён гэгээрүүлэгч Күнз нь тэр үеийн Луулсын хүн юм. Энэ нь одоогийн шаньдуны Чүфү хот юм. Шаньдун нь Хятадын эдийн засаг соёлын томоохон мужаас гадна, соёлын хувьд Күнз гол төлөөлөл нь болсон Луулсын үеийн соёлтой холбогддог юм.

- Та манай уншигчдад Күнзийн талаар товч хэлж өгөхгүй юу?

- Күнз бол Хятадын агуу их соён гэгээрүүлэгч, сэтгэгч юм. Түүнээр төлөөлүүлсэн Күнзийн суртал хэдэн мянган жилийн туршид хятадын улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, урлаг зэрэг олон салбарт гүн гүнзгий нөлөө үзүүлсээр ирсэн түүхтэй. Күнз хятадын эртний “зохирол” хэмээх соёл иргэншлийг анх дэвшүүлсэн. “Эв зохиролтой”, “Эвсэг найртай”, “Энх амгалан” байхын чухлыг дурдаж, “Санаа зохирохуй”-г номлосон байдаг. Энэ нь дэлхий ертөнц хийгээд нийгмийн энх тайван, эв зохиролт хөгжлийн тухай номлож, дэлхий улс үндэстнүүд эв зохирол, эе найрын хүрээнд, хөгжлийн өөр өөр замаар замнаж болох тухай сургасан юм. Эдгээр сэтгэлгээ нь өнөөдрийг хүртэл цагүеэ элээж хуучраагүй байна. Тиймээс Күнзийг хятадын соён гэгээрүүлэх хийгээд сэтгэлгээний түүхийн гэрэлт хөшөө гэж хэлж болно. Эдүгээ Хятадад төдийгүй дэлхий дахинаа маш олон хүн Күнзийн сонгодог бүтээл, сэтгэлгээг судалж, Күнзийн суртал нь хятад хүний сэтгэлгээ хийгээд ажил үйлд нөлөөлсөөр байна.

- Күнзийн сонгодог судар хийгээд шавь нарын тухай яривал манай уншигчдад сонин байх болов уу?

- Түүх шастирт өгүүлснээр, Күнз 3000 шавьтай, ихэд тоодоггарын шавь 72 байсан гэдэг. Күнзээс өмнө “ордон хүрээнээ суралцдаг”, суралцахуйд “ялгавартай” байжээ. Өөрөөр хэлбэл, сурч боловсрох эрх зөвхөн

цөөхөн ноёд язгууртны мэдэлд байсан хэрэг. Күнз “Эрдэм сургахуйд элдэв ялгал үгүй” хэмээн сургаж, “ордон хүрээнээ суралцдаг” ёсыг эвдэж, хувь хүний эрдэмд суралцах, боловсрол олох хүрээ хязгаарыг тэлсэн түүх нь Хятадын боловсрол соёлын үйлсэд түүний оруулсан агуу их хувь нэмэр юм. Күнз шавь нараа “хүн хүний чадварт тааруулан сургах”-ыг ихэд чухалчилдаг байжээ. Сургалтын ийм сэтгэлгээгөнөөгийн өндөрлөгөөс харахад маш зөв болох нь харагдаж байна. Күнз өтөл насандаа “Шүлэглэлт ном”, “Засагт ном”, “Ёслолт ном”, “Зурхайт ном”, “Хөгжимт ном”, Хавар намар” зэрэг зургаан сонгодог судрыг эмхтгэн бүтээсэн түүхтэй. Эдгээр сонгодог судар туурвил нь өнөөдөр эртний улс төр, эдийн засаг, утга зохиол, гүн ухааныг судлах чухал хэрэглэгдэхүүн болдог бөгөөд нэн үнэ цэнэтэй өв юм.

Ярилцлага сонирхолтой байлаа. Танд амжилт хүсье.

Б.Төгсжаргал 2009.12. “Цаг төр хүмүүс” сэтгүүл

Миний уран бичлэг бол зохиолчийн гар бичмэл гэдэг талаасаа чухал юм



Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, Яруу найрагч Г.Мэнд-Ооёо

Г.Мэнд-Ооёо, О.Дашбалбар, Д.Нямсүрэн. Хүүхэд балчир байхаас аавтай минь ах дүү, багш шавь бололцсон энэ эрхэм хүмүүсийн тухай би бусад хүүхдүүдээс арай илүү мэддэг. Манай гэрт зочлон ирдэг байсан олон, олон найрагчдаас аавтай минь насан туршийн номын садан нөхөр бололцон өнө хойчдоо ч нутагус, хуучин дурсамж, хуур ятга эгшиглэн дуулах мэт гэгээн мөр бадгаар дүүрэн шүлэг найргууд нь аав амьтай гэгээн бодлуудыгүргэлж сэргээдэг.

Тэдний маань нэг Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн Г.Мэнд-Ооёо ах он, онд олон шинэ бүтээлүүдийн нээлт хийж, их найрагч Явуу багшийнхаа эрт цагт зөгнөн бэлгэдэж хэлсэн шүлэг найргийн үнэ цэн, үнэнийг мэдрүүлж хүлэг морьтойгоо, шүлэг найрагтайгаа алдрын алтан титэм тэргүүндээ асаагаад дэлхийн тавцан дээр зогсож байна.

Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, яруу найрагч Г.Мэнд-Ооёо хэмээх эрхэм алдраараа түүчээлэн өдгөө дэлхийн хүмүүн болсон юм. Шинэ оны эхээр уран бүтээлийн хишигөдрүүдээ зохион байгуулж, ном соёлын хишиг түгээсэн нь урлаг соёлын төдийгүй эрдэмтэн мэргэд, уран бүтээлчид, хойч үе залуусдаа үлгэр дууриал болохуйц үйл явдал боллоо.

Монгол соёлоо дэлгэрүүлж, эх хэлнийхээ эрдэнэсийн их сан хөмрөгийгуйгагүй онгичин, ухааны далайгаар өөрийн урлаж бүтээсэн цэнхэр өнгөт завиар яв явсаар дэлхийн тавцанд гарах гэрэлт замыг төвөггүй олсон нь түүний зөв сэтгэлээс үүдэлтэй болов уу.

“Он цаг нисэн ирнэм” хэмээн тэмүүлж, “Он цаг нисэн одном” хэмээн гуниглавч,

Эрин зуунуудыг эрхилсэн хуучин судрын хуудсанд

Элэнц хуланц дээдсийн минь оюун сүнс буй


Хөлөөрөө яваад хүрэхгүй элин галавын тэртээд

Хэлээрээ улаа нэхээд хүрэхийн ерөөл буй

хэмээн шүлэглэж, монгол шүлэг найргийн удис шидийг улам тодорхой, илүү гүнзгий таниулсан өдрүүд байлаа. Монгол шүлгийн айзам хэмнэл, монгол бичиг соёл өв уламжлалаараа бахархаж байгаагаа бүтээл бүхнээрээ нотлон харуулсан.

Дарьгангын яруу найргийн дэг сургуулиас төрөн гарсан, томоохон төлөөлөгчдийн нэг Г.Мэнд-Ооёо найрагч анх 1980 онд Монголын утга зохиолын их өргөөнд “Бодлын шувуу” болон нисэн ирж, тоонон дээр нь удаан эргэлдэлгүй, хойморт нь заларсан эрхэм хүмүүн.

“Гэрэлтэх агшин бүр”, “Хэсэг цагаан манан” гэдэг шинэ шүлгийн түүврүүдээ гаргах хүртлээ яруу найрагчийн анги ондоо амьдралаасаа уйдаж ухралгүй харин ч үе тэнгийн нөхөд болоод өнөө цагийн найрагч залуусаа дагуулан Дэлхийн яруу найргийн томоос том харш уруу хөтөлж орсон түүхэн гавьяатай.



“Утгын болор сүм” үзэсгэлэнгийн урилга 2012-02 сар

1980-аад оны сүүл үеэс монголын түүх соёлын өв, үндэсний бичиг, ном соёлыг хамгаалж сэргээх “Мигжэд Жанрайсаг” хөтөлбөр, соёл эрдэм шинжилгээний “Сувдан сондор” аялал, “Бичиг соёл” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, 2006 онд дэлхийн яруу найрагчдын 26-р их хурлыг Монголдоо амжилттай зохион байгуулсан гээд олон сайхан оюунлаг, гэгээнлэгүйл бүтээснийг хуурдаж дуулан, хуучилж яриад ч дуусашгүй агаад он цагийн саалтад ч тодрон

гэрэлтэхийн ерөөл билэгтэй.

Бага насандаа хонины хишигөдрийг олонтаа өнгөрөөж уудам тал, уул ус, малын бэлчээрээс уран бүтээлийн ундрам

сэдэл санаагаа олж найраг шүлгийн мөрүүдээ тэрлэж, 1991 онд “Бичиг соёлын хишиг” өдрийг анх санаачлан, жил жилийн хавар номын хишгийг Монгол даяараа өрнүүлэх болсон билээ.

Ерөнхийлөгчийн зарлигаар “Бичигүсгийн баяр” болон хишиг соёл гэдэг үг хасагдсанд нь сэтгэлийн тохь тух алддагаа ч нуусангүй. Хишиггэдэг үгийн үнэ цэнэ утга учрыг ихэд бэлгэшээн бодож явдгаа үзэг нэгтнүүд номын садангуудтайгаа илэн далангүй хуваалцан уншигч олондоо оюун билгийн өглөг хишгээ хүртээсэн энэ өдрүүд

Одон ертөнц, түмэн бодис намайг нээнэм

Одох ирэх цаг хугацаа намайг нээнэм

хэмээх шүлгийг нь хүн бүхэн өөр өөрийнхөөрөө нээж ойлгох шидийг бүрдүүлсэн юм.

“Г.Мэнд-Ооёогийн уран бүтээлийн хишигөдрүүд” хөтөлбөрийг анх түүний анд нөхөд хамтран зүтгэгчид нь санаачилж, яруу найраг, бичиг соёл, утга зохиол оюун билгийн ертөнцийг нь уншигч олонд цогц байдлаар танилцуулах боломжийг бүрдүүлж буйгаараа онцлогтой. Жирийн шүлэгч залуу байхдаа “Дэлхий ээж тандаа би хайртай” хэмээн шүлэглэсэн нь мянган сонгодог шад мөрүүд, зөөлөн ай хэмнэлтэй нь хөтөлсөөр дэлхийн тавцанд хүрч “Алдрын алтан титэм” тэргүүнд нь асаалаа.

Дэлхий ээжээ чин зүрхнээсээ хайрласан найрагчийг дэлхий дахин хүлээн зөвшөөрч улам хайрлаж, найргийн онгодыг нь тэтгэсэн нь ерийн хэрэг биш байлаа. Энэ бүхэн “Үгийн эрчим хүчний шидэт долгион” лекцийн нь утга агуулгын хураангуй мэт санагдаж, үгийн хүч чадлыгулам бататгасан юм. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Энэ сайхан дуугаа англиар орчуулан дэлхий нийтийн дуу болгох хэрэгтэй” хэмээн урам хайрласан тухай шинэ номынхоо нээлтийн үеэр Г.Мэнд-Ооёо найрагч номын садангууддаа баяр хөөртэй дуулгасан. “Дэлхий ээж тандаа би хайртай” хэмээх дөрвөн зүгийг бэлгэдэх дөрвөн эрдэнэ мэт энэ сайхан үгээр нь авьяаслагуран бүтээлч залуу тамга сийлж,

эхний дардасыг нь Ерөнхийлөгчид, удаахийг нь хөгжмийн зохиолч Р.Энхбазарт бэлэглэсэн нь даруухан зантай, дориун их бүтээлтэй уран бүтээлч андаа бусдад дахин нээж таниулсан юм.



Яруу найрагч Г,Мэнд-Ооёогийн “Алдрын алтан титэм”

Хишигөдрүүдийн үеэр “Утгын болор сүм”, уран бичлэг, бичиг соёлын үзэсгэлэн, “Зөөлөн ай” яруу найргийн уншлага, яруу найргийн багц шинэ ном, CD, “Үгийн эрчим хүчний шидэт долгион” яруу найрагчийн лекц, яруу найргийн үнэт зүйлсийн тухай эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт ярилцлага зэрэг олон үйл явдал болж манай улсын оюуны сор болсон эрдэмтэн мэргэд хөлхөлдөж, билигтэй сайхан үгээр эрхилэн хэлхэлдэж байсныг хэлэхийн учир буй.

Энэ бүхэн монголын ард түмний эрдэм билэг, оюун соёлын өв, уламжлалыг эрхэмлэн дээдлэхийн чухлыг эргэн санагалзуулахын хамт эдүгээ цагүед нийгмийн хөгжил хийгээд ард түмнийхээ гэгээрлийн үйлсэд уран бүтээлч, зохиолч, яруу найрагч хүн яаж тэдэнд урам зориг, эрч хүч өгч болох вэ? гэдэг санааг дэвшүүлж байгаагаараа онцлогтойг найрагч дурьдлаа.

“Утгын болор сүм” үзэсгэлэнгээрээ монголын бичиг соёлын сэргэн мандалт, орчин үеийн уран бичлэгийн сэтгэлгээ болон чиг хандлагыг тодорхойлон, өвөг дээдэс нүүдэлчин монголчуудын өв уламжлал, ХХ зуунд хэсэг хугацаанд тасарсны дараах ХХI зууны эхний жилүүдэд эргэн эрчимтэй сэргэж байгаагийн дүр төрхийг илэрхийлж, залуу үеэ, өв уламжлалаа улам сайн залгамжилж ирээдүй уруу өвөг дээдсийнхээ бичиг соёлыг тод томруунаар авч ороосой гэсэн хүслийнх нь тухай хуучилан ярилцснаа уншигч та бүхэндээ хүргэе.

- Таны уран бүтээлийн хишигөдрүүд тун өвөрмөц, өргөн цар хүрээтэй шинэлэг боллоо. Улам их эрч хүч авч, урам зориг тань сэргэсэн болов уу?

- Их сайхан боллоо. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нээлтэнд оролцож тууз хайчилсан нь Монголын төрөөс өв уламжлал, бичиг соёл, яруу найраг, утга зохиолоо анхааран харж байгаагийн тодхон жишээ гэж бодож байна. Долоо хоногийн турш өдөр бүр хөл хөдөлгөөнтэй байлаа. Монголын бичиг соёл, оюуны хүмүүс, уран бүтээлчид уншигчид дэмжигчид их ирлээ. Ийм үзэсгэлэнг Монголдоо төдийгүй хилийн чинадад Монгол соёл өв уламжлалаа сурталчилах зорилгоор гаргаж болно гэж бодогдож байна. Хүмүүс ч санал тавьж байна. Ер нь манайд үндэсний бичиг соёлоо сурталчилах музей байтугай танхим ч байхгүй. Ирээдүйд уран бүтээлийн томоохон өргөө цогцолборыг сүндэрлүүлэх эхийг бий болгох гэсэн гол санааг

маань хүмүүс дэмжиж байна. Ер нь аль ч улс оронд эх бичгийн орд өргөө байдаггэсэн гол утга санааг агуулсан. Долоо хоногийн турш өв соёл бичигүсгээ хөгжүүлэх, яруу найрагута зохиолоо үндэснийхээ бичигүсэгтэй яруу найргийг найрсуулж ирээдүй зүг руу авч орж болох талаар бодол санаагаа хуваалцаж, улам лавшруулж авлаа. Энэ чухал гэж би бодож байна.



Яруу найрагч Г.Мэнд-Ооёогийн тамганы цуглуулга

- Үзэсгэлэнд өнөө цагийн уран бичлэгийн гол төлөөлөгчдийн бүтээлээс гадна таны цуглуулгын сан хөмрөгийн ная орчим бүтээл дэлгэгджээ. Та өөрөө ч бас чамгүй уран бичлэгтэн болохоо харуулж ач хүүгийн тань бүтээл хүртэл тавигдсан нь сонирхол татлаа.

Миний уран бичлэг бол зохиолчийн гар бичмэл гэдэг талаасаа чухал юм. Ер нь зохиолч яруу найрагчид үндэснийхээ бичиг соёл, хэл сэтгэлгээгээ эзэмших ёстой. Өөрийнхөө яруу найргийг төрөлх бичгээрээ илэрхийлж, бийрийн торгон үзүүрээр яагаад буулгаж болдоггүй юм бэ гэж бодогддог байсан. Ингээд каллиграфийн төрөл уруу орсон. Бидний уламжлалд бийр бэхсийг эзэмших язгуур нь байгаа учраас зохиолч үүнийг эзэмшиж болно гэж боддог. Зохиолчийн гар бичмэл бол асар их үнэтэй шүү дээ. Дахин хэзээ ч давтагдашгүй. В.Инжиннаш, С.Буяннэмэхийн уран бичлэгүүд байдаг. Иймээс манай зохиолчид өөрийнхөө шүлэг зохиолын гар бичмэлийг болж өгвөл өөрийнхөө бийр бэхэсийн гайхамшгаар үлдээвэл хэзээ ч арилшгүй мөнх үлддэг.

Миний яруу найрагтай бүтээлээ найрсуулсан манай уран бичлэгийн нэрт мастерууд, авьяаслаг залуучууддаа баярлалаа. Д.Баттөмөр, Д.Ганбаатар, Л.Түвшинжаргал, Ц.Тамир, Жалайр Батбаяр нарын зэрэг олон хүнийг нэрлэж болно. Миний өөрийн гар бичмэл, манай каллиграфч залуусын бүтээлүүд, цуглуулгууд гээд ихээхэн сан хөмрөг бий болчихлоо. Энэ бол ирээдүйд бий болгох монголын бичиг соёлын их орд, өргөөний эх үүсвэр байж болох юм.

- Та дэлхийн яруу найрагчдын олон их хуралд оролцож, эх орондоо зохион байгуулж, мөн монголын яруу найрагчдаас анх удаа Дэлхийн урлаг соёлын академийн алдрын алтан титмийг хүртсэн. Энэ танхимын хойморт алтан титмээ залсан нь үзэсгэлэнгулам баяжуулж байгаа санагдлаа.



“Утгын болор сүм” үзэсгэлэнгийн танхим

- Энэ бол монголын утга зохиол, ялангуяа монгол нүүдэлчний оюун сэтгэлгээ зөөлөн намуун ая эгшиг, ай савыг багтаасан монгол яруу найргийн бүтээлд дэлхий томоохон үнэлгээ өглөө гэж хүлээж авсан. Маш их баяртай байгаа. Өөрийнхөө энэ хишиг өдрүүдээр уншигч, дэмжигч анд нөхөддөө үзүүлж алтан титмийнхээ хишгийг хүртээлээ. Мөн яруу найрагчийн тамга, бичгийн хэрэгсэл, ховор гар бичмэл, цуглуулгын дээжис орж байгаа нь үзэсгэлэнг маань улам утгатай болгосон. Тусалж дэмжсэн бүх найз нөхөд болон, уран

бүтээлчид, уран зургийн галерейн хамт олонд талархаж байна гэж ярьснаар бидний яриа өндөрлөсөн юм.

АНУ-ын Калифорни муж улсад бүртгэлтэй Дэлхийн урлаг соёлын академи, түүний ивээл дор зохион байгуулдаг “Дэлхийн яруу найрагчдын их хурал” 1969 оноос “Поэт лаурэт” цолыг алтан титмийн хамт олгодог болсон бөгөөд Плутцрийн шагналт Роберт Пэнн Баррен, Леофолд Седар Сенгхор, Маниуэл Марнинез Лэвия, М.Карунандхи нарын цөөн яруу найрагч энэхүү нэр хүндтэй шагналыг хүртэж байжээ. Монголоос анх удаа яруу найрагч

Г.Мэнд-Ооёо хүртэж, Унгарын нийслэл Будапешт хотноо болсон Дэлхийн яруу найрагчдын 29-р их хурлын нээлтийн ёслол дээр тэргүүнд нь асааж баяр хүргэсэн нь Монголын утга зохиолын их далайд цуггасан тасрашгүй цутгал гэж хэлж болно.

“...Нүүдэлчний уг чанар нь яарамгүйхэн тасралтгүй сэлгэх хөдөлгөөн, алслаг намуун аялгуу, зөн совинлог мөрөөдөмтгий эрэлч сониуч зан, юм бүхний гэрэлтэй талаас нь харах зөөлөн уянгат сэтгэл болой. Нүүдэлчин өвгийн язгуур чанарыг шүтэж, намуун зөөлөн уянгыг эрхэмлэн нандигнаж, түүнд улам шимтэж уусан шингэсээр уджээ, би. Зөөлөн ай бол миний яруу найргийн зан чанар юм. Өвс ногоо үл халцлах модон тэрэгний мөөр эргэж, зулагт монгол гутлаараа цэцэг зайчилж алхах өвгөдийн тайван намба, хаалга нь цуургагүй нүүдэлчин итгэл... ариусах дөт зам тэнд л байх шиг...” (“Миний зөөлөн ай”. Г.Мэнд-Ооёо) хэмээн өгүүлэх яруу найрагч зөөлөн ай эгшигээ эгшиглүүлэн, шүлэг найргаа бичиж, бийрээ барьж, билиг авьяасын түмэн хишгээ түгээсээр л явнаа.

Нүүдэлчин айсуй үзэгдэхэд ер бусын хөгжимлөг агаад зөөлөн аялгуу сонсдоно. Та анирлаарай. Тэр бол Дэлхийн яруу найргийн алдрын алтан титмийг тэргүүндээ асаасан яруу найрагч Г.Мэнд-Ооёогийн уран бүтээлийн язгуур чанар болой.

Зуун шарга зээр гөрөөс гүйлдэхэд зул болж асмуй би



Монгол түмнээ Эрээнцавын хэмээн алдаршсан Дорнын их яруу найрагч Д.Нямсүрэн

Нэг. Захидлаар зангидсан дурсамж

Даруухан Хөх уулыг Үүлэн гэнэ

Даанч сайхан нуурыг Тарь гэнэ

Тэртээ хол явчихаар эргэж очмоор санагдах

Тэр гайхам нутгийг Эрээнцав гэдэг ээ

гэж миний аав шүлэглэсэн байдаг. Энэ шүлгийг Эрээнцавынхан одоо ч гэсэн унших дуртай. Сургуулийн урлагийн үзлэг, сумын клубын бүжиг, албан байгууллагуудын тэмдэглэлт үйл явдал, цагаан сар, шинэ жил болгоноор Эрээнцавынхан уншдаг гэж сонсоод сэтгэл уярдаг юм.

Бүх юмс өөр өөрийн хувь тавилантай болохоор аав, Д.Нямсүрэн ах хоёр маань найз байгаагүй бол энэ шүлэг бас төрөхгүй байсан болов уу гэж боддог. Сайн найз, сайхан нөхөрлөлөөс үүдэлтэй гоё шүлэг гэж би аавынхаа

шүлгийг магтах дуртай. Өвс ногоо нь шаргалтаад, нуур ус нь мэлтэлзэн, тогоруу шувууд нь нисэлдсэн, эх орны дархан хил хязгаарын торгон зааг. Эрээнцав гайхалтай нутаг.

Энэ нутгаа Монголын ард түмэндээ шүлэг найргаараа таниулсан хүн бол их найрагч Данзангийн Нямсүрэн. Эцэг эхээсээ илүү эх нутгаараа овоглоно гэдэгуран бүтээлч хүний ер бусын хувь тавилан юм даа.

Цаг цагийн найрагч, уран бүтээлч, энгүй их түмний маань бахдан ярьж шүлэглэх дуртай төрсөн нутаг Дарьганга, Алтан Дарь-Овоо, Шилийн богд, Дагуурын цэнхэр хязгаар, Дорнодын тал нутгийн дов толгод нь хүртэл Эрээнцав, Эрээнцав хэмээн өндөлзөхийн учир юусан билээ.

Өнөөдөр би өвсөн дээр гишгэнэм

Өнө хойчдоо тэд над дээр урганам

хэмээх гайхамшигт мөрүүдийг тэрлэж тэнгэрийн орноо одсон ч эргээд л бидэндээ өвс болон ургаж, цас болон будраад бороо болон шаагин буух тэр их хүмүүн бол Монголын Зохиолчдын Эвлэлийн болон Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, Утга зохиолын шилдэг бүтээл шалгаруулах анхны “Алтан-Өд” шагналын эзэн, Монгол түмнээ Эрээнцавын хэмээн алдаршсан Дорнын их яруу найрагч агсан Данзангийн Нямсүрэн билээ.

Өвс адил ноцсон би

Өвс адил норсон би

Өвс адил согтсон би

Өвс адил одоо дуугүй

хэмээн шүлэглэж биднийг бодлын далайгаар аялуулж, Монголын утга зохиол хэмээх их өргөөнөөс “Цаг нь болж нөхцөл нь бүрдэхэд, Шамбалын оронд шүлгээ бичихээр одсон” ч эрхэм анд Г.Мэнд-Ооёогийн нь өгүүлснээр “Нэг хүн байтугай нэгэн үеийнхэн ч бүтээж чадахааргүй сонгодог шүлгүүдээ үлдээгээд одсон” байгалийн найрагч даа.

Эрээнцавынхаа уулс шиг намхан биетэй, эгэл даруухан шүлгэн өмсгөлтэй, хөлчүүхэн найрагч буурал суусан гэзгээ байн байн илбэж, ойр ойрхон гишгэлээд хорвоогийн үнэнийг тольдон өвсний үндсийг гүнзгий мэдэрч, дэрсний нөмөрт суугаад цасны амтыг амтлан, шувуудын жиргээг сонссоор түмэн бадгийг туурвисан. Наанаа омогтой ч цаанаа цагаахан гунигтай найрагчийн тавилангаар амьдарсан шүлгүүдийг нь сонссон болжмор хүртэл жиргэхийн учир юусан билээ.

Нэрт зохиолч Пүрэвжавын Пүрэвсүрэн 1984 онд “Уншигч таны өмнө нэгэн авьяаслаг шүлэгчийн анхны номыг дэлгэж байгаадаа баяртай байна. Энэ залууг Данзангийн Нямсүрэн гэнэ. 1949 онд Сүхбаатар аймгийн “Хужиртын гол” гэдэггазар төржээ. Бага, дунд, багшийн сургуульд суралцаж, ардын цэргийн алба хаасан. Одоо Дорнод аймгийн Эрээнцавын төмөр замын өртөөнд ажиллаж байна. Д.Нямсүрэн дотно нөхөр, яруу найрагч агсан Д.Шагдарсүрэнд анхныхаа шүлгийгүзүүлэн, түүнээс урам тэтгэх үг сонсон шавь орсноос хойш бас ч арван он өнгөрчээ. Энэ жилүүдийг хэрхэн өнгөрөөснийхөө тайланг энэ номоороо тавьж байгаа юм.” гэж түүний анхны шүлгийн түүвэр “Хаврын урсгал” номынх нь өмнө бичиж байв.

Ийм л энгийн намтар түүхтэй анхны номоо гаргаж байсан яруу найрагч маань өнөөдөр Монголын утга зохиолын том цагаан өргөөний хоймор зүгт заларч чадсан их яруу найрагч болжээ.

1988 оны намар. Аав минь Дорнод аймгийн “Үнэн” сонины сурвалжлагчаар томилогдон очиж манайх гэрээрээ нүүсэн юм. Л.Түдэв гуайн энэ томилгоонд хамгийн их баярласан хүн бол Д.Нямсүрэн гэж аав минь ярьж байсан юм. Д.Нямсүрэн ах Эрээнцаваас ирвэл манайд заавал ирнэ. Тэд уулзалдвал хүүхэд шиг л хөл хөөрцөг болно.

Шинэ ном, шүлэг найраг , найз нөхөд, хот хөдөөгийн уран бүтээлчид Эрэнцав, Дарьганга гээд тэр хоёрт минь ярихгүй юм байхгүй. Харин Нямсүрэн ах аавтай адилхан ан гөрөө хийдэггүй хүн байсан тул энэ тал дээр л тэр хоёрын яриа үл нийцнэ. Ээж Нямсүрэн ахыг хэдэн цагт, хэдүүлээч орж ирсэн гарын хоол цайгаараа дайлдаг ч тэрээр дэндүү бага идэж ээжийг минь “гомдоодогсон”.

Зарим хүмүүс түүнийг архи их уудаг, шил шилээр нь шөнөөдөргүй уудаг гэж дэгсдүүлэн бичдэг. Нэг шил архийг тэрбээр нэг шөнөжин найз нөхөдтэйгөө ууж, хамгийн гол нь бусдын анзаараагүй зүйлсийг тухлан ярьж, ярьж байхдаа л бодож бясалгадаг тийм ер бусын хүн байсан гэдгийг би батлан хэлж чадна. Эрэнцавдаа бол хэдэн сараар архи уухгүй, уран бүтээлээ туурвиж, хашаа саравчаа янзлаж, үнээ малаа маллаж Д.Нямсүрэн ах нээрээ хийж байсан юмуу гэж гайхмаар олон ажлыг амжуулж долоон хүүхэд, хань Хандмаагаа халамжилан тусалдаг сайн аав сайхан хань байсныг нь нутгийнхан нь ярьдаг юм.

Эрэнцавд хол ойроос очсон хүмүүс энд их яруу найрагч Данзангийн Нямсүрэн гуай амьдардаг гэсэн гээд хүндэтгэн гэрт нь зориод очвол ах дүү амраг садан нь ирсэн мэт хөл хөөр болж чаддаг тийм л эрхэм хүн байсан гэдэг. Энэ тухай найрагчийн гэргий Г.Хандмаа эгч уярмаар сайхан дурсамж их ярьдаг даа.

Уран бүтээлийн өрөө нь нэг ч тоос шороогүй, эрээвэр хураавар зүйл байхгүй бүгд байр байрандаа. Ханаа дагасан намхан номын тавиур дээрээ зарим номыг музейн үзмэр шиг байрлуулсан байдаг. Нөхдийнхөө дурсгасан ном, авсан шагнал, Халхголоос олсон сумны хонгио, модон сандал гээд түүнд дэмий юм гэж огт үгүй. Бүгд ер бусын эрхэм нандин. Тэр байтугай архины шилнүүдээ цуглуулаад хэдэн оны хэдэн сард ямар өдөр хэнтэй ууснаа бичиж наагаад цуглуулдаг байсны заримаас нь би Эрэнцавд очихдоо харсан юм. Ялангуяа номын шүүгээ, тавиур бол хамгийн эмх цэгцтэй, цэвэр, шороо тоосгүй. Хүн ямар ч зүйлийг нандигнаж болдгийг их хүмүүний амьдралаас харж болно. Яруу найрагч хүнд байх ёстой хамгийн том чанар ч байж мэднэ.

Яруу найрагч Г.Мэнд-Ооёо ах түүний хамгийн сүүлд хэвлүүлсэн “Аглагхан талаасаа” номын оршилд “Эгэлгүй юмсын эгэлгүй төрх, жирийн амьдралын жир бус бүхэн нь Данзангийн Нямсүрэнгийн яруу найрагт цогцолж,

Монголын утга зохиолд өөрийн гэгээн өргөөг дугуйлсан билээ. Хувь заяа нь түүнийг шүлэг бичүүлэхээр томилсон юм” гэж хэлсэн нь найрагч нөхрийн нь сэтгэлийн хөдлөл, уянгын халил төдий үг биш. Их найрагч шүлэг бичихийн төлөө, гагцхүү орчлонгийн явдлыг шүлэглэхийн төлөө оршин аж төрснийг гэрчилдэг билээ. Эгэл юмыг анзаарч, ажиглаж, хайрлаж, гоёчилж нэмж хачирлалгүй утга санааг нь тодруулж, шүлэг бичих ажлыг Д.Нямсүрэн найрагч бусдаасаа илүү хийж өгсөн дөө.

Тэрбээр:

Шүлэг бичиж суухад хаалга онголзуулж болохгүй

Шүлэггэдэг шувуу үүдээр гараад нисчихнэ.

Нэгэнтээ тэр одвол нэхэж хөөгөөд гүйцэхгүй

Эрвээхэй наадах нугадаа

Эрдэнийн солонго шиг нисчихнэ.

Шүлэг бичиж суухад чи минь эрхэлж болохгүй

Шүлэггэдэг шувуу өвөр дотор буухгүй

Нэгэнтээ түүнийг алдвал нэг насаар олдохгүй

Амраг чи бидэнд баригдахгүй

Алтан загас болчихно... хэмээн шүлэглэсэн бол

Сар хиртсэн шөнө шүлэг бичиж болохгүй

Шаргын ууланд гөрөөс хуйлраад шүлэг бичиж болдоггүй

Зүүнд чи минь гараа хатгачих гээд

Шүлэг бичиж болдоггүй...

хэмээн шүлэг бичихийн жаргал зовлон нарийн мэдрэмжийг хаанахын ямар найрагч ийн хэлсэн билээ.

Найрагчийн анд зохиолч Д.Нямаа “Сэтгэлийн байгаль” хэмээх 1991 онд хэвлүүлсэн хоёр дахь номын өмнөтгөлд “Амьдралын юмс үзэгдэлд мэдрэмхий хандаж, урнаар сэтгэн, үнэмшилтэй дүрсэлж, сэтгэлд сэрхийтэл хэлдэг, уран бүтээлийн хөдөлмөр хичнээн нарийн эмзэг болохыг санамсаргүй мэт хэлсэн энэ шүлэг түүний яруу сайхны сэтгэлгээний өвөрмөц онцлогийг таних боломж олгож

байна” гэж бичсэн байдаг юм. Яруу найрагч хүн хоёр дахь номоо гаргана гэдэг бол том алхам боловч тэрээр энэ номоо гарахаас өмнө Монголын утга зохиолын хүрээнд томоохон орон зайг эзэлчихсэн байсныг түүний тухай бичсэн уран бүтээлчдийн нийтлэл өгүүллүүдээс харагддаг. Өнгө аяс, арга барил, яруу сайхны хувьд нэлээд чөлөөтэй, үе тэнгийнхнээсээ эрс ялгаатай, энгийн хэрнээ цэцэн цэлмэг, уянгалаг, хүний сэтгэлд хоногших чадвар сайтай шүлгүүд Д.Нямсүрэнд олон бий гэж хэд хэдэн шүлгийг нь иш татсан байдаг юм.

Харин Д.Нямсүрэн ахын 1989 онд аавд бичсэн нэгэн захидалд аймгийнхаа утга зохиолын нэгдлийн 30 жилийн ойд оролцож чадаагүйдээ өөрийгөө их л азгүйд тооцож, “Та нар ямар шинэ уран бүтээл хийх гэж байна, Г.Мэнд-Ооёо арван сард Баруун-Уртад очсон сурагтай, О.Дашбалбар, Б.Магсаржав нар очоо юу, анхны номны уралдаанд хэн ямар номоо явуулсан бол, та нараас сураггүй болохоор хөдөө цөлд ганцаараа хаягдсан мэт санагддаг” гээд их л гоморхсон үгнүүд байдаг юм. Энэ захидалд “...Би хоёр дахь шүлгийн номон дээрээ ажиллаж байна”, “Ирж байгаа цас” гэсэн нэр өгөөд явж байна. Энэ онд арай өгч амжихгүй болов уу

даа. Энэ ном маань бүтвэл дараа дараачийн үйл явдал, хийж бүтээх зүйл санаанд минь тодрон гийх мэт болном. Бидний хэнийг ч гэсэн цаг хугацаа хүлээхгүй бизээ. Уран бүтээл дээрээ тууштай, зоригтой ажиллах үе болсон мэт...” гэж бичсэн байдаг юм. “Сэтгэлийн байгаль” ном тэгэхээр анх “Ирж байгаа цас” нэртэй хэвлэгдэх гэж байсан юм болов уу.

Мөн аавын нэгэн захидал байна. Он сар нь тодорхойгүй байсан ч цаг хугацааны хувьд тун ойрхон бичигдсэн нь захианы агуулгаас уншигддаг. Учир нь “Дооёо багш гишүүн болсон, утга зохиолын нэгдлийн ойд зориулсан ном хийж байна, шүлгээ ирүүлээрэй. О.Дашбалбар энд ирсэн байгаа, Г.Бат-Өлзийгийн номыг хэвлэх шийд өгсөн, Боргилынхоо номыг бэлдээд хойтон уралдуулья, Доржцэрэн чиний үгэнд одоохондоо ая хийгээгүй байна... гээд сонин ихтэй захиа.

“...Уран бүтээлч нарын намтрыг харахад дөчин насны дотор л гол юмаа хийдэг аж. Чиний хувьд байгалиас заяасан

авьяас, мэдрэмж хоёр бусад хүнд олон заяахааргүй олдсон юм шүү. Энийг нөхрийн үнэн үг гэж бодогтун. Үүний тулд нэгэнт байгаагаа зарах, хэрэглэх, хөгжөөх хэрэгтэй. Ингэвэл чи анхны хүний үргэлжлэл, аав Данзангийн үргэлжлэл төдийгүй ахиад зуун зуунд үргэлжилнэ гэж бодогтун. Намайг цэцэрхэв гэж сануузай. Шүүн бодвоос энэ үнэн байж таарна... Д.Нямсүрэн, Г.Хандмаа нар болон Эрээнцавд суугаа Дарьгангын бүх хүн тэдний үр хүүхдэд ёслол. И.Батсүх” гэсэн захидал аавын минь өвд хадгалаастай байдаг.

Ийм л жудагтай, журамтай уран бүтээлч хүмүүсийн хойч үе болохын хувьд тэдний хэмжээнд сэтгэж туурвиж үл чадах ч бие биенээ хайрладаг, хүндэлдэг ерөөлтэй үгээр мялаадаг нандин ёсод нь мөргөнөм.

ХОЁР. Дуу хураагууранд үлдсэн дурсамж


Яаж би, Амиитаба шиг хүйсний нууцыг хуруугаараа томьёолох вэ? Яаж би, Амиитаба шиг хүүхний бэлхүүсийг алтан харганаар үйслэх вэ?

Өндөр гэгээн Занабазарын 17-р зууны үед бүтээсэн Язгуурын таван бурханы нэгэн болох “Амиитаба” хэмээх гайхамшигт бурхан бүтээгдэж, Д.Нямсүрэн найрагч ийн шүлэглээгүйсэн бол утга зохиолын хүрээнийхэн Амиитабаг анзаарах байсан гэж үү.

Бид ийн мэдэрч, сэтгэж, шүлэглэж, зүйрлэж чаддаг их хүмүүнтэй нэгэн цагүед амьдарч, гэгээн тунгалаг шүлгийн мөрүүдийг нь унших, сонсох хувьтай юм. МУСГЗ, яруу найрагч Г.Мэнд-Ооёо ах “Яруу найрагч Д.Нямсүрэн “Яаж би, Амиитаба шиг чамайгаа бурхны тигд бүтээх вэ?” хэмээх асуулт болоод эрмэлзлийн дор яруу найргийн нэгэн цогц номыг бүтээжээ. Тэрбээр яруу найргийн туурвил зүйн шинэ зам мөрийг зогсолтгүй хайж, өөрийн яруу найргийн “тиг” болоод дэгийг олж, “Амиитаба” хэмээх шүлэгтээ

тодорхойлон тунхагласан болой. “Амиитаба” бол бурханы тиг дагаж бичсэн шүлэг бус, жинхэнэ яруу найргийн туурвилын тигд бурхан болоод энгийн юмсыг төгс гоо сайхнаар бүтээхийн үлгэр мөн” гэж өгүүлжээ.

Жинхэнэ яруу найраг бол цаг хугацаа, орон зайнаас ямагт ангид оршдог бөгөөд Д.Нямсүрэн найрагчийн шүлэг энэ үгэнд хамгаас илүү хамааралтайг түүний шад мөр бүхэн нь илэрхийлж байна.



Өндөр гэгээн Занбазарын бүтээсэн “Амиитаба” бурхан

“Амиитаба” шүлгийгуншихад үл мэдэх ер бусын нууцад нэвтрэн орж, сэтгэлийн тайтгарал, чинад нууцад улам нэвтрэх шинэ замыг олох шиг санагддаг.

Их яруу найрагч-гүн сэтгэгч Д.Урианхай гуай: “Яруу найраг нь хvнээс илүү мэдсэнээ, хүнээс илүү мэдэрснээ хүмүүст хэлэхсэн гэх их тэмүүлэл. Яруу найраг бол хvнийг хvн болгох хvслийн хамгийн хүнлэг, хамгийн гоо сайхан

дуун алдалт мөн” хэмээсэн нь “Амиитаба” шүлгийг товч бөгөөд тодорхой, энгийн ойлгомжтойгоор бидэнд өгүүлсэн хэрэг болно. Дорно дахины яруу найргийн онолд яруу найргийн чанарыг эвсэл найралт, маш тунгалаг, тэгш чанарт, яруу сонсголт, орь залуу, утга тодорхой, агуу их, сүр жавхлант, уран сэтгэмжит хэмээх эрдэм байдаг. Энэ бүхэн “Амиитаба” шүлэгт цогцолсон ” гэж бичсэн байдаг.

Ингэж Д.Нямсүрэн гуайн шүлгүүдийгуран бүтээлч бүхэн өөр өөрийн билгийн мэлмийгээр тольдон харж, бийр бэхэсийн шидээр урлан бичиж, оюун санааны гэгээн ертөнцөөс олж шүүрдэн ончтой үгээр өгүүлсэн нь тун олон юм. 1970-аад оны дунд үеэс эхлжлтэй Монголын уран зохиолы “Гал“, “ГУНУ“ урсгалын анхдагчдын нэгэн бөгөөд яруу найргаар төгөлдөрших, гэгээрэлд хүрэх зам мөрийг сонгосон найрагч болохыг нь судлаачид дуу нэгтэй үнэлсэн байна.

Тэрээр “Дөрвөн цаг”, “Амитаба”, “Үзэсгэлэнт Хасарваань мод цэцэглэхэд” гээд сонгомол шүлгүүдээ тэрлэж “Хаврын урсгал”-ыг “Сэтгэлийн байгаль”-аар урлан бичиж, “Аглагхан талаасаа” чимээгүйхэн одсон найрагч юмаа.

2002 оны 1-р сар. Улаанбаатар хотод “Алтан-Өд” шагнал авч, “Аглагхан талаасаа” шүлгийн түүврээ шинээр хэвлүүлээд хоёр сар шахам болохдоо найрагч нөхөд залуусын дурсгасан хоёр хайрцагтай номтой ирлээ. Хот хүрээ орохоороо их л уддаг хүн. Уран бүтээлч найз нөхөд, дүү нартайгаа уулзана. Зохиолч, найрагч хүний баяр баясгалан тэр л юм хойно.

Би санаачилж, Дорнод аймгийн төв номын сангийн эрхлэгч С.Алтанцэцэг эгч дэмжиж, Ц.Дамдинсүрэн гуайн нэрэмжит номын сангийн хоёр давхарт “Чинад хязгаарт хүрэхүй” яруу найргийн наадмыг дунд сургуулийн хүүхдүүд, оюутан залуусын гэсэн хоёр заагтай аймагтаа томоохон наадам хийхээр боллоо. Д.Нямсүрэн найрагч, яруу найрагч Ц.Буянзаяа, эрхэм дүү Ц.Дарь, Сүхбаатар нартайгаа ирсэн юм. Харин бидний хэн нь ч түүнтэй хамгийн сүүлд найргийн наадам хийж байгаагаа мэдээгүй нь хорвоогийн явдлыг тольдон харж болдоггүйн нэгэн үлгэр энэ бизээ. Наадамд олон хүүхэд оролцож их л өрсөлдөөнтэй болсон юм.

Маргааш нь 2002-02-09 буюу цагаан сарын битүүний өглөө, хүргэнийд нь очвол ах маань гэргий Хандмаадаа яарч, аймгийн төвд сурдаг хэдэн хүүхдүүд ач зээгээ аваад Эрээнцавдаа очихоор зэхэж байв.

Дуу хураагуураа үүрээд “Хотын сонин” сонсох гээд очлоо. Бид хоёр нутаг ус, аав ээжийн тухай хэсэг ярьлаа. За би ямар ч байсан дүүдээ ярилцлага өгнөө гээд бид надад “Хотын сонин” ярьлаа.



Яруу найрагч Дарьганга нутгаас төрөн гарсан Их яруу найрагч Д.Нямсүрэн, О.Дашбалбар, Г.Мэнд-Ооёо, Д.Маам МУ-ын гавьяат багш С.Лувсанноров, миний аав И.Батсүх Дарьганга сум (Анхны алтан овооны тахилгаар 1992 он)

- Утга зохиолын шилдэг бүтээлд олгодог “Алтан-Өд” шагналын анхны эзэн болсонд баяр хүргэе?

- Заа, ах нь хотод их удлаа. Өчүүхэн авьяасыг минь үнэлж ийм шагнал өгсөнд баярлаж байна.

Та нарын шимтээд байгаа хэдэн шүлгүүдийг төрсөн нутаг Дарьгангын үзэсгэлэнт байгаль, алс буйдхан Эрээнцав минь өгсөн юм даа. Дорнодын тал нутаг, Эрээнцавын өртөөнөөсөө

ажил амьдралын гараагаа эхэлсэн. Үр хүүхэд минь төрж өссөн. Эрээнцав минь надад гайхамшигтай амьдралыг бэлэглэсэн нутаг. Дарьгангынхаа алтан харганыг Дорнодынхоо Дүнжингарав цэцэгтэй зүйрлэж явдаг юм. Ах нь нутагусаа ярих дуртай, бодох бүр ч дуртай даа.

- Таны яруу найргийн торгон мэдрэмж, онгод ямар үед төрдөг вэ?

- Сайхан асуулт байна. Хариулахад хүнд юм. Ер нь их сонин л доо. Миний онгод яг л тэр аглаг хөдөөдөө, байгаль дээрээ, их цасан шуурга, нэг их бороо шаагих, халиурсан их өвс, мөн ногоо ургахад ...За тэгээд хүүхдүүд та нарыг зэмлэж загнаж байх тэр үед ч шүлгийн санаа төрдөг. Сэтгэл хямарсан үед онгод орж ирнэ. Загнаж чадахгүй үедээ бичиж чадахгүй болчих шиг санагддаг юм.

- Таныг байгалийн яруу найрагч гэдэг. Цагулирлын тухайд таны бодол.

- Би өөрөө их сонин мэдрэмжтэй хүн. Хүнтэй яриад сууж байхад тухайн хүний харц, бодож байгаа зүйлийг задлаад харчих шиг болдог. Гэхдээ энэ бол миний ойлголт шүү дээ. Эцэг эхээс минь заяасан ч юмуу. Зөнгөөрөө бүхнийг мэдэрч шүлэг бичих үе байдаг юм. Ийм л юм. Гэхдээ та нар миний шүлэг бичиж суухыг харахгүй. Өвөл, хавар, намар цагт шүлгээн бичиж харин зуныг жаахан нозоороод л өнгөрөөдөг юм (инээв).

- Он оныг элээж, олон хүүхдүүд тань бужигналдан өссөн Эрээнцав таны уран бүтээлийн амин сүнс боловуу гэж би ойлгодог. Нутгаа нэг сайхан магтвал...

Эх орон минь дуу шиг сайхан Эх нутаг минь шүлэг шиг сайхан Эргэх дөрвөн улиралд амьд явах сайхан Эрээнцавд минь цас орох сайхан

- гээд “Дөрвөн цаг” гэж их урт шүлэг. Ер нь зөндөө дөө.

Эрээнцав нутгаа шүлэглээд байх тусам гоо үзэсгэлэнг улам бүр мэдэрч байдаг юм.

- Яруу найргийг гутга зохиолын хүрээнийхэн янз бүрээр тодорхойлсоор ирсэн. Таны бодлоор...

- Зуны өглөө үүр цайх хичнээн сайхан байдаг билээ. Үнэгэн харанхуй арилж, болжмор шувуу жиргээд, үүр манхайн цайдаг шүү дээ. Тэрэн шиг л оюун ухааны гэгээрэх зам мөр уруу яруу найраг хөтөлдөг. Ариун тансаг, тэнгэрлэг ертөнц гэж яруу найргийг л хэлэх байх. Тэгээд ч их хүмүүс уран зураг бол харах урлаг, яруу найраг бол сэтгэлийн урлаг, хөгжим бол сонсох урлаг гэж хэлдэг. Би санал нэг байдаг. Минийхээр төгс төгөлдөр нэг цул юм даа.

- Улаанбаатарт их удлаа шүү?

- Монголын утга зохиол жилээс жилд өөрчлөгдсөөр байна. Ялангуяа манай залуучууд очих бүр өөрчлөгдөж, дэгжин дээшилж байгааг олж харлаа. Шинээр бүтээж туурвих, урлагутга

зохиолоо хөгжүүлэхэд их анхаардаг болжээ. Манай зүүн бүсийн яруу найраг сонирхдог хүүхдүүд бас ийм байгаасай. Боловсрол эзэмшиж, ном судар их уншдаг болсон нь үнэхээр бахархмаар зүйл. Би бараг бүгдтэй нь уулзаж шүлэг зохиолыг нь уншуулж жаал хөөрлөө. Нийслэлд удсан минь энэ дээ.

- Таныг нэгүдээ шүлгийн буян ихээ гэж дуу алдсанд тань сэтгэл их хөдөлсөн шүү.

- Шүлгийн буян дэндүү их. Шүлэг минь намайг Эрэнцавд томилсон. Хандмаатай минь ханилуулж, долоон хүүхэд заяасан юм. Шүлгийнхээ буянаар би юугаар ч дугааж үзээгүй. Харин би шүлэгч байгаагүй бол шүлгээр дугааж гундуухан амьдрах байсан ч байж мэднэ. Сайхан нөхөд, шавь нараа дурсмаар байна. Монголын тэнгэрт аянгын гялбаа мэт нэгэн тод од зурсхийгээд өнгөрсөн. Энэ бол миний эрхэм шавь

О.Дашбалбар байлаа. Яруу найргийнх нь багш байсан. Түүнд би яруу найраг, их үс гээг, уур уцаар, омголон зан, онгод хийморь бүхнээ өгсөн. Харин миний шавь намайг тухайн үед зохиолчдын хорооны гадаад асуудал хариуцсан Намбарын Энхбаяр гэж залуутай уулзуулж, Хар далайд амруулан, юм үзэж нүд тайлуулсан билээ. Тэр цагт ч би шүлгийн минь буян ихийг мэдэрсэн дээ. Яруу найрагтай холбогдсон хувь заяандаа их баярладаг. Нутгийн дүү засаг дарга Д.Одбаяр, тамгын газрын дарга Н.Хүрэлбаатар, бизнесмен дүү Мөнхтөр нар маань сая “Алтан-Өд” шагналаа авахаар Улаанбаатар явахад унаа машинаар тусалсан. Дорнодын ард түмэн, Эрэнцав, Дарьганга гээд нутгийнхаа буянаар энэ шагналыг хүртлээ. Эрэнцавын минь тэнгэр дор хоёр сар илүү шүлэг төрсөнгүй гэж бодоход сэтгэл нэг л гунигтай. Их л яарч байна. За Төгсөө минь цай уу, хоол унд ид гээд цааш ярихыг хүссэнгүй. Бидний яриа хоёр цаггаруй үргэлжилсэн юм. Тэр бүр

ярилцлага өгөөд байдаггүй хүн гэхэд дажгүй удаан ярилцсан санагдлаа. Д.Нямсүрэн ах маань Эрэнцаваа их л санасан нь илт. Ярилцлагын төгсгөлд нэг сайхан шүлэгуншиж өгнө үү гэж гуйхад хэсэг цааргалангүй байснаа, “Аглагхан талаасаа” шинэ номоо гаргаад

Зуун шарга зээр гөрөөс гүйлдэхэд Зул болж асмуй би...

хэмээх шүлгээ бүтнээр нь уншиж өгсөн нь цэнхэр хуурцганд хадгалаастай байдаг юм.

Харин олон олон шүлгүүдээс ямар зөн совингоор гагцхүү тэр шүлгийг сонгосон юм. Ёстой тэнгэр л мэдэх байх. Тэрээр одоо бидний зүрх сэтгэлд зохиол бүтээлтэйгээ зүрх сэтгэлийн минь угаас зул болон ассаар байна.

Орой галт тэрэгний өртөөн дээр Б.Энхтуяа эгчтэйгээ гаргаж өгөхөд, “За миний хүү шүлэг л сайн бич дээ. Эрэнцавд минь нэг оч л доо” гэж эцгийг минь санагдуулам духыг минь үнэрлээд инээмсэглэн одсон доо.



Яруу найрагч Д.Нямсүрэн 2001 он

Уулзсан учирсан хэнд ч болов “Эрээнцавд минь очоорой” гэдэг энгийн болоод уриалгахан үгээ хэлж Дорнод нутгийнхаа их өвсөн дундаас “тэнгэрийн унаа”-гаа унаад явчихсан ч уран бүтээлээрээ бидний дунд амьдарсаар л байна.

XX зууны шувгарга үеийн монголын яруу найргийн гарамгай төлөөлөгч, яруу уянгын утгач, Дорнын их найрагч Д.Нямсүрэн хүмүүний сэтгэлийг рашаан мэт тэтгэгч шүлгүүдээ туурвиж, “Дарьгангынхаа Алтан харганыг, Эрээнцавынхаа Дүнжингарав цэцэгтэй зүйрлэж аж төрсөн”. Үзэсгэлэнт Дарьганга нутагтаа хүй цөглөж, хүүхэд бага насаа өнгөрүүлсэн хэмээн дээдэлж, хэнтэй ч ижилгүй мөрүүдийг тэрлэж амьдарсан Эрээнцав нутгаасаа “Нацагдоржийн харанхуй хад руу зүглэсэн” найрагчийг дурсахын учир олон буй. Дуу хураагууранд үлдсэн дурсамжийнхаа төгсгөлд хамгийн сүүлд надад хуучилсан “Хотын сонин”-ыхоо дараа өөрийн дуу хоолойгоор уншсан шүлгийг нь бүрэн эхээр нь нийтэллээ. Тэр ямархан зөвн совоинг зөгнөн энэ шүлгийг

уншиж өгсөн нь таашгүй оньсого мэт боловч түүний мөн чанрыг бүрэн илтгэх мэтээ... Сайхан шүлэг мандтугай.

Б. Төгсжаргал 2003.11. “Дорнод” сонин.

* * * Алтан навчис намар шуургалан исгэрэлдэхүйд Анзааралгүй дэргэдүүр нь хүмүүс өнгөрөхийн ижил Алтан тэр навчсанд орон исгэрэхэд Алга болмуй би Нойрмоггалуу ганганах үүрээр Ногоон өвсний зүүдэн дундуур Сарны гэгээ бүсгүй хүн шиг явахад Салхи болж дагамуй би Аянга цахих тэнгэрийн хаяанд Аадрын өмнөх байдал дор Аяархан дохих цэцгэнд шилжээд Алга болмуй би Нохойд Эрээнцавд боорлох үдшээр Нойтон үүлний шиврээ манан дундуур Зуун шарга зээр гөрөөс гүйлдэн өнгөрөхөд Зул болж бадмалмуй би Намрын байгаль алтан долгисоор гүвэлзэж Наран тэнгис мэлтэлзэн урсахүйд Навчисан завинаа суун сэлүүрдэхүйд Нацагдоржийн “Харанхуй хад” уруу зүглэвэй би Зүггүй алга болсон шүлэгчийн хаана буйг Зүлэгтийн уснаа хөвөх шувуун гүц Зүүн хийдийн гэлэнмаа Амитаба Зүгээргүй

явсан хүүхнүүдээс минь асуугаарай Зуны өдрийн үд дундад Зураг мэт уулсын мөнх цасан
Зуурхан зуур гялбасхийн үзэгдээд Зузаан хязгааргүйн чинадад намайг нууцлана...

Түүхийн номнуудыг ангасан хүн ус залгилах мэт уншиж байгаа



“Ногоон нүдэн лам” номын зохиогч Ц.Оюунгэрэл

Номын худалдааны салбарт тэргүүлэгч “Интерном” их дэлгүүр жил бүр “Grand book” ёслолын үйл ажиллагааг зохион байгуулдагуламжлалтай. Өнгөрсөн өдрүүдэд борлуулалтаараа тэргүүлсэн номуудаараа үзэсгэлэн худалдаа гаргаж уншигчдын хөлд дарагдаж байлаа. Уран зохиол, эрүүл мэнд, хувь хүний хөгжил, бизнес, эдийн засагтээ 10 төрлөөр нийтдээ 100 номыг шилдэг, шилдгийн шилдгээр өргөмжлөн эрт үеэсээ ном судраа торгоор баринтаглан, хоймортоо залж дээдэлж ирсэн түмэндээ номын хишиг хүртээсэн сайхан үйл явдал болсон юм.

“Grand book-2010” ёслолын үйл ажиллагааны шилдэг номын шалгаруулалтад хоёр жил дараалан шалгарсан

“Ногоон нүдэн лам” номын зохиогч Ц.Оюунгэрэлтэй уулзаж ярилцлаа. Үнэн бодит амьдралаас сэдэвлэн бичсэн энэ ном 2008 онд нээлтээ хийж, уншигчдын хувьд “хуучин найз” болжээ. Гэхдээ үргэлж нөхдийнхөө сэтгэлээс мартагддаггүй тийм дотны найз болж чадсан нь он оны уншигчдын сэтгэгдэлээс харагддаг.

Номын борлуулалтандаа маркетингийн нэг ч төгрөгний зардал гаргаагүй байхад шилдэг борлуулалттай номын жагсаалтыг тэргүүлнэ гэдэг том амжилт хэмээн сэтгэл хөдлөн хэлж байгаа зохиолчийн чин сэтгэлийн үг номын ертөнцийнхөнд талархалтай санагдсан юмаа.

“Ногоон нүдэн лам”, “Америкт суралцсан тэмдэглэл”, “Миний ажлын ноу-хау” нэртэй номуудыг бичсэн зохиолч Ц.Оюунгэрэлийгуншигч та бүхэнтэйгээ уулзуулья.

- Юуны өмнө шилдэг номын шагналыг хоёр жил дараалан хүртсэнд тань уншигчдынхаа өмнөөс баяр хүргэе?

- Хоёр дахь удаагаа шилдэг номын шагналыг нэг номоор гардан авч байгаадаа маш их баяртай байна. Анхны ном “Америкт суралцсан тэмдэглэл”-ийнхээ шагналыг оруулаад гурван жил дараалан уншигчдаасаа үнэ хүнд хүртлээ. Цаашид илүү сонирхолтой, хэрэгтэй,

чанартай ном бичих үүрэг хариуцлагыг мэдэрч байна.

- “Ногоон нүдэн лам” хэвлэгдэн гарснаар уншигчидад ямар нөлөө үзүүлсэн бэ?

- Залуучуудыг зузаан том ном уншихаас айдаггүй сэтгэлгээтэй болгож өгсөн гэж надад олон залуус бичсэн. Зарим хүмүүс бүр “бүтнээр нь уншиж чадсан анхны ном минь байлаа” гэж бичдэг. Энэ бол аливаа номын уншигчиддаа үзүүлж чадах нэг сайн нөлөө гэж бодож байна. Мөн өөрсдийн удам судраа сонирхох, эмээ өвөөгийнхөө намтрыг судлах нь чухал гэдгийг илүү ойлгож мэдэрснээ надтай хуваалцаж байсан. Тэгэхээр хүмүүст түүхдээ хүнлэг хандах сэтгэл төрүүлж чадсан юм болов уу гэж боддог.

- “Ногоон нүдэн лам” Азийн шилдэгуран зохиолын шагналд нэр дэвшиж, 150 номноос 24-т бичигдэж, гадаадын нэр хүндтэй хэвлэлийн агентлагуудын анхаарлыг татсан тухай мэдээлэл гарсан. Энэ тухай тодруулбал?

- Тийм ээ. Азийн шагналд зохиолчид өөрсдөө л горьдлого тээж номоо явуулдаг. Унаган англи хэлтэй Энэтхэг, Филиппинчүүд юм уу, хүний олон дотроос цохиж гарч ирсэн Хятадууд тэр шагналд илт илүүрдэг л дээ. Энэ жил миний ном шилдэг 24-ийн жагсаалтанд багтсанд олон улсын сонирхогчид үнэхээр соргог хүлээж авсан. Монголоос хүртэл англи хэл дээр чанар сайтай зохиол ирдэг болсон байна, унших юмсан гэх мэт сэтгэгдэл энд тэнд бичигдсэн байсан. Ингээд номыг маань төлөөлж барууны зах зээлд гаргаж өгье гэсэн агентуудаас захидал ирж байна. Тэдгээрээс аль нэгийг нь сонгож амжаагүй байхдаа ном маань дэлхийн номын яармагт танигдах болсон тухай өөрийнхөө Facebook дээр бичтэл миний Facebook-ийн нэг найз тэр мэдээг маань өөрийн бас нэг найзын Wall дээр бичиж дамжуулсан. Тэгтэл Facebookийн шугамаар танилцсан агент маань зохиогч бидэнд хамгийн их таалагдаж бид түүнтэй гэрээ байгуулсан.

- “Ногоон нүдэн лам”-ыг бичиж байхдаа түүхээ их судалж, нутгаараа олон удаа явсан тухай та хэвлэлд ярилцлага өгсөн байсан. Зохиолоос хасагдсан сонин содон үйл явдлаас уншигчдадаа сонирхуулбал.

- Зохиолыг анх бичсэн хувилбар тэр чигээрээ өөрчлөгдсөн учраас анхныхаас 800 орчим хуудас бүгд орхигдсон. Дараа нь шинээр бичсэн хувилбараасаа бараг 300-аад хуудсыг номд огт оруулаагүй. Уншигчдын хэзээний танил болсон Бүргэдийн Халх голын дайн, Нацагийн чөлөөлөх дайнд оролцсон, Цэрэннадмид ламтаны хувь заяа цаашид хаана яаж төөрч будилсан тухай хэсгүүдийг номын эцсийн хувилбарт оруулж чадаагүй. Маш сонирхолтой бичиж бэлэн болсон ч уран зохиолын дүрмээ дагах хэрэгтэй болж, гол баатар

Баасангголчлон дагасан учир түүний олон зүйлийг хассан даа.

- Хоёрдугаар дэвтэрт Баасан лам яах бол? Та үйл явдлын товчоос өгүүлж болох уу?

- Баасан лам шоронд явж “биеийн там”-д нэлээд амьдарсан. Хоёрдугаар дэвтэрт харин “сэтгэлийн там”-д унана. Гунигтай боловч үнэн амьдрал нь учраас зохиолоо хазайлгахгүй бичнэ. Хайртай хүнтэйгээ ханилах заяа тохиогоогүй эр хүнд учирдаг бүхэн түүнд учирна даа.



“Ногоон нүдэн лам” зохиолын гол дүр Баасангийн охин Б.Наранцэцэг

- Энэ номны хэл найруулгын хувьд уншигчид ямар санал шүүмжлэл танд ирүүлдэг вэ?
- Уншигчид маань хэл найруулгын талаас нь зарим хэсгийг магтдаг, зарим хэсгийг шүүмжилдэг. Гэхдээ амтанд нь нэг орчихвол тэр хэл найруулга ч яамай гэж хэлсэн олон хүн бий. Бид зохиолоо анхнаас нь англи хэлээр бичсэн болохоор монгол хэл дээр орчуулгын стилигтэй болсон. Зохиолч Б.Золбаяр ч редактор хийх үедээ тэр стилээс нь гаргаагүй зориуд орчуулгын хэлбэрээр нь орхисон гэж өөрөө хэлж байсан. Гэхдээ хэд хэдэн хэсэг дээр үнэхээр сайхан уянгалаг хэллэгтэй болгож өгч тусалсан.
- Та ер нь шүүмжлэлд яаж ханддаг вэ?
- Шүүмжлэлд дуртай. Шүүмжлэлийг нэг л сонсчихвол дараагийнхаа ажил дээр тэр дутагдлаа давтахгүй юмсан гэж хичээнэ. Угаасаа надад олон шүүмжлэгч байдаг учраас тэдний буянаар ажил маань үргэлж л сайжирч байдаг гэж боддог.
- Таны багадаа уншсан номуудаас одоо ч хүртэл номын санд тань хүндтэй байр эзэлдэг ямар ном байдаг вэ?
- Монголын Нууц товчоо, Цагаан соёот, Эрдэнийн сан Субашид, Андерсоны үлгэрүүд, С.Эрдэнийн түүвэр өгүүллэгүүд.
- Олон шилдэг номнууд шалгарч, цаана нь олон шилдэг номууд өрөөстэй байна. Таны хувьд ном унших сонголтоо хэрхэн хийх ёстой вэ?

- Хүн тухайн үеийнхээ хэрэгцээгээрээ л сонголт хийдэг. Энэ жил “Ногоон нүдэн лам”-ынхаа хоёрдугаар дэвтрийг бичиж эхлэх төлөвлөгөөтэй байгаа болохоор дандаа түүхтэй холбоотой номнуудыг ангасан хүн ус залгилах мэт уншиж байгаа. Харин ном бичээгүй байхдаа тааваараа сонголт хийдэг байлаа. Энэ жил бас өөрийнхөө огт уншиж байгаагүй “буддын” гэсэн жанрын номыг их уншина гэж төлөвлөж байгаа. Буддын шашныг тайлбарласан, эсвэл судар номыг буулгасан бүх номыг яаж ийгээд уншиж байж л миний номын 2-р дэвтэр миний хүссэнээр бичигдэх болоод байна. Бас цаг олдвол архивт олон хоног суумаар байна. Цаг олодохгүй бол ном бичих хугацаа маань төдийчинээ оройтох гээд л...

Ямар ч хэрэггүй ном бичсэн байна гэж хүмүүс шүүмжлэх явдал байдаг. Нээрээ ч цаг, цаасаа барсан юмуу даа гэж хэлмээр ном бишгүй л бий. Энэ талаар та ямар бодол тээж явдаг вэ?

Ямар ч хэрэггүй ном гэж байхгүй. Ном бүхэнд хүнд хэрэгтэй мэдээлэл байдаг. Өнөөдөр биш юмаа гэхэд маргааш нь заавал хэрэг болно. Тэгэхэд л хүн номд үнэхээр хайр хүрдэг юм. Энэ мэдрэмжийг олон ном хайж, олж, уншиж үзсэн хүн бүхэн мэднэ дээ.

- Хамгийн сүүлд та уран зохиолын ямар ном уншсан бэ?

- Харин сүүлийн үед дандаа судалгааны шинжтэй ном уншиж байгаа болохоор уран зохиолд цаггаргаж чадаагүй. Гэхдээ хамгийн сүүлд уншсан Жак Уэтерфордын “Монголын Их Хатдын нууц товчоо” бол маш сонирхолтой ном байсан. Үнэхээр гоё ном.

Англи хэл сурч байгаа залууст хэрэг болж чадахуйц сайн ном бичсэн хүний хувьд урам өгмөөр сайхан зөвлөгөө хэлнэ үү?

Англи хэл сурахад оройтохгүй. Өөртөө хамаатай зүйлээс эхэл гэж зөвлөө. Жишээ нь интернэтээс өөрийнхөө өдөр тутмын зурхайг аваад “ба бэгүй” орчуулж үзэж бай. Зурхай дээр юугэж хэлэх нь хамаагүй, тэнд хэрэглэж байгаа үг бүхэн танд хамаатай учраас орчуулах сонирхлыг тань хэзээ ч бууруулдаггүй сайн талтай. Өөртөө итгэлтэй болоод ирмэгц төлбөртэй орчуулга хийж эхлээрэй. Мөнгө таныгурамшуулж, бусдын өмнө хүлээсэн үүрэг таньг ташуурдаж чадвал англи хэл сурах идэвх тань улам сайжирна.

- Эх хэлээ бүрэн эзэмших, хайрлах, хүндлэх тухай таны бодол?

- Ерөөсөө дэлхийн тавцан мөрөөдөж байгаа бол эх хэлээ л сайн мэддэг байх шаардлагатай. Тэр тусмаа түүх соёлоо мэдэх нь хамгийн чухал. Гадаад харилцааны мундаг мэргэжилтэн болъё гэж мөрөөддөг хүүхдэд би

нэг зүйл захих дуртай. Та нар Монголоо мэдэхгүй бол гадаад харилцаа хийж чадахгүй шүү гэж хэлдэг. Хөдөө гарч үзээгүй хүн гадаадад яваад амжилттай харилцаа тогтоож чадахгүй. Монгол хэлээ хамгийн сайн мэдэж, мэдэрдэг хүмүүс хамгийн сайн орчуулга хийдэг. Монгол хэлээ мэдэх, судлах, хайрлахаас л бүх амжилтын гараа чинь эхэлнэ гэж залуустаа хэлмээр байна.

- Таны шинэ номууд хэзээ хэвлэгдэн уншигчдын гарт очих вэ?

- Шинэ он гармагц эхний гурван сардаа багтааж гурван номыгуншигчдынхаа гар дээр тавихын төлөө ажиллаж байна. Үүний хоёр нь олуулаа хамтарч хийж байгаа гарын авлага, харин нэг нь миний бие даасан бүтээл байгаа. Хэвлэгдэн гарах гурван номынхоо нээлтийг хийчихээд “Ногоон нүдэн лам”-ынхаа хоёрдугаар дэвгрийн ажилд идэвхитэй орно доо.

Таны бүтээж туурвих их ажилд тань амжилт хүсье.

Б.Төгсжаргал 2009.12.26. Үнэн сонин №225

“Өрмөн уул”-ын өөдрөг хатагтайтай уулзсан тэмдэглэл



“Өрмөн уул” ХХК-ийн Ерөнхий захирал Д.Оюунбилэг

Зүүд амьтай, ижсий буянтай их ажлын эхлэл

Уулзаж ярилцсан бүсгүй маань, эзэмшсэн мэргэжил, эрхэлсэн ажлаараа амжилт гарган, ундарсан их ажилдаа түүртэлгүй, олон хүний жаргал зовлонг хуваалцан бүхий л зүйлийг өөдрөг гэгээнээр төсөөлж өөдөлж, дэвшиж яваа эрхэмсэг нэгэн.

Зовлон тааравч зориг мөхөсдөлгүй зорьсон үйл хэрэгтээ улам тэмүүлж, жаргал дүүрэгч заяаг минь түшсэн нутагус, уул овоо, ураг төрөл, ах дүү нөхдийн минь буян гэж бэлгэшээн хайрлаж, бусдын төлөө гэсэн өгөөмөр их сэтгэлээр хандаж явдаг бүсгүйчүүдийн нэг бол “Өрмөн уул” ХХК-ийн ерөнхий захирал Дагдоржийн Оюунбилэг юмаа.

Хуучилж суухад сэтгэлийн дулаан илч, итгэлийн зөөлөн үгс нь бодол дундуур минь гол ус тунгалагшин урсах мэт зөөлөн гэгээн мэдрэмжийг төрүүлж, бүсгүй хүний сэтгэлийн их хат тэнхээгүзүүлэхийн гайхамшигийгүлгэрлэн амьдарч яваа нь илт. Бүтээсэн үйл хэрэг нь Өрмөн уул

шигээ өндөрсөн харагдах авч өгүүлэн ярих нь энгийн даруу гэж хэлбэл илүү оновчтой санагдлаа.

Анх Эрдэнэтийн их цасан хучлагатай уулсын дунд нутгийн зөвлөлийн аяллаар явж байхдаа танилцаад урлагийн хүн юмуу даа гэж бодсон юм. Ардын жүжигчин Ч.Мөнхшүр, нэрт нэвтрүүлэгч Соёлын гавьяат зүтгэлтэн Б.Рагчаа гээд урлагийн мастеруудыг нутгийнхаа уулзалтанд урьж Эрдэнэтэд суурьшсан нутгийн зон олондоо дуу хуурын бэлэг барьж байсан юм.

Цаг товлон уулзаж уул уурхайн салбарт зүтгэж яваа эрхэмсэг, хөдөлмөрч бүсгүйн тухай илүү ихийг мэдэж билээ. Албархан жийрхэж, аминчилж нуршаагүй ч нэг мэдэхнээ цөөнгүй зүйлийг ярилцжээ. Өгүүлэн хэлэх бүртээ эх орон маань улам хөгжиж, иргэн бүхэн маань баян байгаасай гэсэн ухаалаг, шудрага, ажил хэрэгч, хамт олноо гэсэн сэтгэлээр дүүрэн ажиллаж ирсэн түүхийг өгүүлнэ. Их сургууль дүүргэсэн цагаасаа эхлээд эдийн засагчийн ажилдаа үнэнч байж аливаа бүхнийг сөрж амьдарсан сайхан сэтгэлтэй, дүүрэн итгэлтэй нэгэн юм даа гэж бодогдсон юм.

Монголынхоо ирээдүйд хувь нэмрээ оруулж, олон хүнийг ажлын байраар ханган, амьдрал ахуйг нь өөд нь татаж яваа ажил хэрэгч бүсгүйчүүдийн нэг Д.Оюунбилэг захиралд ажилчдынхаа амьдрал ахуй, салбарынхаа хөгжил дэвшил, эх орон ирээдүй хойчийнхоо тухай анзааралгүй орхидог ажил үйл гэж нэгээхэн ч үгүй ажээ.

Харин компаниа яагаад “Өрмөн уул” гэж нэрлэсэн юм бол гэсэн сониучхан бодол хамгийн түрүүнд санаанд буун асуухад, “Дүү Д.Цогтбилэгийнхээ хамт энэ компаниа байгуулах гээд нэрийг нь бодож байсан үедээ Сэлхийн зуслангийн аманд байдаг ээжийнхээ бор гэрийг зүүдэлсэн юм. Дотор нь ганц нэггазраа шаргалтсан нэг их том өрөм шиг уул тогтсон байна гэнэ. Ээжээ энэ юу вэ гэсэн чинь,

-Өрөм шүү дээ гэсэнд,

-Хөөх таны өрөм чинь уул шиг загсдаг юмуу даа гээд жаахан охин болчихсон асууж байх юм. Өрмөн уул Сэлхийн амнаас дээшээ өгсөн улам их загсаж өндөрсөж байхад нойрноосоо сэрчихсэн” гээд хүүхдийнх шигэхөөрдөм

зүүдээ ярьлаа. Энэ тухай дүүдээ хэлээд ээжээс минь эх ундаргатай “Өрмөн уул”-аа бэлгэшээж нэрлэсэндээ сэтгэл дүүрэн явдагаа ярьж, нүүрэнд нь баясал гийх нь миний сэтгэлийг ч бас хөдөлгөлөө. Зүүд амьтай, ээж буянтай энэ нэрэндээ олзуурхан, үйл ажиллагаагаа эхлээд зовлон бэрхшээлийг давж, компаниа хүүхдээр бол хүний дайтай явна даа гээд бахархаж суугааг нь харахад сайхан байлаа.

Булган аймгийн Бүрэгхангай суманд үйл ажиллагаагаа эрхэлж, аливаа зүйлд хууль ёсны дагуу хандан, хөдөлмөр зүтгэлээрээ байгаль дэлхийгээ хайрлан буян хишгийг нь хүртэж, үр шимийг нь хүн зонтойгоо харамгүй хуваалцаж яваа өгөөмөр бүсгүй. Ээжийгээ хайрласан хүн үргэлж бурхнаас ерөөл буянаар шагнуулж байдаг юм гэсэн. Түүний эцэг эхээ хүндлэн дээдэлж, бурханчлан шүтэж амьдарсан нь их ажил, эгнэшгүй амжилтынх нь эхлэл болжээ.

Эрдэнэ хадгалсан уул шиг эгэл бүсгүйн амьдрал

МУИС-ийг 1979 онд төгссөнөөс хойш барилгын машин, механизмын баазад нягтлан бодогчоор ажлын гараагаа эхлээд, дараа нь Дарханы Барилгын материал үйлдвэр дундын авто баазад ерөнхий нягтлангаар ажиллаж, ханьтайгаа тэнд танилцаж байжээ.

1997 оноос гэр бүлээрээ бизнес эрхлэхээр эхэлсэн суурин дээрээ дүү Д.Цогтбилэгтэйгээ ярилцаж, гадаад дотоод худалдаа, барилгын зураг төсөл зохиох үйл ажиллагаа эрхлэх “Төсөлч” компани байгуулжээ Аав Таяагийн Дашдорж нь Сүхбаатар аймгийн Асгат сумын уугуул. МУИС-ийн эдийн засгийн дээд сургуулийг онц дүнтэй төгсөн, намын дээд сургуулийг дүүргэн насаараа хариуцлагатай алба хашиж ирсэн буурай байжээ.

Ээж нь сайхан дуулдаг, аман билгийн авьяастай, хурц сэргэлэн ухаантай нэгэн байсан учраас өөрөө ч бас урлагт их элэгтэй тухайгаа ярьж байлаа. Д.Оюунбилэг захирал аавынхаа ажил эрдмийгөвлөн, ээжийнхээ загсаасан “Өрмөн уул”-ын ач буянаар амжилтын эзэн болж чаджээ. Компания

2000 онд албан ёсоор барилгын зураг төсөл зохиох, уул уурхайн хайгуул, ашиглалт, гадаад дотоод худалдаа, аялал жуулчлалын чиглэлээр үүсгэн байгуулаад өнөөдрийг хүртэл арван жил уйгагүй зүтгэж, дараа дараачийн олон арван жилүүдэд хэрхэн ажиллах хэтийн төлөвлөгөөгөө гаргаад заримаас нь эхлүүлжээ. Анх хориод ажилтантай түрээсийн техниктэйгээр бүтээн байгуулалтын үйл ажиллагаагаа эхэлж байсан бол эдүгээ 100 гаруй ажиллагсадтай, орос, канад, хятад, солонгос, америк, герман техник тоног төхөрөөмжөөр бүрэн шинэчлэгджээ.

Алт олборлолтын үйлдвэрлэл нь өсөж, улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамж, даатгалын төлөвлөгөөг бүх төрлөөр давуулан биелүүлж, ажилчдын нь дундаж цалин өсч, нийгмийн асуудлыг шат дараатай авч хэрэгжүүлж байгааг хийсэн ажил, үйл бүхнээс нь хараад бахархаж байлаа.

Мөн гадаад харилцаагаа өргөжүүлэн аялал жуулчлал, зам барилга, газар тариалан, хүлэмжийн аж ахуй эрхлэн, жимс жимсгэнэ нарийн ногоо тариалж, эрүүл хүнсээр ажилчдаа болон эх орныхоо дотоодын хэрэгцээг хангахад хувь нэмрээ оруулах хэтийн төлөвлөгөөний дагуу ид ажил өрнүүлж байгаа эвсэг хөдөлмөрч хамт олны удирдагч.

Энэ их амжилтанд хүрэхэд хагацал гуниг, зовлон бэрхшээлтэй олонтаа тулгарсан ч цэвэр өөрсдийн хөрөнгө, хичээл зүтгэлээр босгосон доо гэж ярьж суух нь их ажлын ард гарсан хөдөлмөрч хүний сэтгэлийн үг байлаа. Ингэж өр зээлгүй өдий зэрэгт хүрсэндээ баярлаж, хамт олноороо бахархаж суугаа эрхэмсэг бүсгүйн зөв санаа, зөв сэтгэлээр шудрага амьдарвал хүн амжилтанд хүрнэ гэдгийг бусаддаа үлгэрлэсэн амжилтынх нь хөтөч байсан боловуу.

Хамт олны маань аз жаргал миний сэтгэлийн баяр баясгалан

Би найман дүүтэй. Манайх гэдэг айл хүүхэдгүй юм шиг чимээ аниргүй, эмх цэгцтэй, сурлага хүмүүжлээрээ

бусдад үлгэр жишээ болсон айл байлаа. Олон дүү нараа “командалсаар” байгаад багаасаа удирдах авьяастай болж, хоёрдугаар гарын үсэг зурдаг санхүүгийн мэргэжилтэнээс эхлээд компаний захирал болсон доо. Гол нь боловсон хүчний нөөц, чадвар, зохион байгуулалт юу юунаас илүү чухал.

Манай хамт олны хувьд бүх зүйл цэгцэрсэн. Санаа сайхан бол заяа сайн гэдэг. Зөвхөн өөрийнхөө төлөө биш бусдын сайн сайхан, тэдний зөв амьдарч, зөв алхам хийхэд тусалж гэр бүлийнх нь жаргал зовлон хүртэл компаний ажлын нэг хэсэггэж бодож ажилласан маань эвсэг хамт олон төлөвшихөд тустай хэрэг болсон. Эхэндээ гэр бүл үр хүүхдээсээ хол байгаа эрчүүдийг хөдөө ажиллуулна гэдэг бол амаргүй ажил байсан. Би бусдад итгэл өгч ажиллуулах дуртай. Байгууллагадаа мөнгөн хуримтлал бүрдүүлж, хамт олноо шагнаж урамшуулах бодлого барьж, хуваарилалтаа олон талаас нь нягталж байж хийдэг нь үр өгөөжтэй. Цалингаа аваад машин авсан, байраа шинэчилсэн гээд авгай хүүхэд нь сэтгэл хангалуун байгааг хараад удирдах хүний хувьд бас сэтгэл амгалан болж өөриймсөг сэтгэлээр баярлаж явдгаа хэллээ. Энэ бүхний нарийн шаглааг эмэгтэй хүн л шаглаж чаддаг онцлогтой учраас Оюунбилэг захирал их л уран шаглаа хийж чаддаг нь ажлынх нь үр дүнгээс харагдаж байна.

Одоо уурхайн орчин нөхцлийг сайхан бүрдүүлж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд нь анхаарч, амьжиргаагаа дээшлүүлэхэд нь туслах, хүүхдийнх нь сургалтын төлбөрийг төлөх, шууд орон сууцаар хангах гээд анхаарах асуудал цөөнгүй.

Жилдээ 20-30 хүнийг аялуулж, 7-8 хүн орон гэртэй болж, 70-80 хувь нь орон сууцаа сайжруулсан даа. Намар ажлаас буугаад ажилчид маань эмнэлэг сувилалд эмчлүүлээд, гадаадад сурч байгаа хүүхдүүд нь ээж аавыгаа амрааж байна. Уурхай маань илүү өргөжинөгөж ирээдүйгээ сайхнаар төсөөлдөг. Жилийн дөрвөн улиралд ажилчдаа ажлын байраар ханган, аялал жуулчлалыг хөгжүүлэн Төв аймгийн Эрдэнэ сумын Цонжин болдогийн орчим зөвхөн хүүхдүүдэд

зориулсан сувилал байгууллаа. Өөрсдийнхөө нөөц баялгийг ашиглаад монгол хүн хийж чадна, заавал хийх ёстой гэсэн зарчмыг баримталж ажиллаж ирсэн.

Монголдоо бол нэг их дээгүүрт орохгүй юмаа гэхэд үндэсний үйлдвэрлэгч компаний хувьд хууль дүрмийнхээ дагуу шудрага ажилладаг. Компанийхаа 100 гаруй ажилчид тэдний гэр бүлд туслахаас гадна нийгмийн олон ажилд оролцож хандив тусламж өгч, зөвхөн уул уурхайгаараа биш зүрх сэтгэлээрээ аав ээж, өвөг дээдсээ бодож буян хийдэг дээ. Одоо хот дотор техникийн засвар үйлчилгээний талаар янз бүрийн ажил хийхээр төлөвлөж, боловсон хүчнээ энэ чиглэлээр бэлтгэж байна гээд түүний хийж бүтээж байгаа ажил дундаршгүй их ч түүртсэн зүйл ер үгүй.

Ажлыг хийсэн шиг хийж, амьдралыг бүтээсэн шиг бүтээн цогцлууулж чадахын жишээг Д.Оюунбилэг захирлын ажлын туршлага, амьдралыгүзэх үзлээс тольдон харлаа.

Би бүсгүй хүний сониуч зангаар алтны уурхайн захирал бүсгүй гоёл чимгэндээ хэр анхаардаг тухай асуувал, “Алт хүн төрөлхтөний түүхэнд оройд гарахгүй жаргал гэж ярьдаг. Тийм их үнэ цэнэтэй. Хүмүүс бараг түүхий шахуу алтаар хийсэн ээмэг зүүлт зүүчихсэн байдаг. Үүнийг таашаадаггүй. Эзэмшиж байгаа газрынхаа хэвлийгээс гарсан алтыг зүүе гэж боддоггүй. Гадагшаа явахдаа өөрийнхөө шохоорхсон үнэт эдлэлийг авдаг юм. Миний зарчим энэ” гэж даруухан өгүүллээ.

Баялгаа ард түмэндээ зөв хүртээвэл монголчууд дэлхийд байхгүй баян хөгжилтэй болно гэдэгт итгэж байна

Манай компани үндэсний үйлдвэрлэгч. Төр засгийн бодлого маань үндэсний үйлдвэрлэгчдээ бага дэмждэг. Манай компани үндэсний үйлдвэрлэгч. Төр засагүндэсний үйлдвэрлэгчдээ бага дэмждэг. Гадны хөрөнгө оруулалт бол гадных, эргээд дандаа өр байдаг. Монголчууд яагаад ядуу зүдүү амь зууж байна вэ гэхээр төр засгийн холч бодлого дутаад байна. Монгол эрчүүдээ гадагш явуулснаар, гэр бүлийн тэнцвэрт харьцаа их алдагдлаа. Гэр бүл салалт ихсэж,

үр хүүхэд өнчирч, эр бяр нь тэнцсэн сайхан залуус харьд өөр хүнтэй ураг барилдаад, эх орондоо эргэж ирэх сонирхолгүй болж байна. Монгол хүн чадна гэдгийг салбар бүрт ажиллаж байгаа бизнесменүүдийн амжилтаас харж болно.



Өнөөдөр зам засвар, барилга байшин барихадгадаадын иргэдийг ажлынбайраар хангахын оронд яагаад монголчуудаа ажиллуулж амьдралыг нь өөд татаж болохгүй гэж. Монгол орон маань дандаа ийм байхгүй, бүтнэ, хийнэ, чадна гэдэг сэтгэл монгол түмэнд байгаа. Өөдрөг сэтгэлтэй амьдрах ёстой. Хүн хүнийхээ хийсэн бүтээснийг нураамааргүй байгаа юм. Мөлжинө шулна. Энэ хэзээ ч байж болохгүй. Жишээ нь уул уурхайн салбар маш их ирээдүйтэй. Гаднаас хөрөнгө оруулалт авч болно. Үүнийгулс төржүүлэхгүйгээр ард иргэддээ ашигтайгаар, улс эх орныхоо хөгжилд хурдац нэмэхээр шийдвэр гаргах нь чухал шүү дээ. Хоёр сая хүн амтай манай ард түмэнд олон нам, намчирхал огт хэрэггүй. Баялгаа ард түмэндээ зөв хүртээвэл монголчууд дэлхийд байхгүй баян тансаг хөгжилтэй болно гэдэгт итгэж байна” гэсээр бид яриагаа өндөрлөлөө.

“Өрмөн уул”-ын өөдрөг захирал бүсгүйтэй ярилцахад ийнхүү дандаа л ажил ундарсан их амжилтын эзний гэгээлэг сайхан яриа өрнөж билээ. Хүн бүхэнд сайн сайхныг ерөөж, хүсэл мөрөөдлөө биелүүлэх жигүүр нь өдлөхөд дэм болж, өндөрт нисээсэй гэж ерөөж явдаг эрхэмсэг бүсгүйн ажилд амжилт хүсье.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

“Жавхлант шарга” сэтгүүл 2010 он. № 3

Үг болгоноос нь гэрэл цацарч үйлс бүхэнд нь буян хуралдмой



МУСГЗ, Бурханч лам Г.Пүрэвбат

Бурханч лам Г.Пүрэвбат Монголынхоо соёлын үнэт өв уламжлалыг сэргээн хөгжүүлж хойч үедээ өвлүүлэн үлдээхийг зорьж, олон арван шилээвэр бүтээл туурвин, сургууль байгуулан, зааж сургасан гавьяатай хосгүй их авьяас билигтэн билээ. Тэрээр хүмүүний төгс бие бялдараар төлөөлүүлэн бурхдын шүтээн зургийг бүтээж, үүндээ итгэл бишрэлийг төрүүлэх чин сүсгийг шингээсэн байдаг.

Бүтээл туурвилд нь 17-р зууны Монголын анхны Богд, алдарт соён гэгээрүүлэгч, уран барималч, Өндөр гэгээн Занабазарын арга барил, дэг сургууль нөлөөлсөн байдаг ч тэрээр өөрийн уран бүтээлийн өвөрмөц хэв шинжийг бий болгож Монголын орчин үеийн шүтээн зургийн хамгийн шилдэг төлөөлөгч болохоо хийж бүтээснээрээ нотолсон билээ. Үүгээр зогсохгүй баримал, уран барилга, суварга бүтээн шүтээн зураг судлал, урлагийн түүхийн судалгааны ажлыг гүйцэтгэж, ном хэвлэл туурвин, заах арга зүйг

боловсруулах зэрэгөргөн хүрээтэй сэтгэж бүтээдэгуран бүтээлч болохыг нь түүний бүтээлүүд харуулж байна

Түүний бүтээлүүд нь бурхны шашны урлагийн сэргэн мандалтад үнэтэй хувь нэмэр оруулж, бурхны шашны эртний өв уламжлалыг сэргээн, бурхны шашин, соёлыг дэлгэрүүлж байгаагаараа үнэ цэнэтэй. Энэхүү гэгээн үйлс нь Монгол орны төдийгүй дэлхийн нийт бурхны шашинтнуудад танигдаж, Нидерландын Хун тайж Клаусын нэрэмжит 2008 оны шагналыг хүртсэн билээ. Үг болгоноос нь гэрэл цацарч, үйлс бүхэнд нь буян хурсан Бурханч лам Г.Пүрэвбаттай Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд уран бүтээлийн үзэсгэлэнгээ толилууж байхад нь уулзаж, ярилцснаа уншигч та бүхэнд хүргэе.

- Дэлхийн хэмжээний нэр хүндтэй шагнал хүртсэнд уншигчдынхаа өмнөөс баяр хүргэе. Үзэсгэлэнгийн талаар танилцуулна уу?

- Монголчуудын уламжлалт сонгодог урлаг нь уран дархан, уран барилга, цам бүжиг, хот мандал, сийлбэр, шүтээн зурагтээ нийтдээ 36 төрөл зүйл байдаг. Үүнээс зөвхөн сонгодог шүтээн зургаа голлосон, хамгийн шилээвэр сайн 78 бүтээлээрээ үзэсгэлэн гаргалаа. Сонгодог шүтээн зураг нь бурханы шашны урлах ухааны нэгэн ай савд багтдаг. Монголчуудын

урлахуйн ухаан нь таван их ухааны нэг. Ийм их ухаан болдогийн хувьд энэ зургийг бүтээж байгаа тогтолцоо нь хүнийг гэгээрэлд хүргэх арга замтай барилдсан байдаг. Зурж байгаа хүн нь бясалгал бүтээлийг хийгээд ном эрдэмд суралцаад, сэтгэлээ хөглөж хөгжүүлдэг. Үзэж харсан хүн биширч сүсэглэн, бясалган бүтээж гэгээрэлд хүрдэг арга зам болдогучиртай. Бурхан Будда багшийн айлдсан наян дөрвөн мянган номын цогцыг дүрсээр илэрхийлсэн, бэлгэдлийн урлаг гэж ойлгох хэрэгтэй. Энд байгаа хэлбэр дүрс, өнгө будаг, зураас татлага бүхэн өөрөө утга санаа агуулдаг. Бид цагаан толгойн 35 үсгийг цээжлээд холбож унших аргыг нь заалгаад хүний ярьж хэлж болох бүх зүйлийг бичээд уншиж ойлгодог. Үүнтэй

адил энэ өнгө, дүрс, зургийг онолын тогтолцоогоор харж бясалгаж, бурханы сургаалийг мэдэж, тогтоож гэгээрэлд хүргэдэг. Энэ нарийн гүн ухааны бэлгэдэл номлолын тогтолцоог бий болгосон урлаг бол монгол оронд уламжлагдсан Очиртарнийн хөлгөний шашинд байгаа урлаг. Ийм урлаг өөр ямар ч улс оронд байхгүй. Ховор гайхамшигт үзэгдэл яах аргагүй мөн. Монголчууд бид энэ гайхамшигийг өвлөж авснаараа бахархах ёстой

- Таны эдгээр бүтээл ямар хугацаанд бүтээгдсэн бэ?

- Хугацаа гол биш. Хэр хэмжээний том, ямар бүтээл болох гээд тухайн хүний хөдөлмөртэй холбоотой. Анх зурж эхэлсэн цагаас өнөөдрийг хүртэл зурсан бүтээлүүдээсээ дээжлэн хүргэж байгаа нь энэ юм. Хүн төрөлхтөн дэлхий нийт Монголын өв соёл, сонгодог урлагийг ойлгож мэдэрч эхэлсэн энэ цагүед бид өөрсдөө илүү гүнзгий ойлгох, мэдэх, сэргээх, суралцах цаг нь нэгэнтээ болсон. Тухайн улс орны үндэсний соёл нь тэр орны хэв шинж дархлаа нь болдог. Өвөг дээдсийн өвлүүлсэн их баялаг сан маань бидний бахархал болж байна. Үүнийгээ мэдэхгүйгээр бид өөрсдөөрөө бахархах, дэлхийд таниулах боломж хаагдмал. Иймээс Үндэсний урлаг соёл уламжлал шинэчлэгдэж байгаа энэ цаг үед монголчууд түгээн дэлгэрүүлэх, ойлгож, дэмжих, суралцах үйлсэд гар бие оролцох цаг нь болсон гэдгийг хэлэх байна.

- Үзэсгэлэнгийн гол онцлогийн тухай тодруулж хэлж өгнө үү? Үзэсгэлэнгийн хувьд гурван том онцлог байна. Үүнд уламжлалт урлагт байгаагүй хоёр зүйлийн шинэчлэл хийсэн. Хувь хэмжээний онол гэж бурхныг зурдаг онол байдаг. Гоо сайхныг илэрхийлэх онол гэж хэлж болно. Гэтэл амьтныг ингэж хувь хэмжээнд оруулан хялбар зурж сурах онолыг шинээр зохиолоо. Энэ онолоор зурж сурах юм бол амьтныг сарын дотор л ямар ч алдаагүй зурах аргад суралцаж болох онолын

тогтолцоог боловсруулан гаргасан. Энэ онолын жишээ болсон зургууд үзэсгэлэнд тавигдсан байгаа. Хоёрт нь, үндэсний урлагт гэрлийг, амтыг, хөгжмийн эгшгийг хүртэл яаж илэрхийлж гаргаж болох вэ гэдгийг зориуд үзүүлсэн бүтээлүүд ч бас байна. Мөн сонгодог уламжлалт урлагийг бүтээх хамгийн сайн шилээвэр арга ажиллагааг нэг бүтээлд нэгтгээд, цогц болгон урьд бүтээгдэж байгаагүй өвөрмөц шүтээн зургийн буюу уламжлалт монгол зургийн төрөл зүйл, сургууль дэгийг бүтээснээ батлан харуулсан бүтээлүүд тавигдснаараа ихээхэн онцлогтой юмаа. Монгол зургийг торгоор зээглэж болон хатгаж бүтээж болдгийн жишээг ч энд тавьсан. Ийм онцлогууд оршиж байна.

- Уулзалтын үеэр Энэтхэгийн элчин сайд тантай нэлээд удаан ярилцлаа. Мөн зарим элчин сайдууд эх орондоо үзэсгэлэн гаргахыг урьсан тухай мэдээлэл өгч байсан. Энэ тухай тодруулж

хэлж өгнө үү?

- Тийм. Зургийн материал, арга барил, багш чинь хэн байсан гэхчлэн сонирхож байна лээ. Бусдын үндэсний урлагийг мэдэх хэрээр улс орнууд бие биеэ гүнзгий ойлгодог юм байна. Хамгийн сайхан харилцаа гэдэг чинь энэ. Бид 1937 онд хамаг соёлоо үгүй хийчихсэн улс. Түүх нь худлаа, үндэсний соёл урлаг нь хаагдмал байлаа. Харин 1990-ээд оноос хойш түүх, соёл, шашнаа судлаад мэдээд ирэхээр энэ тухай бие биедээ хэлэх, дэлхий дахинд таниулах хэрэггарсан. Тэр цагүе нь одоо юм. Ямар ч байсан үндэснийхээ сонгодог соёл урлагийг гадны улсад зөв таниулж чадах юм бол Монголын тухай үзэл, ойлголт, сэтгэгдэл, харьцаа өөр болох учир энэ үзэсгэлэнг зохион байгууллаа. Монголчууд мартагдсан соёлоо мэдэж, ойлгоно гэдэг том бахархал шүү. Герман, Энэтхэгийн Элчин сайдын яамныхан энэ талаар их сайн ойлголттой. Чехийн Элчин сайд ч их өндөр сэтгэгдэлтэй байгаагаа хэлсэн. Германд, Нидерландад үзэсгэлэн зохион байгуулья гэж урьж байна. Соёл урлаг, шашин нь тухайн улс орны тусгаар тогтнолын гол суурь

болж, ард түмнийг нэгүзэл санаатай болгон нэгтгэдэг. Америкийн Индианчууд, Манж Чин гүрнийг хар л даа. Үндэсний соёлоо алдсан учраас түүхийн хуудаснаас хэзээ ч гарч ирэхгүйгээр арчигдаж, уусаад алга болсон. Ингэж устдаг учиртай.



- Зарим бүтээлүүдээсээ тайлбарлаж өгнө үү?

- Монголчууд өвөг дээдсээ шүтээнчлэн бүтээдэг уламжлалыг харуулсан “Манзушир хутагт Цэрэндорж”ийн дүр, хөрөг шүтээн зураг байна. Эндээс Монголчууд өвөг дээдсээ хэрхэн яаж шүтээнчлэн бүтээж болдогийн жишээ болгож, хэд хэдэн бүтээлээс дээжлэн үзүүлсэн нь энэ. Манай монголчууд эрт дээр үеэсээ багш нараа, өвөг дээдсээ хэрхэн шүтэж дээдэлж ирсэнийг шууд харж болно. Хувь хүмүүсийн хөрөг дүрийг ч ингэж бүтээж болно. “Энхийн эгшиглэн” гэж лимбэ үлээж буй сайхан монгол бүсгүйн хөрөг зураг. Оюутан байхдаа бүтээж эхэлсэн загвар зургаа төгс бүтээлийн хэмжээнд хүргэж зурсан. Хүний сэтгэлийн амар амгалан, байгаль дэлхийтэйгээ шүтэн барилдсан зохилдолгоог эгшиг дуу маягаар зурагт харуулсан. “Зүүд” гэж хатгамал зураг бол унтаж буй согоо, үүлэн дунд нэг сайхан хангал буга янзагаа дагуулаад нисэж байгаа ардын зохиомжийгуран хатгамалын аргаар бүтээвэл ямар зохимжтой болохыг

үзүүлсэн. Ер нь бурхан зурж сурахын тулд эхлээд хүн амьтаныг сайн зурж сурах хэрэгтэй. Энэ нь нэг ёсны дадал болж өгдөг. Мөн Уран барилгын уламжлалт урлал бол гайхамшигтай. Ялангуяа хот мандал гэдэг том урлагийн төрөл зүйл нь уран барилгын гол үндэс. 15400

орчим хот мандал байна. Цогт үр цогцолсон суварга Хөвсгөл аймгийн Жалханз хутагтын Дүнхор дацангийн хажууд байсан суварганы уламжлал. Ингэж бүтээсэн нь манай Монголоос өөр оронд байхгүй. Хорин дөрвөн метр өндөр бүтээн босгох гэж загварыг нь хийсэн юм. Ирээдүйд энэ сайхан сүм суварга баригдах байхаа.

- Таны байгуулсан сургууль орчин үед уламжлалт урлагийг өвлүүлэхэд маш их гавьяатайг мэргэжлийн хүмүүс үнэлдэг. Шавь нарынхаа тухай ярина уу?

- Урлах ухааныг сэргээхэд хамгийн гол нь онолын хувьд сайн сэргээж, ном товхимлыг нь хийж хойч үед гарын авлага болгон гаргах ёстой. Хоёрт нь, хувь хүмүүст шавь сургалтаар олон хүнийг сурган бэлтгэх хэрэгтэй. Ингэж байж уламжлагдана. Харин туршлагаас харахад ганц нэг хүнд заагаад нэмэргүй. Нэг хүн сайн сурчихаад таалал төгсөх юм бол уламжлагдах явдал осолтой болно. Ийм учраас сонгодог сургалтыг өвлүүлсэн дэг, тогтолцоо, сургуулийн хөтөлбөр бүх юмыг нь би өөрөө гардан хийж шавь нарыг бэлтгэн сургаж эхэлсэн. Дундаас нь орхисон шавь нарыг эс тооцож, маш сайн сурсан 70 гаруй шавь байгаа. Буриадын сайн сурсан дөрвөн шавь маань одоо тэндээ салбар сургууль байгуулаад сайхан ажиллаж байна. Тува хүүхдүүд ч их сайн сурч байна гэхээр Монгол туургатны хэмжээнд хүрээгээ тэлж байгаа юм. Мөн 21 аймгийн сүм хийдүүдээс нэг хоёр хүүхэд сургасан нь одоо аймаг аймагтаа очоод ажиллаж байна. Эцэст нь урлаг бол худлаа байж болохгүй. Бодот хийсэн бүтээлээрээ хэмжигддэгчраас нотлон үзүүлэх хэрэгтэй. Мөн сонгодогуламжлалт урлагийн 24 төрөл бүр дээр нь онолын ном гаргана гэж бодож, анхны номоо гаргасан . Одоо хоёр дахь номоо бэлтгэж байна.



“Энхийн эгшиглэн”


- Та эрдмээ өвлүүлсэн багш нарынхаа тухай эргэн дурсвал сонин байх болов уу?

- Би Дүрслэх урлагийн сургууль, шашны сургууль төгссөн. Миний өвгөн багш нар Данзан багш, Доржжанцан гээд сайхан буурлууд байсан юм. Өөр заалгаад өвлөөд авсан хүн лам нарын дотор байсангүй. Мэргэжлийн зураач хүү ирлээ гээд баярлаж надад итгэж, заагаад, цаашид уламжлан дамжуулаарай хэмээн захисан. Гэрээслээд авсан учраас өрөнд орсон хүн шиг л хүссэн хүсээгүй энэ бүгдийг хийж таарах учиртай болсон доо. Дутуу, онцгой бусад зүйлийг нь Энэтхэгт Төвдийн бурхан урлалын сургуульд сурахдаа гүйцээж авсан. Ингээд миний гараар тасрах шахсан монголын урлах ухааны 36 төрөл зүйлийн хорин дөрөв нь сэргэлээ. Бусад нь нийтийн бус цөөхөн хүнээр дамждагучраас тооцохгүй л дээ. Ийм том том зүйлүүд нэг хүнээр дамжин уламжлагдан үлдэнэ гэдэг бол хэр баргийн хүний санаанд багтамгүй. Хамгийн гол

нь уламжилдаг тогтолцоо нь нарийн юм. Үүнийг нарийн ойлгох хэрэгтэй. Тэгсэн цагт л боломжтой.

- Уламжлалт урлагаа дээдлэн дэлгэрүүлэх ажилд авьяас билгээ зориулах гол сэжим нь юу байв. Таны өвөг дээдэст чинь уран зураач, лам хүн байсан уу?

- Ээж маань багадаа өнчирсөн. Өргөж авсан хүн нь урьд лам байгаад хар болсон Шарав гэж сайхан буурал байсан юм. Өөрөө хүүхэдгүй, хэдэн өнчин хүүхэд авч хүн болгосны нэг нь миний ээж. Амралтаараа өвөөгийн дор очиж туслаад, өвөөгийнхөө орой болгон ном уншихыг дагаж сурч, их үлгэр домог яриулдаг байлаа. Гарма, мядагма, дэчивма, лүйма гээд тахилын охин тэнгэрийн нэрийг дуудаж байгааг нь мэдэхгүй учир “Манай өвөө дандаа хүний нэр хэлдэг” гээд шоолдог байлаа. Гэхдээ өвөөгөөсөө сурсан домог түүхээ хотныхоо хүүхдүүд, сонирхсон хэнд ч ярьж өгч, цээжилж тогтоосон маанийн үсгээ өнөөдрийн энэ урлагийг хөгжүүлэх үйлсэд хөтөлсөн сэжим гэж хэлж болно. Мөн сонссон үлгэр домог багаасаа зурдаг байлаа. Дүрслэх урлагийн сургуульд ороод дандаа түүхэн баатар зурахад, зохиомжийн багш Ардын зураач Амгалан гуай намайг хэрэгт орно гэж цааргалдаг байсан ч би өөр юм зурах дургүй. Дандаа үлгэр домогийн үйл явдалыг зурдаг байсан. Дипломын ажилаа “Амар сайхан жаргав” гэсэн нэрийн дор Чингис хааныг домог болгож зурсан нь тэр үед хүмүүсийн анхаарлыг их татаж байсан юм. Хожмоо Дүрслэх урлагийн сургууль төгсөхөд, манай урчуудын эвлэлийн хороо, Н.Цүлтэм гуай маань их дэмжиж, бие даасан, цалинтай уран бүтээлч болгож авсан юм. Би нэг жил ажиллаад, саналаараа цэрэгт явсан ч эцэст нь хүртэл монгол зургийг сурья гэж бодсон учраас тууштай зүтгэсэн. Сайн монгол зураач болохын тулд бурханы шашныхаа гүн ухааныг ойлгохгүй уншихгүй бол хэзээ ч Монголын сонгодог урлагийг ойлгож зурна гэж байхгүй. Иймээс шашныхаа чиглэлээр гүнзгий суралцаж, үндсэндээ урлаг намайг хөтөлсөн гэж хэлж болно.



“Зүүд” хатгамал

- Үндэсний шашин соёлын онцлог нь юу вэ?
- Монголыг түүх шашнаас нь салгах юм бол Монгол монгол биш болно гээд түүхийг нь гуйвуулж, шашин соёлын маань маш их өв сангустгасныг хүн бүхэн мэдэж байгаа. Соёл шашин гэдэг бол тухайн улс орны тусгаар тогтнолын гол суурь нь болж, ард түмнийг нэгүзэл санаатай болгон нэгтгэдэг. Америкийн Индианчууд, Манж Чин гүрнийг хар л даа. Үндэсний соёлоо алдсан учраас түүхийн хуудаснаас хэзээ ч гарч ирэхгүйгээр арчигдаж, уусаад алга болсон. Ингэж устдаг учиртай. Дэлхийн бүх улс орнууд үндэсний хэл соёл түүх, шашнаа хуульчилан хамгаалдаг. Манайхан дэлхий нийтэд үндэсний соёл шашнаа таниулж чадалгүй 1937 онд устгуулсан. 1990-ээд оноос л сэргэлээ шүү дээ. Саяхан намайг оюутан байхад бурхан зурлаа гээд л хотын цагдаагийн газраас нэгждэг шалгадаг байлаа. Өнөөдөр харин цаг өөр болж бидэнд боломж нээлттэй байна.
- Монголын урлаг дэлхийн түвшинд авч үзвэл ямар хэмжээнд үнэлэгдэж байна вэ. Саяхан таны хүртсэн шагнал бас энэ хэмжүүрийг нэлээн дээд түвшинд байгааг харуулсан том жишээ боллоо гэдэгтэй та санал нийлэх үү?
- Манай үндэсний сонгодог урлаг зарим зүйлээрээ хүн төрөлхтөний соёл урлагийн хамгийн дээд түвшинд, тэргүүнд байгаа гэж хэлж болно. Би үүнийг сэтгэлийн хөдөлгөөнөөрөө хэлж байгаа юм биш. Уншсан, судалсан, нягталсан хүний хувьд баталгаатай хэлж байна. Ганц жишээ дурьдая. Европынхон бол хүний гаднах төрх улмаар гоо үзэсгэлэнт бүсгүй, булчин шөрмөслөг эр хүний гадаад дүр төрхийг гайхамшигтай сайхан дүрсэлсэн байдаг л даа. Олон жишээ болсон бүтээлүүдийг бид мэднэ. Ер нь урлаг бол хүний гоо сайхныг л магтан дуулдаг. Алдарт Джокондагийн зургийг бүтэн хорин дөрвөн цагийн турш харуулууд хамгаалдаг. Энэ бол маш их хүндэтгэж байгаа хэрэг. Харин Дорно дахинд, ялангуяа манай монголын уламжлалт Очир тарнийн шашинд хүний сэтгэлийн гоо сайхныг бүтээдэг. Хүний сэтгэл нь ариусаад ирэхээр бие нь хувьсан гоо сайхан болдог. 33 бэлгэ, наян найрал гээд нийт 112 гоо сайхны шинжээр хувьсан чимэгдэж гоо сайхан болдог. Тэр гоо сайхны онолыг бурхан багш хувь хэмжээний онолоороо номлосон нь гоо сайхны маш том шалгуур болдог юм. Энэ

бүхнийг зураас шугаманд оруулаад тигийн онолыг бүтээсэн. Энэ онолоор тухайн бүтээлийг ямар хэмжээнд бүтээгдсэнийг шалгаж болдог номтой. Би Түвд, Энэтхэг Япон, Солонгос, Хятад гээд хэд хэдэн улс орнуудын шилээвэр гэсэн бүтээлүүдэд судалгаа хийж үзэхэд, 60-70 хувьдаа ч хүрэхгүй байгаа юм. Харин Өндөр гэгээн Занабазарын бүтээлүүд дээр судалгаа хийхэд уруулын шөмбөгөр, нүдний өнцөг нь гээд л бүх талаар энэ онолдоо зуун хувь таардаг. Энэ тухай би Японд одоогоос гурван жилийн өмнө болсон олон улсын шүтээн зургийн их

хуралд оролцохдоо илтгэл тавьсан. Хүний сэтгэлийн ариушлаар гоо сайхныг бүтээсэн, илэрхийлсэн бүтээж чадсан хүмүүс бол дэлхийд Монголчууд л байна. Өндөр Гэгээн Занабазарын бүтээлүүд ямар гайхамшигтай, монгол хүний ур ухааны чадвар дэлхийд тэргүүн эгнээнд байгааг баталж байна. Үүнийгөвлөж авснаараа бид азтай агуу ард түмэн. Бахархаж, судалж, дэлхийн хэмжээнд илүү мэдрүүлэх ёстой. Сонгодог урлагийн эх орон Нидерландын Хунтайжийн нэрэмжит шагналыг олон улс орнуудаас онцолж ийнхүү уран зургийн төрөлд өгсөн нь Монголын үндэсний урлагийг хүлээн зөвшөөрсөн их том үнэлэмж гэж бодож байна. “Монголчуудын өвөг дээдсээс уламжлагдан ирсэн өв соёл, монголчуудыгүнэлсэн үнэлэмж” гэж Элчин сайд нь өөрөө айлдсан.

- Баярлалаа. Таны уран бүтээл, Үндэсний шашин соёлоо дэлгэрүүлэх гэгээн үйлсэд тань өлзий бэлгэдэе дээ.

“Цаг төр” сэтгүүл. 2008 он 04-р сар.

Хариу нэхээгүй хайр гэдэг хамгийн агуу хайр



Төрийн соёрхолт зураач С.Саранцацралтын “ТIМE” үзэсгэлэнгийн үеэр

Төрийн соёрхолт зураач бүсгүй С.Саранцацралт “ТIМE” нэртэй үзэсгэлэнгээ Хаан банкны Арт галерейд дэлгэн үзүүлсэн нь уран зураг сонирхогчид, судлаачид, мэргэжил нэгт уран бүтээлчид, оюутан залуус гадаад дотоодын олон зочдын билгийн мэлмийд гэрэл нэмж, сэтгэлийн цэнгэл бэлэглэлээ.

Зураач бүсгүйтэй баглаа баглаа цэцэг тэвэрч, олон зочидоороо тойрон хүрээлүүлээд байхад нь уулзая гэж бодсонгүй. Үзэсгэлэн буух өдөр. Түр амсхийсэн, нам гүм байдалд ярилцахыг илүүд үзсэн юм. “Урлаг ямар ч хүнийг аз жаргал, хайр, гэрэл итгэл үнэмшилд хөтөлдөг. Энэ бол урлагийн ид шид, эрч хүч, утга учир. Урлаг худал хуурамч байх боломжгүй ариун нандин зүйл” шүү гэж инээмсэглэн хэлсэн нь түүний амьдралыгүзэх үзлийн нь гол төв нь болов уу гэсэн таамаглал төрсөн. Би зөв таасан гэдэгтээ итгэлтэйгээр ярилцсан юмаа.



“Цуутын цагаагч гүү” С.Саранцацралт

- “ТIМE” уран бүтээлийн үзэсгэлэн урлагийн ертөнцөд багагүй шуугиан тарьлаа. Үзэсгэлэн буух энэ агшинд та ямар сэтгэгдэлтэй байна.

- Нээлтийн өдрөөс арай өөр дүгнэж цэгнэсэн, олны санаа бодлыг тунгаасан, бас илүү эрч хүчтэй, шинэ уран бүтээлийн санаагаар дүүрэн байна. Ер нь үзэсгэлэн бууж байгаа өдөр их сайхан байдаг. Энэ миний 25 дахь бие даасан үзэсгэлэн. Үзэсгэлэнгийн үеэр л үзэгчидтэйгээ уулзах, дотно ярилцах, тэдний санаа бодлыг сонсох боломж илүү олддог. Зарим хүмүүс

“TIME” үзэсгэлэнг маань Булган, Хэнтий, Эрдэнэт гээд холоос зорин ирж, үзээд халуун урам хайрлан сайхан байлаа. Ер нь үзэсгэлэнгийн өдрүүдэд сэтгэл маш их догдолдог. Шинэ үзэсгэлэн гаргах бүртээ үзэгчдийн уран зургийг ойлгох нь илүү сайн болж байгааг мэдэрдэг. Бас үзэгчид их залуужжээ. Их амжилттай, сэтгэл хангалуун байна.

Цаг хугацааны үнэ цэнийгуран зургаар ийн илэрхийлжээ. Үүнийг үгээр хэлвэл...

Цаг хугацааны тухай хүн бүр өөр өөрийн бодолтой байдаг. Өнгөрсөн хором мөч бүхэн эргэж ирэх билүү гэдгийг би өөрийнхөөрөө анхаарч, ажиглажэнэ бүтээлүүдээ туурвисан. Цаг хугацаа бол алт байтугай аминаас ч үнэтэй зүйл. Ийм учраас энэ үзэсгэлэнгийнхээ зураг бүрийн ард нь хэзээ эхэлж, дууссан цаг хугацааг нь тавьсан байгаа. Жишээ нь “Эрвээхэйг ямар их гоо үзэсгэлэнтэй бүтээсэн юм бэ дээ. Эрвээхэй ердөө 2172 цаг амьдардаггэнэ. Энэ хугацаа нь магадгүй өөрийнх нь хувьд 93 жил ч байж болох юм” гэсэн тайлбарт би цаг хугацааны тухай л өгүүлсэн.

- Та уран бүтээлээ яг ямар чиглэлээр илүү урладаг вэ?

- Би өөрийгөө дотоод сэтгэлгээний зураач юм гэдгийг ойлгосон, таньсан. Ямар ч хүн амьтан, эд зүйлсийн гаднах төрх үзэгдэх байдлаараа энгийн ойлгомжтой. Харин дотоод мөн чанарыг нь таних, ухаж ойлгохыг би илүү хичээж, өөрийн мэдэрсэн, хүртсэнээ бүтээлдээ тусгадаг. Хэдийгээр энэ амаргүй ч зураач хүн өөрийнхөөрөө нээж тайлдаг. Хүн өөрийнхөө дотоод мөн чанарыг мэддэггэж үү? Зарим хүнээс та өөртөө итгэлтэй байна уу? гэж асуухад, тийм би маш итгэлтэй байна гээд дэгжин хувцаслалт, цоглог төрх, зан араншиндаа илүү итгээд дотоод мөн чанар, хүч энергиэ мэдрээгүй ярьснаас болж үр дүн нь бодот байдлаас нь өөр болж хувирдаг. Би энэ мөн чанарыг л илүү их гаргаж, зургуудаараа нотлон харуулахыг хичээлээ. Миний бүтээл бүрийнхээ ард бичсэн тайлбар цаг хугацаанаас гадна үзэгсэд өөрийнхөөрөө бас их тайлбарлаж байна.

- Үзэгчид үзэсгэлэн үзэхээс гадна хайрын тухай ном уншсан мэт сэтгэгдэл төрөхөөр тайлбарууд нь зураг бүрийг чинь илүү тодорхой болгожээ гэж бодож байна.

- 1992 онд би анхны үзэсгэлэнгээ дэлгэж байсан. Өнөөдрийг хүртэл хайрыг олон бүтээлдээ шингээсэн. Аливааг хайрлах энэрэх хөрөнгийг бурхан бидэнд анх төрөхөд өгдөг. Гэтэл хүн өөрийнхөө тэр хөрөнгийг дараад байдгаас олон муу үр дагавар гардаг болов уу. Энэ хөрөнгийг исгээд сайхан хайрын талх бариад бусдад

хүртээх юм бол амьдрал улам аз жаргалтай болдог л доо. Хайр бас хөгжинө. Хайрыг бид өөр өөрийнхөөрөө хөгжүүлэх боломж байна. Үүнээс хариу нэхэхгүй хайрлах нь хамгийн чухал. Зарим нь би тийм их хайрлаж байхад даанч дээ гэж халаглаад байдаг. Харин хариу нэхээгүй хайр гэдэг бол хамгийн агуу хайр. Хариу нэхээгүй хайрын хаялга нь түүнийгээ дагаад их өгөөмөр, амар амгалан, илүү их эрч хүчийг өгдөг гэж би боддог.

- Танд огт хайрламааргүй зүйл байдаг уу?

- Байхгүй дээ. Хайр бол их эрч хүчтэй зүйл. Дургүй зүйлээ үнэн сэтгэлээсээ хайрлаад, урмаар тэтгээд өгөхөөр аяндаа өөрийн хүссэнээр болдог. Над руу хичнээн их дайрч

доромжилсон ч гэсэн би түүнийг хайрлах нь л чухал. Хайрламааргүй байна гэдэг чинь хүсэлд нь нийцэхгүй болоод л тэр биз дээ. Тэгвэл эсрэгээр нь хайрлаад үз. Манай монголчууд зөөлөн нь хатуугаа гэж ярьдаг шүү дээ.



“Дарь эх” С.Саранцацралт 2010

- Төмөр даашинзтай зураг их сонирхол татлаа...

- “Энэ ертөнц дээрх хүмүүсийн зовлон гэдэг яг л ийм төмөр даашинз өмссөн мэт байдаг. Энэ төмөр

даашинзыг хүн өөрөө урладаг. Уур хилэн, үзэн ядалт, атаа хорсол, айдас, эргэлзээ хэмээх таван өнгийн утсаар урладаг. Гэвч үүнээс өөр даашинз урлах ур ухаан чадвар хүнд байдаг уу? Би хэн бэ? Хаанаас ямар зорилготой ирэв? Би зүгээр л бие махбод, бодгаль төдий зүйл биш. Энэ гараг ертөнц дээрх бүх л зүйлс хүмүүстэй холбоотой. Би оюун санаа, гэрэл долгион, эрчим хүч хайраар холбогддог. Надад зорилготой утгатай амьдрах хүч бий. Яг л од, гараг эрхэс оргил хөдөлгөөндөө зүй зохицлоороо оршин байдагтай адил би бас тэр төгс төгөлдөр, зүй зохицолдоо оршин байгаа. Би өөрийгөө зөв газраа, зөв хугацаандаа зөв зүйлээ хийж байгаа гэдэгтээ итгэл дүүрэн байна. Энэ зургийг 7 өдөр 56 цаг 32 минут 15 секундэд зурж дуусгав.” Энэ тайлбараас бүх зүйл тодорхой харагдаж байна. Би өөрийнхөө бодлыг л ингэж зурсан хэрэг.

- Таны баримлуудыг хүмүүс андахгүй. Баримал урлаж байна уу?

- Хийж байгаа. Зөвхөн барималч гээд баримлаа бариад, зураач гээд зураг зураад л байх юм

биш. Уран бүтээлийн санаагаа олоод нөхцөл нь бүрэлдсэн л юм байх юм бол цаг харамгүй туурвидаг. Миний хувьд яг нэгийг нь барьж дагнадаггүй. Хийе гэснээ л хийдэг.

- Ер нь өөрийн эрхгүй л зурчихаад байдаг дуртай өнгө чинь ямар өнгө вэ?

- Би бүх л өнгөөр зурах дуртай. Тэр дундаас хар өнгийг илүү эрхэмлэдэг. Хар өнгийг хар муу, муухай бараан гэдэг ч миний хувьд их гэгээлэг өнгө. Учир нь ямар ч өнгөтэй найрсахдаа маш гоё найрсаж, хувьсаж, эвсэж чаддаг, бусад өнгөө өөд нь татаж, ялгаруулдаг их чөлөөтэй ардчилсан өнгө шүү. (инээв). Өөр өнгөнүүд бол бусдаас илүү байх гэж тэмүүлдэг гэж хэлж болно. Цагаан өнгө сайхан, бас гэгээтэй ч эрх чөлөөнд минь халдаад байх шиг санагдаад биеэ барьж, энэ өнгөөр зурахдаа их л хичээгээд байдаг. Цагаан хувцас өмсчихөөрөө бид их

болгоомжтой болчихдог шүү дээ. Яг үүнтэй адил. Би хувцаслалтандаа ч хар өнгийг илүү таашааж сонгодог юм.

- “Цуутын цагаагч гүү” зургийн түүхийг манай уншигчдад сонирхуулахгүй юу?

Энэ зургийг таван настай хүүхэд байсан үеийнхээ дурсамжаас сэдэвлэж зурсан. “Намайг бага байхад ээж маань “Цуутын цагаагч гүү” гэдэг сайхан үлгэрийг ярьж өгөхөд миний сэтгэлд их гүн сэтгэл төрүүлдэг байж билээ. Тухайн үед би тэр үлгэрийг сонсож суухад яг л энэ зураг шиг дүр төрх надад харагддаг байлаа. Энэ дүр төрхийг би яагаад ийм удаан, ийм олон жил оюун санаандаа хадгалан үлдээсэн хирнээ өнөөг хүртэл уран бүтээл болгон зураагүй юм бэ? гэж өөрөөсөө асуусан. 40 жил буюу 14600 хоног 357120 цагийн дараа энэ зурагуран бүтээл болон танд хүрч байгаагаараа онцлогтой. Үнэхээр аливаа зүйл өөрийн гэсэн цаг хугацаатай байдаг. Цаг нь болж нөхцөл нь бүрэлдэх үеийг тэсэн хүлээж сурах хэрэгтэй юм байна л даа” гэсэн тайлбартай. Би ээжийгээ ярьж өгөхөд үлгэрийн баатруудыг нь өрөвдөөд үнэхээр их уйлсанаа одоо ч мартдаггүй юм. Харин зурах тухай ерөөсөө бодож байгаагүй ч ёстой цаг нь болж нөхцөл нь бүрдээд л ийм бүтээл болж чадлаа. Би өөрөө амьтныг хүнтэй адилхан хайрладаг.

Энэ дашрамд сонирхоход таны нохойнууд хэр олон болсон бэ?

- Одоо 40-өөд нохой байгаа. Саяхан би бас нэг сүүжийг нь хуга өшиглөчихсөн нохой олоод гэртээ сувилж байгаа. Удахгүй хагалгаа хийлгэнэ. Яагаад гудамжинд өлсч гэдэс нь наалдах шахаад явж байгаа нохойг сүүжийг нь хугартал өшиглөдөг байнаа. Нохой ч гэсэн сайхан дулаан орчин, сайн эзэн хүсдэг. Миний дээр өгүүлсэн хайрын хөрөнгөө исгээгүй хүн л өшиглөсөн байх даа.

- Үзэсгэлэнд цэцгийн зураг олон харагдлаа. Та өөрөө цэцэг тарьдаг уу?

- Би цэцэг арчлах тухайд ээждээ хүрдэггүй юмаа. Миний ээж сайхан цэцэг тарьдаг. Гэрт маань цөөхөн цэцэг бий.

- Уран зургаараа гэрээ хэр их гоёдог вэ?

- Загасчны морь усгүй гэдэг шиг би үүнийг нэг их гол болгодоггүй. Гэхдээ зураач хүний

гэрийг өөрийнх нь зурсан зургийгөлгөж тавиагүйгээр төсөөлөхгүй биз дээ (инээв).

- Нууц биш бол үзэсгэлэнгийн үеэр зургаас чинь зарагдсан уу?

- Өнөөдөр нийгмийн амьдрал ямар байгаа билээ. Бүтээлийг минь авья гэсэн уран зургийгүнэлдэг, хайрладагүзэгчиддээ тийм ч их өндөр, дэлхийн уран зургийн хэмжээний үнэ ханшийг санал болгоогүй. 1,5-6 сая төгрөгийн хооронд л байсан. Цөөн тооны зураг зарагдсан.



“Үнсгэлжин” С.Саранцацралт 2010

- Өнөөдрийн Монголын уран зургийн хөгжлийн талаар та ямар бодолтой явдаг вэ?

- Манай зураачид дэлхийн хэмжээний үзэсгэлэнд очоод тэдэнтэй эн зэрэгцэнэ үү гэхээс гологддоггүй. Үүгээрээ бахархдаг. Дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц боломжтой урлагийн бүтээлээрээ дүрслэх урлагийн салбар илүү байдаг. Харин манайхан урлагаа дэмжих тал дээр дутагдалтай хэвээр байсаар. Бид ч яахав ингээд бор зүрхээрээ явсаар өдий зэрэгтэй боллоо. Чадварлаг, авьяастай залуу уран бүтээлчид гарч ирж байна. Тэднийг хөгжлийн бодлогоор дэмжээд өгвөл сайхан авьяас, амжилтын эх булаг оргилж байгаа шүү л гэж хэлмээр байна. Гадаадын улс орнуудыг хараад байхад улсын бодлогоос гадна бизнесменүүд нь дэмжээд хөгжүүлээд байх жишээтэй. Манай зураачид чадалтай шүү дээ.

Бидний яриа ийн өндөрлөлөө. Энэ ч дэмий юмуу даа гэсэн нэг үг үсэг өгүүлбэр ч байхгүй сайхан гэгээлэг ярилцлага боллоо. Хар өнгийн хувцасаар гоёж, хар өнгийн нүдний шил зүүж, хар өнгийн машин хөлөглөн инээмсэглэн ярьж суугаа С.Саранцацралт зураачийн зураг болгоны цаана гэрэл гэгээ тунарах авай.

Яг одоо би нэгэн өвөрмөц зохиомжтой бүтээлийнх нь өмнө зогсож байна. Энэ зургийн урд нь чамин ганган өсгийтэй, гоёмсогулаан шаахайгаа тайлаад тавьжээ. “Би өөр лүүгээ явлаа. Тэнд шинжлэн судлах, танин мэдэх зүйл маш их байна. Буцаж ирэхдээ амар амгалан, хайр гэрэл гэгээ авчирч та бүхэнд бэлэглэнэ” гэсэн тайлбартай. Ахуй байдал, гаднах төрхийг эс анзаарч, дотоод ертөнцийнхөө хязгааргүй орон зайгаар чөлөөтэй аялагч уран зураач маань бидэнд ийнхүү өөр лүүгээ яваад ирсэн аян замынхаа тэмдэглэлийг “TIME” нэртэйгээр хүргэсэн нь энэ ажээ.

Өнгөрсөн, одоо, ирээдүй болон цаг хугацааны тухай нийт 30-аад шилдэг бүтээлүүдээ дэлгэн,

зурж эхэлсэн болон дууссан цагийг нь тэмдэглэсэн нь содон. 1 минут 1 секундээс эхлээд “40 жил буюу 14600 хоног 357120 цагийн дараа төрсөн бүтээл гээд цаг хугацааны тайлал бүхий олон сонирхолтой тайлбаруудыг бичсэн нь үзэгчдэд улам ойлгомжтой, нээлттэй, зураачийн дотоод мөн чанарт нэвтрэн орох зам, жим болж байсан юм.

С.Саранцацралт. Нэрнээсээ эхлээд үзэл бодол, үг яриа, хийсэн бүтээсэн туурвиснаараа онцгой, олны танил нэрт зураач боловч үзэсгэлэн болгоноороо бусдад танигдаагүй дүр төрхөө илүү гаргаж шинэ танил мэт содон сонин шийдэлтэйгээрээ хүмүүсийн анхаарлыгтойд татдаг гэж олон хүн үнэлж цэгнэдэг.

Энэ удаагийн үзэсгэлэнгээрээ ч амар амгалан хайр гэрлээр дүүрэн бүтээлүүдээ дэлгэсэн нь олон хүмүүний нүд сэтгэлийг баясгаж чадсан юм.

2009-04-28ны 12.48 минутаас 13.45 минут хүртэл Хаан банк Арт галерейд ярилцлаа.

2009.05.01 “Үнэн” сонин

“Огторгуйн очир”-ыг тунгаахуй

Ноён хутагт Данзанравжаагийн нэрэмжит шагналт Яруу найрагч Т.Содномнамжил

Хур бороо царайчилсан зуны дунд сарын нэгдөр юм даа. Нутагуснаасаа хол удаан явж ирснийхээ маргааш нь ээж хүү хоёроо дагуулаад, идээ өргөлөө бариад, Дорнод нутгийнхаа “гандан”-г зорилоо. Бурхан шашны нэр нь Данрагданжаалин хийд.

Үүх түүх нь өгүүлэх хүмүүнтэй маань зайлшгүй холбоотойн учир хэрвээ өдгөө амьд сэрүүн байгаасан бол хийдийнхээ баруун хойно нь суугаад, баринтагтай судраа дэлгэн маань мэгзмээ уншиж суугаа даа... гэсэн гунигтайхан бодол тээсээр гарч одсон юм. Тэр оройноо ээжээс нь шинэ номын дээжийг нь аваад эхний хуудсыг дэлгэх тэрхэн зуурт гуниг арилах шиг болж билээ. Т.Содномнамжил найрагч “Би “Ганцхан” гэдэгганцхан ном бичнэ” гэж хэлдэг

байсан юм. Харин түүний бүтээлийн өв санд хэд хэдэн ном болохоор бүтээлүүд үлдсэн юмаа.

Өдгөө хөх тэнгэрийн орноо туурвигч, их шүлэгчийн эгэлгүй мөрүүд өнгөрч одсон цаг хугацааны үнэн, зовлон жаргал аливаа бүхэнтэйгээ хамт бас нэгэн хөлгөн судар болж бидний өмнө дэлгэгдлээ.

I

Т.Содномнамжил. 90-ээд оны авьяаслаг найрагчдын нэгэн болох талаар мэдэх нэг нь мэднэ, мэдэхгүй нэг нь мэдэхгүй. Хамгийн гол нь мэдэх, мэдэхгүй нь хамаагүй. Нар нь газраасаа ургах шиггайхамшигтай гэгээн зүгийн шүлэгч “Үг бол тарни” хэмээн итгэж сүсэлсээр тэнгэрийн таалалд одсон авай.

“Зөөлөн мандах саран дор” тэрээр,

Урагдаж буй ертөнц нь цуурч буй даалимба

Урсаж буй орчлон нь цутган ирэх мөрөн

Хагарч буй ертөнц нь болор тунгалаг мөс

Хагацаж буй орчлон нь борооны дараах чимээ

Тун тунгийн бороо тунсаггэгээн өнгөтэй

Тунгалаг ариухан бүсгүй сэтгэлийн дотор чимэг

Цун цунгийн үүлс нь нисэн алсрах тогоруу


Цуурга цоожгүй сэтгэлд гоо үзэсгэлэн цуглана

хэмээн аливааг таньж, “Орчлонгийн явдал гунигтай”-гүе тэнгийн хэн бүхнээсээ эртэч нэгэн зөнч шувуу адил мэдэрч, анги ондоо олон шүлгүүдийгүзэглэн, өөрийн гэсэн өнгө, өвөрмөц ертөнцтэй Монголын утга зохиолын их өргөөнд орж ирсэн юм. Арван долоотой найрагч хүү энэ их өргөөний хаалгаар орж ирэхдээ эрхи эргүүлж, маань уншин, шар дээл, улаан орхимжтой байсан юм.

“Хаалга задгай Шамбалын Хаанаас нь ч орж болно”

гэж шүлэглээд тэнгэрийн орноо одсон тэр зун манай нутагт цэцэгс хүртэл намрын эхэн сартай золгож амжилгүй хагдарч, тэнгэр хүртэл их л уйлагнасан.

Эрхэс инээж байснаа больчих шиг болж, эргэж бодохоос өөр аргагүй олон бодлууд бүдгэрч өгөхгүй, харь хол явсан нэгнийг хэзээ ирэх бол доо гэж хүлээсээр, хаяа нь шуугаастай гэрийн сүүдэрт хөгшин эх нь нуухгаж суугаа харагдана. Хэцэн дээр өлгөөстэй байсан хоёр монгол цамц хэдийнээ хатаж, хэлхээтэй эрхиний нь зуун найман бөөр элэгдэхээ больж, дорно зүгийн салхи дахин нэг найрагчаар дугаад, бороо хүртэл хэтэрхий зөөлөн ганц нэгээрээ дуслан, болорын үзэмжит “Оюунтөгс”-ийн мэлмий гунигтай. Тэрбээр арван наймтайдаа миний эгч Б.Энхтуяатай үерхэж тэдний хайрын цэцэг болсон хөөрхөн охин Оюунтөгс нь аавтайгаа ямар адилхан гээч.



Дорнод аймгийн Данрагданжаалин хийдийн анхны лам нар. Яруу найрагч лам Т.Содномнамжил (Арын эгнээнд зүүн гар талаас) 1990

Т.Содномнамжил найрагч “...Оршин буй ертөнцийн хамаг үзэгдэл таны сэтгэлийн эрхээр элдэв чанарыг илтэд үзүүлэх боловч цөм өөрийн тоо хэмжээ, цагулиралтай байдаг. Энэ нь дотоод бясалгалын гүн агаараас номын ёсыг ямар мэт номлосныгүлгэрлэн хэлэх хөгжимт шинэ үдшийн аялгуу

юм. Хэдэн оны цаанаас цуурайтах эгшиглэнт аялгуу, өнгө хэмнэлийг мэдэрч, дэлхий даяар гялбаж буй хурц гэрлийн өнгө буюу ерөөс нэгдмэл гоо сайхны тухай ариун мэдрэхүйг олно. Буй... хоосон... гэсэн үгсийн байр хичнээн солигдовч ертөнц аль үгнээс нь эхэлсэн бэ гэдэг дээр өдий хүртэл маргасан хүн төрөлхтөний маргаан дуусаагүй байна. Янаг амраг мэт энэ хоёр үг сонсоход өөр мэт боловч угтаа нэг л утгыг илэрхийлнэ” хэмээн орчлонг таньж, уншиж, бичиж, сүсэглэж, зөгнөж байсан найрагч байсныг “Огторгуйн очир” судрын хуудсууд өгүүлнэ.

Их яруу найрагч О.Дашбалбар “Сэтгэлийн байгаль буюу Данзангийн Нямсүрэн” хэмээх алдартай нийтлэлдээ: “Дарьгангын яруу найргийн сургууль” бол өөр ойлголт бөгөөд тэр нь “Торой банди” хэмээх алдарт дууг зохиосон “Шар маань”, монгол ардын уртын дууны нэг манлай Дарьгангын “Жаахан шарга” дууг бүтээсэн Инжээ Норов, бүр сүүлд соён гэгээрүүлэгч их гүүш Доржийн Гомбожав, өвөрмөц соргог найрагч Д.Шагдарсүрэн, миний багш И.Батсүх нараар дамжин бидэнд улбаалан ирсэн, одоо “Дарьгангын гурав” гэж хочлогдох Д.Нямсүрэн, Г.Мэнд-Ооёо бидний шүлэгт тусгалаа олсон нэгэн сэжим буй хэмээн бичсэн нь буй.

“Дарьгангын яруу найргийн сургууль”-ийн хүрээний үргэлжлэл бол яахын аргагүй яруу найрагч Тогоонтөмөрийн Содномнамжил байсан юмаа.

Анх “Т.Содномнамжилын дорно дахины аястай, танин мэдэх чанадын нууцад нэвтрэх, эрмэлзэл дүүрэн тансагхан шүлгүүд нь эгэл даруухан энэ хүүд асар их авьяас билэг нуугдаж буйг харуулам.” хэмээн өгүүлэх их найрагч О.Дашбалбар агсны билгийн нүдэнд өртөж, холын бодолд нь олзлогдсон энэхүү цөөхөн магтаалын үг

Эрдэнийн гэрэлт охин алтан ховоогоор ус утгахуйд

Энхрий намуун аяс алсаас зөөлөн сонсдоно

Өлмийд нь ариун бүхэн хуран чуулж

Өнгө төгөлдөрийн яруу зохиролын эх ажээ

хэмээх яруу тансаг шүлгүүдээс нь үүдэлтэй. “Миний оюун санааны ертөнцөд гэгээ гэрэл гялбуулсан хүн бол миний нутгийн сэтгүүлч яруу найрагч Ишийн Батсүх. Номын гэрэлт өргөөнөөс нь би анх “Үүлэн зардас” Дандины “Зохист аялгууны толь” Уолт Уйтмений “Өвсний навч” гээд л Монголын болоод орчуулгын олон сайхан номыгуншиж гайхаж биширсэн юм. Харин энэ л номын санд тэмүүлэх эхлэл бол миний багш О.Дашбалбарын “Оддын аялгуу” түүвэр юм даа” гэж бахархан дурсаж суугаа найрагчийн сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлэхийн аргагүй. Хүн хүнээрээ бахархаж амьдрахын үнэ цэнэ, үнэн юм даа л гэж бодож суулаа.

Шашны дээд боловсрол эзэмшихээр Улаанбаатарт анх ирж байхдаа бурхны номоо сурахаас гадна “Оддын аялгуу” гийн зохиогчтой танилцана гэж бодож мөрөөдөж ирсэн нь мөнөөх буддын шашин, яруу найраг хоёр бол мөн чанар нэг юмаа гэсэн үзэл онолоо тээсээр л явсан хэрэг. Намрын нэг налгар сайхан өдөр эртний ерөөл ч юмуу би Дашбалбар багштайгаа Гандангийн Очир дарь хэмээх учралын бурхны өмнө танилцсан юм.

Багш надтай цөөхөн үг ярьж, мөргөл үйлдээд гарахдаа цүнхнээсээ “Цог” сэтгүүл гаргаж ирээд ард талын хуудасны нь “Хүүхдэдээ уншиж өгөөрэй” гэсэн хэсгийгурж аваад утасныхаа дугаарыг бичиж өгч гарт минь атгуулж бурхан багшийн мэлмий шиг нүдээрээ нэг их том харж инээгээд л цааш алхсан юм даг.

“Энэ бол яахын аргагүй миний амьдралын гэрэлт агшин” гэж яриад цонхны дэргэд очиж

ТЭНГЭРИЙН ЗҮГ ЯЛЫГҮЙ ИНЭЭМСЭГЛЭН ХАРЖ ЗОГСОЖ БАЙСАН ТЭР ӨДӨР ӨЧИГДӨРХӨН МЭТ БОДОГДОЖ ӨНГӨРСӨН АГШНЫГ ЭРГҮҮЛЖ АВЧИРАХ МЭТ САНАГДСАН НЬ ГАРЦААГҮЙ.

Улмаар тэд багш шавь бололцон, Со хүү О.Дашбалбар багшийндаа амьдарч, тухайн үеийн Соёлын сайд асан, одоогийн Ерөнхийлөгч Н.Энхбаяр, утга зохиолын судлаач шүүмжлэгч С.Энхбаяр гээд багшийгаа дагаж утга зохиолын хүрээний томчуултай уулзаж, буддын шашин, яруу найргийн тухай сонирхолтой яриа өрнүүлж байсан нь дамжиггүй.

Мөн О.Дашбалбар багшийнхаа эрдэнийн эрхи болсон олон шүлгийн нь анхны уншигч, сонсогч байсандаа тэр дотоод сэтгэлдээ маш их сэрэл авч, “сэрэл, мэдрэмж” гэдэг үгийн чадал үнэний гайхамшигийг олж авч чаддаг байсан тухайгаа ярьсан нь дуу хураагуурт минь одоо ч хүртэл бичээстэй байна. Энэ хуурцгийг сонсох бүртээ би хувилгаан найрагчтай дахин дахин ярилцах шиг болдог юм.

2001 онд юм даа. Улаанбаатраас Дорноддоо шилжээд ирлээ. Одоо ах нь буцаж явахгүй ээ, хийддээ сууна, нутагтаа ээжтэйгээ байна гээд ярьж байна. Аймгийн холбооны газарт байрлах бүсийн олон нийтийн радиогийн өрөөнд маань хааяа ирнэ. Хэд хэдэн удаа халамцуу ирсэн санагдаж байна. Ирэх бүртээ өөрийнхөө шүлэгнээс цээжээр хэдэн мөр уншиж өгдөг байлаа. Удалгүй Данрагданжаалин хийдийнхээ хамба лам болж бид ч их хөл хөөрцөг болов.

Харин намайг хааяа хотод ирэхээр яруу найрагчид, зарим найз нөхөд нь “Со юу хийж байна” гээд л асууна. Шүлгээ бичихээ больсон уу гэж асуух хүн ч таарч байлаа. Ингэж асуух бүрт нь ахыгаа уран бүтээлээ хийж байгаа гэдгийг нь мэдрүүлмээр сайхан ярилцлага аваад шинэ шүлгүүдээс нь төвийн хэвлэлд нийтлэх юмсан гэсэн санаа төрж билээ. Энэ тухай өөрт нь хэлэхэд огт тоодоггүй байсан юм.

2005 оны цагаан сарын шинийн хоёронд ээжтэй золгохоор манайд ирэхээр нь би бөөн баяр болж ярилцлага хийж, ээжээс нь шинэ шүлгээ бичсэн дэвтрийг нь өөрт нь хэлэлгүйгээр авчихлаа. Шүлэг, ярилцлагаа “Өдрийн сонин”-ы сэтгүүлч Б.Золбаярт хүнээр дамжуулаад явуултал “Дорно зүгт шүлэг төрсөөр л байна” нэртэй бичээд 2005-04-16-ны дугаарт нийтэлж өгсөн юм. Зөвшөөрөл авалгүй шүлгийн дэвтрийг нь авсандаа жаахан гэмшиж

байсан ч “Ийм том сонинд миний ярилцлагыг хэн хэвлүүлж өгөө вэ” гээд инээмсэглэн хэлж билээ. Үүнээс хойш бид уулзаж чадаагүй. Хайлаар хотоос зуны амралтаараа ирэхэд минь бурхны орон руугаа явчихсан байж билээ.

Их яруу найрагч О.Дашбалбар агсан “Ертөнц дээр хүн яруу сайхны цэнгэл эдлэж, ухаарах гэгээрэх, сэтгэлээ номхтгон амгаланг олж сайн үйлс бүтээх гэж ирдэг. Яруу найрагч үүнийг огоорбол мөхнө. Ертөнц дээрх хамгийн хуурч болдоггүй юм бол яруу найраг. Шүлэг бичнэ гэдэг бол өөрийгөө хойч үеийн шүүхэд өгч буй явдал. Үгээр тоглосон яруу найргаар маазарсан бүхэн мартагдалын далайд живдэг. Цагүедээ зохицож уншигчдыг илбэдсэн хуурсан бүх шүлэгч мартагддаг. Чин сэтгэлээс гараагүй мөр бүхнийг цаг хугацаа арчдаг” хэмээн их Т.Содномнамжил шавь шигээ олон авьяаслаг залуусыг найргийн гэгээн өргөөнд хөтөлж ирсэнийг өнгөрсөн цаг мөчүүд нэхэн санах дуртай...

Шилэн ээмэг шиг хаврын бороон дунд

Шинийн цасан адил чиний царай гэрэлтэнэ

Шинийн саран төгөлдөр уудам огторгуйн чинадад

Чиний царай юутай тод гэрэлтэнэ вэ

Мишээл төгс чиний минь арван наймтай дүр

Миний сэтгэлийн гуунд зураг болон үлджээ

Орчлон ертөнцийн эрхээр чамд дурлахаа больсон ч

Охин хонгорын үзэсгэлэн зуун зуунд мөнх өө...

гэсэн гэрэлт мөрүүдийг тэрлэж үлдээсэн идэр залуухан найрагч “цахилдган зултай хараацайн сүмд” заларч суудгаа болиод, “мөнгөн хонхтой мөнөөх сүмийн тагтаа” шиг яруу найргийн ертөнцөд “мөнхийн амгалан хутгийг олоод”, “Холхи ертөнцийн гэрэлд цасан будрах нь гоо эх орон минь” хэмээх сайхан мөрүүдийгүлдээж, “Задгай сансараар дур зоргоороо хэрэн тэнүүчлэхээр” оджээ.

Д.Нацагдоржийн “Миний нутаг”-ийг Монголын шинэ үеийн утга зохиолын “А” үсэггэж итгэдэг зургаахан настай жаалхүү байхаасаа шүлэг цээжлэн “Уншигч байхаас гадна сэтгэгч байж” (Д.Батбаяр “Мемонтог бүтээхүй”) “их хотын

шуугиант амьдралын өдрүүд”-ийгөнгөрөөх болсон арван наймтай найрагч тэр үеийн шүлэг яруу найргийн ертөнцийг “тэсэлж” явсан үе тэнгийн Ж.Болд-Эрдэнэ, Ц.Буянзаяа, Ш.Уянга, Одгэрэл, А.Эрдэнэ-Очир, Б.Галсансүх, Л.Өлзийтөгс, Г.Аюурзана, М.Саруулдалай, шар Баттулга, шар Мягмарсүрэн ах, урт үст Ц.Бавуудорж, Хар хорины Дамдиндорж, Гандангийн Дээсайхан, Хөхөө Болд, лам Мөнх-Очир (өөрийн нь нэрийдсэнээр)-той нөхөрлөж явснаа бурхны хишиг хэмээн бардамнадаг байсан юм.

III



Яруу найрагч Т.Содномнамжилын анхны ном 2005 он

Эрхи, үзэг хоёр бол түүний ахуй. Үүнээс өөр ахуй гэж байгаагүй. Байлгахыг ч хүсээгүй. Хязгааргүй “Эрэл” дунд нь ахуйн тухай анир чимээ нэгээхэн ч үгүй. Харин цагулирлын өнгө

аяс, Хэрлэнгийн хөвөө, Оюунтөгсийн инээмсэглэл, Энхгуяагийн захидал, эс бөгөөс нэг их бараан үүл, цагаан цас, хэтэрхий гуниг харуусал гээд орчлонгийн явдлын үнэ цэнийг эрэлхийлэн өөрийн ертөнцөөр өнгө будгийг тодруулж суусан юм даа.

“Хаш хундаганд сөгнөсөн сархад”-ыг амтлан ер бусын оюун санаат ертөнцийн дорно зүгийн тэнгэр дор

инээмсэглэн зогсож “Зүг бүхэн гэгээн” гэж хэлж байхдаа, “шинэ сар өвсөнд авирна” гэж ангид сэтгэж, орчлонд өгүүлэхгүй орхиж болохгүй нэг ч зүйл үгүйг олонтаа мэдэрч, хэдэнтээ шүлэглэнэ. Тэрээр

... Гэрэлт алтан шүлгүүдээ

ертөнцийн бөмбөрцөгт цацаж

Гэнэн охидын мөнгөн чимгийг хүйтэн агаарт царцааж

Сүлд модны чимэг шиг солонгорсон дэнлүүг асааж

Сүмийн дээвэрт хоносон тагтаа шувуудыггэрэлтүүлнэм

хэмээн бардамнаж,

Уйтгарт орчлонгийн үүрэглэгч амьдралд

Улаан сувд гэрэлтэх ийм гоё шөнө

Дахиад хичнээн Гулранса өөрийгөө давтан үл шүлэглэх

Давтагдашгүй тэр гоо сайханд цаг хугацаа

бид амьд үлдэнэ

гэж шүлэглэсэн нь гурван цагийн тухай содон өгүүлэмж. Түүний шүлэг бүхэн нь ийм ангид өгүүлэмжээр дүүрэн байдаг нь,

Наран саран чимэгт нүдэнд үзэгдэх хорвоог

Налжарва нугууд эзэгнэсэн билгийн чинадтай жишихүй

Найрагт эхийн билэг тэргүүтэн

төрөн түгэхүйг санагалзан

Наян наймын тэнгэрийн шимээр бүтэх

ном дор биширмүй

хэмээн шүтэж, шүлэглэн үлдээсэн нь бурхны сургаал мэт ажгуу.

Ийм их авьяас, мэдрэмжийг нь хэдийнээ олж харсан их найрагч Д.Нямсүрэн “Яруу найраг бол ерөөл биш, магтаал ч биш, бүр философи ч биш. Тодорхойлж боломгүй тэгсэн мөртлөө аугаа тэнгэрлэг нь мэдрэгдэж байдаг тийм

зүйл... Өөрийнхөө ариун нандин гэрэл гэгээ бүхнээ аван гараад бурхны зурсан зургаар байгалийн зүгт явж чадвал миний таньж мэдэх хөвгүүд, охидоос Тогоонтөмөрийн Содномнамжил, Лувсандоржийн Өлзийтөгс хоёрыг дэлхийн дэвжээний барианы газар монголчууд хүлээж авах болно” гэж мэдрэхээс илүү үнэнийг бид хаанаас эрэх вэ дээ. Найрагч найрагчаа ингэж олж, таньж, мэдэрч зөгнөнөгэдэг гайхалтай юм даа.

Манай жижигөрөөнд байх аавын хүрэн модон номын тавиур дээрээс “Эрдэнийн сан Субашид“-ийггаргаж ирснээ “Бурхны сургаал, яруу найраг хоёр бол угтаа нэг л зүйл юм” гэж хэлж байсан нь одоо ч чихэнд сонсогдох шиг болдог юм. “Илбийн байшин”, “Шинэ охин” гээд л “энгийн бөгөөд эрдэнийн чулуу шиг үгийг сэтгэж, их найрагч Д.Нямсүрэнгийн шүлэглэснээр “Алтан жүнзэнд мөнгөн шувуу сөгнөж” явснаа хамгийн жаргалтай өдрүүд гэж нэрлэх дуртай. Үүнийг нь Улаанбаатарын цөөхөн хэдэн эртэч болжмор, ташуухан ургасан мод бургас, Туулын хөвөө, цардмал зам мэдэх буй заа.

Насны эрхээр гуниг төрж ертөнцийг таних нь уйтгартай Налсан өвс мэт гандан хоцроод цаг хугацаанд гүйцэгдмүй Гуниггүй амьдрагч хүүхнүүд хаана байна вэ би тэднийг хармаар байна Гуних нь мунхрал мөн бас гэгээрэл мөн

хэмээн бичсэн нь агь тарнийн ид шидийг эзэмшиж тарнийн ёсонд гүнзгий нэвтэрсэн сод хүн Равжаагийн агуу мэдрэмж амьдралын хоосон чанарыг хэдэнтээ өгүүлдэгийг сануулаад байх шигээ. Ийнхүү их хүмүүнтэй зүйрлэн хэлэхээ ч үзэглэгч миний бие өчүүхэн ч хэтрүүлэггэж санахгүй байна. Энгийн л нэг миний тайлж үл чадах оньсого байж болох боловч энд яруу найргийн охь чанар зэрэгцэн оршиж чадаж байгааг олж мэдсэний учир билээ.

Уйт намрын хөх үдэш навчисын сэрчигнэхийг сонсоод

Уян сэтгэлийн алтан хонх жингэнэн дуурсах яруухан

Гансрал гуниг, ерийн үнэн, ертөнцийн хэрэгт

би уйтгарлаад

Гадаа зул асаасан өвлийн шөнө,

шамбалын орныг зоримуй.

Энэхүү дурсамжаа яруу найрагч Я.Бадамсүрэнгийн: Шүлэг гэдэг сэтгэлээс нисч, сэтгэлд шингэдэг жаахан дуут шувуу ажгуу. Тэр дуут шувуу өвсөн дундаас дэрхийн үргэж, малгай шүргэн нисээд тэнгэрийн хаяа чигтээ одно. Бас үдэш бүрий барайд алтан хараацай хэн хүнийг тойрч хэрэн дагасаар гэрийн гадаа ирдэгсэн билүү. Энэ алтан агшин бүр гагцхүү яруу

найрагч хүнд л хамаатай мэт байдагаа. Сэтгэлийн утас эрвэгнүүлж, гоо тансаг мэдрэхүйгээр дамжин оршихуйн ариун ертөнцөд хүрч болох нэгэн гэрэлт харгуй буй. Энэ нь шанзны утас мэлмэрэх, салхинд хөдлөх өвс лугаа адил охидын уран галбираар дамжин илрэх амой. Ийн учирлахуй Дарьгангын яруу найрагч Тогоонтөмөрийн Содномнамжил найрагчийн зөөлөн эгшигт аялгуу хотлыгуярал хайланд умбуулмуй. Тэрбээр гол мөрөн намуухан урсах шүлгүүд тэрлэсээр л... Хааяа Гандангийн Дээсайхантай хамт орхимжоо дарцаглуулан, хамаг амьтны тусын тулд дарс балгаж явна гэх... Гэлээ ч өвсөн дээр шүүдэр буух нь л аниргүй” хэмээн өгүүлснээр жаргаая.

“Улаан гэрэлт шамбалын шүлгүүд” улам орших болтугай.

“Утга зохиол урлаг” сонин. 2006.02.16

Үхээнц ноомой явахыг үзэн яддаг би



ÌÇÝ-èéí øàrìàèð, ñyòrγγē÷, βδyυ íàéðàr÷, çyðàà÷ Àé.Òèìèð-Î÷-èð

Àäyυíú “òyñrãàð òîròííē”-ûr ìàrðàí äyγēæ, ÷ííúí øàrãé ìðü äyγãàγγéγγçýγγēyæ, Àìãðèkèéí àðèíðèèèør÷-èä çãðèããè àé÷-èæ, Òàðrèè Àèðàéí yγèàíã rγγ yíàrãèæ, ìyòrèéí ìyγðàíã ðyí ÷yγèãðãã yγð÷ yññàæ, “Yðýýíð ìíííé yããðûr γçýí yããàr àé” rýñýí àyñòàé γrèér øγèýr áíèríííñ ìü yíøèæ áíèíð yíý ðγíèé ðyðàé èðèéã ørγγèæ áíèíð àèèýý.

... Ýððèé äãðàí ìyòrèéíðãã ðèèèø Ýèñýíí øèððýr ÷yèyυíúðãã ðèèèø Ýèrýý ýrøýýã Çγððýý çγãðýýã Ýãýý ðè÷-ýýã Òγ÷-ýý ìýròrýã

Àòrã ÷-èìð øíðíííúðíí ðèèèø Àèrã äãðàí rãçðüíðãã ðèèèø Àìãã ìýýã! Yrýý ðýèüã! Àìèã rýýã! Çíãèíríí çíèü,!

Òγγíèé yðyυ íàéðrèéí ÷-èìør ìü ýð ìðíí, rãçãð øíðíí, ýð ìyòàr, ðyñrãàð òîròííē. Èéíýýñ Àé.Òèìèð-Î÷-èðüí ðyðàé

ìíírèüí yòrã çíðèíèüí ðíèííðò ñyυñàí “ãããðrγyã” øγγí ðyírããæ, γíýèæ ðýrýíýýí ààéãàr þìãã.

Àðãüí yðàí çíðèíè÷ Òàírããüí Æãèñàí ðγγíèé “Àçüí àèðãáí ìðü” ìíííúð ìü øíèòòrèèã “Ìãíæ ìãírãñ ìãíæ Ìíírèüγγçγγðýýñ ìü γíðýæ, çãðããñ ìü çãèrèæ àãèñàí ðýð òàrò ýð ìðíí÷ ýðýèðýr ðããí Æãèããí áíøríð “Ìèíèé ìyòrèéí rãçãð øíðííííñ áyððàí rγèñàí ÷-ãγγ ør” rýñýí çãðèèrèér øíèèãèð Æãðüírãíã ìyòrèéí ðγγ, Æãíãèíú Ñγðãããðãðüí “ãγγ” rãíèèrèéí äyγrããð òãñèáí rãñèãæ, ýðèrèí çãíããð÷ áãéíã.

Ýðèí òàrèéí èðýíð øγèýr÷ øèr ýðãýýðýéí àãèãã÷-ðãíããð, ríèèðíèíí ríírèíèííð yγóíú ìyðèãò yèòrãð yíèãðòyγèãèγγé, ýð ìðííúðíí ðyãü çãýãíú ðèèèø yéýr ìü ýíòýð÷, yγøèr ìü yðãrããæ, ðèèýíð èð ðýíðèèéí ðýírýðýr äýèãýæ yããã ìãíæ γãèéí Òããíãíð Ìãðèðè áíè

Àðèýí Æãírúí yñããð ðãøããèñàí

Àèðàí Áírãüí òãðèyðããñ ýíòýðñýí

Àãüýãñ àèèrèéí rãèããð øγíøèrèýñýí

Àéèòγγεί δγγ Òθειò-Î÷èð àæààìγγ...

γγæ àé÷ñýí àáéää. Ýíý áíê Àé íàéðàγ÷èér ìàγòàð òèäéé γγ àèø ìííííèä èéí ÿðγγ íàéðàγ÷èä ìèíí àáèrààñàé γñýí èð íàéðàγ÷èéí àðθèè γγæ àé áíáíæ çàèäèðää..

1994 ìú ðàààð... Ààâγγé áíèíí ãýæ òèñθèèè ÷ γãýè ðγγðýä æààðáí àáéñáí þì. Õγíä èáñèí ààää ìèíú íàéç íèðèä, øàâü íàð, àð äγγñ, ðíè íéðííñ ñàéí γñýí áγðíèér çàìúí ðíè çàðäèúí èðèér γñ òííòíí àä÷èð÷ èγ÷ àéèýý. Íγγýí ÿí÷ ÿγòèéíðàà ÿéýýíèè ìàð èääýè ÿãýðíý γγæ ðýéýä. Ààâúí ðàìγèéí ðàéððàé øàâü íàðúí ÿγ ÿðóó íàéðää÷ Àé. Òθειò-Î÷èð γγæ áýéýí òýöýí γγòýé, γñýý ÿðð ÿðγγýèñáí àð ààâúγ ÿðγγðýð Ñγðáààðð àéìγàñ èðèýý. Ààâ ÿýý ÿ÷èðàà ðýèðýè ìðíðèκèðíé Àäðüàíγà ÿæ íàéç Äγγàðñγðýíðýé ÿú ðàìò ÿéýý àñíàää èðèýý øγγ. Ààâúí ìèíú àéä àð ÿú èð àíðàñíí àáéñáí ÿ÷ðàñ çγγ çγγýýñ àä÷èðñáí áγðýí ÿγ èð òγñ áíèíèγγé ÿàèγγé áγððíú ìðííä ìáñíí þì.

Óýð ðγíä ðýöγγ èäðγγäýýñ ÿðèýýä èíθèäèér ðγððýè àéäýíðýé ìèð àíòíí àáéæ “Íàìàér Àäðüàíγúí ààγà ñγðγγýèüä ñγð÷ àáéðàä, èð ÿòà çíðèíèúí ðγí áíèíð çàìúγ ìèíú çààæ èñèíí È.Áàðñγð áàγø ìèíú” γγæ äγðñàð äγððàé. Àé ÿýý γγèér ñíííð áγðèèäýý àäýðèääàγ. Ìèíèè ààâ ìèíí ðγíèè ñγòγýèä èíγγæ ðíííγèñíí àíí.

Ààγø øààééí ààðèèäèàγúí ðγðàé Ìíííè Õèñúí ðèðèéí øàííàèð, ÑÃÇ Ä.Õííáíè “Àéèòγγεί δγγγ Àäðüàíγúí ñγðγγýèüä ñγðàèèððààð àíð èðýðýä ÿðγγ íàéðàγ÷, ñγòγγýè÷ È.Áàðñγð ðíííí àáñáí ÿú òýð ðí,ðúí àðθèè àáéèää. Àíðíííáèéí àíàγàð ÿðàáíú äýíä ñγðγγýèüä ì÷èðíä ðèäèè ÿγòèéí ðàìγèéí ÷èìèðýé γγãäýγèíèè Õ.Õýðýíáíðæ ÿððáí àä÷ øγγñèér ÿú øàðàæ, øγèγèér ÿú ìíγòíèñíí ÿààæ ÷ òíðèíèäè àáèγàγγé. ÿγñèéí ñγðýγ àäýýèð, ÿýííèè ÿððà àäýèð ÿðàáíä Àé çíðèíè÷ ñγððèè γàððñáí ÿ÷ðúγ ÿðæ òèðèèä àáéð ÷ þìγγé ñáíàγàáíä” γγæ “Ýííγð ðàð àçàðγà” ìíä ÿú àé÷ñýí àáéää þì. Àé.Òθειò-Î÷èð íàéðàγ÷ èéí è ðγíγγñèéí àèèèéí ÿéíèèä “íèçèííáíæ”, àèèèè àäüýàñàñ ÿú ÿíðàí γàðð àðθèèðýé γγñèér ñííííæ ÿàààγ ðèéíððíé íàéðàγ÷ àà.

2009 ìú çýíú ÿðýí ñàð. Õγðýý ðíðíä òγð ñààðáí, çíðèíè÷-àúí èð ðγðàèèää ìðíèèíæ, Çààðáí àéìàγò áíèíð Àíðíúí èð ÿðγγ íàéðàγ÷ Áýγçèéí Òäýðýèáíγèéí 80 ìáñíú ìéä çíðèñèíáí ÿðγγ íàéðγèéí èð ÷ÿèγàíä øγèäýý òíèèðààð ðγèγèéí æíèí çàèäèäàñ ÿú èíèèθíàèð γγýýí Çàíààçàðúí ÿçàéä ÿγèçèää.

Òòγà çíðèíèúí ðγðýýíèèðýíáýý “Àé ñýöýí” ðýíýýí àèäððèñáí íàéðàγ÷ àð ìàáíú “Áýγçèéí Òäýðýèáí áíè Àäüýä γγæ ñàéðáí áγñγγèðýé ðàíèèñáí. Ìáíáé ÿγòèéí ðγðγýí γγãèèγγýíøèγ÷èä àíáàðγγé. 1981 ìá ìèíèè ààγø Èèèéí Ààðñγððýé Àäðüàíγàð ÿæ, èð íàéðàä÷ Òáóó ààγøèér ìàáíú Àäðüàíγúí ÿýàðýððèè ðíèú” γγæ ðýèñýí þì. Ìγòàγñàà γàðúí àèγà øèγγý ÿýääýγ áýðèúí ðíè÷ γä, ñàéí ààγøèéí øàâü, γγ èð ÿðüæ, γñýý èð ÿðγγýèààγèéí ðýðýγ þγñáí àéèýý. Èð ÿàð÷ òýíγγýæ àáéíä. Á.Òäýðýèáí γγàéí àé÷ñýí

Àáíγà ÿÿðààñ ÿáñáí ðγí ìàìððàà çàààè ÿðγýáγ

Àáíγà ÿÿðàíä èðñýí ðγí ìáñáíàà çàààè èðäýγ þíàà

γñýí ñàéðáí äýγ ÿú ìáí ÷ àèä äýýèää. Ìòííðýíγýð Àèðáí-Ìáí ðí,ð ñààáí ðèðèèéí ðíèáííðíé ðèéíðü ÿýèñ.

Ýíý ðýáýí èäðγγäýä Çààðáí ìèíèè ñγòγýèéí àáèèàγà, äýýèàγà, ìèðèèèè áíèæ àáéíä.

Ìòrîíòýíγύðòóý áíð î÷îîâ îîrîâ ðèèíðü çàààð÷ äýèýð÷ èðýð áàéð γýæ áíâîæ áàéíà” ðýíýýí îîîrñîîð çàìà ràðñàí. Ó÷èð ïü òýðýýð áíð ÿààà ýíý ðàéððàíü îèíèðò ì÷èðòò ãýæ áàéðàà þì áèéýý.

Õýäýí èàðèéí ààðàà àð ìèü ìàéðrèéí ìàààìà ÿàñàí áíè àíî rýæ ñýðàr ÷èíýý àñýðàà “Õèð ìàíðàí òýíýðèèr ýçýrîíýðýí ðèðèè” ÿðý ìàéðrèéí èð ÷ýèràìààñ Àð ðàéðüí àèðàí, ìèírèí òàìràòàè ßèrýñàí ðýòàrò ×èíýäòýðýí ðýòàròüí ìýðýìæèð øàrìàè ðýððóæ, èð ìàéðàr÷èéí rýðèéí áýððèí áýýð øýèrýý ÿìèè, áí÷èí ààâ Áýrçèéí ìü ìýðàrèàæ áàèñàí Õýçèéí èàèèæèè, ßìààí ÿñàíà î÷èè, Õàéààüí ×èèààæàà ìàéðàr÷èéí Àèðàé ìýðrààð èðòèèèðí ðèèíðòíè èðæ ÿààà ñàéðàí ìýäýý áýèràñàí þì. Õýçìòýé ìàéðrèéí øýìèèròýé Çààðàí ìýðrèèr çìðèèññ èìíèðòí ðý÷ ðèððñíèè òíèèèýýèý.

- Çýçì çýrèéí ìàéðàr÷ òàìðàé ýíý æèèèéí çìðèè÷àüí ðýðèüí ñýòrýræýýð ÿðèèèèàràà ÿðèýà.

- ßàñàí àèààððýý áàéíà, ÷è àèà òíð ìýr ÷èrèéí ÿèñýä øýç áýý. (èíýýà) Çýçì çýrèéí ñàéðàí ÿðýý ìàéðàr÷èè ìààíü ìýr ðýñýr ìü áýððíü ìðíà î÷ñíí àíî. Áàèrààrààñ Ñ.Àìàðòàéààí ìààíü àæèè ìü çàààñàírýé. Æàìàèràðàà æàìæéí áíèñíí ýý, ràìæéí áíèñíí ýý àèrà. Æîìàüí Íýìàà rýýà ñàéðàí èàrèí ýíà áàèràà ÷ ààñ è àìæñàírýé. Ñýè ìðü øèr ÷èèèòýèrèðèè àè è èðèýý. Õèààìààðàðò àè èððæ áàèrààrààðàà ÷è ààñ áàéð øèà áýý. Ñìírîràñíí ÿèððèàrýýàüí ðýäüà çàèýý÷ýä ríèäýý. Ìèìèè ìàñíüðàí ÷ ààñ áàéíà. Áíè ìü ÿòà çìðèèññ ìýàáýr, ìýäýðàýr ýèýr ñýòrýèòýé, çìðèè÷àüíðíí ÿððèèr ðàìrààèæ, òýýæ, ÿðð÷ ÷àààèè ðýí ÷ ààèñàí ÿàðàà. Õàðèí Ìîírèèüí èð ÿòà çìðèèññ ðèræèèéí òíìðíí ìðíí çàèr ýçýrîíýr÷,

ýìýòròýé çìðèè÷èè, ðèèèèèèèðèí ìrò ìðñíírýé. Ìîírèèüí ìþýü àððèíò rýðýýð Õèààìààðàðòüí ÿààáí àìòíðò ðýäýí ðýí àèø øýç áýý. Àè áíñíæ ÿr ÷ ðýèñýírýé. Ýíý ÿààà ààìààà ìèðàèèðèè ÿrèèr ñíñíæ ñýýèàà. Õèñ ðèðà áíè àð ìü èððèéí çàìðàé, ìèðòýé, ðýíýýñ ÷ àéòrýé ÿrýý ðýèýýà “ñàìàðààr ø áýý” (èíýýà) Õýèrèéí ìèðèèð ðàðèí ðèð òàìðèèýýæ áíèíí øýç. Àè ÿðàí áýòýýè÷àèèðýý ðýìèèð ìü ÷ ríâíè ààýðòr ñíñàñr. Õàðèí ìýr ÿìçýrèýñýí çýèè áíè çàðèí ìýr ìü çìðèèè ðýððàèèààr ñàéðàí ÿçrýýðýý àèà àèàìýý ìàðñàí, àè÷ñýí, ðýèñýí áàéðòr ðàðààà ÿìçýrèýæ áàéíà. Õèèí çàì ÿðàí áýòýýè÷ ðýìà çìðèèðýé, áàèèè áíèèðýé.



Сүхбаатар аймгийн “Эвтэй дөрвөн найрагч” Баруун гар талаас Ай.Төмөр-Очир, С.Амартайван, Б.Төгсжаргал, Ч.Эрдэнэбаатар

- Шинэ уран бүтээлийн олз омог ихтэй юу?

- Би уран бүтээл сайн уу гэхэд улаан галзуу гэж л хэлдэг. Уран бүтээлч хүмүүс нэг дарга гарахаар бууж суудаг, хашгираад больдог хүмүүсээс онхи ялгаатай байх ёстой. Цагүеийнхээ бурантагтай тэмээ байж болохгүй гэсэн үг л дээ. Өнгөрсөн жил өдийд “Азын дөрвөн морь” номоо дөрвөн сайхан найраглалаараа хийсэн. Монголчууд дөрвөн бэрх буулаа гэж бэлэгшээдэг. Үүнтэй холбоотой.

Морь унаж, шагай тоглож, шүлэг бичиж өссөн монгол хүүхэд би ер нь гурван номоо мориор бэлгэшээж нэрлэсэн. Анхных нь “Адууны нутаг Дарьганга”, удаах нь “Эмнэг хар азарга” сүүлчийнх нь “Азын дөрвөн морь” юм даа. “Арван хангалын төвөргөөн” гэдэг ном яг бэлэн болоод байна. Дараа нь “Унага янцгаасан тал” номоо дуусгаад шүлэг найргийн нэг сүрэг адуу, азарга адуутай болно гэж боддог. Номын нэр гэдэг их учир утгатай. За яахав баян хүний тэнэг хүүхэд гэдэг шиг сайхан хавгастай, сайхан нэртэй байгаад доторх нь тааруу, хавгас нь тааруу ч доторх агуулга нь гайхамшигтай номнууд ч бий. Сайн ном хавтсандаа биш, сайхан хүүхэн хувцсандаа биш гэж миний уран бүтээлийн анд шар Мийгаа хэлсэн юм. Минийх бол эр унага шиг номнууд гэж бардамнана. Би ийм ном нэлээдийг хийнэ гэж бодож байгаа. Цаг хугацаа байна. Зэврэхгүй, зэсрэхгүй, их утга зохиолоос уйдах урвах, төөрөх, мөөрөх аль нь ч болоогүй өөрийнхөөрөө л туурвиж явна.

- Иргэний уянгын баатарлаг найраглал бичих нь таны уран бүтээлийн цөм гэж бид ойлгодог. Таны хувьд?

- Би ойр зуурын сэдвээр жижиг сажиг юм бичиж яваагүй. Бичдэг нэг нь байлгүй л яахав. Иргэний уянгын баатарлаг найраглалаа бичиж, тусгаар тогтнолоо дуулж, бэхжүүлж, хөгжүүлж энэ чиглэл руу дүү нараа дагуулах бодолтой байгаа. Би бол бусдаас зүг чиг асууж, хаагуур үүлтэй манантай байх вэ? гэж асуудаггүй. Тусгаар тогтнолыг магтан дуулагч яруу найрагч хүн. Сонгуулийн дараа эдгэрчихнэ, эвлэрчихнэ гэсэн юм мэдэгдэхгүй л байна. Хүмүүсийн хайр сэтгэлийн сэдэв бол насаа явчихаар дуусчихдаг, эд хөрөнгөнийх бол компани бусад юмаа дагаад дампуурчихдаг. Нийгмийг эмчилж эрүүлжиж дуустал тусгаар тогтнолыг бичнэ гэж бодож байгаа. Минийх тусгаар тогтнолын сэдэв учраас хэзээ ч дампуурахгүй шүү дээ. Би яруу найргийн уран барилга барих тоосго туйпуугаар дутахгүй. Маргааш үхнэ гэдгийг

мэдлээ ч миний ажил дуусашгүй мөнхийн гэж боддог. Ямар нам, ерөнхийлөгч гарах нь хамаагүй. Төрийн минь сүлдэнд морь янцгааж, гэрийн минь үүдэнд нохой хуцаж байгаа цагт монголын төр остох вий дээ гэж айдаг. Энэ л санаагаа давтан барьдаг. Манай нутгийн их зохиолч Д.Маам гуай: “Хүү минь эгнэгт төрсөн газар шороогоо л гэж яв, түүнгүй бол хөл чинь юун дээр гишгэх билээ гэж “Газар шороо” романыхаа оршилд бичсэнийгуншаагүй хүн байхгүй биз дээ. Энэ бол миний үзэл санааны гол цөм.

- Таны адууг дээдлэх үзэл бодол уран бүтээлд тань их тодорхой туссан байдаг. Адуу, Ай хоёрыг салгаж ойлгох боломжгүй шиг санагддаг.



Зураач Ай.Төмөр-Очир “Жаргалын найман морь” таталбар. 2012 он

- Адуунаас монгол эр хүнийг салгаж ойлгох боломжгүй. Бид төрийнхөө сүлдэнд адуутай. Аваа ээжээ гэлгүй адуу гэж анх хэлд орсон маань худалгүй үнэн. Адуу бол миний их багш, хөтөч, миний ухаан, сургамж.

Би мориноос ойчиж, эмнэг, даага сургаж, адуунд өшиглүүлж өссөн. Намар орой гүү унага нь торниод ирэхээр хажиг болчихдог юм. Ийм үед нь өмөртөл хазуулж байлаа. Азарганд тангаруулж, чангарсан аавын хүү. Тиймээс адууг судалсан, сурвалжилсан, сурагласан, зурсан, бичсэн гээд дуугарах тоолондоо л би адуу ярьчихаад байдаг юм. Нэгүдээ тэмээний тухай шүлэг бичээд, зуртал зохиомол санагдаад, уран бүтээлч нөхөд маань ч зөвлөж адуугаа л зурж бичиж явна даа ах нь. Монголын тусгаар тогтнол оршин тогтнож байгаа цагт адууг бас дуулахгүй байх аргагүй ийм л чухал сэдэв шүү.

- Монголын утга зохиолд Дарьгангын яруу найргийн дэг сургууль бий болсон. Та тэдний залгамж халаа болохын хувьд нутгийнхаа найрагчдыг эргэн дурсана уу?

- Би Догшин Балбарын баруун суганд, Дорнын Нямсүрэнгийн зүүн цавинд, дэлхийд данстай Мэнд-Ооёогийн дээлний өрөөлд багтаж, их бичээч Ишийн Батсүхийн идүүрийг нь долоож, Барсан хэвнэгт Доржийн Гомбожавын бар мөр дээр гишгэж өссөн болохоор муу явахын учиргүй, мулгуу байхын эцэсгүй гэж бодсон, бичсэн. Дарьгангын цэлгэр тал, Дарьгангын үлгэр түүх, үнэн домог, үүлс уулс бүгд учир утгатай, сайхан бүхнийг зангидсан, цогцолсон, дагшин нутаг. Бас Данзаннъямын Шагдарсүрэн гэж дошгин адуу шиг дүүхэлзсэн, далай шиг цалгисан авьяас билэгтэн явсныг нанхиадач Ц.Базаррагчаа абугай намайггэрт нь очиход бахдан дурсаж байсан даа. Тэдний минь нутаг. Миний багш, чиний аав И.Батсүх нэгүдээ, “Төмөр-Очироо чи урд насандаа адуу байсан юм байна” гэж хэлсэн. Би тэгээд “Хойд насандаа ч хонь, нохой болохгүй” гэж багшдаа хэлж ийм сайхан ерөөлөөр шагнуулж байсан азтай. Тэрэндээ омогшиж амьдардаг. Дарьгангын яруу найраг гэж тусгай хийцтэй, хэлцтэй, сургамжтай, сургалттай, сургуультай. Голдуу тэмцэгч, эх оронч дайчин, давшингуй байдаг. Үглэсэн, үхээнц царайлсан, үхэр шиг мөөрсөн, ингэ шиг гунганасан юм байдаггүй.

Тачигнасан адуу шиг, чонын улиан шиг байдаг. Өөд болоочдоос үлдсэн, голомт сахиж байгаа олны нэг би ч гэсэн тавь гарчихлаа. Одоо буурал, саарал толгойтой болж байна. Үс саарал

болсон болохоос үг саарал болж болохгүй гээд монголынхоо тусгаар тогтнолын тул шүлэг найргаараа жинтэй хувь хандиваа оруулж яваа юм. Манай нутгаас Чулуунбаатарын Эрдэнэбаатар, Доржийн Гомбожавын зээ Сүхчулууны Түмэнбаяр гээд сайхан залуус шүлэг бичиж байна. Чамд ч их итгэл тавьж байна. Монголын их утга зохиолд наран ургах зүгийн цэнхэр хязгаарын Шилийн богдын босоо шүлгүүд, эр хар чулуу шиг шүлгүүдийг бичиж, энэ бүхнээрээ Монголын төрийг түншилж л байх ёстой гэж бодож байна.

- Таныгулс төр, уран бүтээл, уяач, дуулаач олон нөхөддөө мөнгөн аяга бэлэглэж, яруу сэцэн найраг шүлгээрээ мялаадаг тухай сонссон. Одоогоор хэдэн мөнгөн аяга бэлэглээд байгаа вэ? Би бол цуглуулж биш тарааж амьдардаг. Мөнгөн аяга бэлэглэх дуртай. Манай Дарьганга нутаг цалин цагаан мөнгө, уран дархчуулын орон. Дарьгангын яруу найрагчаас цалин мөнгөн аяга авсандаа их л ерөөлтэй гэж авсан хүмүүс маань ч баяртай байдаг. Яруу найрагч хүн ядуу буурайгийн туйл биш. Хүнд байгаа юмаа өгч чаддаг хүмүүс шүү. Одоогоор 56 мөнгөн аяга бэлэглээд байгаа. 2004 онд “Азын дөрвөн морь” ном хэвлүүлсэндээ бэлэгшээж, 2008 оны Алтан овооны их тахилгаар их насны дөрөвт хурдалсан Хэнтий аймгийн Баян-Адрага сумын монгол улсын алдарт уяач Гончигийн Содном, түүний наян настай ээжид нь есөн мөнгөн аяга бэлэглэсэн. Аав ээж, арван ах дүүгийнхээ нэрийг бичээд өгсөн энэ аягануудыг одоо хүртэл орсон гарсан хүнд ярьж, үзүүлдэггэж би олон хүнээс сонссон. Сайхан байдаг юм. 2003 оны Улсын баяр наадмаар “Хүй долоон худаг” руу таван мөнгөн аяга өвөртөлж гарахдаа МУ-ын гавьяат хуульч Н.Жанцан, МУ-ын гавьяат

малчин цол хүртсэн тод манлай уяач Д.Онон, манлай уяач Б.Содномцог нартаа бэлэглэсэн. Харин нэр бичээгүй хоёр аягаа “Хүй долоо” худагт “Хэн миний сэтгэлийг хөдөлгөнө тэрэнд бэлэглэнэ” гэж бодож очсон. Манай нутгийн алдарт уяач Ц.Бямбадорж ахын “Мөнгөн хөлт”-ийн төл нь улсын наадамд айрагдаж, миний найз Д.Батмөнх шинэ машин авсанд баярлаад бэлэглэсэн. Энэ орчлонд би авсангүйдээ харамсдаггүй ээ. Үхэх сэхэхээ мэдэхгүй өвдөж зовох үедээ өгч амжихгүй болчих вий л гэж хамгийн түрүүнд бодогддог. Ер нь хэзээ нэгдөр 81 юмуу 108 мөнгөн аяганы найр хийнэ шүү. (инээв)

- Ийм их онгод хийморьтой, цэцэн билэгт хүмүүн хэрхэн гунигладаг бол?

- Гунилгүй яахав. Амьдрал алганы ар өвөр гэдэг шиг хоёр талтай. Дандаа аз жаргалтай, инээд хөөртэй байдаггүй. Гэхдээ би бол гутамшигтайгаар гунигладаггүй. Гунигийг учираар, очироор зангидаж, шүлгээрээ хийморио сэргээгээд явчихдаг. Шүлэгуншаагүй өдөр сэтгэлийн тоос зузаан гэж. Зарим өдөр нулимс цийлэгнэх үе байдаг л юм. Аавыгаа, ахыгаа санагалзаж, ээж маань хэдий наслах бол доо гээд л. Амьдралд гэхдээ гуньж үзэж байж аз жаргалын амтыг мэдэрнэ шүү дээ. Уран бүтээлч хүн гэхээр заавал бүхэнд омголон амьтан биш шүү. Гуньж чаддаг, гунигаа арчиж чаддаг л байх хэрэгтэй.

- Баярлалаа. Адуу шиг яв алзахгүй, морь шиг яв мохохгүй гэсэн таны хэлэх дуртай үгээр ярилцлагаа өндөрлөө.

“Үнэн” сонин. 2009.06.28

Ухааны ураа бийрийн шидээр амилуулагч буурал зураач



МУЭ-ийн гишүүн, зураач Б.Төмөр

Уран бүтээлчид гэж хичнээн зүйлийг бүтээвч дундаршгүй хүсэлтэй, авьяас билгийн эх ундарга болсон сайхан хүмүүс. Тэдний нэг зураач Б.Төмөр гуайтай Эрдэнэт хотод уулзаж хууч хөөрсөн юм.

Зураачийн урлан гэдэг маш содон ертөнц. Тэр дундаа сэтгэл зүрхний нь урлан юутай ч зүйрлэшгүй гайхамшигтай юм. Цаг хугацаа харвасан сум шигөнгөрч ханьтайгаа үр хүүхэд, ач зээ нараа тойруулсан буурал боллоо ч үргэлж уран бүтээлээ туурвиж, аймаг орон нутагтаа бүтээн байгуулах, урлах ажилд цаг наргүй зүтгэж явдаг эрхэм хүмүүн. Авьяас тэтгэвэрт гардаггүй гэж үнэн үг шүү.

Сүхбаатар аймгийн Баянтэрэм суманд 1947 онд төрж, Монголын Урчуудын Эвлэлийн хорооны зураач, эрхлэгч, музейн захирлын алба хашиж дөч шахам жил ажиллажээ.

Хөврөн одох он цагийн хэлхээсээр тэргүүнд нь гэгээ цахилсан ч урлах бүтээх ухаан билэг нь улам гялалзан, уран бийрийн үзүүрээр урласан бүтээлүүдээс нь үзэсгэлэнт хөдөө нутгийн өнгө тансаг цэцэг алаглан, үнэр ялдам агь ганга үнэртэж, уул толгод сүндэрлэн, гол ус тунгалагшин урсаад сэтгэл уярам.

Хүн бүрийн амьдрал нэгэн хөлгөн судар гэсэн үг байдаг. Буурал зураачийн хөлгөн судар он цагийн уртад зузаарсаар л...Хөдөө нутагтаа өсөж торнисон жирийн малчны хүү багаасаа л зураг зурах дуртай байсан тухайгаа хуучлан ярьж, алдарт зураач Г.Одон гуайн шавь болсноороо бахархан, өнөөдрийг хүртэл өнгө будгийн нийлбэр шиг амьдралыгур ухаан бийрийнхээ шидээр зурсаар л явна.

“Аав минь намайг бага байхад агентад ирсэн найман ширхэг зургийн дэвтрийг бүгдийг авч өгсөн юм. Би олон зураг зурсан даа. Манай нутагт Жамбал гэдэгуран хүн байж билээ. Хүүхдүүд түүнийг Жаамаа гэж дууддаг. Морь зурахдаа хоёр чихийг нь дөрвөн туурайг нь хошуу сүүлийг нь хол хол зурж, түүнийгээ холбоод зурахыг нь их л харж ажиглаж байгаад ингэж зурдаг болох юмсан гэж мөрөөддөг байж билээ. Сургуульд ороод ангийн ханын сонин, сурагчдын дүрэмт хувцас, хичээлийн үзүүлэнгийн зураггээд л зөндөө юм зурдаг. Зав л гарвал зурагурлалын газраар очдог байлаа” гэж хүүрнэх нь сэтгэлд дотно сайхан санагдаж билээ. Зураачийн сэтгэл бүтээлээс нь илүү тод гэрэлтэх ажээ.

Бүтээлээс бүтээлдээ шинийг эрэлхийлж зурдаг Б.Төмөр гуайг Хөдөлмөрийн баатар Ардын зураач агсан Н.Цүлтэм гуай “Энэ хүүхдийг дээд сургуульд явуулж, суралцуулж чадсангүй. Авьяастай хүүхдийг хоосон орхиж хэрхэвч болохгүй хэмээн чин сэтгэлээсээ санаа тавьж Германы Дрезден, Оросын Попольска хотуудад суралцуулж өдий зэрэгтэй болгосон ачийг санаж явдаг юмаа” хэмээн өгүүлсэн дурсамж тэр үеийн ахмадуудын авьяастныг олж харж мэдэрч чаддаггайхалтай чанар харагддаг. Уран бүтээлчид бусдын ач буяныг хэнээс ч илүү зүрхэндээ тээж, бүтээлээрээ урлаж, мөн чанараараа харуулж чаддаг энгүй сайхан хүмүүс дээ.



“Мөнххаан сум” Б.Төмөр

Хүргэн Б.Сурмаахоролийнд нь очиход охин Т.Сарангэрэл нь аавынхаа уран бүтээлээр гэрээ гоёж, аавын минь зурсан зураггэж бахархан ярина. Бага хүү Т.Цогоо нь аавынхаа мэргэжлийгөвлөж, бүтээж туурвиж яваад нь Төмөр гуай их л баяртай байлаа. Уран зураачийн хүүхдүүд сэтгэлийн гэгээн өнгөнд нь уусаж, урлаж бүтээх уур амьсгал дунд өссөн болохоор аливаад урамшин догдлох нь бусдаас арай ондоо байдгийг би илүү мэдэрсэн юмаа. Ургийн алтан хэлхээний үргэлжлэл үр хүүхдүүд нь аавынхаа сэтгэлийн жаргал зовлонг хамгийн сайхнаар харж, урлан бүтээхийн урам дэм болдог нь дамжиггүй ээ.

“Аймгийн салбарт дагалдан зураач болж, уран хэмээх Б.Дампил, Х.Чойжилсүрэн, Ц.Дамдиндорж нарын ахмад зураачид намайгуран бүтээлийн замд минь хөтөлсөн. 1963 онд Улаанбаатар хотод зураачдын мэргэжил эзэмшүүлэх курс нээгдэж, Ардын зураач Б.Гомбосүрэн гуай багшилж, дүрслэх урлагийн тухай анхны мэргэжлийн хичээлүүд зааж байлаа. Одоо тэдний ихэнх нь гадаад дотоодын дээд сургууль дүүргэн, сайн зураачид болоод, зарим нь их дээд сургуулиудад багшилж байна. Зураач эрхлэгчээр ажиллаж, зураачдынхаа авьяас, мэдлэгийг дээшлүүлэхэд багагүй зүйл

хийсэн дээ” гэж үг болгон нь урлаж бүтээсэн тухай байж, үе тэнгийн бийр будаг нэгт нөхдөө дурсан сууна.

Хөдөө орон нутагт 70-80 оны үед зураг чимэглэлийн ажил ихтэй. Хулдаасан хэвлэл, цахим бичүүрийн бараа сураггүй байсан цагүед гудамж талбай чимэглэх, ухуулах байр тохижуулах, хөшөө дурсгал босгох, бэлэг дурсгалын зүйл хийх, сумдад захиалгаар зураг зурах гээд чамгүй ажилтай. Энэ бүхэнд Б.Төмөр гуай уран бүтээлчдээ удирдан зохион байгуулж цаг тухайд нь хүлээлгэн өгч байжээ. Миний төсөөлж байгаагаар одоо ч тухайн газруудад нь засвар хийж сайжруулаагүй л бол будаг нь жаахан халцарсан байдалтай буурал зураачийн залуу цагийн бүтээлүүд байж л байгаа.

“Илгээлтийн эзэн”, “Хурдан хөлөг”, “Сармагчингууд”, “Хэнтийн ноён уул”, “Алтан овоо”, “Дэлгэр овоо” зэрэг олон арван зураг зурж үзэсгэлэнгүүдэд оролцож, зарим нь төв орон нутгийн музейд хадгалагджээ. Хангалын нуурын орчимд “Гурван бүрдэт”, “Биндэрьяа нутаг” ханын диаграм зураг, “Бид энэ нутгийнхан” чулуун шигтгэмэл мозайк зэрэг бүтээл хийж уран барилга, эртний барилгын засал чимэглэлийг нэлээд сонирхож урлан үзэсгэлэнгийн байрны зураггарган бариулж, “Хөхөө хэрэм”-ийн барилгыг сэргээн засварлахад мастерийн үүрэг гүйцэтгэсэн гээд өөрийн ажил мэргэжилтэй холбоотой бүхэнд ур ухаанаа гарган ажиллаж байсан тухай их зүйлийг өгүүлж болно. Эрдэнэт үйлдвэрийн музейг шинэчлэхэд л гэхэд байгалийн, тосон будгийн 300 шахам бүтээл хийжээ. Удахгүй Эрдэнэт хотынхоо 35 жилийн ойд зориулж, есөн хөлт цагаан туг хүртэл хийхээр зэхэж байгаагаар ярьж байлаа.

Эрдэнэтээс буцахын өмнө “Уурхайчин” соёлын ордонд байгаа урлагийн тэнгэр Янжинлхам бурхны аравнайлан хөрөгт мөргөлөө. “Галын эздийн өндөрлөг”-ийн өмнө дурсгалын зургаа татууллаа. Энэ бүхэн миний уулзсан буурал зураачийн бүтээл болохыг мэдэж авьяас хөдөлмөр хоёрыг хослуулсан аргагүй л бүтээлч хүн юм даа гэж биширч билээ.



“Вiæèèðàì áýððàì” Á.Òèìèð

Èéíðүү 50 îð÷èì æèèä ðýäýí àðààí уðèàгèéí òììíðìí áγòýýèγγä ðèèð, çàèуу γáý ñуðгàð, àðäüí èð өä уèàìæèäèùг өàèүүèýð, íýðгýæèèéí ñуðгууèèуäàà ñуðàèöууèæ, íýðгýæèèéí уðàí áγòýýè÷ áýèòгýð, уèñ îðìí íуðàгòàà гàèðàгààð, ýð îðìíðìí íýðèéí ðууäàñ áíèñííí уðèàгèéí áγòýýèγγäèèг ðууðàèðäàà îðууèñàí ðуäü íýíýð, îèñíí àìæèèèðùг äуðüäààä äàðгýé èð ñì.

“Ãàèüí ýçàèéí àèäàð ðèèèè”, “Ýðäýíýð” гèèääýðèèí ðүүðýí çàìàèèüí ðàìðèì, “Óуððàè÷èì” ñì,èüí îðàíí äàðü уðèàгèéí ðýíгýð ýгòèгò ýð Вiæèèèðàì áýððìü ðàè ðèàгèð äàðèàè, Àèìгèéí íýгèèí

yäèðäëàrûí îðäíîä çàëñàí “Òèðèéí àñèí ðèèð òàrààí òγγ” çýðýγ Ìððíí àéìγèéíðàí ðèäèéγγé ýíý íγòγààð èðæ, áγòñàí γàääää äíðíîäúí îéíí çγγí çí÷éí γèé÷íèé ðγíäëýè àèððýèèèγ ðèðγγèñýí ñàéðàí áγòýýèγγä áγγðàè çγðàà÷ééí γíäàðñàí èð àäüγàñ, îðγèññíí ñàéðàí ñýòγýèèéí γð øèíýðð áγòýýγæýý.

Àìüäðäëúí àç æàðγàè, γýγýí γγíèγèéí øèäýð àééðèèγ èðèéí äíðíîä ñýòγýèèéí íàíäèí ìýäðýìæ, γð γðààíðàé íàéðñγγèáí ýààà Á.Òèèð çγðàà÷ääà ýγøèγò îðéí òýíγýðèéí øγíøèγ ðγðàéèñàí áγòýýèýý òγγðàèæ, çγγí íàíðúí ðγð áíðííí äγíä γýð÷, ðàéòγàð÷, γèáí èð γðèæ áγòýýí çγðγàäääé àèðàí òäýγ òγèæ íàñèàðúí γýγýí äðèèèèðð ýíýðγγ òýíäýγèýýý æàðγàðγ.

“Ýíýí” ñííèí 2009.05 ñàð

Дотоод сэтгэлийн өнгийг тольдохуй



МУЭ-ийн шагналт нэрт зураач С.Төгс-Оюун Дарьганга сум 2012 он

Нэг

Би санаандгүй багын найзынхаа ажлын өрөөний бичгийн ширээн дээрээс “Дотоод сэтгэлээ өнгөөр илэрхийлэхүй...” гэсэн уран зургийн танилцуулга бүхий нарийхан урт ном олж авлаа. Найз маань их л өмчирхөж “Би хүнээс гуйж авсан юм шүү” гээд харамлангуй. Уран зургийн талаар мэргэжлийн хэмжээнд ойлгож чадахгүй ч зураач нартай ойр дотно байдгийн хувьд С.Төгс-Оюун зураачийн бүтээлийн танилцуулга болохоор их л хичээнгүйлэн үзсэн юм.

Тэрээр “Хүнийг анх мэндлэх мөчөөс л хорвоогийн олон өнгө түүнийг угтан авдаг. Хүн хэлд ороогүй байхдаа өнгийг ялган хардаг. Би бусад хүүхдийн адил ухаан орж эхэлсэн цагаасаа л зурж эхэлсэн. Тэр үед би өөрийн зөн совинд хөтлөгдөн орчин тойрны таних мэдэх бүх хүмүүсээ дүрсэлдэг байсан ч одоо бодоход миний зураг томчуулд

тийм ч их ойлгомжтой байгаагүй болов уу? Харин миний эргэн тойронд байгаа бүх өнгөнд би дурлан тэмүүлдэг байлаа. Байгалийн дөрвөн улиралын хувирах өнгөнүүдэд сэтгэл минь их хөдөлдөг” гэж гоёчлоогүй үнэн сэтгэлээсээ яг л хүүхэд шиг энгийн бичсэн дурсамж нь миний сэтгэлийг их л уяраалаа.

Бүтээлийг нь олонтаа үзэж байсан ч өөртэй нь уулзаж дотно танилцаагүй байсан болоод тэрүү дурсамжийг нь уншсанаас хойш “Төгсөө” гэж адилхан нэртэй, адилгүй мэргэжилтэй зураач эгчтэй танилцах юмсан гэсэн хүсэл байснаас цаашгүй цаг хугацаагулираасан ажээ. Цаг нь болж нөхцөл нь бүрдсэн нэгэн цагт бид уулзана даа л гэсэн бодолтой явсан хэрэг.



Харин танилцсан түүх маань гоё сайхан номыг нь санаандгүй олж үзсэн шигээ мөн хөрш амьдрах болсноо санамсаргүй мэдсэнээс үүдэлтэй. Хөлсний байранд амьдрахаар ирээд жил гаруй болсон хойноо зураач Төгс-Оюун эгчтэй таарч билээ. Төгсөө эгчийг байрныхаа үүдэнд бяцхан ач охин Дөлгөөнийгөө хөтлөн зугаацаж явахад нь уулзаж, хөрш болохоо сая мэдэж, уран бүтээлийн эгч дүүс болон дотноссон юм.

Найзынхаа ганцхан өдрийн хугацаатай “зээлээр” уншуулсан номыг, би зураачийн өөрийнх нь гарын үсэгтэйгээр авч ихэд баярлаж билээ. Уриалгахан энгийн

зантай зураач бүсгүйн бусдаас илүү хүнлэг сэтгэл, дотно нөхөрсөг, бүтээлч, хариуцлагатай чанарыг нь би үргэлж хүндэлж хайрладаг.

“Магтаал, зэмлэл хоёр надад яг адилхан санагддаг” гэж эрхэмсэг өгүүлэх энэ бүсгүй үнэн төрх, үнэн үг, үнэн сэтгэл, үнэн, үнэн, үнэн... Чин үнэн байдлаараа бусдын хайр хүндлэлийг татаж, жаргал хийгээд зовлонг нь хуваалцан явдаг нь ер бусын ухаалаг. Хэн нэгнийг хайрлаж, тусалж, баярлуулж явдгаараа хэзээ ч гавьяархаж, бардамналгүй хийх ёстой ажилаа л хийчихсэн мэт баярлан, цоглог хөөрхөн инээмсэглэлээрээ угтаж,

-Цай уух уу, кофе уух уу? гээд дайлах дуртай уран бүтээлч эгчийнхээ урлангаар орж, олон ч удаа дайлуулж дээ. Урлангаар нь зочилсон хэн бүхнийг тийнхүү цайлахдаа сонгодог хөгжим, яруу найраг, шилмэл дуунууд сонсгон дайлна. Ер бусын баясал хөөртэй уур амьсгал тэр жижигхэн өрөөнд өрнөдөг юм.

Монголын дүрслэх урлагийн салбарт эмэгтэй уран бүтээлчид тун цөөхөн байсан үеэс бүтээлээрээ эрчүүдтэй эн зэрэгцэн мэргэжлийн түвшинд урлаж, Москва хотын Суриковын нэрэмжит Уран зургийн академийг зураасан зураг, номын чимэглэл зураачийн мэргэжлээр дүүргэснээсээ хойш өнөөдрийг хүртэл уран зургийн ертөнцөд өөрийн гэсэн өнгө төрхтэйгөөр бүтээж туурвиж явнаа.

Урлаг судлаач Ц.Уранчимэг “Зураач С.Төгс-Оюуны бүтээлүүд шатаж буй өнгө, долгионтсон зураасны хэмнэл, хавтгай дүрслэл зэргээр эрчимтэй хөдөлгөөнтэй, амилаг болж харагддаг онцлогтой. Тэрээр хөрөг, үлгэр, домог, шашин, өдөр тутмын аж байдал, байгаль зэрэг өргөн сэдвийн хүрээнд бүтээлээ туурвидаг бөгөөд тод хурц өнгүүдийн хоорондын нарийн уялдаа, тэдгээрийн хэлбэр дүрстэйгээ нийлж байгаа зохицол нь эл зураачийн бүтээлүүдээс миний хамгийн их онцлох дуртай чанар билээ. Эмэгтэй хүний халуун хайр, үр хүүхэд, хань ижлийнхээ сэтгэлийг дулаацуулдаг, халуун илчийг түүний ямар ч бүтээлээс нь мэдэрч болдог” гэж түүний бүтээлийг тун ончтойгоор үнэлж дүгнэсэн байдаг.



“Тэнгэрлэг охид-2” 2012 он

С.Төгс-Оюун зураач эмэгтэй хүний байгалиас заяасан гоёж гоодох дуртай занг хэний ч тоож үл анзаарч харамгүй мод, цэцэг, энгийн чулуугаар илэрхийлэх нь түүний мөн дотоод сэтгэлийн нэгэн тод өнгө болон харагддаг юм. Түүнд зохиогүй гоёл гэж огт байдаггүй бөгөөд түүний тэр өвөрмөц гоёлууд нь өөр хүнд бол яагаад ч зохихгүй боловуу гэсэн этгээд бодол надад төрдөг л дөө.

Хамгийн гол нь өөдрөг сэтгэлээрээ тэжээгдэн, бүтээж туурвин, эргэн тойрныхон нь эрүүл эсэн байвал улам аз жаргалтай инээмсэглэн алхаж явдаг. Харин өвдөж зовбол өөрөө өвтгөчихсөн мэт өмнөөс нь шаналж бусдын төлөө чин зүрхнээсээ ханддаг байдал нь уран бүтээлээс нь ч уншигдаж мэдрэгддэг. Танд ч бас тэгж л уншигдаж таарна.

Хоёр

Төгсөө эгчийг би зураач болоогүй бол зохиолч юмуу сэтгүүлч болох байсан болов уу гэж итгэдэг. Учир нь тэрбээр нөхдийнхөө тухай маш сайхан дурсамж бичиж хэвлүүлдэг. Өнгөрсөн жил Германы Вурцбург хотод үзэсгэлэнд оролцоод мөн Францаар аялан явахдаа олон монголчуудтай уулзсан тухайгаа ярьсан юм. Тэр дундаа зохиолч, яруу найрагч З.Түмэнжаргалтай элчин сайдын яамнаа таарч, ярилцсан тухай тэмдэглэлийг нь “Утга зохиол урлаг” сониноос уншаад уярч билээ. Хоёуланг нь таних учраас тэмдэглэлийгуншиж байхдаа асуулт хариулт бүхэн нь зохиолч, зураач хоёрын дунд л ийм сонирхолтой хөөрхөн яриа өрнөнө дөө гэж бодогдохоор өгүүлсэн байдаг юм.

Төгсөө эгчтэйгээ хоёр жил дараалан төрсөн нутаг Сүхбаатар аймаг, Дарьганга сумаараа аялж, үзэсгэлэнт хун шувууны чуулганыгүзэж, Алтан Дарь овоо, Хүн чулууд, Талын агуй, Шилийн Богд уулаараа аялсан юм. Зам асуухаар түр зогсож уулзах малчнаас эхлээд буусан айл бүрийн

хүүхдүүдэд чихэр жимс, тоглоом, зураг, түлхүүрийн оосор гээд заавал нэг бэлэг өгдөг, бас зургийг нь дарна. Хотод ирээд зургийг нь угаалгаад дугтуйлан хүнээр явуулна. Яг л төрөл садан нь юм шиг дотносож, хайрлаж хүндэлдэг нь хэн хүнд их л үлгэр дууриалтай билээ. Манай нутгийн уран уншигч Ц.Мөнхзаяа, яруу найрагч Д. Амгаланзаяа хоёртой бидэнтэй адилхан уран бүтээлийн эгч дүүс болсон доо.

Түүнтэй холын замд явж байхад яарч адгах юм гэж огт үгүй. Эхний жил бид Сүхбаатар аймгийн төв дээр Ай.Төмөр-Очир найрагчийнд тухлаад, зураач Ё.Бадарч, яруу найрагч С.Амартайван, сэтгүүлч Г.Сүхээ, Я.Түмэннаст гээд аймгийнхаа уран бүтээлчдээр их л ёслол төгөлдөр “үдүүлээд” оройхон Дарьганга сум уруу хөдөлсөн юм.

Би жолооч. Надаас арай дөнгүүр жолооч бол наснаасаа олон ирсэн нутгийнхаа замаас төөрмөөргүйсэн дээ. Гэтэл төөрчихлөө шүү. Шөнө болсныг ч хэлэх үү, жаахан айлаа. Харин

С.Төгс-Оюун эгч “Санаа зоволтгүй ээ дүү минь. Чигээрээ л яваад бай. Монгол улсын нэг суманд л очно. Хил давчихвал чи хятадаар ярьчихна” гэж хошигнон тайвшруулсаар Дарьгангадаа саадгүй хүрч билээ.

Харин энэ жил бид аймгаас зэхээхэн гарч, нар жаргахаас арай урьдхан Дарьгангад очсон л доо. Энэ тухай С.Төгс-Оюун эгч Ардын зураач Д.Амгалан багшийнхаа тухай дурсамжид “Би эх орноороо аялах дуртай. Яагаад ч юм бэ, хорин нэгэн аймгаасаа хамгийн сүүлд Сүхбаатараар өнгөрсөн жил явлаа. Багш минь ийм л сайхан нутагт төрж өсч дээ гэх бодол алхам тутамд төрж байв. Энэ жилийн анхны цаснаар Дарьганга сум руу ойртон ирэх үед нар жаргах дөхөж тэнгэрт үүлс улайран байв. Нэг л сэтгэлд дотно, танил агшин... Би энэ улаан үүлтэй тэнгэрийг хаана харлаа гэж бодох зуур Амгалан багшийн маань “Мөрөөдөл” зураг тэр хэвээр сэтгэлд буудаг байгаа! Энэ л нутагт төрж өссөн, багадаа ааваасаа өнчирч хоцорсон хүү ийм тэнгэрийг ширтэн сайхан ирээдүйгээ сэтгэлдээ төсөөлөн суугаа байх даа гэсэн бодол төрж билээ” хэмээн бичсэн байдаг юм. Түүнийг ийн бодож байсныг бидний хэн нь ч тааж мэдээгүй. Тэрбээр ийм л бусдын бодоогүйг бодож, анзаараагүйг анзаарч, дотоод сэтгэлийнхээ мэдрэмжээр дамжуулан уран зураг болгон дүрслэн бүтээдэггайхамшигтай бүтээлч бүсгүй юм.

С.Төгс-оюун эгч “Мөргөл” зургийнхаа тухай “Аль ч цаг үед уран бүтээлч хүнд сэтгэл бодлоо хуваалцдаг анд нөхөр хэрэгтэй болдог. Гоо үзэсгэлэн, авьяас билэг төгс хосолсон Дадушири бүсгүй насан туршдаа Говийн ноён хутагт Данзанравжаагийн төлөө залбиран мөргөж, түшиж тулж явсан, тэд олон ч бүтээлээ хамтдаа туурвисан юм” хэмээн бичсэн байдаг. Би энэ тайлбарыг анх уншиж байхдаа тэр бүтээл нь миний гэрийн хойморт бэлэг болон ирэх юм гэж яахин төсөөлөхсөн билээ.

Он цагулирсаар би зураач хөршийнхөөсөө холдон нүүх боллоо. Би тэнд таван жил аж төрсөн юм. Миний хятад хэлний багш Ц.Базаррагчаа, зураач Төгсөө эгч хоёртоо хоргодоод аль нэг тийшээ нүүх тухай бодох сөхөөгүй явсаар

тийнхүү удсан болов уу гэж санах үе ч байдаг л даа. Шинэ байшинд орохоор нүүх болоход бид яг л өөр хот, аймаг сум руу нүүх гэж байгаа юм шиг салж ядаж билээ. Тэр мөчид “Мөргөл”

зургаа надад бэлэглэж, нэг ширээгээ ч тавиагүй байсан зочны өрөөнд маань өөрийн биеэр хүргэж өгсөн нь “Насан туршдаа сэтгэл бодлоо хуваалцдаг, бие биенийхээ уран бүтээлд урам хайрладаг эгч дүүс байя” гэж байгаагийнх нь илэрхийлэл юм даа гэж бэлгэшээн бодож залбирч явдаг.

Мөн “Ганцаардахуй” зурагныхаа тухай “Дэндүү залуугаараа цаг бусаар хорвоог орхин одсон авьяаслаг нөхдөө дурсан өвлийн дүнсгэр жихүүн өдөр урландаа ганцаардан суухад өөрийн эрхгүй энэ зураг төрсөн юм. Хөөрхий тэдний минь сүнс намайг тойрон эргэлддэг ч юм билүү” гэж бодон хуанлийн хуудсыг харахад 12-р сарын 17-ны өдөр дахин ирсэн байв...” гэсэн тэмдэглэл байдаг юм. Тэр өдөр нь түүний анд, нэрт зураач Дуйнхоржавын тэнгэрт хальсан өдөр болохыг би хожим мэдэж билээ. Үнэн хэрэгтээ бол түүнийгганцаардахын аргагүй олон нөхөд нь

хүрээлж байдаг ч тэрбээр бурхан болсон нөхдөө хүртэл хэзээ ч мартдаггүй, үргэлж санан дурсаж явдаг нөхөрлөлдөө үнэнч нэгэн юмаа. Нөхдийнхөө тухай олон дурсамж бичсэн агаад одоо ч гэсэн бичсээр л байгаа.



“Мөргөл” 2005 он

Гурав

Зураач С.Төгс-Оюун эгчийг 1974 оноос эхлэн монголын зохиолч, яруу найрагчдын номын чимэглэл зургийг хийснийг ном бүтээгч андууд, уран бүтээлчид нь сайн мэднэ. 1984 онд Ч.Лодойдамба гуайн “Манай сургуулийнхан” туужаас сэдэвлэн, холимог техникээр хийсэн

гурвал, “Цаатны хүүхдүүд” хулдаасан бар, “Үдэш” төмөр бар, “Монгол хатан” төмөр бар гээд жагсаавал олон хуудас урт дараалал гарна. Сүүлийн үед л гэхэд зохиолч Б.Шүүдэрцэцэг, Х.Сүглэгмаа, Б.Багтулга, М.Уянсүх, Г.Сүхээ гэхчилэн олон арван уран бүтээлчдийн номын чимэг зураг хийснийгуншигчид бас мэднэ.

Анхны номын чимэг зургийн бүтээлүүдээсээ нэгийг онцолсон ийм нэгэн дурсамж байдаг юм. “Усны эргүүлэг буюу Борзооны явдал”. Миний хийсэн анхны номын зурагнуудын нэг хэсэг. Би өөрөө хүүхэд байсан тул энэ туужийг ихэд амтархан уншдаг байв. Дэлхийн хоёрдугаар дайны хүнд хэцүү үед хөдөөгийн сургуулийн сурагчид болон дотуур байрны хүүхдүүдийн амьдрал, хөгжилтэй үйл явдал дүүрэн. Туужид гарах хүүхдүүд бүгд л миний найз нөхөд шиг санагдаж цагаан цаасан дээр хар бэхээр зөндөө зураг зурсан юм. Хожим харин уг номын зохиогчийг сонирхон сураглалат тэр хүн ертөнцийн мөнх бусыгүзүүлснийг дуулаад ихэд харамсаж билээ” гэж бичсэн байлаа. Тэрбээр бусдыг ингэж л дурсаж, хайрлаж, чин сэтгэлээсээ харамсаж чаддаг юм. Хүүхэд байхад бидний ч бас амтархан уншиж байсан энэ зохиолын зургийг Төгсөө эгч маань зурсан гэж бодоход нэг л дотно сайхан сэтгэгдэл төрдөг дөө.

Өнгөрсөн жил “Бясалгагч охины зүүд” номынхоо зургийг таниар зуруулья гээд шүлгүүдээ бариад очлоо. “Үзэсгэлэнт бүсгүйн зүүдэнд өндөглөсөн шувуу”, “Сүмийн эрвээхэй”, “Миний амьдардаг байшин”, “Шилийн Богдын охин чоно”, “Миний гудамжин дахь өвөл”... 60-аад шүлэг байсан юм. Харин энэ номд маань надаас илүү сэтгэл тавьж, гурван настай бяцхан ач охин Ү.Дөлгөөнтэйгөө хамт шүлэгнээс нь олон зураг зурж, номын хавтас дизайнд хүртэланхааран өөрийнхөө номыггаргах гэж байгаа мэт баярлан догдлон байж билээ. Бусдын төлөөнөө баярлаж, бусдын төлөөнөө цаг зав, авьяас билгээ зориулна гэдэгуран бүтээлч хүний хамгийн том чанар юм даа.

Нэг удаа Төгсөө эгч маань намайг бусдын сайн сайхны төлөө үйлсэд сэтгэлээ зориулдаг, дэлхийн 120 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг “Сороптимист” олон улсын эмэгтэйчүүдийн байгууллагын гишүүн болохыгурсан юм. Бид өнгөрсөн хугацаанд хамтдаа харааны бэрхшээлтэй болон хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд туслах төв гээд олон арван байгууллага хувь хүмүүст сайн үйл бүтээх ажилд хамтдаа явлаа.



“Ауһаеааа÷ îðeíû çүү” îîîí “Уеауðeéí ðeññe” øүeауíä çîðeóeñàí çóðää

Ингэж л Төгсөө эгч бид хоёр нэр, үйлсээрээ ижилсэн он оныг үдэж, дотоод сэтгэлийн хамгийн гэгээлэгөнгө гэрлээр сэтгэлээ

сүлэн амьдарч байна.

Бороо орсон ч би шүхэр барих гэж яардаггүй. Цас бударсан ч би өдөн дээлээ өмсөхийг хүсдэггүй. Навч унасан ч би газраар нэг хөглөрөхөд нь гуниглахыгурьтал болгодоггүй. Аж төрөхүйн өдөр хоног бүрийг өөдрөг сэтгэлээр төсөөлөн зурагладаг зураач эгч рүүгээ үе үе яаран алханам.

“Уран зохиол яруу найраг хөгжмийн урлагаас би өөрийн зургуудын санаа, зохиомж өнгийг мэдрэн хүний амьдралд тохиолдох баяр хөөр, уй гашуу, гуниг харуусал, учрал хагацал зэргийг дүрслэн үзүүлэх сайхан агшинг олж авдаг.



Зураач С.Төгс-Оюун. Дарьганга сум 2011 он

Уран бүтээлчийн сэтгэлээ зориулсан бүтээлүүд бүрээс ямагт өөдрөг, эерэг эрчим цацарч бусдад сайхан сэтгэгдэл төрүүлдэггэдэгт би итгэдэг. Миний дотоод сэтгэлийн толь болсон өнгөөр дамжуулан урсан өнгөрөх цаг хугацааг би өөрийн уран зурагтаа хувирган шингээн үлдээхийг зорьдог юм”. Энэ эгчийн минь чин сэтгэлийн үг юм шүү. Та ч бас өөрийн дотоод сэтгэлийн гүнээс тольдон хараарай.

Б. Төгсжаргал Баруун-Урт хот 2012 он.

“У” гараг гэж байгаа тэр тэнгэрийн эрхэсийн бүтэн нэр нь “урианхай” гэдэг гараг

Яруу найрагч, их сэтгэгч Дамдинсүрэнгийн Урианхай

Д.Урианхай ахын “У” гариг буюу Огтлолцохуй-II” гэсэн шинэ бүтээл хэвлэгдэн гарлаа. 1980 оны сүүлээс ертөнц, нийгмийгүзэх өөрийн үзэл бодлыг илэрхийлэх философи сэтгэлгээний бие даасан тогтолцоо боловсруулж эхэлснийг уншигчид, утга зохиолын хүрээнийхэн сайн мэдэх билээ.

Өнгөрсөн хугацаанд “Үр-эх”, “Үр-чанар”-ын онолын үндэслэл болох “Хөгжлийн мөн чанарыг онохуй”, “Оршихуй, Тогтнохуй...”, “Сэтгэхүйн тусгаар тогтнол”, “Тэнгэр бурханыг эрэхүй...”, Орчлонгийн үнэлэхүй зүй тогтол буюу Түгээмэл чанар” зэрэг гүн ухааны олон өгүүлэл, трактат бичиж “Хүмүүн оршихуйн үндсүүдийн метафизик эргэцүүллүүд”, “Үнэнээс цогцолсон зэндмэнэ” номууд хэвлүүлсэн нь уншигчдад шинэлэг, содон мэдрэмж өгөхүйц бүтээлүүд болсныг мэргэжлийнхэн нь дүгнэн хэлсэн нь бий.

1968 оноос уран бүтээлээ эхэлж, шүлэг, арван дөрөвгийн эрхи, дууль, өгүүлсэн шүлэг, найраглал, өгүүллэг, тууж, жүжиг, дуурь, роман, эссээ, туурь, бодрол, нийтлэл, кино, уран зохиолын онолын өгүүлэл, орчуулга зэрэгуран зохиолын “Бишүбү” урсгалын онолыг боловсруулсан юм.

Ард түмэн минь ядуу байгаа цагт би алдар хүндийг эрхэмлэж, гавьяа шагнал авахгүй гэж “Төрийн соёрхол”-оос хүртэл татгалзснаа тунхаглан зарлаж, зохиолч, яруу найрагч хэмээх эрхэм алдраараа овоглож ирсэн их хүмүүний шинэ номыгуншигч та бүхэн шимтэн уншаарай. Би та бүхнийг зохиогчтой уулзуулья.

- Утга зохиол судлалын төвөөс таны “У” гараг буюу Огтлолцохуй-II” гэсэн содон нэртэй яруу найргийн шинэ номыг хэвлэжээ. Хэвлэн нийтлэгч, профессор Д.Гүн-Үйлс энэ номыг “маш сонирхолтой ном” гэж мэдээллээ.

- Тийм нэртэй ном хэвлэгдсэн нь үнэн. Уншигчдын “цөөнх”-өд л сонирхолтой, “олонхи”-д нь сонирхолгүй ном байгаа байх.

- Яагаад тийм гэж?

- Түвшин нь тийм юм. Зохиомж, бүтэц, агуулгын багтаамж, бичлэгийн арга барил гээд элдэв шалдав юмнууд ч...

- Хэр их хугацаа зарцуулсан бол?

- Олон жил!

- Тодорхой тоо хэлвэл?

- Багцаа нь сүүлийн 5-6 жил! Зарим шүлэг нь арваад жилийн ч өмнөх огноотой байгаа байх шүү!

- Тийм удаан бодсон байх гэж үү? Эсвэл бичсэн?

- Мэдээжээр өдөр болгон бодоод явахгүй шүү дээ. Анхны санаа сэрхийгээд, шүлгээ ноороглон сар, өдөр нь л тэр! Тэр ноорог хэд хичнээн засагдаад, хичнээн боловсрогдоод миний санаанд нийцсэн шүлэг болтлоо

дарагдаж хэвтсээр арав шахам жилийгүдчихсэн л байгаа хэрэг. Түүнээс биш арван жил нэг шүлгийг бичих гэж яаж байх вэ! Гёте “Фауст”-аа бичихэд 40 жил зарцуулсан гэдэг ч өдөр бүхэн бичээд, бодоод байгаагүй л байлгүй дээ!

“У” гараг буюу Огтолцохуй-II” гэдэг нэрийн тухайд асуумаар байна. Товч ойлголт өгөөч! Уншигчдынхаа өмнөөс тайлбар хүсч байна л даа!

“У” гараг гэдэг нь огторгуйн хязгааргүйд өөрийн тойрог замаар орчиж буй тэнгэрийн эрхэс! “У” гэдэг нь тийм нэг сансарын жижиг ч юмуу том ч юмуу нэг биетийн нэрний эхний үсэг буюу тэмдэглээ. Харин бүтэн нэр нь болохоор, “Урианхай” гараг. Номын зохиогч өөрийгөө бодгалын хувьд болоод өөрийнхөө оюун санааны, сэтгэлийн, үзэл бодлын ертөнцийг амьд орчлонгийн нэг эрхэс гараг гэж үзэж буйгаа илэрхийлсэн утгатай! Би чинь өөрийгөө Монголын яруу найрагт ч, дэлхийн яруу найрагт ч тийм хэмжээгээр бодож томордог хүн шүү дээ! (хэлээ гаргав) Тоглож байна шүү, битгий үнэмшчихээрэй! Харин үнэнийг хэлэхэд, ном минь жаахан хүнддүү талдаа шүү!

- Харин тийм сэтгэгдэл нэрнээсээ эхлээд л төрүүлээд эхэлж байна л даа. Номын тань нэрэнд бас “Огтолцохуй-II” гэсэн үг болоод ром тоо байна. Юугэсэн учир утгатай юм?

- Тэр ч яахав дээ, зүгээр л, “Шинэ шүүмж” төвөөс 2007 онд нийтэлж шилдэг бүтээлийн “Алтан өд” наадмын тэргүүн шагнал хүртэж байсан “Огтлолцохуй” шүлгийн номын минь хоёрдугаар дэвтэр нь л гэсэн үг ба тоо! Энэ хоёр номд хоёуланд нь бидний “Бишүби” урсгалын онолын үндэслүүдэд тусгагдсан туурвилзүйн зарчимууд хэрэглэгдсэн байгаа. Сэтгэлгээний шинэчлэл, хэлбэрийн эрэл, туршилтууд, байгальлаг сэрэл сэрэхүйн долгио, амьдралын философлог драм

гэх мэт! Энд дэлхийн яруу найргийн “бодотчилох”, “хийсвэрлэх” дүрсэлгээний сэтгэлгээ өөр өөрийнхөөрөө ашиглагдахын хамт ямар нэгэн нууцлаг, үл тайлагдах зөн сэрэхүй, совинлог мэдрэмж, сэтгэлийн аяс хөг, дотоод бясалгалаар синтезлэгдэж, аль нэгүтгандаа гоо сайхан чанартай шүтэн барилдаж бэлгэ билгүүний “хярд” тэврэлдэн найралдаж байгаа! Энэ бол “Бишүби” урсгалын аргын үндсэн зарчим юм.

Д.УРИАНХАЙ

"У" ГАРАГ
БУЮУ
ОГТЛОЛЦОХУЙ - II



“У” гараг буюу огтлолцохуй-II яруу найргийн түүвэр 2011 он

- Гол нь юуны тухай ном бэ?
- Юм юмны л тухай байх!
- Тэр ч мэдээж ойлгомжтой л доо. Харин нарийвчилбал
- Хүний л амьдралын тухай! Хүний амьдрал угтаа зовлонгийн мөн чанартайн тухай, мөнх бус зуурдын мөн чанартай тухай, хүний амьдралын драм, бас, олдошгүй ховор чанартайн тухай!
... Өөр юуны тухай байхав дээ.
- “Огтлолцохуй” гэхээр нэг л сөргүү ч юм шиг, эсвэл сонин ч юм шиг, нэг л хэлж хэвшээгүй дуулдаад байна л даа! Хийсвэрээр төсөөлж ойлгох ойлголт юмаа даа?
- Жирийн л нэг ойлголт, жирийн л яригддаг үг шүү дээ. Нэг шулуун нөгөө шулуунтайгаа, нэг тойрог нөгөө тойрогтойгоо, амьдралд нэгүзэгдэл нөгөө үзэгдэлтэйгээ огтлолцож, хаа нэгтээ цэгт юмуу орон зайд, аль нэг цаг хугацааны тохиолд бие биеэ заавал дайрч өнгөрч байна. Өөрөөр хэлвэл, учирч хагацаж, таталцаж, түлхэлцэж, нэгдэж тусгаарлаж, өөр өөрийнхөө ахуй оршихуйн мөн чанараар харилцан үйлчлэлцэж, тэгснээрээ, өөр өөрийгөө харилцан идэвхитэйгээр танин мэдүүлж, үр дүнд нь нэг талаар хүлээн зөвшөөрөлцөж, нөгөө талаар үгүйсгэгдэж өөр өөрийнхөө шинж чанараар оршин үргэлжилж байна. Иймэрхүү л диалектикүйл явцын хөдөлгөөнтэй дүрслэл! Харин, нэгэнт “Огтлолцохуй” гэж утгачилж байгаа учраас жаахан огторгуйлаг, орон зайн хийсвэрлэлт сэтгэлгээ шаардана л даа. Хавтгайн геометрээр, зөвхөн “урт”, “өргөн” гэсэн хоёрхон хэмжигдэхүүнтэй тэгш хавтгай гадаргууг ойлгох ойлголтоор бус, “урт”, “өргөн”, “өндөр” гэсэн гурван хэмжээстэй, зохих мурийлт,

мушгиралт, гажилтуудтай орон зайн талбайд орчиж буй хөдөлгөөнийг, тийм хөдөлгөөнд оршиж буй “биет”-ийн сэтгэлгээний шинж төлөв, бодит үнэнийг хийсвэрлэн ойлгох ойлголтоор хандахыг шаардана. Тэр “биет” нь яруу найрагч хүн болохоор яруу найрагчийн бүхий л үнэн амьдрал, үзэл бодол, дотоод ертөнцийн хямрал нь ч юмуу сэтгэлийн тайтгарал, эвлэрэл өнөө “биет”-ээ тодорхойлох учир улам ээдрээтэй, улам гүнзгий зөрчил, драмтай, ойлгогдох ойлгогдохгүй учир шалтгаантай “биет” болоод явчихна шүү дээ. Жишээ нь: энд энэ “У” гараг өөрийнхөө “Нүдэн доторхитойгоо хийгээд орчин тойронтойгоо”, “Сэтгэл хийгээд цээжин доторхитойгоо”, “Бодол хийгээд тархин доторхи” тойгоо “Байгаагүй”-тэйгээ хийгээд “Байхгүй”-тэй

огтлолцсон байгаа. Ингэхлээр би өөртэйгөө шүтэн барилдсан бараг юм бүгдийнхээ тухай үгүүлсэн байгаа гэж хэлж болох юм.

- Таны үг хэллэг, найруулга жаахан “ачаалал”-тай, түргэн уншихад бэрхшээлтэй байх шиг санагддаг...

- Зарим хүн тэгж хэлэх гээд байдаг юм. Монгол хэлний үгийн сан нь их баялаг шүү дээ. Бичгийн хэл, сударын хэл, аман ярианы хэл гээд л! Илэрхийлэх чадвар нь гаргуун! Ялангуяа уран зохиолын хэл бол сонгодог түвшинд төгс боловсорсон хэл! Би эх хэлнийхээ тэр талуудыг ашиглахыг их хичээдэг. Монгол бичгийн хэлнийхээ үгийн өв сангаас “хумслах” их дуртай.

- Шинэ номынхоо талаар ярилцлага өгсөнд баярлалаа. Урт наслаарай, олон олон сонирхолтой ном туурвиарай.

Ерөөлөөр болог оо. “Номын түлхүүр” сэтгүүл. 2010 он

Би хүн төрөлхтнийхөө өмнөөс маш их эмгэнэж байна



Зохиолч, “Монголын Философийн Холбоо”-ны тэргүүлэгч гишүүн Д.Урианхай

Би зохиол уншихаараа өрөвдөлтэй дүрийг нь бодоод хэсэг гуниглачихдаг. Бусад уншигчидад ч бас ийм мэдрэмж төрдөг байх даа. Д.Урианхай ахын “Ойн сонат”-ыгуншаад нэгээр тогтохгүй хэдэн өдөр гунигтай байж билээ. Уулзах бүртээ л яагаад? гэсэн асуулт асуугаад үнэнхээр болсон явдал яриулах гэж байгаа юм шиг л шалгаадаг. Зохиолч зохиолоо тайлбарлахаас үл цааргална. Гол нь би сайн уншигчдаа биш, Д.Урианхай ах сайн зохиолч болохоор л зохиол нь ингэж хүний сэтгэлд “дараас” учруулдаг гэж ухаардаг. Энэ тухай мэргэжлийн хүмүүс маш их үнэлж цэгнэсэн байдаг учир жирийн сэтгүүлч би олон үг нурших нь илүүц бизээ.

Хавраас хойш Д.Урианхай ахтай “болзоогүй” юм байна. “Би хувьдаа бодохдоо хүний нийгмийн хөгжил бол их олон юм хэрэглэхэд бус, бага цөөн юмыг ухаалаг, гоо сайхнаар хэрэглэх, хэрэглээндээ дээд зэргийн хэмнэлтийн зарчим баримтлах, тэр бага, ариун сайхан, хэрэглээнээсээ их аз жаргал, амар амгаланг олж хүний амьдралын үнэ цэнэ, баяр бахыг бүрэн мэдэрч чадах сэтгэл, оюуны чадварт хүрэх үйл явц л гэж бодоод явдаг” гэж 2012-06-29 нд цахим хуудаснаас уншсан ярилцлага миний ойрд нэг уулзах юмсан гэсэн бодлыг минь дэврээж байсан юм.

Зуны нар, хур тэгш налгар өдрүүдэд “Боролдой” Мягмар гуайн захиалсан гэж өгүүлж байсан нөр хэцүү зохиолоо бичиж дуусгасан болуу, Улсын баяраар яаж наадсан бол, их эрдэмтэн Б.Ширэндэв гуайн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан яруу найргийн наадам Хөвсгөлд болж тэр наадамд “аман хүзүүдсэн”-ийг дуулаад, баяр хүргэе! гээд гар утас уруу нь залгалаа.

Уулзахаар товлосон газраа уулзаж Шадивланд байх зусланд нь очихоор болсон юм. Би түүний “Учрахын баяр их тусмаа хагацахын гуниг хүнд” гэдэг шүлгийн мөрийг нь уншаад нүднээ өөрийн эрхгүй нулимас тордог.

Бидний уулзсан энэ өдөр Урианхай гуай хайрт ханиа алдаад нэг жилийн ой нь тохиож буй өдөр таарч сэтгэл нь их гундуухан байгааг ярианаас нь олж мэдлээ. “Хүнд ханийн үнэ цэнэ элэрнэ гэж байхгүй! Нэг жил ханилсан байна уу, арав, хорь, гучин жил ханилсан байна уу ялгаагүй, амьдын хагацал аймшигтай юмаа! Өнгөрсөн хойно нь их л юм бодогдох юм. Би ч муу аав, муу хань даа. Цаасан дээр үг, өгүүлбэр сараачин суухаас өөрийг мэдэхгүй” гэж өөрийгөө зэмлэнгүй аястай “дүгнэв”. Амьдралд жаргал зовлон хоёр ээлжилдэг хойно доо. Бас энэ өдөр Францын соёлын зүтгэлтнүүд Урианхай гуайн “Инээд шиг хуучин хүний амьдралд...” гэдэг шүлгийг нь “Дэлхийн нэг шүлгийн ном” цувралаараа Францад хэвлүүлээд авчирч өгсөн баярт өдөр байлаа.

Уртын дуу сонсоод л уярч тайтгардаг занг нь мэдэх болохоор машиндаа ярилцаж явах зуураа алдарт дуучин Түмэндэмбэрэл гуайн дуулсан “Дөрвөн Уул” дууг сонгож тайтгаруулсаар зусланд нь хүргэлээ. Охин, хүргэн нь уран бүтээлийн тохилогөрөө барьж өгч байна. Уран бүтээлчид их л ирдэг юм байна. Одоо энэ өргөө баригдаад дуусвал та нар их л ирнэ биз дээ гэж ярилцсаар гэрт нь орсон юм.

Зуслангийнхаа жижигхэн байшингийн голд байрлуулсан хуучин том ширээндээ Бурхан шүтээнтэйгээ зэрэгцүүлээд Л.Н.Толстойн зургийг тавьсан нь их л содон харагдлаа. Ер нь бол библи уншиж, бурхан багшдаа мөргөж тарни тоолдогийг нь сонин хэвлэлээр янз бүрээр бичиж их зохиолчийн сэтгэлийг зовоодог. Харин Д.Урианхай гуай ер ажрах үгүй амирлангуйгаар зохиол бүтээлээ туурвиж, бурхан шүтээнээ залсаар л байна. Их л анги ондоо хүн юм даа.

- Та ардын дуунд их уярдаг гэсэн. Таныг сайн мэдэх олон зохиолчид тэгж ярьж байхыг сонссон. Тэгж уярдаг болсон ямар нэгэн шалтгаан Таны амьдралд байсан байх даа?

- Цогт Хунтайжийн “Хадны шүлэг”-г,

“Халх, Онигуудын нутаг хол болов ч Хайрлан саналцахын агаар нэгэн буй!”

хэмээн сийлэгдсэн байдаг. Амраг хоёр хүн бие биенээ хайрлах, санах, хорвоогийн бор шар хоногт хэн хэнээрээ дуган үгүйлэх хэмгүй халуун гуниг хүний сэтгэлийн хамгийн “жаргалтай зовлон” юм. Энэ бол хүний амьдралыггэгээн утгатай болгож буй нэг том философи! Монгол ардын уртын дуунд ч, богинын дуунд ч (манай нутгийнхан богинын дууг “завхай дуу” гэдэг. Д.Урианхай) дээрх “жаргалтай зовлон”-г уусгадаг. Монгол ардын дууны тун гүн, хөлчүү, цээжнээс уярлын нулимс өөрийн эрхгүй дусагнам үнэн үг, сонгодог сайхан аялгуутай хүчирхэг эрчим над руу нэвтрэхээр би тэсэлгүй уйлчих гээд болдоггүй “муухай” заншилтай л даа, үнэндээ! Ардын дуунд хүлэг морь, уулын хүдэн манан, намрын салхи, нүүдлийн шувууд, хээрийн өвс ногоо, ой мод их дурдагддаг ч чухамдаа тэдний мөн чанарыг дурдаад байгаа ч юм биш, амраг сэтгэлтэн, ахан дүүс хүйтэн хэн нэгнээ үгүйлсэн, хэн нэгнээсээ хагацан шаналсан, уулзан тэврэлцэхийн мөрөөсөлд гансран сэтгэлийн агаараа үерлүүлсэн “Хайрлан саналцах”-ынл нулимсаар нэвчсэн байдаг юм шүү. Тэгэхээр ардын дуугаа ойлгодог, мэдэрдэг,

үг, аяны нь төгс төгөлдөрийг цээжин дотуурхи үндэсээрээ тэмтэрч хором зуур ч болов жаргал, тайтгарал эдлэх соёлтой хүн Монголд минь ганц би биш, айл бүрд хэд хэдээрээ бий шүү! Ингээд, үгээ жаргааж хэлэхэд, монгол ардын дуу бол, миний боддогоор, “Байхгүй”-тэй эвлэрэхийн “Хэцүү”гээс төрдөг “Үгүйлэхийн халуун”-ы хэмийг заадаг.

- Бүтээл төрөх агшин гэж байдаг. Надад ч байдаг. Гэвч тодорхойлох аргагүйддэг. Энэ “хүчин мөхөсдөл” Таныг тойрдог уу, дайрдаг уу?

- Тийм шүү, тэр “хүчин мөхөсдөл” байнга дайрдаг. Гэхдээ, өдий өвгөн насыг энэ хатуу хорвоогоос хүртчихээд, бүтэн жаран шахуу жил зохиол оролдчихоод ийм нодготой асуултанд дуугай, илжиг шиг гөлрөөд байлтай биш дээ, хэдэн үг эвлүүлэхийг хичээе л дээ, хүүхээ! Юугэхээр, алив уран бүтээлийн “хөрөнгө” нь хүний ганцаардал, гуниг, амьдралын нь драм, хайртай хүн хайртай юмаа байтугай хайргүй хүнээ ч хайрлах “дотоод ахуу ертөнц”-ийн хөгжлийн өндөрт хүрсний “зовлонг” байдаг байхаа магадгүй санагддаг. Хүний биеийн халууны дундаж хэм 36°, 37°, харин 38°, 39° хүрэхээр халуурч эхэлдэг. Халууны хэм ихэссээр 40° хүрэхээр юмуу давахаар хүн солиордог. Яг үүн шиг, уран бүтээлчийн сэтгэл халуурч, халуурлынхаа туйлд хүний материаллаг амьдралаас тасрахаар, эсвэл, бүүр гүн рүү нь шургаж хүлцэх ч юмуу эвлэрэх, үл хүлцэх ч юмуу үл эвлэрэхийн зөрчилд тэсрэхээр амьдралд бодитой байдаг хүний махбодын үнэнийг өөрчлөх, шинэчлэх, шинэчлэх шинэчлэхдээ амьдралд бараг байдаггүйгээр гоо сайхан, төгс төгөлдөр, тэнгэрлэг аугаагаар хувьсгалжуулан шинэчлэх хүсэл, хайрын “халуурал”-д дотроо шатаад “самадид” гоц төвлөрч буй агшин уран бүтээл, туурвилын онгодын агшин байхаа магадгүй шүү! Чиний асууснаар, бүтээл төрөх онцгой агшин байж ч мэднэ.

- Та хүний амьдралын зовлонг зохиолчийнхоо мэдрэмжээр яаж мэдэрдэг вэ? Таны мэдрэмж, ойлголт?

- Хүнийг буй болгосон анхны нөхцөл, шалтгаанд нэг “жижигхэн” нууц байх шиг байнаа, ер нь! Нийгмийн ихэнхи “Баагий”-нууд ойлгодоггүй, магадгүй, “Элитүүд” нь ч ухаардаггүй тийм үл тоомсорлом нууц! Тэр бол, миний бодлоор, хүний амьдралд “хэрэгтэй” нь “хэцүү”-гийнхээ ард буюу хойно, “жаргал” нь хүнд хүчир “Бэрхшээл”, “Сорилт”-ынхоо ард буюу хойно, “Сайхан” нь “Муухай”-хаа ялагдалын ард буюу хойно тус тус нуугдан нууцлагддаг нэг “башир” зүй тогтол юм шиг! Энд, “ард” буюу “хойно” байгаа гэдгийг “дотор” нь буюу “хам” байгаа гэж ойлгоорой! Тэгэхээр, “хэрэгтэй” нь “хэцүү” дотор, “Жаргал” нь “Бэрхшээл”, “Сорилт” дотор, “Сайхан” нь “Муухай”-н ялагдал дотор бүгэж байгаа гэсэн үг болно. Эндээс, философи утгаараа ямар дүгнэлт цухалзаж байна? гэхээр “Хэцүү”, “Бэрхшээл”, “Сорилт”, “Муухай”-н ялагдалын ард буюу хойно хэн нэг хүнийг тэсч ядан хүлээж байдаг “Хэрэгтэй”, “Жаргал”, “Сайхан”-д нэвтэрч хүрэхийн тулд наадах “Хадны мангаа”-нуудын хилийг түрэмгийлэн давах хэрэгтэй, хана хэрмийг нь хүчээр, нөр хөдөлмөр, тэмцлийн “хувьсгал”-аар эвдэж зорилгоо чөлөөлөх ёстой!” гэсэн дүгнэлт!

- Та бясалгал хийдэг үү?

- Зохих ёсоор нь бол, хийдэггүй л дээ. Харин өглөө бүр, ямар нэг үг, үгүүлбэр бичихээр ширээндээ суухдаа тарни уншдаг. Гавал доторхи харанхуйдаа гэгээ тусгаж байгаа ухаантай шүү юм.

- Ямар тарни?

- Оюун билигийн Бурхан-Эрдэмийн шар Манзушри, аялгуу эгшигийн увьдас эрхшээгч Бурхан-Эгшигт охин Тэнгэр Янжинлхамын зүрх тарниуд! Буддагийн шашны шүтээн Бурхад зөөлөн дүрээр ивээж, догшин дүрээрээ аюулгадаг.

Эрдэмийн шар Манзушри, Эгшигт охин Тэнгэр Янжинлхамын догшин дүрүүд нь –Очироор аюулган үйлдэгч Ямандаг, Сайн цагийн мянган Бурханы шашиныг хамгаалагч сахиус Балданлхам Бурхан байдаг. Тэдний зүрх тарнийг бас хамтатган уншиж залбирал үйлддэг юм.

- Таныг ямар нэг амьтан бол гэвэл Та ямар амьтан болохыг хүсэх бол? Тэр амьтан нэгудаа ч бол зүүдэнд тань орж байсан уу? Эсвэл, Та өөрөө төсөөлж байсан удаа бий юу?

- Болдогсон бол “Бодь гөрөөс” болохсон гэж хүсэх байх даа. Бурханы шашны сүм, дуганы үүдэнд дандаа хорол залдаг. Хоролын хоёр талд хөлөө өргөн нугалж их алсаас чимээлж буй анир сэрсэн байдалтай зогссон хоёр сонин, сонор сэрэнгэ гөрөөсийг гурд урдаас нь харуулаад зогсоосон байдаг шүү дээ. Тэд бол “Бодь гөрөөс”! Чадагчийн шашины домогт үгүүлдэгээр, Шигэмуни Богд бүтэн зургаан жилийн хатуу чанд дияан, хатуужил, сорилоор гэгээрлийн хутугийг олоод “Дөрвөн үнэн”, “Найман мөр”-өө номлохоор “Номын хүрд” эргүүлэхэд нь хамгийн түрүүнд, хүнээс урьд ирж Бурхан Багшийн эхний айлдварыг сонссон амьтад гэдэг. Анир чимээг чихээрээ бус хөлөө өргөж сонсдог юм гэнэ лээ. Хуучуулаас тэгж сонссон!

- “Хүн төрөлхтөнд хөгжил бус Аврал чухал болоод байна! гэж Та сонирхолтой ярилцлага “Үндэсний Шуудан” сонинд өгсөн байна лээ. Ярилцлагыг тань олж уншаагүй хүмүүст Та товчоор юугэж хураангуйлах вэ?”

- Хүний амьдын нас буюу амьдралын нь жил, хоногууд бол энэ газар дэлхийн нөхцөлд маш ихийг сурч мэдэхээр “Томилогдон” ирж буй цаг хугацаа юм. Нийтэд болоод өөртөө чухал хэрэгтэй юу нэгийг заавал хийж сурах, сурсанаа нийгмийн баялаг бүтээхэд ашиглах, насны эцэст өөрийнхөө амьдралаас түүхэн дурсгал үлдээхэд л зориулагдсан цаг хугацаа!

Харамсалтай нь, хүн төрөлхтөн, эсвэл, “Homosapians” ч гэмээр юмуу, тэдний ихэнхийн амьдарч өнгөрүүлсэн 40 мянган жилийн үйл явц, үндсэндээ, буруу замаар явжээ. Хүн төрөлхтөний түүх бол онооноосоо илүү олон алдаатай түүх юм. К.Маркс “Хүн төрөлхтөний түүх бол ангийн тэмцлийн түүх” гэж тодорхойлсон нь үнэхээр шинжлэх ухаанч зөв дүгнэлт! Гэхдээ, “Ангийн тэмцэл” алдаатай үйл явц! Хүн төрөлхтөний түүх, хэрэг дээрээ, хүн төрөлхтөний буруу хөгжлийн түүх! Хүн төрөлхтөний түүхийн “хөгжил” нь Дэлхий эрхэсээ ухвар мөчидөөр сүйтгэсэн, Оршихуйн хууль зүйг нь “Хүчирхийлсэн”, хомхой шунагаар буруу ашигласан, эцэстээ, Дэлхий хэмээх Бурханы аугаа баялаг, гоо сайхан бүтээлийг сөнөхөд хүргэж буй хөнөөлт үйл ажиллагааны “хөгжил” -ийн түүх болж л даамжирлаа шүү дээ. Хүн төрөлхтөн гал олсон нь ч буруу, хөдөлмөрийн багаж зэвсэг үйлдвэрлэсэн нь ч буруу, өөрсдөө бүтээсэн бус Бурханы бүтээсэн баялагаас ашиглаж хэрэглэсэнээ таваармөнгөний харилцаанд оруулж үнэ өртөг тогтоосон нь ч буруу, бас, төрт ёс гэгч зохиомол үзэгдэл буй болгож зохион байгуулагдсан нь ч буруу! Энэ бүгд цөм хүний хөгжилд огт хэрэггүй, нэн буруугаар нөлөөлсөн гадаад талын шинж чанартай, хүн төрөлхтөнийг “дотоод хөгжил”-ийн нь зүй тогтолоос хазайлгасан сөрөг хүчин зүйлүүд бөгөөд хүний нийгмийг эцэст нь, эцсийн

хугацаанд байгал дэлхийн өршөөлгүй хатуу гэсгээл цээрлэлд зайлшгүй хүргэх замд оруулсан, одоо бүүр ч түргэн хурдацтай оруулж байгаа алдаанууд юм. Харин хүний жинхэнэ хөгжил гэдэг бол дээрхийн урвуу үйл явц буюу хүний амьдрал, оюун сэтгэлийн “дотоод хувьсгал” байх ёстой юм шиг байна. Хүний “Дотоод хувьсгал” гэж би юуг хэлж байна? гэвэл, хүн өөртөө агуулагдсан физик хүчээ үйлдвэрлэл, технологи хөгжүүлэхэд бус, өөрөөр хэлвэл, хүч, хөдөлмөрөө хөнгөвчлөх арга ухаанаар амьдралынхаа хэрэгцээг хангах бус, харин, эсрэгээр, бие махбодын өгөгдөхүүнээ оролцуулаад, дээр нь, хүнд Бурханаас шагнагдсан оюун ухаан, далд ухамсар, зөн мэдрэхүйн бүх био эрчимийн нөөцийг нэмээд өөрийнхөө гэгээрэл рүү, үл байм ид шидийг бүтээж чадах тэр хийсвэр хүч рүү, тэр аврага нууц уурхай руу урсгаж, бодол санаагаа, юу хэрэгтэйг хүсч буй хүслээ шууд материаллагжуулах буюу бодит юмсад хувиргаж чадах увьдас чадвараа хөгжүүлэх үйл явцыг хэлж байна. Хүн төрөлхтөн өнөөдөр өөрийгөө ямархан хөгийн, ямар тэнэг, ямар утгагүй, үр ачгүй зугаа цэнгэлээр жаргал хийж буй төөрөгдөлөө, ямар буруу, хортой үйл ажиллагаагаа хөгжил гэж ойлгож буй алдаагаа огт ухаарахгүй амьдарч байна. Би хүн төрөлхтөнийхөө өмнөөс маш эмгэнэж байна!

- Хоёулаа нэг “хальт улстөржөө”! Та энэ оны (2012) сонгуулийн талаар ямар сэтгэгдэлтэй байна? Та ямар үр дүн хүлээж байв?

- Нийгэмд шудрага ёс тогтоох сонгууль болох нь, сонгуулийн үр дүнгээр Монголын олигархижсан, хүн амын “цөөнх”-ийн “булагнаа төр”-ийг шудрага, ариун ёс журамд захирагддаг ардчилсан төрөөр халж солих нь! гэж баярлаж байлаа. Гэтэл энэ сонгуулиар Монголын төрийн бохир “МАН-АН” бараг цэвэршсэнгүй үлдлээ. Шудрага ёс гэдэг бол, нийгмийн амьдралын утгаар нь ойлговол, нийгэмд өгсөнөөсөө илүүг нийгмээс завшдаггүй байх ёс суртахууны хатуу зарчим юм. Ёс суртахууны зарчим бол нийгмийн оршихуйн дээд хууль. Иргэншсэн нийгмийн харилцаанд амьдарч буй иргэдийн үйл ажиллагааг хамгийн зөв залах дээд ухамсар! Улс орны эдийн засаг, улс төрийн бүх харилцаа энэ “үндсэн хууль”д захирагдаж хөгжсөн цагт нийгэм гэгээрнэ. Шудрага ёсонд өөр хоёр гурван том ойлголт багтана. Нэгдүгээрт, нийгмийн алив иргэн бусаддаа чадлынхаа хэрээр тустай бүтээлч хөдөлмөрөөр амьдарваас зохино. Хүн бусдад тустай юм хийж байж л сая өөртөө тустай байж чадна. Зөвхөн өөрийгөө хайрлаж, өөрийнхөө төлөө амьдрагч бэртэгчин бус, бусдыг өөр шигээ хайрлаж, энэрч, Жанрайсаг Бурханы мэлмийгээр

нигүүлсэн харж, бусдын тус буянд зориулан материаллаг болоод оюун санааны баялаг бүтээж байж л сая нийгмийг өөртөө үйлчлүүлж, нийгмийнхээ амьдралаас сэтгэлийн ханамж, аз жаргал олж чадна. Хоёрдугаарт, шудрага байна гэдэг бол хүн бие махбодиороо, оюун санаагаараа, сэтгэлээрээ, тэр бүү хэл, зөн совин, далд эрчимээрээ ариун байхыг хэлнэ. Ариун байна гэдэг нүгэл хилэнцгүй, хамгийн зөв амьдарна гэсэн үг! Ариун амьдралтай хэн ч Бурханд нүгэлгүй, төрд буруугүй, нийгэмд хор хохиролгүй, ингэхлээр, хуулийн ямарваа зөрчилгүй үйл ажиллагаатай байх жинхэнэ хүмүүнлэг, ардчилсан хуулиар амьдрана гэсэн үг! Гуравдугаарт хүний амьдрал шаргуу бүтээлч, тэнгэрлэг мөн чанар, утга агуулгатай байх хэрэгтэй! Бүтээлч амьдрал л өөрийн үндэстэндээ түүх бүтээж үлдээнэ. Харин, зөвхөн хэрэглэгч, монжигч шинж чанарын зорилготой амьдрал тухайн хүнийг амьсгал хураах эгшин, “авсанд орох” өдрөөс л мартагдана. Монголчууд “өгсөн өөрт, түрхсэн нүүрт!” гэдэг нь хүн төрөлхтний амьдралын том философийг агуулсан үг!

Бурхан Багш Танд нэг хүслээ биелүүлэх боломжийг хүртээе! гэвэл, Та орчлонгийн олон хэрэгцээтэйгээс алийг нь илүүд үзэх вэ?

Бурхан Багштай би амьддаа ч, үхсэн хойноо ч нүүр золгон уулзана гэж итгэж амьдардаг. Гэхдээ намайг магтахаасаа илүү зэмлэх байх даа! гэж айдаг. Бага хөдөлмөрлөсөн, бага бүтээсэн, надад аминчлан хайрласан хүч чадал, боломж нөөцийг бүрэн юүлж чадаагүй, Бурханы хүссэн төгөлдөрт хүрч чадаагүйг минь лав өөгшүүлэхгүй! Бурхан намайг бусдаас илүү ч хайрлаагүй байх, дутуу ч хайрлаагүй байх, үүнийг би сайн мэддэг, Бурхан намайг бусад аугаа хүмүүстэй ч, адагөчүүхэн хүмүүстэй ч ав адил, ижил тэнцүү л хайрласан байгаа! Бурхан надад үнэнхээр хайртай болохоор намайг харьцангуй “дутуу” амьдарсанд их харамсана. Аугаа их хайр ямагт шудрага, үнэнч, асарих өндөр шаардлагатай байдаг. Яахав, аз болж, Бурхан намайг туйлын ихээр өрөвдөн нигүүлсэж “Ямар нэгийг хүс! Хүссэнийг чинь биелүүлж өгье!” гэж элбэрч болох юм. Тэгвэл би “Алдсан бүх алдааны минь эхэнд, тэр алдааг эхлүүлэхгүй байх цэг дээр аваачиж өгөөч!” гэж гуйна. Яагаад гэвэл, миний амьдралд мартагддаггүй юм, -алдаа минь! Тэд ч цөөнгүй! Хэрэв би одоо алдаа алдсан үйл явцынхаа эхэнд буюу “Яах вэ?” гэдэг асуулт, сорилын өмнө, түрүүнд нь зогсож байсан тэр цаг хугацаандаа эгвэл эх орондоо илүү их хэрэгтэй хүн болж чадах байсан байж мэдэх юм. Өөрөөр хэлвэл, алдсан алдаануудаа алдахгүй байсан байж болох юм гэсэн үг шүү дээ. Ийм л нэг яриа. Мэдээж бидний яриа үргэлжилсэн. Шадивланд яагаад энэ нэг хэсэгхээн хадтай газар амьдрах болсон юм, танайхтай ойрхон зохиолчдоос хэнийх байдаг вэ, энд та хэр зэрэгудаж байна, та ер нь хэдэн хүүхэдтэй вэ, энэ бяцхан гөлөгний тань нэр хэн бэ, энэ байшингаа та анх хэдэн төгрөгөөр авсан юм... Ийм саваагүй асуултнуудаас гадна шүлэг, шүлэг, шүлэг.

2012.7.25 Шаддүвлин - “Шинэ Ази” оффис

Он цаг ... тэмдэглэлийн дэвтрийн хуудас шиг эргэсээр л



Миний ах Б.Хасархүү 2010 он

Он цаг, он цаг... Тэмдэглэлийн дэвтрийн хуудсууд шиг эргэсээр, эргэсээр л...

Улиран одох цаг хугацааны турш алдар цуутан, авьяас билэгтэн, алдаж онож яваа олон хүнтэй уулзжээ. Ярилцлага бүхэн минь хэвлэгддэг, бичсэн бүхэн минь шуугиан тарьдаг сүрхий сэтгүүлч болоогүй. Энэ миний туйлын зорилго биш. Харин бичих бол миний хамгийн гол ажил. Тэр дундаа аавынхаа үзгийг нь барьж үйлсийг нь үргэлжлүүлнэ гэсэн том мөрөөдөлтэй миний хувьд үргэлж бичих, орчуулах ажлаа орхиж боломгүй хэрэг.

Ийм том мөрөөдөл тээж дуу хураагуураа барин радиогийн нэвтрүүлгээр ажилаа эхэлж байснаас хойш цөөнгүй нэвтрүүлэг, сурвалжлага, ярилцлага бэлтгэжээ.

Харин ах нарынхаа тухай би юу бичсэн хүн билээ дээ.

Ээж, аав минь дүү, бид хоёрт Б.Барсболд, Б.Зуунбилэг, Б.Хасархүү гээд нөмөр түшигт нь багтаад зогсохгүй утга төгөлдөр нэрийг нь сонсоод уярч бахадмаар гурван ах заяасан юм. Гурван ахтай гэж санахад хэн нэгнээс илүүрхэж, омогших бодол төрдөг ч үзэг дэвтрээ бариад сэтгүүлчээр ажиллаж явахдаа юу бичсэн билээ дээ. Монголчууд ах дүүсийн нандин холбоог зулай зулайгаа гишгэж төрсөн ах дүүс гэж бэлэг дэмбэрэлтэй сайхан үгээр хэлдэг. Миний бага ах Б.Хасархүүгийнхээ тухай цөөн үгээр өгүүлье.

Нэг дуугарах ёстой юманд хэдийнээ гурав дуугарчихдаг занг минь анзаарч хааяа харцаараа жаахан аяглавч хайраараа намайгүргэлж үүрч, тэвэрч явдаг ах минь “Долоо хэмжиж нэг огтлох”-ын ухааныг зааж, залж явсаар өдий зэрэгт хүргэсэн юм.

Б.Хасархүү ах бид хоёр аавынхаа төгссөн МУИС гэдэг босго өндөр эрдмийн их өргөөний үүдээр он дараалан алхан орсон. Ах минь түүх-хүн судлалын ангиа онц дүнтэй дүүргэж, нутагтаа ирж багшлаад, мөн МУИС-даа магистрын зэрэг, Удирдлагын академийн Төрийн удирдлагын ангийг онц төгссөн, “онц” гэдэг нэг л дүн авдаг сурлагатай оюутан байсан юм. Оюутан цагийн хөгжөөнт он жилүүдэд ахтайгаа хамт дотуур байранд амьдарч, аймаг аймгийн хүүхдүүдтэй танилцаж байсан дурсамжтай өдрүүд олон. Тайван дөлгөөн, тусархаг нийтэч зан, үргэлж уншихыг эрхэмлэдэг сайхан чанар нь найз нөхөд, хамт олон, багш нарынх нь бахархлыг төрүүлэн, одоо ч гэсэн оюутан цагийн найзууд маань уулзах бүртгээ ахын минь нөхөрсөг төлөв сайхан сэтгэлийг дурсаж мэнд дамжуулдаг юм.

Ах маань дунд сургуульд байхдаа үлгэрийн баатруудыг үеийнхнээсээ илүү чадварлаг зурдаг байсан юм. Балын харандаа, бэхтэй үзэг, усан будгаар олон олон морьтой баатруудыг зурдаг байсан болохоор нь зураач болох байх гэж боддог байлаа. Мөн тэр үеийн хүүхдүүдийн хамгийн дуртай тоглоом баримлын шавраар нөгөө олон баатруудаа арми армиар нь хийж байлдаж тоглодог байсан нь одоо ч санаанаас гардаггүй. Хүн бүрт заяадаггүй зурах авьяасаа

хөгжүүлсэн бол миний ах сайн зураач болох байсан даа гэж хааяа санагддаг шүү. Манай нутагт аав ээжийнхээ ээжийг гөөгөж дууддаг. Хасархүү ах бол гөөгийн амин эрдэнэ. Хожим гөөгийн тухай “Алтан-Дарь овооны энгэрт эрхэлж тоглож, хүний зэрэгт хүрэхдээ гөөгөөсөө тал нутгийн амьдралын сонин сайхан үлгэр тууж, түүх домгийг эхэлж сонсож, аргал түүж, шилбүүр унан тоглож, ард урд хормойд зүүгдэх шахам явахдаа, үйл хөдлөл бүхэн нь ухааны уртай, үг яриа бүхэн нь холын хараатай, хайр энхрийлэл бүхэн нь бусдыг хайрлахуйд хөтөлсөн зөв замын эх, чиг зам байсан юм” гэж бахархан ярьдаг байсан бүхнээ цааснаа буулгасныг нь уншаад их л уярч билээ.

Монголынхоо төдийгүй дэлхийн түүх шастир, улс төр, нийгмийн талаар дүү нар биднийхээ болон шавь нарынхаа асуусан асуулт болгонд мэдэхгүй гэсэн хариулт өгч үзээгүй ахын минь уншсан, сурсан, судалсан бүхэн нь энэ чиглэлийн мэдлэгээр хаана нь ч хүрэхгүй надад маш их сургамж болдог. Миний ах монголдоо төдийгүй гадаадад нэр хүндтэй түүх, археологи, антропологи нэрт эрдэмтэн доктор, профессор Ж.Болдбаатар, Д.Наваан, Д.Түмэн, М.Эрдэнэ, З.Батсайхан нарын шавь гэдгээрээ үргэлж бахархдаг. Багаасаа л аавын номын сангийн хэдэн зуун номыг бүгдийгуншиж, зарим номыг дахин дахин уншиж түүхийн их мэдлэгтэй болсон болов уу.

Их сургууль төгсдөг жил ах маань миний авах юмсан гэж мөрөөдөж байсан номны эхний хуудсан дээр нь “Мэдсэнээсээ илүүг мэдэхийг хүссэн эрдэм төгс бүсгүйчүүдийн нэгэн яваарай” гэж бичээд бэлгэлсэн юм. Ахынхаа үг сургаал, үлгэр дууриал, эрдэмлэг сайхан дүр төрхөөс нь тэнгэрт очсон аавынхаа дүрийг ахин олж харах шиг болдог болохоор чадах чинээгээрээ хичээсээр л байна.

Энэ мэт ах байхаас гадна аав байхын ачааг хамт үүрч явдаг сайхан чанарууд нь намайгухааруулж мөрөөдөлдөө хүрэх зөв замыг сонгоход хүргэсэн учиртай. Одоо миний ах орон нутагтаа төр засгийн ямар ч шатны ажил алба хаших чадвартай, эрдэм мэдлэгтэй, дадлага туршлагатай хүмүүн болж төлөвшжээ.

Цаг хугацаа тэмдэглэлийн дэвтрийн маань хуудас шиг эргэсээр л... Нэг л мэдэхэд ах маань

өрх тусгаарлан аав болсон. Их сургуульд багшилж, аймгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг хамаарах үүргийг гүйцэтгэх гээд завгүй их ажилтай.

Тал нутгийнхаа олон сайхан ах нарын хайр хүндэтгэлийн төлөөлөл болгож, энгийн зан, энгүй их ухаанаараа зөвхөн өөрийнхөө төлөө биш дүү бид нарынхаа төлөө байгаад зогсохгүй аймаг, орон нутгийнхаа аж амьдралын өөдрөг гэгээн үйлсийн төлөө мэдлэг оюунаа зориулсаар яваа ахынхаа тухай цөөхөн үгээр өгүүлэхэд ийм буюу.

Тэнгэр заяатай

Тал нутгийн ах нарын буян заяа дэлгэрэх болтугай.

“Дорнод” сонин. 2004 10.15



Ах Б.Хасархүүгийн хамт 2010 он

Нар зөв сэтгэлт зөөлөн ахдаа зориулав.

Хаалга тогшоод зөөлөн инээмсэглэсээр орж ирж мэднэ. Үүд нээлттэй ах минь

Хамгийн түрүүнд нар тусдаг шаргал талаасаа намайг та санадаг. Би мэднэ

Хаа холын шувууд цонхон дээр минь жиргээд байна. Заавал сонсоно Хасархүү гэдэг содон нэрийг дуудах шиг болно. Зөн совин мэдэрнэ

Алтан харгана үйслэдэг Дарьгангын шаргал талд унаган нас чинь бий Аав, ээж хоёртоо үр нь болон заяагдсан тэмдэглэлт өдрүүд чинь бас бий Алслах он цаг дандаа хэвээр байхгүйг дуулах шувууд чинь хүлээж буй Айсуй цаг хугацааны салхинд ч элэгдэхгүй хүрэн чулууд, Хөргийн хөндий бүгд бий

Сэтгэлийн хөх нуур үерлэж урсаад, ах дүү болон төрсний учир Сэрсэн зүүд минь бийрээр хөглөгдөж, их хайр минь тань уруу урсдаг Сэлгэсэн бууриа эргэж намартаа нэг уужирахад

Сэтгэлээ чангалж нулимс унагаагүйг минь та мэдчихсэн байдаг

Алаг шүхэрний дор арав хүрээгүй жаахан нас минь дэрвээд л “Ахдаа хэлнэ шүү”-гэж анддаа

ширүүлэхэд минь

өмөөрөөгүй ах минь Амьдрал тэмцлийн дунд нар зөв сэтгэлтэй болохоороо Алдаа, онооны дэнсийг инээмсэглэн зөөллөдөг биз ээ

Равжаа хутагтын найргийн шүншиг шиг зөөлөн хайрыг танаас би мэднэ Рааш анчны үлгэр мэт сэтгэл бол үйлс бүтэхийн шинж гэж та надад хэлнэ Рашаан усны эх булаг шиг ширгэшгүй итгэлийг танаас би олно Равдан гуайн өгүүлсэн түүхэн яриаг танаас би лавлана

Хуучин байшингийнхаа дэргэд та удаан амьдарлаа. Олон жил болжээ Хуур хөглөн шүлэг зохиож, дуулж бүжлээ гээд та намайг дагаж нүүгээгүй Хул шаргал гөрөөс шиг цахилж одох цаг хугацааны уртад Хуурмаг болоод үнэн хоёрын учрыг ялгаж чадсан болохоор тэр бизээ

Үйлс гэгээн явааг чинь сонсоод дүү нь уртаас урт захидал бичихгүй ээ Үүр цайж, Хэрлэн гол урсагаараа урссаар байхад л би хамгийн их дуртай

Үлгэр зүүдэнд биелэх үлэмжийн энэ орчлонд нутгаасаа гараад би удсан ч Үргэлж зүрхэнд минь жиргэх тунгалаг үгсийг чинь мартдаггүй ээ. Ах минь

Үдшийн сарны гэрэл дор бадаг бадаг шүлэг тэрлэж, наран зүг санааширавч Үүрдийн биш энэ орчлонгоо зуурдын гэж

чамлан гуниглахгүй ээ Үргэсэн зээрний нүд шиг торомгор хөөрхөн дүү чинь Үнэн сэтгэлийн гүнээс тань уруугаа дандаа л яарна аа.

“Дорнодын тод залуус” номноос. 2011 он

Найргийн сүмийн тахилч найрагчийн гэргий Г.Хандмаа



Яруу найрагч Д.Нямсүрэнгийн гэргий Г.Хандмаа Киев хот 1973 он

Хандмаа... Ардын дууны эхлэл, аль эсвэл эртний танил дотны хүн минь билүү гэж бодогдмоор аятайхан сонсогдож байгаа биз. Найргийн сүмийн тахилч гээд эхлэнгүүт их найрагчийн гэргий Г.Хандмаа юу даа гэж хэн хүнгүй л таньж, тэнгэр хүртэл талархмаар сайхан бүсгүй гэж ярилцах нь хэтрүүлэг бишээ. Нэрийг нь хэлэхэд яруу найраг шиг зүс нь ердөө л “байгалийнхаараа”, зөөлөн зөөлөн инээж, зөрүүд орчлонг өөрийнхөөрөө аргадаж амьдардаг ийм нэгэн бүсгүй бидний дунд аж төрж байна.

2007 оны намар. Улаанбаатарт ажлаар ирээд буцахаасаа өмнө Г.Мэнд-Ооёо ахтай уулзлаа. “Алт овооны шастир” шинэ номынхоо эхний хуудсан дээр “Найргийн сүмийн тахилч, Найрагчийн гэргий Хандмаадаа” гэж бичээд

Эрээнцавд очвол энэ номыг Г.Хандмаа эгчдээ өгөөрэй гэж хэлсэн юм.

Дорноддоо очоод удаагүй байтал ажлаас маань Эрээнцавд очиж нэвтрүүлэг хийх томилолт өглөө. Г.МэндОоёо ахын илгээсэн шинэ номыг биечлэн хүргэж өгөх завшаан тохиолдсонд их л баярлаж билээ.



Яруу найрагч Д.Нямсүрэнгийн Найргийн сүмийн хоймор

Энэ өдрөөс хойш Г.Хандмаа эгчтэйгээ уулзах, хол ойроос утсаар ярихдаа “Найргийн сүмийн тахилч найрагчийн гэргий Г.Хандмаа эгч минь сайн байна уу” гэж мэнд мэддэг болсон юм.

Энэ эрхэмсэг бүсгүй “Их найрагчийн гэргий, Эрээнцавын өртөөнд гаалийн байцаагч” гээд л товчоон намтартай. Талын намхан уулс, өндөр өндөр өвс ногоо, их цаснаар нь илчит тэрэгний дуу өглөө оройгүй хүнгэнэх алс буйдхан Эрээнцав. Их найрагчийн гүн бодол, яруу үгсийн хурыг буулгаж, тэнгэрлэг авьяасыг нь тэтгэсээр он цагийг хамтдаа элээсэн сайн ээж, сайхан хань юм. “Найргийн гэгээн сүмдээ” долоон бурхан од шиг, долоон хөх толботой” хүүхдүүдтэйгээ амсхийж, “сүмд залрах” хүн бүрийг галт тэрэгний өртөөн дээрээс үдэж тосож суухаа хамгийн их аз жаргал минь гэж хэлэх дуртай.

Их найрагчийн хайрын түүх дүүмэд жаахан Хандмаагаа арван нэгэн жил хүлээсэн ... гээд л шүлгийн эхлэл, дууны айзам хэмнэл, домгийн өрнөл, үлгэрийн төгсгөл баймаар тун ер бусын түүхтэйсэн.

... 1963 он

“Надад тулах цэг өгвөл

Би дэлхийг ч хөдөлгөнө” гэж Архимед хэлжээ. Миний тулах цэг чиний минь сэтгэл билээ. Чи минь. Хандмаа минь... хэмээн тун ч учирлан аргадсан, хайрласан, харамласан, итгэсэн хүлээсэн, хэдэн арваар тоологдошгүй нандин захиануудыг хүлээж авч байсныг Г.Хандмаа эгчийн суралцаж байсан алсын Киев хот хүртэл одоо ч гэсэн мартаагүй нь мэдээж. Хандмаа эгч ийм гэгээн тунгалагөдөр хоногуудыг “Саяхансан” гэж дурсаж байна. Хандмаа эгчийн

тэвчээр алдмаар бухимдсан, санааширсан, гунигласан дүр төрхийг би лав олж хараагүй. Их л тайван амгалан, зөөлөн зөөлөн инээмсэглэж, аливаад хүлээцтэй тэвчээртэй ханддаг ухаалаг эмэгтэй гэдгийг нь ойр дотныхон нь андахгүй сайн мэднэ. Тиймээс их найрагчийн хань нь, ээж нь, эрх шар охин, найраг шүлгийн нь амин гол, рашаан ус нь байж дээ би боддог.

Гэргий минь юманд яваад өгөхөд

Гэр дотор цаг зогсох шиг

Гэгэлхэн шувууны гуниг ирэх нь юутай

Гэргий минь юманд яваад ирэхэд

Гэгээн дуут шувуу гэр тойрон уянгалах шиг

Цаг цохих нь юутай яруухан бэ... гэсэн гэнэн хүүхдийн сэтгэл ч юмуу гэж хэлмээр мөрүүдийн цаана бусдынхаас онхи одоо их хүлээлт, их хүсэл, далд уянга байгааг найргийн хэлээр хүүрнэвэл “сул хөх өвсөн дотор сувд адил хөлбөрч, субашидийн бадаг мэт урин тачаангуй” хүүхэн хонгороо хүлээх найрагчийн араншин үзэгдэнэ.

Хэдэн жилийн өмнө Хэнтийн яруу найрагч Ломбын Нямаа гуай, Данзангийн Нямсүрэн найрагчтай “Он жилүүдийн цаанаас наран ургамой” нэртэй ярилцлага хийж, яруу найргийн үнэнч ханийнхаа талаар... гэж асуухад найрагч, “Энэ гоё сайхан асуулт байна. Харин энэ хүнийхээ талаар хэлэх хэдэн өгүүлбэр надад бий. Долоон болжморыг минь төрүүлж, молхи бичээч надтай тохиосон 21 жилийн өмнөх хаврын цэцэг намрын бороон дундуур цагаан бошинзтой гүйж явсан охин насаа хэдийн мартаж дээ, хөөрхий минь. Шүлгэнд минь ганц солгой гишгэдэлтэй эгшиглэн орохыг, хүн амьтны үнэрийг салхинаа авах гөрөөс лүгээ адил соргогоор мэдэрдэгсэн. Хатууг зөөлөн болгож, хамаг байгалийг хайрлуулж, хөх өвс руу намайг шингээсэн хүн гэж боддог юмаа.

“Их ухаан санааг бүү үймүүл

Элдэв нохойн хойноос бүү хөөцөлд

Эрээнцавд хийх чиний ажил бол

Эргэх дөрвөн цагт шүлэг бичих” гэж эхнэр Г.Хандмаа минь нэгөдөр надад шүлэглэн хэлсэн сэн. Уран бүтээлч үзэг нэгт нөхдийг минь ирэхэд хэзээ ч уцаарлан тээршааж яваагүйд нь эгэл бор шүлгүүд минь ариун гэгээнээрээ үлдэж чадсан юм. Үйлийн үрээр сонин адармаатай хэцүүхэн зохиолч бидэнтэй нөхцөлдсөн эхнэр хүүхнүүд минь мөнх бусын бодисадва болж төрөх нь дамжиггүй улс даа” гэж их л сэтгэл хангалуун хариулжээ. Найрагч ханийхаа сэтгэлд ийм их бахархал, бардамнал, ихэрхэлийг төрүүлж чадсан энэ л бүсгүй яахын аргагүй тэнгэрлэг нэгэн.

Өвдгийг тань дэрлэлээ Хонгор минь Өвсөн дотор шувуу ингэж Амардаг бизээ Үсийг тань үнэрлэлээ, хонгор минь

Үүлэн уулын цэцэгс ингэж анхилдаг бизээ, Гоо хоёр хөлийг тань үзлээ хонгор минь Гол ус ийм намуухан урсдаг бизээ Гоц хасын ялгарах сарны гэрэл дунд тэгээд Гойд нэгэн улаан лийр боловсордог бизээ...

Энэ шүлгийн мөрүүд Данзангийн Нямсүрэнгийн дотоод сэтгэлээс гол мөрөн шиг л урсана. Найрагчийн гэргий болж амьдралын олон даваа гүвээг давж, дааж явна гэдэг бүсгүй хүн бүхний хүсэл мөн гэжүү.

Далайгаар бол яруу найрагч хүний хааяагүйхэн давалгаалах тэр давалгаанд огт шидэгдэлгүй, шүлэг найргийн их ус нууранд “уучлал өршөөл хайр энхрийллийн хатан загас” болон хөвсөөр байх ахуйд, найрагчийн амар амгалан зүрхтэй хамт цохилж эх орны минь зүүн хязгаар, эгэл буйдхан Эрээнцав нутагт хичнээн олныг туурвисныг он цаг, олон сонгодог бүтээл туурвилууд нь гэрчилж байна. Ийн бодохоор яруу найрагчийн гэргий байна гэдэг бас амаргүй тавилан атлаа олдошгүй их хувь юм даа.

Г.Хандмаа эгч “Уран бүтээлчид гэдэг эмзэг, энхрийхэн хүүхэд шиг хөөрхий амьтас байдаг. Миний хань бас л тийм хүн байсан. Энэ “энхрий хүүхэд” - ийн ая эвийг олж явна гэдэг үр хүүхдээ өсгөхөөс дутуугүй ажил юм шүү дээ” гэж хэлээд ямар ч будаггүй цагаахан царайд нь яльгүй гуниг нүүж ирэхийг нь анзаарч би бас жаахан тавгүйрхэв.

“Д.Нямсүрэн ах чинь өглөөдөө өрөөндөө гунганаад л шүлгийнхээ хэмнэл юмыг тааруулах гэж хөлхөж эхлэхэд нь саад болох чимээ анирлачих вий гээд тогоо шанагаа хангинуулахаасч цээрлэдэгсэн. Өвгөн маань өрөөнөөсөө гарч ирэхэд нь баярлаж хүүхэд шуухадтайгаа хөөр хөгжөөнтэй олон өдрийн тоссон доо. Үг хэлэхдээ ч би урам нь хугарчих вий гэж дотроо боддог. Тийм л байсан...” гэж гал өрдөнө.



Д.Нямсүрэн найрагч үйсэн дээр бичсэн “Амитаба” шүлгээ Дарьгангынхаа Алтан харгана дээр тохжээ.

Одоо харин ямар бодол дунд галаа өрдөж, анир чимээгүйг сахиж, хэсэгганцаардсныг энд би дурьдах хэрэггүй. Энэ бол найрагчийн гэргийн “Нам гүм оршихуй” юм.

Шүлэг бичиж суухад

Чи минь эрхэлж болохгүй

Шүлэггэдэг шувуу үүдээр гараад нисчихнэ.

Нэгэнтээ тэр одвол

Нэхэж хөөгөөд гүйцэхгүй

Эрвээхэй наадах нугадаа

Эрдэнийн солонго шиг шингэчихнэ.

1965 он.

Энгийн хэлээр бол эрхэлж жаргах эрхээ хасуулж буй мэт боловч их найрагчийн хэлээр бол “үзэсгэлэнт хасын баланд шандах бөлгөө”. Ердөө л үүгээр жаргал хийж явах тавилан ертөнцөд хүн бүхэнд бус хэдхээн хүнд заяадаг болов уу. Найрагчийн гэргий нараа гэж...

Д.Нямсүрэн найрагчийн уран бүтээлийн өрөөний бүх юм байрандаа эзнээ нэг л өдөр орж ирэх юм шиг хүлээсээр. Намхан шилэн хорго, алтан харгана, үйсэн дээр бичсэн Амитаба шүлэг, сумны хонгио, бичгийн машин, хүмүүсийн дурсгасан номнууд, жааз дүүрэн зурагнууд. Түүнд ертөнцийн бүх зүйлс эрхэм нандин байсныг гэрчлэх олон зүйлийгуран бүтээлийн өрөөгөөр нь ороод гарахдаа мэдэж болно.

Аав ээж хоёрын маань ч зураг байна. Нямсүрэн ахын хүрэн формтой аравдугаар анги төгсөхдөө татуулсан зураг. Жаазтай зурагнуудыг үзээд би түүний гэргийдээ бичсэн анхных захиануудаас нь уншлаа. Аавын захиануудаас уншмаар байна гэж хэлээд найрагчийн энэ ховор нандин ертөнц руу нь цөөн хором ч болов аялаад амжив. Гэхдээ тун цөөхнийг. “Энэ дунд аавын чинь зөөж байсан захиа ч

байгаа” гэж хэлээд Хандмаа эгч инээв. “Аавыг нь насан эцэс болтол би багшаа л гэдэг байсан. Миний нөхрийн сайн найз ч гэсэн намайг Дарьгангын бага сургуульд сурч байх үед уран зохиолын багш маань байсан юм. Монголын болоод дэлхийн уран зохиолоос сурагч жаахан биднийг биширтэл ярьж, цээжээр уншина. Бас цанаар сайн гулгана. Энэ эрдмээ сумын сургуулийн хүүхдүүд бид нарт зааж өгдөг байсан юм. Батсүх багшийг өнгөрсний дараа өвгөн маань нэг хэсэг дуугүй болчихож билээ. Хоёулаа л насалсангүй” гээд Хандмаа эгч санаа алдав.

Бид хоёр үргэлжлүүлээд хэд хэдэн сонин зураг олж харан, түүний зөвшөөрлөөр цөөхөн захидлыг нь дэлгэн үзэж, сэтгэлийн чинад уруу нь бага ч болов өнгийхийг хичээсэн юмаа.

Хандмаа минь

Чи минь

Уйтгар гунигийг минь хөөгч

Үүлэн зардас юм.

1967 он.

Чи минь яруу найраг шиг сайхан бүсгүй

Хэрвээ чи уулын оронд төрсөн бол

Хэн мэдэх вэ. Чөтгөр алгад

Шотландын шүлэгч Борис

Чамд минь санаархахыг хэн байггэхэв.

Хонгорхон өнөөх Жянийгаан мартаж орхиод

Хорвоод чамаас сайхан нь үгүй гэж

Гэнэ алдуулах л байсан уу...

Хамгаас сайхан хайрын захиа авч, гайхан бишрэм олон шүлгийн мөр бадаг бүхний “Эх булаг” болж явна гэдэг бүсгүй хүн бүрт олдошгүй ховорхон хувь тавилан юм даа.

“Гүсим”, “Хонгорзул”, “Оюундэлгэр”, “Амитаба”, “Нэгэн намрын бүсгүй” гээд бүсгүй хүний гоо сайхныгмагтан дуулсан, хайрласан, санагалзсан, дурласан, догдолсон тухай “Миний шүлгийн хүүхнүүд” гэсэн бүтэн номыг бичиж, “Миний ууж баралгүй орхисон цорын ганц дарс бол бүсгүй хүн юм” гээд Д.Нямсүрэн найрагч шүлгээрээ сийлбэрлэн бичиглэсэн. Юутай гайхамшиг.



Миний эгч соёл судлаач Б.Энхтуяа, найрагчийн гэргий, гаалийн байцаагч Г.Хандмаа

Яруу найрагчид бүтээлээрээ бусдын хайр сэтгэлийг ертөнцийн зүг болгонд хүргэж, тэр хайр сэтгэлийн дуудлагаараа олон бүсгүйчүүдийг шүлэглэхэд найрагчийн гэргий амьдрал хэмээх далай мөрөндөө загас адил эрхэмсэг амгалан хөвсөөр буй нь сэтгэлийн амар амгалан юмаа. Ийм амар амгалан хөвж үл чадваас шүлэг эс төрнөгэдгийг хэдийнээ мэдэрч, энэ хувь тавилангаараа бахархах даруухан бүсгүй бол

“Найргийн сүмийн тахилч

Найрагчийн гэргий Хандмаа” билээ. Эгэлгүй нандин гоо сайхны цогц, их найрагчийн зүрхний хэмнэл болсон Хандмаа эгчийн аж амьдрал, хайрын түүх өөрийнх нь хувьд гоц гойд зүйлгүй мэт нууцлаг. Эрээнцавынхаа уулс шиг намхан биетэй, эгэл даруухан шүлгэн орхимжтой, найраг шүлгийн арш Данзангийн Нямсүрэн:

“Буй биеэрээ би цас болно Бударсан их цас болно Энэ биеэрээ би цас болно. Эрэнцавынхаа л цас болно”

хэмээн Г.Хандмаадаа захиад ертөнцийн гэгээн зүг цасан ширхэгтэй адил будран бударсаар одохоосоо өмнө

Тэнгэрийн унаа надад эхэлж ирвэл

Чи минь битгий уйлаарай” хэмээн зөгнөн шүлэглэснийг нь санагалзан, найргийн гэгээн сүмийн гэрэлт зулыг нь бөхөөлгүй, долоон хөөрхөн болжмороо хүний зэрэгт хүргэж, гэгээн бодлоор сэтгэлээ гэрэлтүүлж их утга зохиолын танил дотно Эрэнцавдаа хэдэн хүүхдүүд ач зээ нартайгаа аж төрж байна.

Хандмаа... Ардын дууны эхлэл ч билүү, эсвэл эртний танил дотно хүн минь билүү. Сонсохуйяа чихнээ аятайхан сонсогдоод байх чинь.

“Цог сэтгүүл” 2008 он №3

Манай дарьганга дуу бол үнэхээр эрчимлэг, эрчистэй дээ



Монгол Улсын Ардын жүжигчин Ш.Чимэдцэеэ

Шувуудын торгон дэвэлтээр Ганга нуур минь бидэрлэж Шуранхай урт “Жаахан шарга”наран зүг эгшиглэж байна Инжааны мөнгөн баавар шиг тунгалаг сарны дор Инжээ Норовын цээлхэн хоолой сэтгэл ариусгах мэтсонсогдож байна...гэсэн шүлгээ биччихээд нутгийнхаа алдарт дуучин, Ардын жүжигчин Ш.Чимэдцэеэ эгчдээ уншиж өглөө. Уртын дуугаараа түмэндээ гайхагдаж, уянгалаг сайхан хоолойгоороо хүн зоныхоо сэтгэлийг хөглөөд зогсохгүй “Дууны шуранхайд шүлэг төрнө” яруу найргийн түүврээ баринтаглаад авсан найрагч гэдгийг манай уншигчид андахгүй мэдэх бизээ.

Гэрийнхээ хойморт нутгийн уул овоо, бурхан шүтээн, алдарт дуучин Н.Норовбанзад багшийнхаа хөргийг залж сүслэн залбирч, эгшигт эх Янжинлхамаа тахьсан аргагүй л урлагийн тэнгэр шүтээнтэй, ундарсан их бүтээлтэй хүн юм даа гэсэн гэгээн бодол хөвөрсөөр.

Н.Норовбанзад багшийгаа “Миний багш цагаан гантиг шиггайхалтай бүсгүй байсан. Дахин ийм хүн хэзээ төрөх юм бол доо. Бурхан багш бидэнд хосгүй гайхамшигтай дуунуудаа аялгуулан өгч, ард олноо уяраан баясгаад ир гэж илгээсэн хүн дээ” гэж самсаа нь шархиран өгүүлэх алдарт дуучин маань багшийгаа эрхгүй санаж явдаг нь илт.

Ш.Чимэдцэеэ эгч үг яриа болгондоо эх нутгаа сүслэн залбирч, ижий ааваа, багшийгаа дурсан санаж, уул усаа баярлуулах үйл хэргийн тухай ярина. Намайг гэрт нь очиход “Алтан овооны авшиг” буянтай ажил бүтээхээр зорьж тамгаа дөнгөж гардаж аваад байлаа. Залуу насандаа дуулж хуурдаж үргэлж л өөрийгөө хөгжүүлж, эх орныхоо нэрийг тив дэлхийн өнцөг булан бүрт дуурсгаж явсан. Өдгөө авьяас билгээ өвлүүлэх, амьдралын туршлагаасаа хуваалцах, урлагийн хүний зовлон жаргалыг хойч үе залуучууддаа зааж сургах биет бус соёлын өвд

зайлшгүй тооцогдох бүүвэйн дуу, хурдан морины марзай гийнгоог аялан цомог болгон хэвлүүлэх нийгэм уруу чиглэсэн олон ажлыг санаачлан эхлүүлж байгаа тухай нь хууч хөөрлөө.

Хоймортоо залсан олон арван бурхан тахилыг нь үзээд эрхгүй “Та их сүсэг бишрэлтэй юмаа” гэхэд,

-Ээж аавынхаа хүмүүжлийг дагаж нүүж байгаа буйраа цэвэрлэхээс эхлээд газар дэлхийгээ хэрхэн хайрлах, өвлөж үлдсэн бурхан тахилаа өглөө бүр тоосыг нь авч, усан тахилга тавьж, авшиг аван, идээ ундааныхаа дээжийгөргөн, зул хүжээ бадрааж байх ёс заншлыг суралцсан. Ээж минь сайхан үнэртэнг бурхны дэргэд өглөө бүр уугиулж бай гэж захьсан юм. Энэ бүхнийг нь тасалдуулахгүй юмсан гэж боддог.

Анх “Жаахан шарга-1,2,3” арваад тоглолт хийж, 2003 онд “Дуунд залбирсан тавилан-1” гэж тоглолт хийсэн. Тэгээд хоёр, гурав гээд үргэлжлүүлсэн. Анхны тоглолтонд маань зориулж нэг найз минь Янжинлхам бурхан

бүтээлгэж өгсөнд их бэлэгшээдэг. Урлагийн их бурхнаа үргэлж шүтэлгүй яахав. Инлай багшийн гайхамшгийг манай нутгийнхан их сайн мэднэ. Энэ их хүмүүнээ одоо ч сэтгэлдээ шүтэж дүрийг нь хоймортоо залж биширч явдаг. Жаахан байхад ээж аав минь надад зориулж 21 дарь эх, бүжинлхам бурхан бүтээлгэсэн. Миний аавын хамгийн том ах хөмсөг Ринчин гэж хүн байсан даа. Тиг татсан хүнээр тэр бурхныг бүтээлгэсэн. Бусад олон багш нар бий.

Ардын жүжигчин болоход арилдаа барьсан ариун бурхныг өгсөн юм. Бурхныг чинь тахил дээжийг нь өргөж, идээ ундааныхаа дээжийг тавьж, аргадаж тойглож, цаг заваа гаргаж, яамаар байна вэ тэр бүхнийг нь хэлж гуйж байж байх ёстой. Бурхантайгаа цуг хадгалж явдаг нэг зүйл бол ээжийн минь I,II одон. Миний ээж бол өөрөө бурхан. Ийм олон хүүхэд төрүүлсэн гавьяатай хүн дээ. Хүн ер нь өөрийнхөө сайнд төрдөггүй гэж үнэн үг. Би бурхан тэнгэрийн зарлигаар эхийн хэвлийд бүрэлдэхэд сайхан дуучин болоод дараа нь хүнд тустай юм хийгээрэй гэж захьсан болов уу? гэж бодож хичээж байна. Залуу байхад өөрийн уран бүтээлийнхээ төлөө цаг заваа их зориулж явсан. Одоо хүмүүсийн төлөө илүү их юм хийхсэн гэсэн бодолтой болж, энэ бүхнээ гүйцээхийн тулд зүтгэж явна аа” гэж намуухан өгүүлж суух энэ эрхэмсэг бүсгүйн ярих нь хүртэл дуу дуулах мэт уянгалаг сайхан, уярал хөндөм гэгээн тунгалаг юм даа.

- Төрсөн бууцаа хэр их зорьж байна даа.

- Би Уулбаян сумаасаа холгүй “Хоолойн бууц” гэдэг газар төрсөн. Ээжийнхээ сүүг хөхөж байгаад бор хоолонд ороод л Гүн худгийн уснаас эхэлж амссан болохоор шүтэж дээдлэн зав гарган зорьж очноо. Хүй дарсан газар минь болохоор ижийтэйгээ адилтгаж хайрлан үдэш оройн цагаар дуулж өгч, тахил дээж өргөдөг уламжлалтай болсон. Ус маш нандин учраас нуур ус, гол мөрөн, амалсан усаа үргэлж хайрлаж явдаг. Нөхөртэйгөө очоод нутагтаа нэг сайхан худаггаргаж өгсөн. Нутгийнхаа усыг рашаан мэт санаж хол ойр явахдаа тээгээд л явдаг. Манай сумаас баруухан урагшаа

Уулбаянмөнх гэж хуучны тахилгатай уул байдаг юм. Урд талд нь миний аав таван настай

байхдаа шавилж сууж байсан Даяанчийн хийд гэж байсан юм гэнэ лээ. Тэгээд манай нутгийнхан Уулбаянмөнхөө их шүтэж дээдлэн, баярлуулж байх ёстой юм даа. Энэ уул минь баруун хойшоо харсан, дэл сүүлээ хийсгэсэн хурдан азарганы шинжтэй. Гайхалтай шүү.



Японы “Хойд нутгийн хавар” дууг дуулж байгаа нь

- Та санаачлан энэ ууландаа лусын бумба залуулсан тухай би нутгийн тань хүнээс сонссон юм байна.

- Тиймээ сум маань олон жил гандаж, өвөл нь их зуд болоод манай сумынхан Түмэнцогт, Хэнтий гэж нүүгээд суман дээр таних хүнгүй шахам хэдэн жил их гунигтай байлаа. Энэ тухай гадаадад байдаг нутгийнхаа Г.Цэнд-Аюуш гэж хүнд хэл дуулгасанд манай сумын мал хүнгүй бүгдэд нь их тус боллоо. 2008 онд юм даа. Хэдхэн сарын дараа Энэтхэгт 14 Ренбүүчийгээгээр аравнайлуулсан лусын бумба авчирч, үүнийг тахьдаг ууландаа нуух юм бол сайн болдог гэж хэллээ. Би ганцаараа явж боломгүй учир лусын бумбыг нуух зан үйлийг сайтар мэддэг Энэтхэгт 16 жил, америкт 9 жил болсон хоёр лам, нөхөртэйгөө бумбаныхаа дор хийдэголон зүйлийн юмыг аваад гурван машинтай явлаа. Мөн тэр үеийн манай сумын засаг дарга Шижирбаатар ч байсан. Яг зан үйлийнх нь дагуу нуугаад овоондоо очиж мөргөчихөөд нутагтаа эргээд иртэл сайхан болчихсон байсан. Түүнээс хойш гандаагүй, зуд ч болоогүй. Шүлэг бичээд манай сумын уугуул дуучин Хүрэлбаатар, Батбаатар, Энхжаргал нартайгаа дуулж, чулуун дээр бичиж, магтаад тэнд нь аваачиж залах бол баярлуулах байхаа гэж бодож байна.

- “Алтан овооны авшиг” төрийн бус байгууллагынхаа тамгыг аваад удаагүй байгаад тань баяр хүргэе.

- Баярлалаа. Би шинэ залуу төдийгүй уран бүтээлээ гаргаж чадахгүй байгаа ахмад уран бүтээлчдээ дэмжих зорилгоор энэ байгууллагаа байгуулсан. Өнөөдөр уран бүтээлчид энд тэнд ганц ганцаараа ажиллаад амжилтанд хүрэхгүй, багаараа ажиллавал зүгээр байхаа гэж бодоод залуучууд маань бас их дэмжсэн. Заавал уран бүтээлч гэх албагүй Алтан овооны авшгийг хүртэх хэн боловч орж, дэмжиж болно, дэмжүүлж болно. Заавал урлагийн хүн гэхгүй. Алтан овооны авшгийг хүртмээр байна гэсэн саналтай хүн байвал манай холбоонд элсээрэй гэж урьж байна. Хэн нэгнийг дэмжих зорилготой.

- Сүхбаатар аймгийн соёлын ордноо театр болтол нь ажилласан уран бүтээлчдийн нэг бол та. Анх дуучинаар ирж ажилласан залуу цагаа дурсана уу?

- Би аймгийнхаа соёлын ордонд 16 настай дуучин байхаасаа театр болтол нь 19 жил ажилласан даа. Ёстой л тогоонд нь чанагдаж бүжигчин, жүжигчин, хөгжимчин бүгдийг нь л хийж байлаа. Манай Дооёо багш паарцаа гаргаж чадахгүй байна гээд хөгжмийн өрөөнд ганцааранг маань цоожилж, шөнөжин уйлаад хонож л байсан. 19 жил хуучир, ятга ч тоглож байлаа. Залуу цагийн нэгүеийн уран бүтээлчид бидний зовлон жаргал, өлсөх, өвдөх нь хүртэл ижил шүү дээ. Урлагийн бригадаар явж байхад зам зуураа гурван хоног саатаад

хоол ундтай залгаж байсан үе ч байдаг. Тавин гурав машин дээр жүжигкиноныхоо бүх юмыг ачаад өөрсдөө суун их ч явсан. Аймгийнхаа болон монгол улсынхаа бүх суманд очсон доо.

- Аймгаасаа шилжиж ирээд л морин хуур чуулгад ажилласан уу?

- Тийм. Анх морин хуур чуулгад ороход миний хүүхэд шиг залуус ихтэй хамт олон угтсан. Хэзээ би энэ хүүхдүүдтэй нэг хамт олон болно доо гэж санагдлаа. Удалгүй л хамтран ажиллаж их хүндлүүлж “Тэнгэр ээжээ” гэж дуудуулж явдгаараа бахархдаг юм. Анхны хамт олон аймгийн соёлын ордныхон, морин хуур чуулгынхан, хөгжим бүжгийн дунд сургуулийн багш нар гэсэн гурван хамт олноороо бахархдаг. Тэнхимийн эрхлэгч маань Ардын жүжигчин, Төрийн шагналт 20-р зууны манлай эмэгтэй, дуурийн дуучин Х.Уртнасан. Шавь нартаа бас их баярладаг. Залуучуудад хичээл зааж, хамт уран бүтээл туурвих сайхан байдаг юм.

- Дарьганга дууны онцлогийг эрдэм шинжилгээний үүднээс судлан тайлбарлаж докторын зэрэг хамгаалах гэж байгаа юм байна. Энэ тухайгаа хуучилна уу?

- Нутагтаа олон жил дуулж, хууч домог цуглуулж ном гаргаж байсны хувьд уран бүтээлч нөхдүүд маань, “нутгийнхаа дууг өөрөөс чинь өөр гадарлах хүнгүй болжээ. Үүнийгээ илүү эрдэмлэг болгож үлдээвэл яасан юм бэ” хэлсэн. Нэлээд цуглуулсан материал ч байсан. “Дарьганга дуу, түүний утга төрөл зүйл” сэдвээр хамгаалахаар зэхэж байна. Манай Дарьганга дуу бол үнэхээр эрчимлэг, эрчистэй. Сонсоход ч өөр. Яагаад гэвэл дуу дуучин хоёр нутгаа дагаж төрнөгэсэн эртний үг байна. Дарьгангад 222 унтарсан галт уул байна. Хангай Хэнтийн салхи өмнө зүг тийш яваад Дарьганга зүгт хуралддаг. Энэ нь газар зүй геологчдийн судалгаа. Урдаасаа Хянганы бүлээн зөөлөн салхи сэрүүн салхитай нийлж хуралдаад энерги үүсгэдэг. Тэр

бүхэн өнөөдөр мөнөөх энерги цацсаар байна. 222 галт уул бол 10-15 сая жилийн өмнө цоролзож асаж байсан гэсэн судалгаа байдаг. Тэгээд сав ертөнц шим ертөнц хоёрын дунд өссөн хүн бол эрчистэй төрөөд тэр дуу эрчистэй гарч ирж байгаа юм. Тиймээс Дарьгангын уртын дуунууд дандаа доод өнгөнөөсөө дээшээ эрчилсэн цохилготой. Утаагаар бол эрчилээд дээшээ, галаар бол дөл шиг цоролзохтой зүйрлэм аялгуутай байдгаараа их онцлогтой. Ер нь уртын дууг эрчистэй гэж ярьдаг нь үнэн. Японд уртын дуугаар хорт хавдрыг хүртэл эмчилсэн гэж ярьж байна. Тухайлбал, манай Дарьгангын марзай аялгууны хувьд бол маш өөр. Үнэхээр тэр хурдан амьтны бор тархинд шингээснээр тэр хурдан уралдаж түрүүлж ирэхийн зөн совинд автахаар тийм аялгуу байгаа юм.

- Олон жил дуулж байгаа хүний хувьд дуучин байхын аз жаргал нь юундаа оршдог вэ?

- Дуучин байхын жаргал сайхан даа. Бурхны хишиггэж бодож баярладаг. Ямар ч богино дууг

сайхан дуулдаг улс уртын дууг дуулдаггүй. Цохилго, нугалаа, хугалаа, чимэглэл шуранхай бүгд бурхнаас заяасан ховорхон хишиг. Манай аавын хамгийн том эгч 100 хүрч байгаа хөгшин маань намайг жаахан байхаас л “Чи сайндаа ч дуучин болчихсон биш дээ, цөс нь хавиргаа дэлсэв. Чиний урьд төрөл чинь чамд “Дуутай жинсрэг”-ийг олон дахин уншуулчихсан байхгүй юу даа” гэж хэлдэг юм. “Дуутай Жинсрэг” гэж хойт насанд нь дуучин болгодог тийм ном байдаг байжээ. Том лам хүний гэргий байсан хүн л дээ. Манай аав ч бас тэгж хэлдэг байсан юм. Би ч тэгж их цөс нь хавиргаа дэлсэж, би би гэж байсангүй ээ. Хэзээ ч тэгж явсангүй.

- “Дуунтай жинсрэг” номыг та сураглав уу?

- Би энэ үгэнд итгэдэг. Хойд насны маань хүн дуучин болоосой гэсэндээ олон хийдүүдээр явлаа. “Дуутай Жинсрэг”-ийг ерөөсөө уншихгүй юм. Одоо бол

“Жинсрэг” гэж байхаас дуутай жинсрэг гэж байхгүй юм. Унших газар байвал энэ номыг олон дахин уншуулмаар байна.

- Өөрөө багш болоод уртын дуугаа зааж сургана гэдэг танаас мөн л их мэдлэг, чадвар шаарддаг байх даа?

- Уртын дууны багш болоод долоон жил болохдоо гурван анги төгсгөлөө. Дан авьяас биш заавал хөдөлмөрлөж байж амжилтанд хүрдэгчраас хүүхдүүдээ их хөдөлмөрлөөсэй гэж боддог. Хойноос нь их санаа тавих хэрэггарна. Авьяасаа цалгилуулсан сайхан дуучин болоосой гэж боддог. Хүүхдүүдээ чадлаараа дэмждэг дээ. Мөн нутгаасаа хэдэн сайхан дуучин төрүүлээд бэлдээд хот хүрээ газар урлагийн байгууллагуудад нэг нэгийг оруулах юмсан гэж боддог.

- Та бол яахын аргагүй монголын сор болсон сайхан хүүхнүүдийн нэг. Гоо сайхандаа яаж анхаардаг вэ?

- Урлагийн хүн гэдэгтэй сайхандаа анхаарах нь зүйн хэрэг. Эгч нь анхаараад сүйд болоод байдаггүй ээ. Энгийн л нэг бүтэн бор бүсгүй дээ. (инээв) Яахав сайн явах санааных, сайхан төрөх заяаных гэж үг бий. Би өөрийгөө төрүүлээгүй, гайгүй сайхан харагдаж байвал ээж аавын минь л буян даа. Гоо сайхныхаа бүтээгдхүүнийг хааяа гадагшаа явахдаа авчихдаг юм.

Уртын дуугаа нэг сайхан магтана уу?

Уртын дуу бол их өөр юм. Урлагурлагийн дундаа би уртын дуу дуулахаар зуурдын ертөнцөд илгээгдсэн болохоор маш их хичээх ёстой. Залуу байхад өдөр шөнөгүй дасгал хийж, урт богинын дуугаа дуулж явлаа. Одоо уртын дууны нарийн ширийнийгурлан гаргах тал дээр. Уртын дуу бол дэлхийн сонгодог дуу шүү дээ. Уртын дууны гайхамшиг бол үнэхээр аялгууны өргөн далайцтайгаараа гайхамшигтай. Энэ аялгууг сонссон хүний зургаа дахь мэдрэхүй сэрнэ. 4-5 үг байлаа гэхэд дуулахад л 4-5 минут дуулж, бүтэн роман шигутга санаа хэлнэ. Ийм л гайхамшигтай урлаг юм. Уртын дуу монгол хүний эзэмшвэл зохих мэргэжил, сонсвол зохих дуу. Заавал дуучин байх албагүй. Монголынхоо уртын дууг сонсдог сонсогч байхад л монгол хүн болж төрсний гавьяа гэж би боддог.



Ардын жүжигчин Ц.Батчулуун багшийнхаа хамт

- Таны номын санд хуучны номнууд их олон байна. Ном их уншиж, заан их цуглуулдаг юм байна?

- Залуу байхад нөхрөөсөө салаад 120 төгрөгийн цалинтай болоход хувцас авч хүрдэггүй байлаа. Ноосон утсаар нэхээд л хувцас хийгээд өмсчихдөг байв даа. Харин цалингаараа ном их авдаг байсан. Энэ номын цуглуулгууд миний хамгийн үнэ цэнэтэй зүйлс. Д.Намдаг гуайн зохиолууд, бусад олон арван жүжгийн зохиолуудыг их уншдаг байж билээ. Дээр нь зохиолчдын гарын үсэгтэй номнуудаа би нандигнан хадгалах дуртай.

Харин энэ заанууд бол 2003 онд бид хоёр өөрсдөө авсан чинь сүүлдээ найз нөхөд бэлэглэсээр байгаад тавь гаран заантай болсон.

- Ойрдоо “Ая дан” студид “Бүүвэйн дуу”-ны цомгоо бичүүлээд тун завгүй байна гэж ярьж байсан. Энэ цомгийггаргах болсон тухайгаа сонирхуулна уу?

- Бүүвэйн дуу хүний хүмүүжилд асар их үүрэгтэй. Хүн гэдэг сав ертөнц, шим ертөнц дундаас төрсөн. Энэ нь илгээлтээр ирсэн гэж боддог. Харин ирэхдээ өөрийгөө хүн болгох, тайвшруулах аялгуутай ирсэн нь бүүвэйн дуу юм. Эртний бүх л туужид бүүвэйн дууны тухай байдаг. Бүүвэйн дуу хүүхдээ хэвлийдээ байхаас мэндэлж, хэлд ортол нь хүмүүжүүлэх уламжлалт арга. Тэр үед чинь бүүвэйгээрээ л боловсрол олж авч байсан гэж хэлж болно доо. Боржгон бүүвэй, Төв халхын бүүвэй, Дарьганга бүүвэйг судлан, домгийг нь цуглуулаад бичүүлж байна. Энэ бол тэнгэрээс илгээсэн хүнийг, хүн болгох тухай аялгуу юм. Хуучны хүмүүс ямар их ухаантай байсан. И үсэг бол хүнийг төлөвшүүлэх эгшиг гэнэ. Яагаад гэвэл ижий гэдэг үгэнд гурван И, бүүвэй гэхэд хамгийн сүүлийн эгшиг И. Өнөөгийн ороо бусгаа цагт хүмүүс бүүвэй аялж, сонсгож үр хүүхдээ өсгөвөл ямар их үр дүнтэй болохыг мэдэж байгаа учраас нийгэмд маш их үнэтэй зүйл юмаа.

- Газар газрын бүүвэйн дууны онцлогийн талаар тодруулаач?

- Би арван гурван хүүхэдтэй айлын дунд хүүхэд, миний ээж биднийг маш сайхан бүүвэйгээр бүүвэйлж өсгөсөн. Тэр үеийн ээжүүд хүүхдээ маш их бүүвэйлдэг байсан учраас дээр үед хүмүүс хэрэг төвөгт орооцолдох нь маш бага байсан. Хуучны улс хатуу сэтгэлтэй, хэрэгт орооцолдомтгой нэгнийг эхийн бүүвэй сонсож өсөөгүй амьтан юм байх даа гэж муу хэлдэг. Одооны улс бүүвэй аялахаа байжээ. Дэмий л сэгсчих болсон нь харамсалтай.



Ардын жүжигчин Ш.Чимэдцэеэгийн “Бүүвэйн дуунууд” цомог 2011он

Хуучин цагт ээжүүд үр хүүхдээ зүрхэн хүрдэндээ ойрхон тэврэн байж бүүвэйлдэг байжээ. Хүний долоон хүрдний доороосоо дөрөв, дээрээсээ мөн дөрөв дэх хүрд бол алив зүйлийг амирлуулан тайвшруулах хүрд гэдэг. Зүрхэн хүрдний өнгө ногоон өнгөтэй байдаг. Энэ нь амирлангуй тайван болгож байдаггэдэг. “Хүүхдийг хэдий чинээ их бүүвэйлэн өсгөнө төдий чинээ тэр хүн урт насална. Насных нь цөвийг арилтал бүүвэйл гэж ээж минь захидаг байсан. Хонь мал тойглох, өөвлөх, хөөслөх зэрэгт тэр малын уураг тархины бор хальсанд очиж нөлөөлөн, хүний, өөрийн үрийг авч үрээ болгодог гэсэн шинжлэх ухааны судалгаа бий. Хүнийг хүн болгоход ээжийн бүүвэй ямар их гавьяатайг өнөө цагийн ээжүүд, эхчүүддээ өвлүүлэхийг зорьж явна. Тиймээс би Дарьганга бүүвэй, боржигон бүүвэй, халх бүүвэй, баруун монгол бүүвэй зэрэггазар газрын бүүвэйг цуглуулсан даа Энэ цомгийг хийж үлдээвэл ээжүүд бүүвэйгээ сурч, үрсээ бүүвэйлж, өр зөөлөн, хайр цалгин жинхэнэ хүн болон төлөвшигсөдийг бойжуулна гэсэн гэдэгт итгэлтэй байна.

- Бүүвэйн дууны цомогтой хамт бас марзай дуудсан сайхан аялгууг ч цомог болгох гэж байгаа юм байна. Энэ тухай өгүүлвэл...

- Би жижигхээн биетэй хүүхэд байсан болоод тэрүү 15 нас хүртэл үрээ морь унасан хүн. Миний багад манай суманд Батсүх, Должин, Лхагва марзай уянгалуулдаг хүүхдүүд байлаа. Тэд сүүлд бүгд дуучид болсон. Марзай дуудаад сунгаа хэд хэд тойроход унаж яваа үрээ чихээ солбилзуулан бааж шээн биеэ хөнгөлөөд бушуухан замд гарахын түүс болж амаа булаацалдан цойлдог байж билээ. Энэ аялгуу нь дууны уураг тархины бор хальсанд очиж нөлөөлөн олон

агтны дундаас түрүүлэн ирэхийн зөн билэгт хөтөлдөг. Одооны хүүхдүүд марзайлж гийнгоолох нь цөөрчээ. Үүнд мөн их санаа зовниж Дарьганга, Халх боржигон, Баруун Монгол, Хар дэл, Говь шанх зэрэггазар газрын гийнгоонуудыг судлаад цомог болгон гаргахаар бэлдэж байна. Миний энэ бүтээлүүд монгол хүний хүмүүжил, монгол адууны хурдад нөлөөлөөд зогсохгүй монголын соёлд үнэтэй хувь нэмрийгүлдээнэ гэж бодож байна.

- Нутаг нутгийн марзай өөр өөр үү?

- Манай нутагт бол марзай уншина гэж ярьдаг юм. Бусад нутагт Марзайн гоо гэж хэлнэ. Төв аймаг руу гоо, төв халх руу бол гийнгоо гэж хэлнэ. Би тийм олон жил үрээ унасан болохоор хурдан морь гаргаж байгааг харахаар хөөрхийлөлтэй харагдаад байдаг юм. Хүүхдүүд нь унтармаар нэг юм аялаад. Хуучин цагт бол үгтэй, ая, дантай байдаг.

- Энэ тухай судалгаа ер нь байдаг уу?

- Одоохондоо бол байхгүй ээ. Бүүвэйн тухай бол эрдэмтэн Х.Сампилдэндэв гуай ном гаргасан. Аялгуу талаас бол ийм учиртай. Энэ эгшиг ингэж дуугарч байгаа учраас хүнийг хүмүүжүүлэх ийм авиа эгшиггэж нарийн судалсан юм бол байхгүй. Эрдэмтэд судлах байхаа. Гийнгоо, марзай бол манай Дарьгангад ум

марзай мам сууха, Алтан Дарь овоо минь өршөө, гэгээн богд минь өршөө гэж марзайлдаг. Ум марзай мам сууха гэдэг нь нарны тарни. Ингэж нарандаа хүүхэд морь хоёроо даатгаад явуулж байгаа нь Дамдин бурхны тарни. Үүнийг морио хариуцсан бурхан гэж ярьдаг байх жишээтэй. Аялгууны тухайд бол марзай, гийнгоо бүхэн өөр. Адуу хийморлог амьтан учраас адуунд зориулсан аялгуу бол их өөр байдаг юм байна. Бүр эрчлүүр үүсгээд яг тэр адуугаа сэргээсэн аялгуу нь эрчлээд байдаг. Тийм л сайхан аагтай амьтныг манай эрдэмтэд судлаасай л гэж боддог.

- Багадаа хурдан морь унадаг байсан нь таныгуртын дуучин болоход хамгийн их тус болжээ дээ?

- Манай ард түмний дээр үеийн аялгуу бүхэн нь дандаа уртын дуу байсан. Уртын дууны эхний шат үсгээр бол 35 үсэгний А, тоогоор бол нэг. Дандаа л нэг цохилготой байсан. Би дүү нараа бүүвэйдэг байсан. Ээжийн минь бүүвэй их гоё. Хонь тойглож байлаа. Энэ бүхэн нь миний уртын дууч болох эхийг тавьсан. Манай Н.Норовбанзад багш хонь их сайхан тойглодог. Багшийг тойглохоор илбэ жатгатай юм шигголсон хургаа дорхноо авчихдаг байсан гэж өөрөө ярьдаг байж билээ. Мөн жартгай Тавхай гэж хүний хурдан морийг их унаж байснаараа би уртын дуучин болсон гэж ярьдаг юм.

- Уугуул суугуул нутгийнхандаа хандаж сайхан ерөөлийн үг хэлнэ үү?

- Нутгийнхандаа аз жаргал хүсье. Хүн хүний бодол өөр, гүзээ гүзээний булан өөр гэж үг байдаг даа. Тэгвэл хүн хүний аз жаргал өөр. Өөр өөрийнхөө аз жаргалыг эдлэж, цалгиж яваарай гэж ерөөе. Мөн Уулбаянд байгаа ах дүү нар, хамгийн том эгч Айлтгүйдээ урт удаан наслахыг ерөөе.

Бид хятад хүнийг мэддэг гэхээсээ илүү мэддэггүй зүйл маш их бий



Хэл бичгийн ухааны доктор, Нэрт дуун хөрвүүлэгч М.Чимэдцэеэ

Нэрт дуун хөрвүүлэгч, Күнзийн М.Чимэдцэеэ багшийг хэл соёл, утга зохиолын хүрээнийхэн андахгүй мэдэх болжээ. Монгол хятад орчуулга зүй, хятад хэл, соёл, Күнзийн сургаал сэтгэлгээ, соёлын чиглэлээр голлон ажиллаж, олон арван судалгааны илтгэл, өгүүлэл, нийтлэл бичиж, гадаад дотоодын хэвлэлд нийтлүүлэн, монголдоо төдийгүй дэлхийд хятад судлалын тухайд урдаа барьдаг том эрдэмтэн болжээ.

Дэлхий дахинд нэр алдар нь түгсэн гүн ухааны сэтгэлгээний сонгодог бүтээлүүд болох “Шүүмжлэл өгүүлэл”, “Их суртахуй”, “Сүнзийн дайтахуй ухаан” зэрэг бүтээлийг монгол хэлнээ орчуулан нийтийн хүртээл болгож, утга зохиолын шилдэг орчуулгын “Алтан өд”, Монголын орчуулагчдын эвлэлийн “Дуун хөрвүүлэгч” цол, МУИСийн олон улсын шилдэг судалгааны бүтээлийн шагнал, доктор, профессор Чой. Лувсанжавын нэрэмжит “Алтан од” шагналуудыг хүртсэн юм. Эрдэмт хүн даруу их мөрөн дөлгөөн гэж сайхан үг байдаг. М.Чимэдцэеэ багш шилдэг бүтээл туурвих тусмаа шижир алт шиг сэтгэл нь гэрэлтэж, оюун ухаан нь шинэсэн гэгээрч, шавь нартаа дорны гүн ухаанаас дээжлэн сургаж, даацтай бүтээлүүдээ арвижуулж, улам ихийг туурвихаар он цагийн хүрдийг эргүүлж явна.

2011 онд Дэлхийн Күнзийн институтын их хурлын үеэр “Оны дэлхийн шилдэг хүн”-ий нэгээр шалгарсан анхны монгол эрдэмтэн болсон юм. Эл шагналыг олгодог Хятад болон гадаадын нэр хүнд бүхий хүмүүсээс бүрдсэн шүүгчдийн тусгай баг орон оронд ажиллаж, Күнзийн институтын төвийн нэр дэвшүүлсэн хүмүүсээс тусгай журам, үзүүлэлтээр сонгон шалгаруулдаг ажээ. Өнгөрсөн жилийн “Дэлхийн шилдэг хүн” хэмээх шагналыг Монголоос гадна БНХАУ, АНУ, Англи, Япон, Сингапур, БНСУ, Норвеги, Мажар, Вотсван зэрэг орны Күнзийн институтын захирлууд хүртжээ. Уг шагналыг Бээжин хотод хуралдсан Дэлхийн Күнзийн институтын VI их хурлын нээлтийн ёслол дээр БНХАУ-ын удирдагчдын нэг ХКН-

ийн Төв хорооны Улс төрийн товчооны байнгын гишүүн Ли Чан Чүнь гардуулсан байна. Ийнхүү монголоос анх удаа Цалин цагаан “Мөнгөн медаль”, “Хүндэт өргөмжлөл”-ийг хэлбичгийн ухааны доктор М.Чимэдцэеэ багш хүртэж, монголынхоо хятад судлалыгөндөрт өргөсөн.

Саяхан “Бидний мэдэх хийгээд эс мэдэх хятад, орон соёл, сэтгэлгээ” нэртэй ном хэвлүүлсэн нь манай өнөөгийн хятад судлалд шинэ үзэгдэл боллоо. Энэ номоо хэвлэлтээс дөнгөж гаруут, дээжийг нь доктор, профессор нанхиадч Ц.Базаррагчаа багшдаа гардуулах үед нь уулзаж ярилцлаа.

- Танд шинэ номынхоо эхний хуудсыг нээж байгаа баярт өдрийн мэнд хүргэе. Энэхүү номыг бичих үүдэл санаа хэрхэн төрсөн юм бол?

- Монгол хятад хоёр бол мөнхийн хөрш улс юм. Аливаа хөрш орнуудын хувьд хамгийн чухал нэг зүйл бол

хөршөө маш сайн таньж мэдэх явдал байдаг. Энэ нь улс хоорондын болон хүмүүн хоорондын харилцааны хамгийн чухал жаяг зарчим гэж хэлж болно. Судлаач хүний хувьд миний ойлгож байгаагаар монголчууд орос орныг сайн судалсан, орос хүнтэй олон жил нөхөрлөсөн. Гэтэл хятад хүний тухай мэддэг юм шиг мөртлөө мэддэггүй зүйл маш их байдаг. Хэн нэгэн монгол хүнээс та хятад хүнийг хэр зэрэг мэддэг вэ? гэж асуувал би мэднээ л гэж хэлнэ. Хэрэг дээрээ бол төдийлөн сайн мэддэггүй. Чухам ийм санаанаас үүдэж монгол хүний танин мэдэхүйд тус болохын төлөөнөө энэ номыг бичсэн юм. Миний бие хятадын гүн ухаан, утга соёлыг сонирхдог, судлахыг хичээдэг. Тиймээс энэ номыг бичихэд надад их ойр байсан. Монголд хятад судлалын салбарт хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, төр засаг, эдийн засгийн харилцаа гээд зарим судалгааны ном бүтээл гарч байна. Хятадын уран зохиол, яруу найргийн зүйлээс орчуулсан ном цөөн боловч байгаа. Харин яг хятад хүний сэтгэлгээний хэв маяг, соёл, суртахууны онцлогийг судалсан, бичсэн зүйл урьд өмнө бараг гараагүй. Ийм шалтгаануудаас үүдэн, хэдэн жилийн хөдөлмөрийн үрээр энэ номыг бичиж дуусгаад уншигчиддаа өргөн барьж байгаа юм.

- Шинэ номд тань тэгвэл хятад хүний соёл сэтгэлгээг голлон өгүүлсэн байх нь ээ?

- Тийм тийм. Энэ номд хятад хүний соёл, сэтгэлгээний талаар нэлээд дэлгэрэнгүй бичсэн. Гэхдээ би тэр бүгдийг хувь санаагаараа зохиогоод биччихсэн юм биш л дээ. Эрдэмтэд судлаачдын бичиж туурвисан өдий төдүй бүтээлийгуншиж судалж, харьцуулж, нэгтгэн дүгнэж, шинэ санаа оноо нэмж, баримт жишээ өгүүлж, эртний хийгээд эдүгээгийн судар номоос эшлэж, зарим шүлэг зохиолыг орчуулах зэргээр номоо бүтээсэн. Өрнө, дорнын сэтгэлгээ соёлын ялгаа, тэр дундаа хятад хүний сэтгэлгээний хэв маяг, онцлог зэргийг тодруулан

бичихийг хичээнгүйлсэн юм. Сэтгэлгээ, соёлын онцлогийг сайн мэдэхгүйгээс болж, хятад хүнтэй харилцахад олон бэрхшээл учирдаг. Эндээс үүдэн үл ойлголцох явдал гарна. Бид хятад хүнийг мэддэг гэхээсээ илүү мэддэггүй зүйл маш их бий.



- Яагаад ихэнх хүн хятад л бол муу гээд байдаг юм бол. Энэ үл ойлголцлыг бага ч болов арилгахад таны ном тус болох болов уу?

- Бид шинэ эрин үе, даяаршлын эрин үед аж төрж байна. Сайн муу гээд яриад суух нь үеэ өнгөрөөсөн, улиг болсон хэрэг юм. Өнөөдөр цагүе маш хурдан хувьсан өөрчлөгдөж байна. Тэрхүү их өөрчлөлт хувиралтын дунд улиг домог болсон хуучин үзэл бодлоо таягдаж, хятад хүний сайн, муу талыг бодотой таньж мэдэх нь нэн чухал. Тэгж байж бид зөв сайхан харилцаж чадна.

Хятад түмний нэр нөлөө, хэл соёл дэлхийд их мандан дээшилж байна. Ийм цагүед бидний монголчууд яах, хэрхэн учиртай вэ?

Хятад улс эдийн засгийн хүчин чадал, хөгжлийн хурдаараа дэлхийд тэргүүн эгнээнд цолгорон гараад ирчихлээ. Энэ хурд цаашдаа ч саарахгүй хэмээн эрдэмтэд дүгнэж байна. Үүнийг бүтээгч нь хятад хүн юм. Бид нар хятадын туршлага, эдийн засгийн ололт амжилт гэж яриад байгаа боловч бүтээж байгаа хүнийх нь тухай ярьдаггүй. Иймээс энэ үсрэнгүй хөгжил дэвшлийн нууцын цаана хятад хүний онцлог байдаг. Хүнээс нь эхэлж харах, судлах ёстой юм даа. Хятадын өнөөгийн төрийн бодлого олон талаар урд эртний уламжлал дээрээ бат суурилсан байдаг. Энэ үүднээс уламжлалыг нь судалвал тэр хөгжлийнх нь нууцыг мэдэж болно. Миний бодлоор монголчуудын хувьд хятад орон, хятад хүнийгүнэн бодотой, сайнтай муутай нь таньж мэдэх явдал учир дутагдалтай байна гэж боддог.

- Таны өмнө нь орчуулж хэвлүүлсэн хятадын сонгодог судрууд уншигчдын таалалд их нийцсэн. Шинэ номоо бичихэд тэдгээр номнуудыг орчуулж байсан туршлага их тус болсон болов уу?

- Би орчуулдаг, бас судалдаг хүн. Хятадын сонгодог судар бичгээс сонгон орчуулах гэж

хичээдэг. Күнзийн суртлын сонгодог хоёр бүтээл, Сүнзийн номыг монголоор орчуулсан. Эдгээр бүтээл бараг 2500 жилийн өмнө зохиогдсон сонгодог судар туурвил юм. Дэлхий даяар ихэд алдартай бүтээлүүд. Би “Хятадын сонгодог утга зохиолын дээж” гэсэн цуврал гаргахаар зорьж байгаа юм. Энэ цувралын эхнийх нь энэ гурван бүтээл гэж хэлж болно. Харин шинэ номоо бичихэд дээр өгүүлсэн гурван ном их хэрэг болсон. Тэдгээр бүтээлээс эш татсан зүйл элбэг байгаа.



Күнзийн төрсөн нутаг Шаньдун муж

- Хятад хүний сэтгэлгээ, өрнийн хүний сэтгэлгээнээс ялгагдах гол онцлог нь юу вэ?
- Хятадын соёл, хятад хүний сэтгэлгээ үндсэндээ дотогшоо хандсан байдаг. Өрнө дахины сэтгэлгээ бол гадагшаа хандсан байдаг ажээ. Тухайлбал, хятадын соёлын бэлгэдэл нь тайжиту хэмээх зураг байдаг. Энэ нь дугуй цагирган дотор дүрслэгдсэн арга билгийн зураг л даа. Гэтэл өрнө дахины сэтгэлгээний бэлгэдэл нь загалмай хэрээс байдаг. Энэ нь нэгэн цэгээс дөрвөн зүгт тэлсэн хязгааргүй хүслэнг илтгэдэг байна. Дорно дахины, тэр дундаа хятад хүний соёл, сэтгэлгээнд ямагт төвд тэмүүлэх хүч үйлчилж байдаг. Гэтэл өрнө дахины соёл сэтгэлгээнд төвөөс зугтаах хүч үйлчилдэг байна. Эндээс өрнө дорнын том ялгаа бий болдог. Үүнээс улбаалан өдөр тутмын аж амьдралын хэв маяг, дадал заншил, соёлын ялгаа буй болдог. Бид үүнийг гаднаас нь хараад сайн муу гэж хэлэх нь утгагүй зүйл. Мэддэг байх хэрэгтэй. Муучилдаг биш мэддэг байх ёстой гэсэн үг л дээ.

Хятад хүний сэтгэлгээний авууштай эрхэм зүйлүүдээс жишээлэн тайлбарлаж өгнө үү?

Хятад хүний сэтгэлгээ, соёл дотогшоо хандсан байдаг гэж сая хэллээ. Үүнтэй холбоотой олон

зан чанар илэрдэг. Жишээ нь хятад хүн хэзээ ч бусдыг нүүрэн дээр нь муу хэлдэггүй, хэзээ ч үзэл бодлоо шууд хүнд тулгадаггүй, бусдыг ил цагаан дорд үзэн олтгойддоггүй. Энэ нь хүмүүн хоорондын харилцаанд маш чухал үүрэгтэй байдаг. Хятад хүний сэтгэлгээ нь бусдыг өөрийн дээр тавьж, өөрийгөө доорд үздэг. Энэ бүгд Күнзээс уламжилж ирсэн сургаал номлолтой холбоотой. Мэдээж муу юм байгаа. Өнөөгийн цаг үед нийцэхгүй зүйл олон байвч, цаад язгуур үндэс нь сайн тустай зүйлийг, хүн болохуйн ухааныг номлосон байдаг. Өрнө дахин эдүгээ яагаад Күнзийн сургаал, Бурхан багшийн сургаалыг хүч тавин сонирхож байна вэ гэвэл тэд хөгжил дэвшилд хүрээд эргээд харахуйд хамгийн хүмүүнлэг хамаг нандин зүйл нь дорно дахины, Күнзийн сургаал, Буддын сургаал, Лаозын сургаалд байгаа учраас эргэцүүлэхээс өөргүй болж. Өнөөдөр олон улсын томоохон хурал, форум, ЮНЕСКО, Күнзийн шагнал бий болгосон гээд олон зүйлийг дурьдаж болно. Хятад улсын гадаад, дотоод бодлого чиглэл хандлагад Күнзийн сургаалыг эш үндэс болгосон зүйл олон буй. Тиймээс хятадыг судлая гэвэл Күнзийн сургаалыг судлах хэрэгтэй болжээ. Ийм л харилцан хамааралтай юм.

Хятад хэл соёл гэхээр юуны өмнө хятад хэлийг сурах явдал хамгийн чухал. Энэ тухайд...

- Дэлхий даяар хятад хэл сурах хөдөлгөөн өрнөж байна. Хятад хэл, хятад ханз үсэггэдэг мөн л хятад хүний соёл, сэтгэлгээний иш болдог л доо. 5000 жилийн түүхтэй соёл юм. Хүн төрөлхтний түүхэнд эртний гурван том бичигүсэг бий болсон байдаг. Өнөөдөр хоёр том үсэг бичиг нь урт хугацааны туршид устаж, дурсгал болж үлдсэн бол харин ханз үсэгөнөө хүртэл хэрэглэгдсээр

байна. Энэ бүгд хятадын соёлтой холбоотой. Хятад хүний сэтгэлгээ нь дүрслэлийн сэтгэлгээ голлодог. Дүрслэлийн сэтгэлгээний гол онцлог нь ханз үсгээр нь илэрдэг. Энэ мэтчлэн судлах зүйл олон бий.

Баярлалаа. Цаг зав гаргасан танд баярлалаа

Б.Төгсжаргал www.time.mn 2012-10-22

Хамгийн том хаан бол цаг хугацаа учраас мөнхийн хуультай



Монгол Улсын Гавьяат эмч, нэрт дуун хөрвүүлэгч М.Шагдарсүрэн

Анхны цас хэдийнээ унасан өвлийн тэргүүн сарын нэгөдөр. Саяхан л юм даа. Номын мэргэн ахаас эрт цагт ярьж байсан судар номын сураг ажиг тавьж, хятад ном соёлын талаар зарим зүйлийг тодруулах санаатай зорин очсон юм. Хэзээний л завгүй байдаг ахын алтан цагаас арван таван хормыг нь хороон байж зорьсон хэргээ ярихад огтхон ч төвөгшөөгөөгүй билээ. Харин ч “Ах нь арван боть номоо хэвлүүлж байгаа шүү” гэж хэвлүүлэхээр зэхэж буй ботиудынхаа талаар ярих нь чихэнд чимэгтэй, сэтгэлд дулаахан байлаа.

Нутгаасаа ирэх болгонд уран бүтээлч ах эгч нар минь шинэ бүтээл номоо дурсгаж, үг сургаалаа айлдаж, уран бүтээлийн урам дэм өгч хийж бүтээхийн дэврүүнхүсэлд минь гал нэмдэгсэн. Харин уулзах тоолондоо орчуулсан, хэвлүүлсэн, бүтээсэн гээд хэдий завандаа ийм юмыг амжуулдаг байнаа гэмээр сэтгэгдэл төрүүлдэг, бахархам энэ хүмүүн бол Монголын ард түмэнд “элэгний” хэмээн танигдсан доктор, профессор, дуун хөрвүүлэгч М.Шагдарсүрэн юм. Ижийгээ хайрлах ухаан нь энэрэхүй их үйлийнх нь эх булаг байж, бага сургуулийн жаахан пионер М.Шагдарсүрэн заавал эмч болно гэсэн хүсэлдээ хөтлөгдсөөр АУИС, МУИС, Японы Цүкүбагийн их сургууль, Токио хотын Икашика анагаах ухааны их сургууль, АНУ-ын Калифорни, БНСУ-ын Сон Э хүрээлэн зэрэг дэлхийн түвшний их дээд сургуулиудад суралцан мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн аргагүй л юм үзэж, нүд тайлсан том эрдэмтэн.

Үүгээр зогсохгүй дэлхий дахинаа сорчилон уншиж, шагшин магтдаг олон арван ном зохиол орчуулахын сацуу бусдыг анагааж эдгээсэн, нээлт гэмээр том бүтээл туурвин 2007 оны

анагаах ухааны шилдэг бүтээлийн шагналыг нөхдийн хамт хүртсэн зэрэггэгээн үйлсийг нь тоочоод баршгүй.

“Хүн унших, мэдэх тусмаа өөрийгөө мөн ч болоогүй байна даа гэж чамлах юм” гэж хэлээд шинээр хэвлэгдсэн арван боть номынхоо эхний хуудсыг эргүүлж суух энэ эрдэмт хүмүүний тухай дэндүү их өргөн цар хүрээг хамрах агаад үзэглэхийн төдийхнөөр хязгаарлахын аргагүй. Харин түүний номын садан, эрхэм анд, Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Г.Мэнд-Ооёо, их эмч, эрдэмтэн, дуун хөрвүүлэгч М.Шагдарсүрэндээ зориулж:

Огторгуйд түгэгч од бүхэн өөрийн шалтгаанлугаа тохиоюу

Оюунт хүмүүний гэгээн номын мөр одод лугаа зохилдюу

Орчлонгийн харанхуйд ном эрдмийнмөнхийн зул бадраах нь

Очир эрдэнэсийн хүү сангийн алтан хайрцагнээх лугаа буюу

Мэргэн ухааны сувдыг хязгааргүй далайгаас хэн шүүрдэх

Мэдэхгүйн харанхуй цөлд биндэряан гэрэл хэн асаах

Биндэр ятгын алтан аялгууг

Янжинлхамтай хэн сонсох

Билигухааны их тэнгист хэлний сэлүүрээр хэн аялах

Аглагийн орон руу Бурхан багшийн гэгээрлийн мөрөөр хэн бэдрэх

Андууг арилгагч XIV Дээрхийн гэгээнтний ариуслын оронд хэн очих

Далай лам Цаянжамцын янагийн дууллын нууцыг хэн сонсох

Далайн чанад арлын Японы адармаатай ханзыг хэн тайлах

Эртний Персийн эрээн захаар Омар Хайямтайхэн алхах

Энэтхэг дахины хөлгөн Дармападагийн оронд хэн зочлох

Сарны дор Ли Байгийн гүцтэй сархадаас хэн амсах

Сац бас Нангиадын мэргэн үгийн сувдыг хэн хэлхэх

Бийр барьж шөнө туж нойроо мартаж хэн суух

Бэхэсийн мөр, үгсийн оньсоор цагийн чинадад хэн зорчих

Арван боть номын хөлгөн асарт тэр хүн заларч буй Алжаал, цөхрөл, аврал, итгэл, ялалт цөм

ТЭНД БУЙ

хэмээн яруу тансаг шүлгээ дээжлэн зориулсан нь Дарьганга нутгийн хүмүүний оюун билгийн мэргэн мэлмий машид гэрэлтэн, тув тунгалаг Гангын уснаа сарны гэрэл үзэмж төгс тусах тэрхүү гайхамшигт агшныг танд өгүүлсэн болой. Энэ их хүмүүний тухай өгүүлэхэд үүнээс илүү тодорхой, тунгалаг, гэгээн гэрэлт мөр бадгууд хэрэгтэй гэж үү. Яруу найрагч Г.Мэнд-Ооёо гуай “Хүн болгон нэг хөлгөн судар” гэж бичсэн байдаг. Тэгвэл номын анд нь энэ л хөлгөн судраа хэрхэн туурвисныг найраг шүлгийн уянгалаг мөрүүдэд уран тансаг өгүүлжээ. Арван цагаан буяныг дэлгэрүүлэх мэт арван боть номын нь анхны уншигч та бүхэндээ МУ-ын гавьяат эмч, нэрт дуун хөрвүүлэгч доктор, профессор М.Шагдарсүрэнгэй уулзаж ярилцсанаа толилуулъя.

- Таны энэ өдрийн амгаланг айлтгая. Шинэ номын эхний хуудас нээгдэн буй энэ агшинд тантай уулзаж байна. Баяр хүргэе



Нэрт дуун хөрвүүлэгч М. Шагдарсүрэнгийн 10 боть

- Баярлалаа. Ном хэвлүүлэх бол туйлын зорилго биш л дээ. Хамгийн гол нь би мэргэжлийнхээ чиглэлээр бичсэн эрдэм шинжилгээний ажил, орчуулга, нийтлэл зэрэг бүтээлээ хүнд бага ч гэсэн хэрэг тус болоосой хэмээн хичээдэг. Иймээс бусдын мэдлэгт дусал ч болов нэмэр болж, ажил амьдралд нь тус болоосой гэж санадаг юм. Олонх улс миний нэгэн адил бодож туурвидаг байх. Арван боть ном уншигчдын гар дээр очиж “Шагдарсүрэн” эмнэлэг бас арван жилийн ойтойгоо золгож, давхар баяр болж байна. Хамгийн гол нь ганц жилийн хөдөлмөр биш үзэг цаас нийлүүлж, эрдэм номын мөр хөөж, орчуулгын ажилд шимтсэнээс өнөөдрийг хүртэлх олон жилийн маань хөдөлмөрийн үр шим юм.

- Арван ботид ямар бүтээлүүд тань орж байгаа вэ?

- Эхний боть нь “Бурхан багшийн амьдрал”, ”Шагжамуни бурхны хөрөг оршвой”, түүнчлэн “Махабхарата”, “Монголын эзэнт гүрний арми”, “Мэлмий нээхүй мянган бадаг”, “Омар Хайям”, ”Рубай”, “Япон хайку”, “Хятадын мэргэн ухааны 100 сувд”, “Эртний Хятадын хошин шог”, “Эзэн хааны анагаах судар”, “Сэтгэл гэгээрээсэй” гэсэн арван боть ном хэвлэгдсэн. Бүгд өмнө нь хэвлэгдэн, номын дэлгүүрүүдээр тавигдаад дууссан байгаа. “Дармапада” хятад хэлнээс орчуулсан номнууд гурван хэлээр гарч байгаа болохоор хадмал орчуулга оролддог залуу хүмүүст хэрэг болох магад гэж бодож байна.

- Та “элэгний хорт хавдрыг тэжээх судсыг бөглөх эмчилгээ” гэдэг сэдвээр Монголд анх анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан байхаа?

- Элэгний хорт хавдрыг тэжээх судсыг бөглөх эмчилгээг анх удаа өөрийн оронд 1994 онд хийснийг манай салбарынхан болон эмчлүүлсэн улс маань мартаагүй байх. Одоо ч энэ эмчилгээгээр цөөнгүй хүний насыг уртасгах, тус болох гэж зүтгэсээр л явна. Энэ ч миний хийх ёстой ажил. Яг хорт хавдрын үед бол элэгний тэжээх судсууд нь махийгаад нум шиг болдог. Үүнийг нь нуман шинж гэж нэрлэсэн. Заримдаа түнтгэр байцаа шиг бөмбийгөөд гадагш ургадаг. Элэгний тараагуур судас нь дарсны үйсэн бөглөө авдаг сэндрүү шиг болчихдог содон шинж тэмдгүүдийг тодорхойлон бичсэн юм. Ямар эмчилгээ хийхийг нь бас Монгол орны нөхцөлд тохируулан бичсэн. Өөрийн орны эрдэмтэд бол нуман шинж гэхэд л заавал нээсэн хүнийх нь нэрээр оруулах байх. Манайхан гадаадынхан л нээлт хийдэг гэж ойлгодог. Дээрх эмчилгээний талаар улсдаа анх удаа “Элэгний хорт хавдрыг тэжээгч судсыг бөглөх эмчилгээ” гэдэг ном бичиж, олны хүртээл болгон бүх аймгийн хавдрын болон дүрс оношлогооны эмч нарт тараасан. Иймээс хожмын мэргэд үзэж, улам сайжруулан хойшдын судалгаанд хэрэглэх байх.

- Цаг хугацаа бүхнийг өөрчилдөг бөгөөд тэр нь их говийн элсэн шуурганаас ч хүчтэй, түүнтэй далайн аймшигт шуурга ч эн зэрэгцэж чадахгүй бөлгөө гэж уншиж байсан юм. Та цаг хугацааг хэрхэн үнэлж хайрладаг вэ?

- Олон хүн надаас “Та ер нь энэ их ажлыг яаж амжуулдаг вэ?” гэж асуудаг. Би цаг хугацааг л хайрлахыг хамгийн чухал гэж бодож хичээдэг юм. Завгүйгээ гайхаад хурал зөвлөгөөнөөс хойш суугаад, найз нөхдийнхөө жаргал зовлонгүл ойшоон албархаад байдаггүй. Урилга ирж, оролцох учиртай гадаад дотоодын бүхий үйл ажиллагаанд оролцдог. Эмч хүн чинь яаралтай дуудлагад өдөр шөнийгүл ялган явна. Орчуулгын ажлаа бол голдуу өглөө эрт таван цагаас долоон цагийн хооронд эсхүл шөнө дунд хэвийтэл сууж л амжуулдаг. Сүүлийн гуч гаруй жил би өглөө тавд босож, шөнө дундаас өмнө хажуулдахаар хэвтэж байснаа санахгүй байна. Бүр хэвшил болсон. Одоо л жаахан ядарч байгаа юм мэдэгдэж байгаа ч хийх ажил их байна. Олон жил орчуулаад байхаар сүүлдээ толь бичигүзэх нь багасаад заримдаа хуулан бичлэг хийж байгаа юм шиг л бичдэг. Хоёр цагийн дотор хүн мөн их юм хуулна даа. Ер нь хүний амьдралд цаг хугацаа гэдэг л ямар ч эрдэнэтэй зүйрлэшгүй үнэтэй. Цаг хугацаа бол бүхний хаан гэж би багтай хэлнэ. Цаг хугацааг хайрлаж зөв зохицуулж чадвал санасандаа хүрч хийе бүтээе гэсэн бүхнээ хийх боломж хүн бүхэнд байгаа. Амьсгалын тоо хэмжээтэй учир хэрэггүй юманд цаг заваа зарах нь хайран.

- Та бол яахын аргагүй манай нэрт дуун хөрвүүлэгчдийн нэгэн. “Дармапада”, “Бурхан багшийн сургаал”, “Бурхан багшийн амьдрал”, “Шагжамуни бурхны хөрөг оршвой” гэхчлэн хэд хэдэн бурхны сургаалын ном энгийн хүмүүст ойлгомжтой сайхан орчуулсан нь их үр дүнтэй болсон уу?

- Хавтсан дээрээ алтан үсгээр “Бурхны сургаал” гэж бичсэн номыг Японы Кобе хотын нэгэн зочид буудлын өрөөнд анх олж үзэж эхний хуудсыг сөхөн үзвэл “Хүн бүхэнд бурханлиг чанар заяагдсан буй. Гагцхүү тэр

чанарыг орчлонгийн шунал мунхагийн тоос шороон доороос сэргээж чадах аваас хүн бүхэн

бурхан болох замтай” гэсэн утгатай мөрүүд анх сэтгэлд бууж үүнийг монголчууддаа хүргэх юмсан гэсэн санаа төрсөн гэж олон удаа ярьж дурсаж байсан даа.



Дээрхийн Гэгээнтэн Далай лам, гэргий Д.Тунгалаг нарын хамт

Энэ хүслээ ч биелүүлсэн гэж боддог. 1989, 1990 онд XIV далай ламын сургаалыг орчуулаад хэвлүүлж байлаа. 29000 хувь хэвлүүлээд, зарим хөдөөний улс номын хавтасны нүүрнийх нь зургийг жаазандаа хийчихсэн байдаг байлаа. Дараа нь Энэтхэгт гэр бүлийнхэнтэйгээ очиж, Далай багшид бараалхаж байхдаа дурсахад “Та энэ ном орчуулах буянт үйлсээ цалгардуулж болохгүй шүү” хэмээн айлдаж билээ. Надад нэг алтан шармал бурхан, зандан эрхи адислан хайрласныг одоо ч машид нандигнан хайрладаг юм. Сүүлийн үед бурхны номыг манай залуучууд бас сайн орчуулж байна. Үүнд би маш их баяртай байгаа. Шинээр гарсан номнуудыг нь би аль болох олж уншдаг.

- Амьдралын утга учрыг хүн бүр өөр өөрийнхөөрөө л тайлдаг. Таныхаар?

- Замбуулинд хүн болж төрсөн юм чинь энэ богино насыг утга учиртай, бүтээсэн үйлстэй, хүн шигөнгөрөөх хэрэгтэй байхаа. Хүн дүрстэй болохоос биш хүн бус явдлаар яваад байгаа нэг хэсэг хүн байна. Өөртөө бас өрөөлд тустай юм хийгээд явж байгаа ч хүн бий. Тустай юм чадахгүй бол хортой юм хийхгүй амьдрах хэрэгтэй. Зүгээр л нэг идэж уугаад жаргаад явах юм бол амьтнаас ялгагдахаа болино. Би яахав өөрийнхөө хийх ёстой юмаа хийж байна гэж бодож, жаахан ч гэсэн сэтгэл ханамжтай байдаг. Эмч болсноор бусдын зовлонг нимгэлэхэд бага ч атугай нэмэр болж, залууст сургамж болж чадах хэдэн ном орчууллаа гэж боддог. Боловсрол, хүмүүжил, баян болно гэж шунах шунал гэдэг чинь өөр ойлголт. Зарим улс чинь нэг алттай уулыг аваад, улсыг авсан ч ханахгүй хүн байдаг шүү. Ийм улс түмний нүдэн дээр ил байна. Ер нь энэ шунал гэдэг бол нэгэн зүйлийн эмгэг юм болов уу гэж боддог. Хүн байгаа юмандаа сэтгэл ханах хэрэгтэй. Бурхны сургаалд хамгийн их жаргал нь сэтгэлийн амгалан. Сэтгэл ханах. Гэргүй хүнд гэр нь ертөнц гэж Энэтхэгийн эртний үг байдаг л даа. Ном үзэх нь арай ангид шунал. Энэ шунал бол байх ёстой шунал. Эрдмээр цангаж, түүнийг сурахын тулд шунаж болох юм.

- Буддын шашинд багшийг гурван эрдэнийн нэг хэмээсэн байдаг. Танд эрдэм сургасан багш нараасаа дурсахгүй юу?

- Багш олон байна. Надад “А” үсэг заасан Ж.Хорлоо багш минь одоо хүртэл сэрүүн тунгалаг байгаа. Ач тусаа өгөөгүй багш гэж надад байхгүй. Арван жилийн, анагаахын дээдийн гээд

тоолоход олон. Академич Б.Цэрэндаш, Б.Гоош, Чой.Лусанжав, англи хэлний А заасан Д.Алтангэрэл, элэгний судас сэтгүүрдэх эрдмийг заасан япон багш Ёшида, С.Сүзүки, Америкт анагаах эрдэм, англи хэл заасан багш гээд олон эрдэмтдийн нэрийг дурдаж болно. Харин би төвд үсэг заасан багшнарынхаа нэрийг хүндэтгээд хэлдэггүй юм. Багшийг шүтэх үзэл ер нь их чухал. Багш шавийн барилдлагаас гадна шавийн гурван хор гэж бий. Хөмөрсөн тогоо шиг байж болохгүй. Юу ч хүртэж хүлээж авахгүй гэсэн үг. Хиртэй сав шиг байж болохгүй. Хиртэй саванд буян тогтохгүй хэрэг. Энэ ч ном сургаалд их дурдагдсан байдаг. Зарим улс багшийн эрдмийг сураагүй байж алдааг нь харах явдал бас байдаг. Энэ бол ихээхэн зохисгүй.

- Анх эмч болох хүслийн үүд нээгдсэн тухай хуучилбал сонин болов уу?

- Би нэг дурсамж хуучилъя. 1970 оны өвөл. Сүхбаатар аймгийнхаа төвд есдүгээр ангид сурч байлаа. Тэр өвөл их цас зудтай өвөл байсан. Би өвлийн амралтаараа гэртээ очиход манайх сумын төвөөс нэлээд зайтай өвөлжиж байв. Амралтын хугацаа дуусахад, ээж минь намайг сумын төв руу дөхүүлж өгөхөөр хоёр тэмээтэй шөнө хугаслаад гарлаа. Их цасанд морь явж чаддаггүй юм билээ. Тэр өдөр аймгаас царцаа ногоон онгоц ирж, би сумын төвд нагацын гадаа тэмээгээ үлдээгээд аймаг буцах байлаа. Жаал явж байгаад би ээжийгээ даарч байгаа байх гэж бодоод “Ээж минь та одоо буцна уу” гэхэд ээж минь, “Үүр шөнийн хагацал гэж ярьдаг юм” ээж нь үүр сайхан манхайтал цайлгаад буцъя гэв. Ингээд гэгээ ороход ээж минь буцаад тэмээтэйгээ жонжуулж явахад би араас нь хараад яагаад ч юм бэ, хөөрхий ээжийгээ өрөвдөж билээ. Нүдний нулимс өөрийн эрхгүй бөмбөрч байсан даа. Энэ өдрөөс хойш би өөр хүн больё, их эрдэмтэй эмч л больё гэж бяцхан цээжиндээ андгайлсан юм. Гагцхүү энэ өдөр миний амьдралыг зөв зам руу залж, эрдэм сурах их хүслийн нар сэтгэлд минь мандан гэрэлтсэн гэж болно. Ээж минь харин бурхны оронд одохоосоо өмнө “Миний хүү ээжийнхээ ачийг хариулсаан. Намайг мундахгүй баярлуулсан. Захиж зүйлгүй” гээд духыг минь сүүлчийн удаа үнэрлэж байсныг одоо бодоход зүрх шархирдаг юм даа.



МУ-ын Хүний гавьяат эмч М.Шагдарсүрэнд ууган охин Ш.Эрхэмтөгс, хүү Ш.Түвшинтөгс, бага охин Ш.Амрита нар нь баяр хүргэлээ

- Домог түүхтэй Дарьганга нутгаасаа аж төрөхийнхээ гарааг эхэлж, ажил амьдралаараа үргэлж ахиж дэвшиж ирсэн амжилтын тань тухай олонтаа уншиж байсан юм. Энэ тухайгаа хуучилна уу?

- Хорин дөрвөн насандаа залуухан эмч Дарьганга суманд хуваарилагдан очиж байлаа. Мөр

мултрах, халдварт өвчин, бүх төрлийн гэмтэл, эх хүүхэд гээд 3000 хүний эрүүл энхийн төлөө ганцаараа зүтгэж, дэлхийн бөмбөрцөгийг тойрсон мэт их замыг туулж дуудлаганд явдаг байлаа. Хөдөөгийн эмч хүний алба үүрэггэж ерөөсөө ийм байдаг эрүүл мэндээ ч хайхралгүй элээсэн юм. Дараа нь аймагт ажиллаж байгаад, Улаанбаатарт III эмнэлгийн зүрхний тасгийн эрхлэгч, мэс заслын эмчээр ажиллах болсон. Мэс заслын эмч байхад гарын ур тун чухал. Дан номоор хийдэг ажил биш. Дээл оёход товч шилбийг хүн хүн янз янзаар урладаг. Түүнтэй адил жаахан ур дүй муутай мэс засалч хүн ч байдаг. Мэс засалч гэдэг маш нарийн мэдрэмжтэй, зоригтой уран хөдөлгөөнтэй, эгзэгтэй үед түргэн сэтгэж зөв шийдвэр гаргадаг байх учиртай. Энэ бол ямар ч мэргэжилтэй харьцуулшгүй онцын хариуцлагатай ажил. Гар нэг л буруу хөдлөхөд хүний амь хутганы ирэн дээр ирнэ. Аминд тулсан ажил. Хамт олондоо би бас их баярлаж явдаг. Амьд хүний булгилж савлаж байгаа зүрхийг зүсэж эмчлээд буцааж оёход яагаад ч болхи гар тэнцэхгүй. Булгилж байгаа зүрхэнд мэс засал хийх байтугай тариа хийж байхдаа зарим хүний гар чичирч байдаг. Амаргүй шүү. (инээв)

- “Шагдарсүрэн” эмнэлгийнхээ ирээдүйг хэрхэн төсөөлж байгаа вэ?

- Би эмнэлгээ өргөтгөх юмсан гэж боддог. Манай эмнэлэг янз бүрийн элэгний өвчтэй улсыг авдаг л даа. Хожим би сайн эмнэлэгтэй болох юм бол элэгний хорт хавдартай, элэгний өвчин нь сүүлийн шатандаа орсон хүн ч хүлээн авна. Ийм өвчтөнийг авах газар барагтай бол олддоггүй. Уг нь эмнэлэггэдэг хувийнх ч, хувьсгалынх ч байсан хүн зондоо үйлчлэх учиртай. Төр засгаас дэмждэг болоосой. Хөшөө дурсгал, уралдаан тэмцээн гээд мөнгө их зарцуулж байгаа харагдах юм. Ямар ч улс орон хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологиор хангагдсан эмнэлэг, өндөр боловсрол олгох түвшний сургууль хоёрыг л нэгдүгээрт тавьдаг. Манай улсад ганц элэг ч биш, зүрх, бөөр гээд мэргэжлийн эмнэлэг маш дутагдаж байдаг. Урдаа барьдаг эмнэлгүүд маань нь байшин барилга, багаж хэрэгсэл аль алинаар нь хоцрогдоод байгаа. Америк, Энэтхэг, Япон зэрэг орнуудаар явж байхад төр засаг нь анхаарахаас гадна баячуул нь ивээн тэтгээд хандив өргөөд байгуулчихаад нэрийг нь алтаар “Арслан хандив өргөсөн”, “Мөнгөн хандив өргөсөн” гэх мэтчилэн биччихсэн байдаг юм билээ. Баахан шавар, чулуун хөшөө босгохын оронд мэргэжлийн эмнэлэг байгуулчихвал мөн чиг буян болно доо. Амьдын буян хэмээн олон хүн санал нэгтэй дуугарна биз дээ. Эхлээд эмнэлгээ байгуулчихаад дараа нь тэр хөшөөгөө босговол яасан юм. Монгол эмч нар барилга байшин, багаж, төхөөрөмж, сургалтаар нь хангаад өгвөл хэнээс ч дутахгүй. Мөнгөтэй улс нь гадагшаа гараад жишээ нь нэгөдрийн хоёр сая гаран төгрөгийн төлбөртэй эмнэлэгт хэвтэж байхыг би зурагтаар тухайн эмнэлэг дээрээс нь харуулахыгүзсэн. Мөнгөгүй нь тэгээд яаг гэж байгаа юм бол. Гэтэл манай улсад уул уурхай гэж хэт хошуурах боллоо. Уул уурхай гэж хэт туйлшраад алт алмазаа юу ч үгүй алдаж ядуурсан түүхтэй улс орнууд цөөнгүй байдгийг бид мэднэ шүү дээ.

- “Би харь хэлийг монголоороо тайлах амттай зовлон эдэлсэн жирийн л сонирхогч” гэж даруухаан өгүүлсэн байхыг тань уншсан. Та зохиол бүтээл орчуулахаас гадна англи, япон, хятад гээд олон толь бичиг зохиосон. Харин таны одоо хийж байгаа охь үгийн толь их сонирхолтой юм аа.

- Энэ арван ботиос гадна ахиад арван зургаан дэвтэр ном хэвлэлд бэлэн болоод байна. Тэдний нэг нь энэ охь үгийн толь юм. Дандаа л монгол хэлний өвөрмөц, гоё тансаг үгийг

хэдэн жил түүвэрлэсэн. Одоо монгол хэлнийхээ сан хөмрөгийг мартаж гээд байгаа энэ үед хэрэг болно гэж бодож байна. Монгол хэлний арвин баялаг сан хөмрөг шавхагдашгүй. Өвөрмөц, хэвшмэл үг хэллэгийг хэрэглэж байхгүй бол аливаа хэл утга төгс сайхан сонсогдохгүй. Тавхан үгнээсээ танигдана гэж үг байдаг даа. Дарга, сайд, сэтгүүлч л гэх юм. Үндсэн үгийнхээ утгыг ойлгохгүй байх явдал их байна. Жишээ нь: Телевизээр ах дүүдээ ая дууны мэндчилгээ дамжуулахыг далимдуулаад гээд ярих нь чоно борооноор гэсэн өөр утгатай сонсогдоод байгаа биз. Малын сэгнээс дээж авна гэж ярих юм. Энэ утгаар, тэр утгаар гэж огт шаардлагагүй газар хэрэглээд байна. Энэ чинь үндсэн үгнүүдийнхээ утгыг сайн ойлгохгүй байгаа хэрэг. Сайн толь бичгүүдийгүзэж хэлээ хамгаалах нь чухал. Гадаадад төгссөн хүмүүс “Би уг нь сайн мэдэж байна. Монголоор яаж хэлэхийг мэдэхгүй байна” гээд мөрөө хавчаад байдаг. Нэгөвөрлөгч залуу япон, хятадаа сайн монгол хэлээ мэдэхгүй гэж монгол хэлтэй япон

хүнээр эх хэлээ заалгаж байсан гэх яриа бий. Энэ бол эмгэнэл юм.

- Шүлэг орчуулах амаргүй гэдэг. Харин та Японы хайку, Хятадын Тан улсын шүлэг, Омар Хайям, Цаянжамцын дуулал зэрэг дэлхийн яруу найргийн их ертөнц дэх хамгийн сор болсон шүлгүүдийг орчуулсан?

- Наадах чинь сайхан асуулт байна. Жинхэнэ шүлгийг сонсож, уншиж, мэдэрнэ гэдэг бол нэг их зөөлөн уянгыг надад өгүүлж чаддаг. Надад яруу найрагч нөхөд олон бий. Шүлэг орчуулах амаргүй даваа болохыг орчуулагч нар бүгдээрээ мэдэж байгаа.”Орчуулж болохгүй юмыг шүлэггэнэ. Орчуулах боломжгүй яруу найргийг яруу найраггэнэ ээ” гэсэн ч үг байдаг. Гэхдээ юмыг тэгж хаяж болохгүй л дээ. Тэр олон Ганжуур, Данжуур, Энэтхэгийн олон том ном соёлоос орчуулсан ард түмэн орчуулж л таарна. Омар Хайямын шүлгүүдийг орчуулж “Ялдамхан дүр чинь ямархан үзэсгэлэнтэй” нэртэйгээр хэвлүүлсэн нь уншигчдын таашаалд гайгүй нийцсэн. Нэрт орчуулагч, гүүш Го.Аким гуай, Элчин сайд “Шекспирийн сонет”-ыг яруу тансагаар дуун хөрвүүлсэн Ж.Чойнхор гуай гээд олон орчуулагч, зохиолч, яруу найрагч нөхөд маань урам хайрлаж дэм өглөө. Шүлэг бол үнэхээр хүний сэтгэлийг ариусгах увдистайгаараа гайхамшигтай юм. Жишээ нь: Омар Хайямаас орчуулж байхад:

Тэнгэрийн гэсгээлийг би аль эртнээс тэвчлээ

Тэсвэрийн хариуд хишиг шан хайрлах аваас

Хөнгөн аальтай уран гоо бүсгүйг илгээнэ үү

Хүндхэн ваартай уух дарс бас хүртээнэ үү

Ганхаж буй сарнай цэцгийн бут бүхэн

Гайхам сайхан бүсгүйн чандраас ургасан байж таарна

Өнөөдөр бидний гишгэлж буй өвс бүхэн

Өчигдөрхөн цохилж байсан өр зүрхнээс ургасанбайж таарнагэж орчуулсан. Эргэж харах

тусам янзлаад сайхан болгох санаа төрөөд байдаг юм. Г.Аким гуай “Энд уянга алга гэж хэн ч маргахгүй буй за хэмээгээд зарим алдаа мадаг байхыг үгүйсгэхгүй. Орчуулгын хаан энэ тэр гэж мэргэн дүүдээ цаасан малгай өмсгөхгүй” гэж түс тас бичсэн. Ж.Чойнхор гуай “Сэтгэлийн гэрлээ шингээж нэрсэн уянга найргаараа Персийг төдийгүй ертөнцийг тавируулсаар яваа Омар Хайямыг, төрөхөөсөө эхлээд нүд аних хүртлээ яруу найргаар өлгийдүүлж сурсан цамаан монголчуудын таашаалд нийцтэл танилцуулна гэдэг бас л амаргүй бөгөөд чингэж чадваас нэр төрийн хэрэг даруй мөн” гэж бичсэн юм. Энэ бол ганц намайг магтсан бус. Өсөхөөсөө эхлээд нүд аних хүртлээ яруу найргаараа өлгийдүүлж сурсан тэнгэрлэг ард гэж монгол түмнээ оночтой сайхнаар тодорхойлсон. Ийм ард түмэн хаа ч байхгүй байж мэднэ шүү.

- Цаянжамцын дуулал тань хэвлэгдэж гарах уу?

- Далай лам Цаянжамцын янагийн дуулал. Энэ бас адармаатай хэцүү орчуулга байсан. Гэхдээ зүтгэсэн болохоор өөрийн түвшинд орчуулсан. Удахгүй хэвлэгдэж гарна. Мэргэн уншигчид шүүн тунгаах биз ээ.

Хун галуу зэгст нуурандаа үзэсгэлэнтэй Хургаж жаргаж амьтны ёсыгүзүүлмой Хур борооны улирал нэгэнтээ одохын үест Хугасхан жаргал эдлэх мэт уй гунигийг тээмой. Үзэмж төгс нэгэн бүсгүй үзэгдсэнээс болж Үдшийн чимээг анирлан гуниглан суух боллоо Хайрын цэцгийгүндэслүүлж чадахгүйгээс болов уу Харамлах сэтгэл дээр намрын навчис унаад байна.

За тэгээд эртний хятадын шүлгээс охин Ш.Амритатайгаа хамтран орчуулсан шүү дээ.

Цэцэгсийн дунд гүц дүүрэн архиа дүүргээд

Цэмцийн зогсож ганцаараа хүртэхүй дор

Гэгээн саранд сэржим өргөн ёсорхож

Гэрэл сүүдэр нийлээд гурвуул согтвоо.

- Хятад эх дээрээ “Цэцэгсийн дунд гүц дүүрэн архи гэрэл сүүдэр гурвуул болов оо” гэсэн үг байсан л даа. Гэхдээ би бол эзэн согтсон юм чинь сүүдэр бас согтсон л байж таараа. Тэгээд согтуу хүний нүднээ сар ч бас согтуу гэсэн үг бодож олсон юм. Орчуулга гэж ийм л сайхан сонирхолтой ажил шүү дээ. (инээв) Харин японы хайку бол үнэхээр хэцүү юм билээ. Миний найз Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд С.Хүрэлбаатар надад орчуулах санал болгосон номыг нь би барьж аваад орчуулах гэж хичээсэн юм. Япон хэлэнд шаггүй чамбайрсан хүмүүс халгаад байсан. Япон хүнээс асуухад ч утгыг нь янз бүрээр тайлбарлаж, нэг ёсны уран зураг шиг байсан. Ер нь хайку шүлэг байгаль, нийгмийн үзэгдэл, хүний сэтгэлийн эгзэгтэй дахин давтагдашгүй агшныг маш оновчтой, тодорхой, нэг ч илүү дутуу үггүй хайрцаг томьёогоор гаргадаг юм билээ. Би тэр номоо орчуулаад дуусгасан. Их цаг хугацаа хөдөлмөр зарсан даа. Арван ботийн нэг нь Японы хайку.

- Таныг эрдэнийн чулуу сонирхдог тухай дотны хүнээс тань сонссон юм. Хувийн

цуглуулгатай юу?

- Эрдэнийн чулуу гэдэг бол энгийн чулуу биш, өөр өөрийн онцгой чанараараа хүнд нөлөөлдөг ид хав бүхий гэж би итгэдэг. Энэ нь ч үнэн. Дээр үед өвөө нар үнэтэй чулуун хөөрөг, гаанс хэрэглэдэг. Манай аав төө хэрийн урт соруултай гаанс хэрэглэдэг хүн байсан. Би өөрөө бас чулуу цуглуулна. Гэхдээ би үнэ цохиод хөөрөг аваад байдаг баян хүн биш л дээ. Геологийн төв лабораторийн болон чулуу сонирхдог, урладаг зарим хүмүүсийг таньдаг. Намайг мэднэ. Эрдэнийн чулууны хаан бол очир алмаз. Эзэндээ ээлтэй муу эрчисээс зайлуулдгаас гадна аянганаас эзнээ хамгаалдаг ид шидтэй. Хаш бол маш их эрдэмтэй чулуу гэж ярьдаг. Жишээ нь хаш хүнд ялалт амжилт авчирч, амьдралын хүч өгнө. Урт насалж, гэр бүл аз жаргалтай болно гэж үздэг байна. Гиван олон төрлийн эмгэгийг анагаадаг, гартааман хөөргөөр нүүрээ илбэл янз бүрийн муруй саажилтыг засдаг, маргад эрдэнэ очир алмазаас дутуугүй гээд бүгд цаанаа увидас шидтэй. Пийцүү нь ердөө хумсын толионы чинээ хэмжээтэй эзэн хааны зэрэглэлийн гэдэг нь илүү үнэтэй. Пийцүү ус татдаг тул дээр үеийн олон сараар аялал, бадар гэж явдагулс биендээ авч явахад цангаж үхдэггүй гэж ярьдаг. Хасбуу тамга гэдэг хаш гэсэн үг. Чингэс хааны эмээлийг хашаар чимэглэсэн гэж бичсэн нь бий. Чингэс хаантан бол алмазаар ч чимэглэж чадах хүн. Ингэж чимэглэсэн нь учиртай. Тогоонтөмөр хаан хасбуу тамгаа аваад мөлтөш гэдэг хаалгаар зугтжээ гэж бичсэн байдаг. Сүүлд нь хэлэхэд эртний хүмүүс ном бичигт нарийн юмнуудыг бичээд байдаггүй. Нууц увидасыг нь ихээхэн эрхэмлэдэг байсан. Дэлгээд хэлчихээр ухаад авчихдаг. Одоо хүдрийн заар гэсээр хүдрээ дууслаа шүү дээ. Зэрлэггахайн элэг элгэнд сайн гээд л одоо зэрлэггахай байхгүй болох магадлалтай болчихоод байна.

- Би харь хэлийг монголоороо тайлах амттай зовлон эдэлсэн жирийн л сонирхогч гэж даруухан өгүүлсэн байдаг?

- Шууд л орчуулах биш. Заримыг нь халтарлаад хаясангүй. Олон шөнөөсээ цайтал чөмгөө дундартал суусан үе зөндөө л байна. Намайг ингэ гэсэн ч хүн байхгүй. Ер нь хэлийгуйгагүй өдөр болгон үзэж дор хаяж арван мянган үгийн сантай болох нь чухал. Уйгагүй хөдөлмөр, авьяас хоёр хоёул хэрэгтэй. Авьяасыг хөдөлмөрөөр тордохгүй бол болохгүй л дээ. Ер нь арван мянган үг мэдэж байж орчуулга хийх хэрэгтэй гэж би боддог. Миний өчүүхэн туршлага тийм. Чой.Лусанжав багш “Харь хэл сурах нь амаргүй зорилт, иймд хэл сурах хүн өдөр алгасалгүй ханцуй шамлан үзэх чухалтай. Сайн болж байна хэмээн бардалгүй, саар болж байна гэж гутралгүй улам л цаашлаад байвал чанад эрэгт нь хүрэх цаг буй” гэж сургасан байдаг. Бямбын Ринчен гуайгааснэг хүн яавал орос хэл сайн сурах вэ гэж асуухад, “орос хэл сурах гэж зарим нь бүдүүн бүдүүн орос эхнэр тэвэрсэн нэг сурдаг”, “бүдүүн бүдүүн толь сугавчилсан нь бас нэг сурдаг”. Бүдүүн бүдүүн толь сугавчилсан нь арай илүү сураад байх шиг байгаа юм гэсэн хошин яриа байдаг даа. Үнэний ортой л гэж санадаг. Ярианы хэлийг тухайн оронд нь сураад, бичгийн хэлийг бол эх орондоо эзэмшиж болох байх. Ер нь бол орчуулагч хүний хамгийн үнэт зүйл толь бичиг. Бид анх гадаад хэлийг сурч байхдаа нимгэвгэр толь бичгийг цээжилж байлаа. Үнэ хайрлахгүй авдаг байсан сан. Одоо миний номын санд 100 жилийн өмнө, 200, 300 жилийн өмнө хэвлэгдэж гарсан ховор ном ч бий.

- Дэмий ч байж магадгүй гэнэн ч байж магадгүй нэг асуулт асууя. Бурхан багш таныг сургаал номыг нь олон түмнийхээ хүртээл болгоход их хувь нэмэр оруулсан гэж эргээд арван найман


насанд тань урин залж аваачвал та юу хийх вэ?

- Энэ даанч боломжгүй юм. Нэлээн хашир арван наймтан байж, ёстой олон ажлыг амжуулах байх даа. (инээв) Өмнө нь бол арван найман насаа мөнх ногоон мод, мөрөн гол шиг л санаж явлаа. Гэхдээ энэ бол ертөнцийн боломжгүй зүйлүүдийн нэг. Хүний нас эргэж ирдэггүй. Цаг хугацаа бол нэггэж хэлэхэд л өнгөрнө. Хамгийн том хаан бол цаг хугацаа учраас мөнхийн хуультай юм.

- Баярлалаа. Уншигчдынхаа өмнөөс эдгээн эмчлэх гэгээн үйлс болон, үгийн учгийн түмэн нууцыг тайлах их ажилд тань амжилт хүсье. Б.Төгсжаргал

Өдрийн сонин. 2008.01.12 №009

Гитарын аялгуу тасрахгүй



“Харш” хамтлагийн дуучин Ц.Энхтүвшин

Өнгөрсөн, одоо, ирээдүйн тухай өөрийн бодлоо тунгааж суулаа. Нар оройлсон өөжин цэнхэр дэлхийд минь намар ирээгүй байхад навчис унахаас урьтаж, нисэн одох нүүдлийн шувууд хичнээн олон юм бэ. Ийн бодоод гадагш гарлаа.

Дунд сургуулийн сурагч байхад “Талын цуурай” эстрадын дууны тэмцээн болж, он алгасахгүй оролцож дуулж бүжиглэж их л адтай байж дээ. Үе тэнгийн найз охидууд тэр үеийнхээ дуу бүжгийн тэмцээн наадмуудад хамтдаа оролцож, дууныхаа аяыг бичүүлж байхдаа анх Ц.Энхтүвшин ахтай танилцаж билээ. Тэр тэмцээнд оролцох гэсэн олон олон хүүхэд залуучуудын аяыг бичих гол ажил Ганзоригт, Энхтүвшин ах хоёрт л оногдож байсан юм.

Их л идэвхтэй аяа бичүүлж, ээжээрээ шинэ даашинз оёулан, театр дүүрэн алга ташилт нижигнээд, аймгаасаазайдуухан байдаг хөгжимт драмын театраас тараад бүгдээрээ хэлхэлдэн алхдаг байсан өвлийн өдрүүдийн дурсамж бүхнийг бичээд байвал олон хуудас болно.

Хэзээний л бидний ярианы сэдэв болчихсон байдаг, эргэн бодож, дурсан ярих дуртай 90-ээд он. Улс төрийн амьдралд төдийгүй, урлаг соёл, утга зохиолын хүрээнд энэ цагүеийн

тодотголтой залуу яруу найрагчид, хамтлаг дуучид олноороо гарч, төрөл, хэв загвар цаашлаад хэмнэл айзмаараа өөр өөрийн өнгөөрөө эгшиглэж байсан. Тэдний нэг бол яахын аргагүй “Харш” хамтлаг. Энэ хамтлагийн амьд хөгжим, авьяаслаг залуусын “хит” дуунууд одоо ч мартагдаагүй ээ.

Дурласан сэтгэл минь дундрахгүй

Дуулим хорвоод чамтайгаа амьдарна.

Хөөрхөн алагүртэй болчихоод

Хотоор гурвуулаа зугаалах болно.

Хос залуус гэдэг аз жаргалтай

Хоёулаа бүхнээс дутахгүй хайрт минь

Хоёр биенээ гэсэн сэтгэл байхад

Хорвоод амьдрах жаргалтай.

Одоо хүртэл үгийг нь сонсоод дагаж аялах дуртай “Нарсхан”, “Орчлонгийн амьдрал”, “Шар цэцэг”, “Дурлал” гээд олон сайхан дуунууд нь он цагийн омголон салхинд хийсэн одолгүй хит болж, “Харш” хамтлаг бидний сонсох дуртай хамтлагуудын нэг байсаар байгаа. Харин ямар ч уран бүтээл үргэлж нэг хүсэл нэг сэтгэл дундаас төрөх нийтийн хамт олны бүтээл байдаг. Ийм сэтгэлээр “Харш” хамтлаг маань тодорхой хугацаанд завсарласны эцэст эргэж бүрэн бүрэлдэхүүнээрээ цуглаж, “Дурсахуй” цомгоо гаргаж фенүүдээ баярлуулсан.

Харин өнөөдрийг хүртэл “үнэн цоглог” дуунуудаараа үзэгчдээ баярлуулсаар ирсэн тус хамтлагийн цомгийн “Дурсахуй” гэдэг нэрийг хэлэхэд хөгжмийн хэлээр бол хэмнэлд нь таарахгүй тийм нэг нэр мэт, нэрлэж дуудахад хэцүү айзам аялгуу, далд гуниг. Зөвхөн цомгийг нь л сонсох боломж. Тайзан дээрээс бол хэн нэгний нь орон зай үгүйлэгдэх тийм нэгэн “Эрэл”. Тэгсэн атлаа тэгж нэрлэхээс өөр аргагүй “Үнэн”. Тэнгэр бүхнийг тэгш харах биш тийм нэгэн дутуу тавилан.

Анх байгуулагдаж байхдаа аймаг хотоос цугласан цэргийн найзууд, жирийн андууд дундаа “Дорнодын” гэсэн тодотголтой гоцлол дуучин, ая зохиогч, ая эвийг нь тааруулаад шүлгийг нь ч зохиочихдог Ц.Энхтүвшин гэж авьяаслаг залуу

“Санаандгүй чамтай учирсан Сайхныг чинь харангуугаа мэдсэн” ...

гэдэг дуу анхны үзэгчид, сонсогчидод нь саяхан мэт санагдаж, аялсаар, дуулсаар л байна. Уран бүтээлч хүнд бүтээл туурвил нь ард түмнийхээ сэтгэл зүрхэнд хүрч, аялах дуртай дуу болохоос илүү аз жаргал үгүй юм.. Монголчууд уянгалаг дуунууд, уран бүтээлээр нь “тодорхой тунгалаг” мэдэх тул энэ удаа Дорнод аймгийн төвд амьдрах “Энхтүвшингийнх” гэх энгийн нэг айлаар орлоо. \



Дорнод аймгийн ХДТ-ын уран бүтээлчид 1990 он. Улаанбаатар хот. Соёлын өдрүүдийн үеэр

Даруухан зантай хөгжимчин гэргий, хоёр хөөрхөн ихэр охин, тэдэнтэйгээ тоглож суух арай эгчмэд ууган охин нь намайг ороод очиход үл таних мөртлөө учираа хэлэхэд ер татгалзаагүй найрсаг зан. Хойморт нь энэ айлын хамгийн эрхэм зүйл боловуу гэж үзэгдэх гялалзсан хар гитар харагдлаа. “Хааяа л нэг охид нь бас найзууд нь орж ирээд тоглоход эзэн нь, хань минь эргээд ирчихсэн юм шиг санагддаг” гэж хуучлах эхнэрийн нь яриа сэтгэлд нэгийг хэлнэ. Ийнхүү бид хоёр болдогсон бол өнгөрсөн цаг хугацаа эргэн ирээсэй гэсэн гэгээн бодолтой дурсамж ярьж суулаа.

“Салхи нь урьхан хаврын үдшийг Санаж яваарай хайрт минь чи” “Анх танилцаж байхдаа надад зориулж “Чамдаа” гэж энэ дууг зохиосон юм. Тэр үед бид хоёр сургуулиа төгсөж ирээд, Дорнодынхоо театрт хамт ажиллаж, залуу насны хайр оргилсон гэгээн өдрүүдийг өнгөрүүлсэн. Эцсийн мөч хүртэл энэ оргилуун хайр нь унтарч үзээгүй”. Ууган охин, хоёр хөөрхөн ихэр охидтой ч боллоо. “Харш”, “Цуурай” хамтлаг, үргэлжийн найз нөхдөрөө хүрээлүүлж байсан сайхан чанар, зав л гарвал дөрвөн охинтой юм шиг биднийгээ эрхлүүлж, тоглодогдрууд саяхан даа. Миний хань, олон сайхан хүслээ биелүүлж амжаагүй ч гэсэн хөгжмийн амьдралд үргэлж бүтээж туурвисаар явсан учир би сэтгэл жаахан уужуу байж, сайхан ханиараа цагүргэлж бахархаж дурсдаг юм. Би бас өөрөө хөгжимчин. Ихэр хоёр охид минь аавыгаа байх үеэс л дуулдаг байсан. Ер нь гитарын аялгуу тасрахгүй шүү” хэмээн О.Батцэцэг бүсгүй хэрсүүхэн өгүүлнэ. Ийм сайхан итгэл, энгийн нэгэн айл. Эгэл бүхэнд эгэлгүй нандин оршин нуугдахын учир энэ болой.

Дорнодын тал нутгаасаа эгшиг авч, Монголын ард түмэнд хүрсэн хэмнэл айзам төгс, хэдэн сайхан аялгуунуудаас нь бүрдсэн “Дурсахуй” цомог ч хэвлэгдээд удаагүй байна. “2003 оны 11р сард Солонгост захиалсан цомог нь 11-17-нд ирэхэд ах маань цомгоо ирэхээс нэг өдрийн өмнө нас барсан. 14 дууны 11 нь ахын маань зохиосон дуу юмаа” гэж дүү Ц.Энхгэрэл нь бас дурсан ярьж байсан юм.



Уран бүтээлч нөхдийн хамт 1991 он

Шүлгийн мөрүүд шигүргэлжлэх энэ мэт олон дурсамжуудыг хэлхэж суухад төлөвхөн ханийнх нь “Ер нь гитарын аялгуу тасрахгүй шүү” хэмээн өгүүлэх нь яг л дууны дахилт шиг уянгалаг сонсогдож, хөгжимчин бүсгүй итгэл өвөрлөсөн гэгээн инээмсэглэлээрээ намайгүдлээ. Нар оройлсон өөжин хөх дэлхийд минь намар ирээгүй байхад навчис унахаас урьтан нисэх нүүдлийн шувууд хичнээн олон юм бэ. Гитарын аялгуу тасрахгүй ээ.

“Өдрийн сонин” 2006 он 01.17 (2147)

Түүчээ тогоруу яаж зална, түүгээр л сүрэг нь явдаг шүү дээ



Хууль цаазын итгэмжит зөвлөх Ш.Эрдэнэбилэг

Өглөө босоход асуулаа

Мэнэнгийн тал гэнэ

Үд голлоход асуулаа

Мэнэнгийн тал гэнэ

Үдэш хүүшлэхэд асуулаа

Мэнэнгийн тал гэнэ

Явж байгаад асуулаа

Явж явж байгаад асуулаа

Мэнэнгийн тал гэнэ

Сайхан шүлэг шүү. Мэнэнгийн их тал тэнгэрийг түлхэн, хаяа хярхаггүй сэлүүрэнхэн алсарч, тэрхүү хүй элгэн газрын төвд Хан уул тэнгэрийн цагаан хүлэг мэт үзэгдэх нь содон. Зон олны амьдрал урсдагаараа урсаж, өөрийн хичээл

зүтгэлээр ажиллаж, бүтээж, туурвиж, мөн хайр, итгэл, халуун сэтгэл цогцлохын ерөөл бүрдэнэ.

Ийн өгүүлэхийн учир тал нутагтаа эзэмшсэн мэргэжлээрээ эгэлхэн он жилүүдийгүдэж, угтаж яваа Шагдарсүрэнгийн Эрдэнэбилэг прокурорын тухай цөөн үг хэлсү. Улаанбаатар хотын Хууль Цаазын дунд сургууль, МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Удирдлагын академийг Төрийн удирдлагын арга зүйч, менежерээр төгссөн эрхэм хүмүүний намтар дунд хэцүү хатуу бүхнийг эерүүлэн зөөллөдөг төлөв төвшин, амар амгалан зан чанар ямагт оршиж, хийж бүтээхийн ид хаваар саад бэрхшээлийгүлдэн хөөж амжилтанд хүрсэн зам бий.

Зориод очсон хүн бүхний зовлон жаргалыг тэвчээртэй сонсож, зориг итгэл хайрлан урам дэм болж чаддаг эрхэм нандин чанараараа зөв буруугийн дэнсэн дээр зогсож явсан хичнээн олон хүний амьдралын замыг залж чиглүүлж, алдаа эндэгдлээ давтахгүй байж чадах сэтгэлийн хат хайрласныг тоолоод барахгүй. Тэрээр шудрага үнэнийг шүүн тунгааж, хуульч хүний ёс зүйг эрхэмлэн дээдэлж, алтан соёмбот сүлд, андгай тангарагтаа үнэнч явахыгтол чиг замаа болгон ажилладаг олон арван шилдэг прокурорын нэгэн юмаа.

Эгэл жирийн ажилтнаас төрийн өндөр дээд албан тушаал хашин зон олныхоо итгэлийг даан амьдрах их хүчийг Алтан Дарь овоо, Ганга нуур нь харамгүйгээр түүнд бэлэглэжээ. Сайн явах санааных хойно доо. Түүний хичээл зүтгэлийг заяа буян нь бат түшсэн юм.

Өгсүүр зам хэцүү, бартаатай бол бүр хэцүү. Гэвч өгсөж явна гэж санах, хариуцлагаа улам тод мэдрэх, эгэл олныхоо итгэлийн ноён нурууг хугалахгүй явах гэдгээ үл мартаж л төрийн хүний гүн бат сэтгэл, бас зүтгэл аж. Ийнхүү өгсүүр замын бартаа дунд хөвөрсөн түүний намтрын гэрэлт хуудас он цагийн салхинаа сэрчигнэнхэн эргэхийн тоолонд хүн болгон нэгэн хөлгөн судар болой хэмээх мэргэдийн үг дахин сэтгэлд шинэсэн гэрэлтлээ. Ш.Эрдэнэбилэг прокурор улсад 19 жил ажиллахдаа шүүхэд нарийн бичгийн дарга, тогтоол гүйцэтгэгч, сэргийлэгч-түрүүч цолтой цагдаа цэрэг,хяналтын прокурор, туслах прокурор, аймгийн прокурор гээд энэ салбарын үе шат бүхэнд амжилттай ажиллаж үргэлж ахиж дэвшиж явсаар 2003 оноос өнөөдрийг хүртэл Дорнод аймгийн прокуророор томилогдон ажиллаж байгаа юм.

Дуудах нэрийг эцэг эх нь

Дуурсах алдрыг өөрөө олногөж монголчууд ярьдаг.

Ардын багш ааваасаа үлгэрлэн замнаж, ажил үйлээ чин сэтгэлээсээ хийх, нэр төрөө эрхэмлэх, зөв үйл хэрэгт нэгэн үзүүрт сэтгэлээр хандах нандин сэтгэл, сэтгэлгээгөвлөсөн түүнд хичээл зүтгэлийн нь хариу ирсэн нь аж амьдралаас нь тодхон харагдана. Бурхан багш өөртөө тусалдаг хүнд л тусалдаг гэж ярьдаг шүү дээ. Ийнхүү өөртөө тусалж сайны үр шимийг хүртэж, бусдыгаа дагуулсан түүний гэгээлэг зан чанар, ажил амьдрал анд нөхөд гэр бүл хамтран ажилладаг бүх хүмүүстээ тийм нандин чанарыг өөрийн биеэр үзүүлж, төрийн албыг нэр хүндтэй залгуулж ирсэн олон амжилтыг дурьдаж болно.

Сүүлийн жилүүдэд Дорноговь, Дорнод аймгийн прокурорт ажиллахдаа прокурорын

байгууллагын өмнө дэвшүүлсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, төлөвлөсөн ажлын биелэлтийг хангуулах, ажлын хамт олны эв нэгдэл, хамтач ажиллагааг бий болгох, хяналтын ажлын тоо, чанар үр дүнг дээшлүүлэх, УЕПГ-аас батлан гаргасан удирдамжийн баримт бичгийн зүйл заалт, өгсөн чиглэл үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь ажил хэрэг болгох, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шуурхай шалган шийдвэрлүүлэх гээд удирдлага зохион байгуулалтын дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлснээр үр дүнг нь үзэж системдээ тэргүүлж яваа хамт олныг удирдаж байна. Түүчээ тогоруу яаж зална, түүгээр л сүрэг нь явдаг шүү дээ.

Ийн хамт олноо манлайлан хошуучилж, удирдан зохион байгуулах авьяас чадвар сайтайг нь хамт олон нь дуу нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Бүхий л ажилтнаа нэг чиг зорилгын

төлөө хөтлөн авч явах чадвартай хүнийг удирдагч гэнэ гэж бид олонтаа уншсан. Дорнод аймгийн прокурорын газрын ажил үйлс нэн бүтэмжтэй, тэргүүлж яваа нь энэ хүний удирдан зохион байгуулах авьяас чадвартай холбоотойг тал нутгийн зон олон хэдийнээ мэдэх болжээ.

Амжилт өөд тэмүүлэх зам үргэлж дардан байдаггүй ч тэрээр огт шантралгүй, өргөсөн тангарагтаа үнэнч байж, өөдөлж дэвшихийн эрхэм зорилгоосоо хором ч ухраагүйг он цаггэрчилнэ. Жирийн ажилтнаас “Хууль цаазын итгэмжит зөвлөх” болтлоо өсөж дэвшсэн нь түүний хөдөлмөрч чанарын үр шим байж, ихийг бүтээж гэрэлтүүлэх “шанг хагалсан” билээ. Ганга нуур шигээ тунгалаг зөөлөн сэтгэлээр орчлон хорвоогийн зөв бурууг тольдож, Оргихын булаг шигээ ололт амжилтаар оргилон даргиж, Дарьганга нутгаас жигүүр дэлгэн ниссэн болохоор тэрбээр Дорнод, Сүхбаатар Дорноговь гээд говь талыг хэмжин түмэн олныхоо гэрэлт ирээдүйг түшилцэн, бурууг нь шүүн засч, зөвийн гэрэл цацруулж буй тухай их зүйлийг өгүүлж болно.

“Зорилготой бай

Зоригтой бай

Зогсолтгүй бай”

гэсэн их зохиолч Р.Киплогийн дайчин уриа байдаг тухай би энд зориуд үзэглэлээ. Чухам энэ уриагаар жанжин тугаа хийж шударга үнэний төлөө тэмцэж яваа гэсэн цомхон үнэлэлт өгч болох ч томхон ажлыг нугалж явдаг хүмүүн бол яахын аргагүй Ш.Эрдэнэбилэг дарга.

Эгэл хүний төсөө ойлголтоор төрийн хүн гэхээр л их зантай, ихэмсэг бардам байдаг бус, харин ч “их мөрөн дөлгөөн” гэж өгүүлэхтэй дүйцэх энгийн төв, элгэн найрсаг байдаг нь жирийн олонтойгоо амь нэг, ажил үйлс нь өөдлөн дэвшихийн сэжим болдог. Өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхийн сацуу шинэ залуу ажилтнуудыг сургаж, дадлагажуулахад үргэлж анхаарч зааж зөвлөн, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулж, прокуроруудыг үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор

хангахад чиглэсэн багагүй ажлуудыг хийж, байгууллагадаа урлаг, спортыг хөгжүүлэхэд ч анхаардаггээд өргөн цар хүрээтэй, хүртээмжтэй сэтгэж бодох, хийх бүтээхийг эрхэмлэн үүнийгээ ажил хэрэг болгож чаддаг нь нүднээ илт.

Ингэж тэрбээр очсон газар бүхэндээ хүмүүсийн сэтгэлийн галд өөдрөг ажиллаж амьдрах “урмын гэрэлт бамбар” асааж явдгийг Сүхбаатар, Дорнод, Дорноговь аймгийнхан мэднэ. Ийм хүний ажил үйлсийн зам дэвжин дээшлэхээс ч аргагүй юм. Сайхан хүн гэгч чухамдаа ариун сэтгэлээр дотроосоо гэрэлтсэн хүнийг хэлнэ” гэж их зохиолч Чадраабалын Лодойдамба гуайн хэлсэн үгийн үнэнийг түүнээс харж болно.

Эрхэм прокурорын тухай үзэглэж суухад “Морь уях төрийн хэрэг” гэсэн үг бодлын чинадад эргэлдсээр байлаа. Хууль сахиулах хариуцлагатай ажил хэргээс нь гадна хүлэг морио бурханчлан шүтэх эр хүний хийморь лундааг нь өгүүлэхгүй байхын аргагүй.

Дөрвөн туураинд нь галтай цахиур маналзсан дүрэлзэн гэрэлтэх их хийморь тэнгэрийн ажнай, алтан туурт хүлэг морио эрхэмлэн дээдэлдэг тэрбээр бас шаггүй уяач. Төрийн сүлдэнд мөнхөрсөн хүлэг сайн морио шүтэн дээдэлдэгийн учир түүний төрийн алтан цулбуур өргөлцөх үйлс төгөлдөр бүтэмжтэй яваа болов уу гэж сэтгэл уярлаа. Бодол улам уужирлаа. Мандах нарыг магнайдаа духдуулсан Алтан дарь овоо, Шилийн богд, Хан уул шигээ үргэлж мөнх “эрхэмсэг нандин, эгэл боргилын туйл” явахыг хүсье.

“Дорнодын прокурор 80-н жил” ном. 2010 он

Эрэнцавын өвсөн дахь гурван өндөгний нууц



Дорнод аймгийн Эрэнцав суманд бүтээсэн Их яруу найрагч Д.Нямсүрэнгийн хөрөг барималын дэргэд гэргий Г.Хандмаа нь хамгийн анх шургааг модыг нь түшин хамтдаа зогссон агшин. 2009 он.

I

Дарьганга, Эрэнцав, Данзангийн Нямсүрэн. Утга зохиолын хүрээнийхэн төдийгүй уншигчдын хувьд энэ гурван нэрийг аль нэгэнгүйгээр нь төсөөлөхийн аргагүй болжээ. Их яруу найрагчийг 2002 оны сар шинийн өмнөхөн Эрэнцав хүрэх галт тэрэгний өртөөн дээр үдээд зогсох зуур олон зүйл асуусан. Энэ бүхнээс “Дарьгангынхаа Алтанхарганыг, Эрэнцавынхаа Дүнжингарав цэцэгтэй зүйрлэн санаж хайрладаг даа” гэж аяархан хэлээд санаа алдах нь дуу хураагуурт их л тодхон сонсогдоно.

Ингэж ярилцаж байхдаа их найрагчийг хөшөө болон мөнхрөх тухай огтхон ч төсөөлөлгүй явсан мөчүүдээ эргэн саналаа. Аавын номын өрөөнд тухлан, хорвоогийн сонин хачин, нутаг нуга, шинэ бүтээл, цэнхэр цэцэгс, ирж буцах шувуудыг догдлонгуй өгүүлэх найрагчийн тухай цэнхэр туузтай бага нас тийм их зүйлийг эргэцүүлж бодож мэдэх биш дээ.

Эрэнцаваасаа огтхон ч одоогүйг нь гэрчлэх хөх өвсний үнэртэй шүлгүүд, хөөрхөн бор болжморууд шиг долоон жаахан үр, хэдэн хөөрхөн ач зээ, Улз гол, Баруун, Зүүн Эрэнцавынхаа хүн зон, хуучин байшингуудынхаа дунд хөшөө болон бодол болж зогсох тухай хэн ч төсөөлөөгүй л хэрэг.

Цаг хугацаа гэдэгүргэлж хувьсаж хувирч байдаг юм хойно доо. Долоон болжмор үүрнээсээ нисч, том охин Цасанчимэг нь багш болж, Зэв зээ нь сургуульд орж, Бөртэ охин нь найргийн сүмийн тахилч найрагчийн гэргий Хандмаа эгчтэй хамт аавынхаа уран бүтээлийн урланг

сахиж суугаа сурагтай. “Наранбаатар, Хөхдэй мэргэн хүү минь аавтайгаа бүр л адилхан болоод байгаа биз” гэж инээмсэглэн ярих Г.Хандмаа эгч энэ хөшөөний дэргэд хамгийн анх зогссон хүн шүү гэж зураач, уран барималч Ж.Дүүрэнтөгс ах хуучиллаа. Тэр хоёр яг л зэрэгцэж зогсоод гангар гунгар ярьж байгаа мэт дотно сайхан харагдаж байсан шүү гэж нутгийнхан бас ам сайтай байлаа. “Та ер нь голдуу ямар улиралд шүлгээ бичдэг вэ? гэсэн асуултанд маань,

-Ах нь зуныг жаахан нозоороод л өнгөрүүлдэг. Та нарын унших дуртай хэдэн шүлгийг намар, өвөл л бичсэн дээ” гэж өгүүлэх нь дуу хураагуурт хөвөрсөөр. Намрын дунд сардаа өвсний амьтай гэгээн шүлгүүдээ бичсээр хөшөө болон дахин “мэндэлсэн” нь Эрээнцавынхан их найрагчтайгаа дахин уулзсан мэт баярлаж байлаа.

II

Гурван өндөг хамгийн түрүүнд нүдэнд тусна. Ойроос үзсэн улс их адилхан болжээ гэж ярилцана. Зураач, уран барималч

Ж.Дүүрэнтөгс ахтай уулзахаар утсаар ярихад: “Хийсэн юмныхаа тухай ах нь ер нь дахин дахин ярих дургүй. Надаас өөр хүмүүс л хэлэг. Гэхдээ уран бүтээлч хүн удаан уулзаагүй хүнтэйгээ түр тухлаж, шинэ сонин зүйл ярихад юу нь буруу байхав. Ахынхаа шинэ урланд завтай үедээ очоорой” гэж уриалгахан хэлсэн юм. Хуучнаар сүлжмэлийн үйлдвэрийн байранд шинэ урлантай болж байгаа юм байна. Шинээр орсон уран бүтээлчид тэндээ төвхнөж л байгаа бололтой. Ж.Дүүрэнтөгс зураач шинэ урлангийнхаа өрөөнд хийж бүтээснээ ярих шинжгүй, харин нутагус, ах дүү, уул овооны түүх домог, хүн чулуу гээд сонирхолтой зүйлүүдийг бидэнд ярьж өгсөн юм.

Гурван өндөгний нууцыг асуухад: “Алтан шаргал өнгөтэй гурван өндгийг их найрагчийн амьд ахуйдаа гаргасан гурван номоор л бэлгэдэж хийсэн. Тэрэгний арал түшүүлж зогсоосон юм. Яруу найрагчид зураач бид нараас илүү гоё сайхан үгээр урладаг сайхан хүмүүс. Модон гүүр үү? Хашаа юмуу гээд янз бүрээр л төсөөлж бичсэн байсан. Хүн хүний төсөөлөл өөр юм болохоор юутай ч зүйрлүүлж хэлсэн надад бүгд л дотно сайхан санагддаг. Д.Нямсүрэн ахад жирийн энгийн зүйл гэж байдаггүй. Ямар сайндаа төмөр гоё гэж хэлсэн байдаг шүү дээ” гэж ярилаа.

Ж.Дүүрэнтөгс зураачид их ажлын ард гараад ядарсан зүдэрсэн эсвэл нэг их омогшиж бардамнан гавьяархсан зүйл нэгээхэн ч алга. Хийх ёстой ажлаа л хийсэн уран бүтээлчийн ая зантай суугаа нь сайхан санагдлаа. Дархан хүний бурхан ухаан гэж юутай ч зүйрлэшгүй. Сүхбаатар аймгийн төвд их жанжны хөшөөг шинээр бүтээж, нээлтээ хийж ирээд дөнгөж дөрөө мултлаад байхад нь уулзаж ярилцлага авч байсан. Энэ хүн энгийн сайхан яриагаа дэлгээд л сууж байсан. Жинхэнэ уран бүтээлч дээ.

“Д.Нямсүрэн гуайн хөшөө бол жирийн нэг цээж баримал, эсвэл гараа дээш өргөсөн, нэг их тэмүүлсэн байх нь зохимжгүй. Ийн бодсон, үл ялиг гунигласан байвал оновчтойг л дотроо бодож төсөөлсөн. Тийм их холыг бараалж, дээгүүр харсан, дэндүү их юм санаж явдаг хүн биш хамгийн энгийн зүйлийг ч гоё сайхан болгодог нь сайхан

юм даа. Эрэнцавын дундуур Улз гол нь урсаад гүүрний хоёр талд байдаг юм билээ. Энэ гурван өндөг бол түүний амьд ахуйдаа урласан ертөнц. Би бусдын адил түүний энгийн зүйлийн энгүй их нандин эрхэмсэг байдлыг олж хардаг бодь сэтгэлийг нь үнэхээр их хайрладаг”. Ж.Дүүрэнтөгс зураач ийн өгүүллээ.

Их яруу найрагч өдгөө сэрүүн тунгалаг байсан бол намрын намарт Дагуурын цэнхэр тогоруудаа дагаж нисэх нь холгүй догдолж, Дарьгангынхаа цэнхэр нуураас хун шувууд нисэж байгаа гэж бодон зүүдэлж, галт тэрэгний дуунаар босож сууна. Гадаа хөдөөнөөс түүнийг зорин очих хэн бүхнийгуриалгахан угтан авч, Хөхдэй, Бөртэгээ гүйлгэж тосуулаад, хэсэгтээ л хөөрч баярлаж догдлоод хэдэн сайхан шүлэг бичих байсан гэж бодогддог юм.

Ш



Хөрөг баримлыгурлаж байгаа уран бүтээлчид.2008

Хөшөөний тухай хот, хөдөөгүй л ярьж, бичиж байна. Сайхан хөшөө болжээ, тун ч адилхан бүтээж шүү гэж талын намхан уулсыгөртөөлөн хүрээ хот, гүрэн дамжиж яригдсаар л байна. Дэргэд нь очиж үзэхсэн гэж ярих хүмүүс ч зөндөө.

Сэтгүүлч, яруу найрагч, орчуулагч Ж.Нэргүй: “Тийм л бурхны суудаг нутаг шиг хол, “од мэт дан сууцнаас өөр торойх юмгүй” Эрэнцав нутагт Ж.Дүүрэнтөгсийн бас нэг туурвил босжээ. Даанчиг сайхан зөөлхөн хөшөө, үгүй ээ, дурсгал! Янжинлхамын нулимс шиг, Гоолингоогийн ая шиг! Данзангийн Нямсүрэнгийн шүлэг шиг эгэл гэдэг нь жигтэйхэн, хажуугаар нь бас гэгээн өглөөний нар шиг хөөр баяр цацруулсан хөшөө! Модон тэрэгний арал ч юмуу, нэг хөндлөн шургааг түшээд, хөөрхий нэгэн хөдхи эр зогсоно. Ж.Дүүрэнтөгсийг Торой бандийн хөшөөг ч бас урласныг нь сонсоод, “Ухаан нь жагссан хүн л ийм юм хийнэ дээ. Даанч тэр нь дэлхийн мэлмийгээс дэндүү алсад, “далдын далд, даалингийн мухарт”, ёстой л Тоорой бандийн хэрэн хэсэж явсан газар нутаг шиг хол байдаг нь харамсалтай. Тэрийн болгон харц мялаахын заяа дутна” гэж найрагчийн сэтгэл үнэн дүр зургийг өгүүлжээ” (Өнөөдөр. 2009.09.30) гэж “Хөшөө” нийтлэлдээ бичжээ.

Ж.Дүүрэнтөгс ах “Би урьд нь нэг хөшөө бүтээж байгаад дутуу орхичихсон хүн юм шиг байгаа юм. Хориод бүтээл байгаа” гэж даруухан өгүүлж суулаа. Дарьгангад Шилийн сайн эр Торой банди, Сүхбаатар аймгийн төвд Их жанжны морьт хөшөө, Дорнодод Өүлэн эхийнх гээд Дорнод Монголын тал нутагт урлан босгосон хөшөө бол олон доо, олон. Хориод хөшөө

сүндэрлүүлнэ гэдэг амаргүй бөгөөд хөшөө бүхэн нь бодот өгүүлэмж, уран санаагаараа бусдаас гойд ялгарч байдаг тухай судлаачид үнэлж цэгнэдэг юм.

Ийнхүү Эрээнцавын өвсөн дахь гурван өндөгний нууцын тухай хичнээн ихийг өгүүлж болох билээ. Утгын ундарга, оюун санааны охь болсон их яруу найрагчийн тухай ийн бичиж суухад Хандмаа эгчээс захидал ирлээ. “Эрээнцавд их цас орсон, Цасанчимэг ирээд явсан, Зэв хүү хичээлдээ яваад...” гээд л сонин сайхан хуучлан ярьж суугаа мэт бичжээ.

Хэрвээ Данзангийн Нямсүрэн найрагч амьд сэрүүн байсан бол гурван алтан өндгөн дээр анхны цас унаад хайлах сайхан тухай бас нэгэн уянгалаг шүлэг төрөх байсан бизээ.

Идэр есийн хүйтэн цагаар хүрээ хотын давчуухан гудамжаар яаруухан алхах танд гурван алтан өндгөн дээр цас унасан тухай өгүүлсний учир, “Цас” болон будран орох сэтгэлийн илгээмжийг нь хүргэюү.

Үнэн сонин. 2009. 11.22 Б.Төгсжаргал



Table of Contents

[Уялга үг](#)

[Хоног хэдий олон ч холдуулж мартуулах нь үгүй](#)

[Хоёр. Аавын өрөө](#)

[Миний ээж](#)

[Усан луу жилийн зун цаг ээж бид хоёр](#)

[Ажиа гэгээнтний “цагийг бэлгэдэгч Наран чөлөө”-д өгүүлмөй](#)

[МУСГЗ. нэрт дуун хөрвүүлэгч, сэтгүүлч Г.Аким](#)

[Олонтой явсан аавын хүү](#)

[Заяаны эмгэнийг зааж өгсөн багш минь](#)

[Чулуу үл өгүүлэхийн тулд хүмүүнээ тааламжтай гэж үг байдаг](#)

[Кино урлаг бол төрд хэрэгтэй зайран](#)

[Миний сэтгэл шиг нуур](#)

[“Хилийн заставын хар нүдэн бүсгүй” гэдэг шүлэг маань дорхноо л дуу болсон](#)

[Ганга нуур минь ширгэж, гангар цагаан хун шувуудаар дутах вий](#)

[Энэ хүрэл хөшөөг би 10000 жилийн настай гэж баттай хэлнэ](#)

[Хэл бичгийн ухааны доктор, Толь зүйч С.Дэмбэрэл](#)

[Кино нэг талаасаа урлагийн бүтээл, нөгөө талаасаа арилжааны том хэрэгсэл](#)

[“Чонон сүлд” монголчуудын ширээний ном болно гэдэгт эргэлзэхгүй байна](#)

[Монгол соёл-хүн төрөлхтний үүсэлтэй Чацуу](#)

[“Д.Сүхбаатар сан”-гийн тэргүүн МУ-ын гавьяат багш С.Лувсанноров](#)

[580 гаруй ханз үсэг сайтар эзэмшвэл Хятадаар сонин хэвлэл бараг уншдаг болно](#)

[Миний уран бичлэг бол зохиолчийн гар бичмэл гэдэг талаасаа чухал юм](#)

[Зуун шарга зээр гөрөөс гүйлдэхэд зул болж асмуй би](#)

[Түүхийн номнуудыг ангасан хүн ус залгилах мэт уншиж байгаа](#)

[“Өрмөн уул”-ын өөдрөг хатагтайтай уулзсан тэмдэглэл](#)

[Үг болгоноос нь гэрэл цацарч үйлс бүхэнд нь буян хуралдмой](#)

[Хариу нэхээгүй хайр гэдэг хамгийн агуу хайр](#)

[“Огторгуйн очир”-ыг тунгаахуй](#)

[Үхээнц ноомой явахыг үзэн яддаг би](#)

[Ухааны ураа бийрийн шидээр амилуулагч буурал зураач](#)

[Дотоод сэтгэлийн өнгийг тольдохуй](#)

[Яруу найрагч, их сэтгэгч Дамдинсүрэнгийн Урианхай](#)

[Би хүн төрөлхтнийхөө өмнөөс маш их эмгэнэж байна](#)

[Он цаг ... тэмдэглэлийн дэвтрийн хуудас шиг эргэсээр л](#)

[Найргийн сүмийн тахилч найрагчийн гэргий Г.Хандмаа](#)

[Манай дарьганга дуу бол үнэхээр эрчимлэг, эрчистэй дээ](#)

[Бид хятад хүнийг мэддэг гэхээсээ илүү мэддэггүй зүйл маш их бий](#)

[Хамгийн том хаан бол цаг хугацаа учраас мөнхийн хуультай](#)

[Гитарын аялгуу тасрахгүй](#)

[Түүчээ тогоруу яаж зална, түүгээр л сүрэг нь явдаг шүү дээ](#)

[Эрээнцавын өвсөн дахь гурван өндөгний нууц](#)